

БААБАР

Бас

ИНГЭЖ ӨГҮҮЛЭВ



Хэнтийн гурван

ТЭНЭГ

Хэнтийн гурван тэнэг
Зохиолч: Б.Батбаяр "Баабар"
Эрхлэн гаргасан: "НЭПКО" хэвлэлийн газар

ISBN: 978-9929-861-6-6

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Ш. Зууны сүүлчийн золиос

Олон тулгуур ба олон туйл

2000 онд Ельцин буцаж, Путин ирлээ. Хэзээ нэг цагт Бээжинд Тэнгэрийг тэтгэсэн явж, Хэвт ёсны хаан тодрох нь Монголын дотоодын амьдралд маш чухал үйл явдал байлаа. Мөн энэ зуунд Сталин үхэж оронд нь хэн гарч ирж байгаа нь мэдэгдэхгүй Монголын улс төрийг баахан бужигнуулж байв. Ямар сайндаа Сталинийг үхэнгүүд Зөвлөлтийн их эзэнт улсад нэгдье гэсэн өргөдөл тэвэрсэн манай дарга нар Москвад Оросын удирдагчдын гайхлыг төрүүлж байхав дээ. Гэтэл Ельцин зайлж, сонгуулиар Путин гарч ирж буй нь өнөөгийн монголчуудад нэг их ач холбогдолгүй болчихжээ. Хэдэн жилийн өмнө өвгөн Ян Шэнкунь тэтгэвэртээ гарч “төгөлдөр хуурч” Зэнь Зяминь тодров. Дараа нь тэрээр тэтгэвэрт гарч Ху Жэнтаогийн ээлж ирэв. Аль алин нь бидэнд Хашимото Обучигаар, Обучи Козумигээр эсвэл Коль Шрөдэрээр, Шрөдэр Маркэлээр солигдож байгаагаас нэг их ялгаагүй болчихсон байгаа биз? 1999 оны 12-р сарын эхээр Монголын ерөнхийлөгч Хиргис, Недерланд улсад айлчлаад Чех, Польшийн ардчилалын 10 жилийн ойд оролцоод буцах замдаа Москвагаар дайрч өнгөрөв. Гэвч ямар ч албан ба албан бус айлчлалд тооцогдохгүй энэ дайралтаа дотоодын суртал нэвтрүүлэгт ашиглах зорилгоор ихээхэн ач холбогдол өгч Ельцинтэй уулзах уулзалтыг өөрийгөө томоохон дипломатич гэж харуулах үндсэн шалтаг гэж тооцжээ. Уулзах ч яахав, уулзаж. Монголын ерөнхийлөгчийн гарыг атгасан Ельцин тэс хөндлөн харан

–Иванов, иди сюда гэж дуудах нь тэр. Оросын ГЯЯ-ы сайд ойртон ирэв,

–Скажи, сколько у меня друзей?

–У вас пять гэж сайд өчлөө.

–Тогда шестой у меня нашелся, нет? гэж хэлээд пар пар хөхрөв.

Энэ нь шууд утгаараа “би зургаа дахь найзаа оллоо” гэсэн үг л дээ. Гэхдээ энэ бол үгийн тоглоом юм. Орос хэлэнд “шестой” гэдэг бол гар хөлийн үзүүрт зарагддаг бууны нохой гэсэнүг. Тэдний тоглодог уламжлалт хөзөрт зургаа хамгийн мууд тооцогдогоос энэ үг гарсан гэж хэл зүйчид үздэг юм билээ. Шоронгийн хэлээр бол бандидуулдаг жижиг гарын бага банди нарыг ч “шестерка” гэж дуудах нь бий.

Уул нь оросууд монгол хүнийг хагас дутуу хэмээн басамжланүзэх үзэл Зөвлөлт засгийн үед буй болсон шинэ ойлголт л доо. Олон зуун жилийн турш хятадууд ч, оросууд ч төр улсыг нь нэгтгэж хүчирхэгжүүлж өгсөн, жаахан бүдүүлэгдүү боловч эрэлхэг дайчин монголчуудыг хүндэлж, цаагуураа ихэд жийрхдэг байжээ. Арав салчихсан байсан Хятадыг XIII зуунд монголчууд нэгтгэж хүчирхэг Юань династийг буй болгожөгч байв. Хоорондоо учраа олохоо болиод биенээ хэмлэж байсан оросуудыг мөн зуунд монголчууд илдийн хүчээр нэгтгэн, Киевийн Орос хэмээх оройлогчийн эрх мэдлийг Москвагийн Орост шилжүүлж байв. Үүнд Новгородын ван Невийн Александрийг Бат хаан өргөж авч хүүгээ болгон өсгөжөндийлгөн

хүчирхэгжүүлсэн билээ. Монгол хаадтай Юань династийг түлхэн унагаж жинхэнэ хань үндэсний Мин династийг байгуулахад цэргийн жанжин нь монголын эрлийз хүн байсан байх юм. Чухам тэр нөхрийн удирдсан цэрэг Монголын гүн рүү халдаж Хархорумыг сүйтгэжээ. Догшин Иван хааны дараа Борис Годуновын үед Оросын төр хямарч дээд зэрэгтээ тулжээ.

Чухам энэ үед боярууд ярилцаад Оросын төрийг түр ч гэсэн төвштгөхийн тулд Чингисийн удмын хүн Семенийг хэсэг хугацаанд хаан ширээнд залж байсан байх юм. Монголчуудын байлдан дагуулж нэгтгэсэн Юань династийн их эзэмшлийг шууд өвлөн авсан учраас л үе үеийн хятадуудын бахархал болдог Мин династи олон жил амар тайван оршсон билээ. Догшин Иванаас эхлээд Оросын хаад монголчуудын үлдээсэний өвийг ээлж дараалан эзэлсээр дэлхийн хуурай газрын зургааны нэгийг захиргаандаа оруулж авсан билээ. Чухам энэ олон жилийн шургуу тэмцлийн явцад оросууд европ хүн байхаа больж азижсан, бүр тодотговол түрэгжиж, монголжсон билээ. Иймээс европчууд Оросыг өөрийн тооноос хасч азийнхан гэжүзэх болсон ба “Орос хүнийг сайтар маажвал цаанаас монгол хүн гараад ирнэ” гэсэн алдартай афоризм буй болжээ. Кравчук ерээд оны эхээр тусгаар Украина улсыг буй болгоход ч “Бид бол Киевийн Русь, Византийн шууд удам харин та нар бол монголжсон оросууд, бидэнд хамаагүй” гэсэн маргаан сонины хуудсаар байнга гардаг байлаа.

Оросын үе үеийн том сэхээтнүүд нь монголжсон, түрэгжсэнээ нуудаггүй харин ч бахархдаг байв. Оросын хамгийн их үндэснийүзэлт соён гийгүүлэгч Карамзинийг Харамжин хэмээх монгол угсаатнаас гаралтай гэдэг юм билээ, үнэн худлыг мэдэхгүй. Лавтайяа аугаа Лев Толстой “Цусанд чинь монгол хольц байхгүй юм бол чи ямар юмных нь орос хүн байх вэ дээ” гэж өгүүлсэн ба үнэхээр ч түүний жартгар нүд том шанаа нь үүнийг батлах мэт. Мин династи өөрийн гялалзсан үеэ элээж туйлдан хямарч эхлэхэд хятадуудын “умрын зэрлэгүүд” гэж тооцдог монголтой гарал үүсэл ойр манж нар Бээжинг эзлэн дахин хүчирхэг Хятадыг байгуулав. Манж нар Чингисийн хасбуу тамгыг өөрийн болгосныгоо Хятадыг эзлэн нэгтгэх эрх олсон гэж тайлбарлаж байв. Харин тэд дараа нь монголчуудыг мөн өөрийн харъяалалд булаан авсан юм. Гэхдээ үүнд 150 жилээ зарцуулсан юм шүү. Энх Амгалан хааны эхнэр нь Чингисийн алтан ургийн боржгон овгийн хүүхэн байсныг мэднэ биз дээ? Яг л энэ үед Романовын удмынхан Оросын хаан ширээг эзэгнэх боллоо. Чухам энэ үеэс оросууд Европ руу тэмүүлэх болов. Петр хаан Орос орныг өрнөдүүлж технологийн дээд эрэмбэд гаргах гэж яаж үйлээ үзсэн гэж санана? Екатерина хатан хаан Оросын империалист санаархлыг өрнө тийш нь тэлэх гэж хэрхэн чардайсн гэж санана? Романовынхан цусаа зөвхөн иргэншсэн өрнөд Европын “цэнхэр цусаар” сэлбэж байлаа. Гэвч Орос орон өрнөдөд басамжлагдсан, монгол түрэг хольцтой, Византийн уламжлалтай, үнэн алдарт шашинтай, хувьхүнийг юман чинээ боддоггүй, төрийн төлөө бүхнээ золиослодог, матюшка Россия-гийн төлөөх үзэл сурталд биенээ тоохгүй алчижчаддаг Азийн Орос хэвээрээ л хоцорсон юм даа.

Хүчирхэг Зөвлөлт династийг үндэслэгч Ульянов–Ленин мөн л дөрөвний нэг монгол цустай эр байлаа. Түүний нэр нь хүртэл монгол гаралтай, юу гэвэл слав овгийн хэлнүүдэд морьт цэргийг “улаан” гэдэг аж. Орчин үеийн улаан Хятадыг үндэслэгч Мао Зэ Дунг ч монгол гаралтай гэх юм билээ. Хунань мужид төрсөн Маогийн аав нь Юнань мужаас ирсэн том биетэй монгол хүн байсан гэнэ. Ерөөс Тогоонтөмөр хааны үед Юнаньд олон монголчууд үлдсэн юм. Өмнөт хятадынхан Дэн Сяопин шиг жижиг биетэй давжаа хүмүүс байдаг учраас өмнө зүгийн Мао тийм том биерхүү байдаг нь өөрийн эрхгүй нэгийг бодогдуулж, эл яриаг

бодитой байж магадгүй гэсэн сэжиг төрүүлнэ. Түүхийн давхцал л юм биз дээ.

Тавиад жилийн өмнө Чукоткын дарга гэдэг уран сайхны кино гарчээ. Тэр кинонд “однако” гэж ярьсан чукча үндэстнүүд гарна. Уг нь алив нэг үндэстнийг доош нь хийсэн кино биш харин ч магтсан соцреалист бүтээл байв. Гэтэл нийгэмд эсрэгээр тусч,

Чапаев киноноос болж тэнэг Чапаев, Петька, Анькагийн аман дүрүүссэн шиг чукча хэмээх тэнэгийн хэв шинжит дүр буй болжээ. Польш хэлэнд энэхүү тэнэгийн хэв шинжит дүрийг монгол юм уу орос гэсэн нэрээр илэрхийлдэг, харин Америкт тэнэгийн тухай онигоо “нэг польш эр байжээ...” гэж байгаад эхэлнэ. Норвегид шведийг, Филиппинд монголыг тэнэг болгож ярьна. Ийнхүү Зөвлөлт засгийн үеэс чукчагийн тухай ярьж хөхрөлдөх болсон ба үүндээ жартгар нүдтэй, хавтгай хамартай болгоныг хамааруулна. Гэхдээ эртний соёлт хятад, япон, солонгос үндэстэн энд хамаагүй. Харин монгол бол хамгийн түрүүн багтана. Ямар сайндаа Халимагийн ерөнхийлөгч Үлэмжинов “Би чукча, тэгээд яагаав?” хэмээн сэтгүүлчдэд ярдаглаж байх вэ. “Монголия не заграница, курица не птица” гэдэг зүйр үг ч их хэлдэг байлаа. Уг нь биологийн үүднээс үзэхэд тахиа бол яах аргагүй шувуу л даа. Зөвлөлт засгийн үед цоо шинээр буй болсон монголыг басамжилдаг энэхүү синдром ардчилсан Орос оронд бүрцагаандаа гарч, “гласность” болон, өөрийгөө хүндэтгэдэг, бусдад ухаантай гэж харагдах гэсэн Оросын сэхээтэн болгон Монгол руу уралдаж нулимаж болов. Үүнийг Жваницкий, Петросян нарын шог гараа, түүнийг үзэж сонсоод элгээ хөштөл инээж буй үзэгчдээс үргэлж ажиглаж болно. Тэд Монгол гэж тусгаар улс оршин тогтноод, бас ч үгүй ном уншдаг, бүр байчихаад төгрөг хэмээх үндэсний валюттай байгаа явдалд элгээ хөштөл инээнэ. Саяхан Петербургт нэгэн авилгач баригдсан ба гэрийг нь нэгжихэд фин марк, швед корон, америк доллар гарч ирсэн ба Оросын төв зурагтийн нэвтрүүлэгч “одоо энэ нөхрийн нуусан монгол төгрөгийг олох л үлдлээ” хэмээн цэцэрхэв. Уул нь сүүлийн арван жилд орос рублийн ханш монгол төгрөгнөөс их чүгүй бага ч үгүй мянга дахин илүү унасан юм л даа.

Хэдэн жилийн өмнө Москвагийн их сургуулийн багш нар, математикч Г.В.Носовский, А.Т.Фоменко нар Империя гэдэг шуугиантай ном хэвлүүлсэн ба одоо түүнийхээ үргэлжлэлийг бичин бөөн сенсаци үүсгэж байна. Монгол, Орос нь түүхийн хувьд байтугай цусны хувьд хоорондоо холилдоод хамаатан садан болчихсон үндэстнүүд. Гэтэл Зөвлөлт засгийн үеэс чукчад тооцогдох болсон монголчуудыг Оросын түүхээс хасч хаяхад уг номын зорилго оршжээ. Зохиогчид монгол гэсэн нэрийг “могл” гэсэн польш үгээр тайлбарлаж “чадамж” гэж орчуулжээ. Сянби улсыг өнөөгийн сербичүүд, Бат хааныг өргөмөл хүү Александр нь “батя” гэж дуудаж байснаас болж ийм нэртэй болсон гэх мэтчлэн бичсэн шинжлэх ухааны ямар ч үнэ цэнэгүй, түүхийн өчүүхэнч үнэнгүй энэ “бүтээлийг” шүүмжилнэ гэдэг хэт доошоо орсон хэрэг болох болов уу. Өнөөгийн монголчууд бол эртний хятадын малчид юм, харин дундаг зууны мөнөөх алдарт монголчууд бол Чингистэйгээ, Өгөөдэйтэйгээ цэвэр оросууд байлаа гэж хэлэхийн тулд бичигдсэн энэ ном дэлхийд оюун ухаанычадамжаараа гайхуулдаг оросын сэхээтнүүдэд биш, номхон хүлцэнгүй оросын тариачдад, одоо дахин үй олноороо буй болж буй адал балмад козак цэргүүдэд зориулсан үзэл суртлын дуудлага бололтой.

Монголчууд бид хамаатан садан оросын их ард түмний өмнө их өртэй. Хэзээ нэг цагт тэдний тарж бугарсан орныг монголчууд нэгтгэж өгч байсан бол, энэ зуунд оросуудын буянгаар бид

өрний иргэншилд орж, ертөнцийг таних болсон юм. Иргэншиж соёлжиж технологийн шинэ эрэмбэд гарсан өнөөгийн Монгол орон бол яах аргагүй Оросын ард түмний ач тус. Тиймээс ч өнөөгийн Монгол нь Оросыг Достоевскийтэй нь, Чайковскийтэй нь, Сталинтай нь хэл соёлтой нь, онигоотой нь сайн ойлгодог мэдэрдэг магадгүй ганц “заграница” нь байх. Оросыг ойлгодог ороо бид дэлхийд Израйльтай л өрсөлдөх болов уу.

Дэлхийн улс төрийн байдал тэс өөрчлөгдөж, богино хугацаанд шал өмнөө нөхцөл байдал буй боллоо. Зуун жилийн турш ганц тулгуурт гадаад бодлого баримталж байсан Монгол орон олон тулгуурт бодлоготой болов. Бид энэ хорвоогийн улс үндэстэн болгонтой найрамдаж сайн харилцаатай байхаар боллоо. Тэр дундаа хөрш Орос, Хятад, ойрын хөрш Солонгос, Казакстан, Япон, дэлхийн хүчирхэг орон Америк, хуучин сайн анд Герман, Зөвлөлт засгийн үед тэнд багтаж байсан шинэ тулгар орнууд, нэг системд хамаарч байсан Европ Азийн орнууд, алсын шинэ танил Дани, Люксэнбургтэй бүгдтэй нь сайн харилцаж, бүгдэд дээр нь тулгуурласан олон тулгуурт бодлого бол бидний шинэ мянганд баримтлах үндсэн баримжаа юм.

Саяхан Монголын ерөнхийлөгч Москвагаар дайраад Ельцинтэй уулзаад өнгөрснийг Орост хамгийн олон хэвлэгддэг алдартай сониний нэг болох Московский комсомолец тайлбарлан бичихдээ “Ельцин зөнөглөөд үргэлж многополярная политика (олон туйлт бодлого) гэж ярих болжээ. Түүний олон туйлынх нь нэг бололтой Монголын Ерөнхийлөгч гэх бас нэг “полярник Кремльд саяхан үзэгдээд өнгөрөв” гэсэн байна. Энд үгийн тоглоом бөөнөөрөө байна. Ельциний яриад байгаа олон туйл бол Америк дэлхийд ганцаараа тэргүүлэх болсон өнөөгийн бодит байдлыг үл зөвшөөрч Хятадтай хамтран бас нэг тэргүүлэх туйл буй болгох ёстой гэсэн санаа. Харин Московский комсомолецүүнийг нь мушгин туйлын хүн буюу чукча гэж доромжилж байгаа хэрэг.

Үнэндээ Монгол бол Ельциний хэлээд байгаа полюс нь ч биш Московский комсомолец –ийн тодорхойлоод байгаа полярник нь ч биш. Хэрэв Монголын Ерөнхийлөгч зөв ойлгоод зөв илэрхийлж чадсан бол манай бодлого олон тулгууртай л юм. Бид Оросыг Ельцинтэй нь, Хятадыг Зэнь Зяминтэй нь ойлгож байна. Хүйтэн дайны дараа энэ дэлхийг Америк дангаараа эзэгнэх болсон. Никсон, Бээжински нар үүнийг цаашид удаан тогтох ёстой төлөв байдал гэж улаан цагаангүй ил хэлдэг. Ийм нөхцлийг цөмийн хүчирхэг гүрэн Орос, Хятад хүлээн зөвшөөрнө гэдэг үнэхээр хүнд. Иймээс Ельцин Бээжинд Зэнь Зяминий хажууд хуруугаа занган байж “Ганц туйлт бодлогод энэ дэлхий дээр орших зай байхгүй” хэмээн сүр далайлган орилоход хятад найз нь толгой дохин инээмсгэлж байсныг бүрнээ ойлгож байна. Харин Монгол шиг жижиг улсад томчуудын орон зай булаацалдаж байгаа асуудал огтоос хамаагүй юм. Бид үүнийг дэмжлээ ч яалаа, эс дэмжлээ ч яалаа, биднээс хамаарч энэ асуудал шийдэгдэхгүй нь лавтай. Үүгээр бид хуучин найзаа орхиж буй хэрэг биш, дэв зиндаанаасаа хамаараад улс орнуудад оролцох ба үл оролцох асуудал гэж бий.

Орос орон 2000 оны босгон дээр Ерөнхийлөгчөө сольж байна. Оросын төр Годуновын үеийнх шиг хямарч байна. Харин иймүед нь монгол цус тус болж байсан нь нэг бус удаагийн үзэгдэл. Хагас монгол Шойгу одоогийн энэ хямралыг даван туулахад тус болох ч юм бил үү!

Браво Марфушка, Браво

Дэлхийн хамгийн ядуу улсын нэгэнд яах аргагүй Этиоп багтдаг. “Африкийн эвэр” гэгддэг тэр хавь ер нь най байхгүй дээ. Сомали, Жибутти, Эритрей, Судан, Этиопийн ядууг батлах гэж статистик руу ч өнгийх шаардлагагүй. Дээр нь ядуу хэвтэж дайн байлдаан тасрахгүй. Ядуу учраас ч тэгдэг ч юм бил үү! Турж үхэж байгаа том гэдэстэй хүүхдийн дүрс зурагтаар харуулаад байдаг чинь тэр хавийнхан шүү дээ. Дөнгөж цаашлаад л Африкийн шугуй руу орохоор амьдрал хамаагүй дээрдээд, тарган тарган харууд буу барьчихсан хувьсгал хийгээд нааж яваа. Харин Африкийн эвэр хавиар нэг хүнд оногдох ДНБ 100 хүрэхгүй ам. доллар болоод явчихна. Хаа очиж сайн тал нь цаг агаар дулаахан учраас манайхан шиг заавал 64 см ханатай байшин барьж халуун паар гүйлгэж, дөрвөн улирлын хувцас базаах хэрэггүй. Тус газраа самбаагаар халхалсан ч болно, гараараа тагласан ч болно, юутайч даарахгүй, баталгаатай. Өөрөөр хэлбэл, амьжиргааны өртөг манайхыг бодвол хамаагүй хямдхан.

Этиопоос манайд шөнийн цэнгээний газар ажиллахаар таван хүүхэн иржээ. Тус бүр сардаа өлхөн хоёр мянган ам.долларын орлого олно. Энэ бол юун Этиоп, юун Монгол, Америкт ч дажгүй цалинд тооцогдоно шүү дээ. Бодоход Африкийн эвэрт бүтэн тосгоноороо нийлээд ийм цалингийн хагасыг олдоггүй биз. Гэтэл нөгөө хүүхнүүд чинь цэлмэг хөх тэнгэртэй сайхан Монгол орныг минь голоод алга болчихож» Нутаг буцжээ. Даарсан гэнэ. Ийм аймаар хүйтэн газар хоёр мянган доллар сард олсноос нутгийнхаа элснээс царцаа түүгээд идэж явсан нь дээр гэнэ. Ингээд бид негргүй боллоо. Тэднийг нүцгэн хүүхнийг үзэж чаддаггүй, шалданчуудтай тэмцэх ажлыг амьдралынхаа философи болгоод яваа Нямдорж сайд хөөгөөгүй, учир нь тавуулаа биш дөрөв нь буцсан, нэг нь баатарлагаар тэсэн үлдээд орлогоо улам нэмэгдүүлсэн. Харин цааш аль зэрэг тэсэх, хаврын урь хүргэжчадах эсэхийг бүү мэд.

Миний эх орон сайхан. Наддаа л диваажин. Америкт таван мянган орлоготой голийж байснаас эндээ тарваганы ялбаг идээд, тэмээний бөх хүлхээд, борцтой шорвог цайгаа оочсон шиг байхад наддаа л хаваасаг. Би монгол хүн, бэлэнчлэх сэтгэлгээтэй, билэг танхай, биеэ угаадаггүй, бэлгэвч хэрэглэдэггүй, би монгол хүн, яадгийм! Заримдаа тавин хэм дөхдөг ч би өвөлд дуртай, хавар шороо шуураад жаахан тийм, гэхдээ л дажгүй. Гадаадад явахаар салхиүүгүлээд цээж давчдаад байдаг. Миний эх орон дэлхийн хамгийн өндөрлөг газрын нэг, иймээс агаар сийрэг учраас тэнгэр нь хөх харагддаг, одод тод үзэгддэг. Хүчилтөрөгчийн нэлээд дутагдалтай, энэ нь биеийн эрүүл мэнд, ялангуяа тархины үйл ажиллагаанд олигтой биш л дээ, гэхдээ би дасчихсан юм чинь. Чийгшил маш бага, хэт хуурай, энэ нь гоо сайханд төдий л тааламжтай биш гээд би одоо гоо сайхнаар юугаа ч хийх юм билээ! Элдэв төрлийн витамин болоод зарим элементүүд чухам тэрхүү хуурай, өндөр, хүйтэн халууны харшлаас болоод нилээд дутагдалтай байдаг л даа. Гэвч шинжлэх ухааны судалгаа үүнийг илрүүлсэн учир жишээ нь бид одоо иодтой давс хэрэглэх болсон шүү дээ. Би хөөсөн ч эх орноосоо явахгүй, энд төрсөн, эндээ үхнэ.

Гэвч бидний эх орноо хайрлах хайр маань бүх ертөнц Монголд шунаж шүлэнгэтэж байна гэсэн үг мөн үү? Чухам тэгж бэлчээрийнхээ хэрээр сэтгэсэн ойлголтдоо тулгуурлаад улс орноо таг хааж, ертөнцөөс тусгаарлах ёстой юу! Нэгэнтээ яруу найрагч Галсансүх “надад амьдрах долоон шалтгаан бий, нададүхэх долоон шалтгаан бий” гэдэг сайхан шүлэг уншиж

билээ. Тэгтэл саяхны “Зууны мэдээнд” ҮАБЗ-ийн ахлах референт Х.Доржпалам гэгч (энэ нөгөө Бат-Үүл Зоригийг хутгалж байхыг харсан үзмэрч байх даа, чааваас!) өгсөн ярилцлагадаа гадаадынхныг Монголд нэвтрүүлэхгүй долоон шалтгаантоочжээ. Хуурамч бичгээр үйлдвэрлэл явуулдаг, авгайтай нь гэр бүл болсон, охидыг нь садар самуунд татсан, тэгээд бас хүүхэдтэй болгоод хаясан, янхандах байртай байдаг, дээрээс нь халдвартөвчин өгчихсөн, тэгээд гэрт нь хоргодоод байдаг гэнэ. Үстэй толгойгоо зулгаах ийм долоон шалтгаантай тэрээр хонзонгоо авахын тулд Багабанди, Нямдорж хоёртой нийлж байгаад гадаадынхныг алж өгөх сайхан хууль санаачилсан ба үүнийг УИХ удахгүй хэлэлцэх юм байна. Ярилцлага шууд ингэж л ойлгогдож байна. Хоёргүй нэг утгаар шүү!

Уул нь зүгээр л юм. Лос Анжелесын америк Монголд тусламж үзүүлэхийн тулд виз авахаар ертөнцийг талыг туулан Вашингтон орох ба тэндээсээ эргээд манай хөх тэнгэрийн орон руу тэмүүлнэ. Өмнөд Африкийн бизнесмэн эхлээд Лондон орж байж Монголд даарах эрхээ олж авна. Өөрөөр хэлбэл хил дээрээс визээ авдаг журам дөрвөн жилийн өмнө буй болгосон нь “Ардчилсан эвсэл” гэгчийн шаарнуудын Монголыг сөнөөх гэсэн далдуур муухай бодлого байсан нь ингэж илэрлээ. Орж ирсэн хүн сараас дээш хугацаагаар байх бол бүртгүүлдэг байсан журам ч далдын муухай бодлоос үүдэлтэй нь баригдчихжээ. Одоо гадаадын хүн орж ирүүтээ л цагдаагийн газрыг хайгаад пижигнэх болно. Ногоон нэхсэн сайхан гарууд угтана даа. Нэг л үгэндээ “гадаадынхан та нар ороод ороод ир, ороод ир, ороод ирэхээр чинь бид алаад өгье” гэдэг сайхан хуультай болж байгаа юм байна.

Үүгээр зогсохгүй монгол хүн гадаадад хамаагүй явах нь хайран сайхан жинхэнэ монгол генээ гамгүй тараах нөхцөлийгүүсгэдэг учраас бас бодолцож байгаа юм байна. Жасрайгийн үед гадаадад явах гэвэл Цагдаагийн газар очиж оочерлон мөнгөө хураалгаад шар хуудас авч байж богоонд суух эрх олддог байлаа шүү дээ, тэр сайхан цаг эргэж ирж байна. Тэр шар хуудас бол эх орны итгэл найдвар ба түүнийг өвөртөлчихөөр удмын ховордсон сангаа яс харамлах сэтгэгдэл төрөн, санаадгүй гоожсоныг нь гялгар уутанд савлаад эргүүлээд оруулж ирэх учиртай юм гэнэ. Жасрайн үед хөөцөлдсөөр байгаад Орос болон Зүүн Европынорнуудтай визтэй болж нэг санаа амарч билээ. Одоо манай Гадаад яамныхан дэлхийн бүх улстай зөвхөн визээр харилцах талаар санаа зовон хөөцөлдөж байгаа. Мөн гадаадад гарчихаад эргэж ирэхгүй байгаа хүмүүсийн зориуд мөнгө төгрөг гарган групп явуулж гавлан авчрах ажиллагаа хэдийнээ эхэлсэн.

Үйлдлийг Швейцариас эхэлж байгаа ба энэ нь хүний эрх зэрх гэж хамгийн их донгосдог тэднийг юун түүрүүн хохироох гэж байгаа юм. Солонгос руу хуурамч визээр гарч байгаа явдалд тэдний хилийнхэн биш манай Гадаад харилцааныхан илүүтэй санаа зовж байна. Тэр байтугай “Зүүн хойд Азийн орнуудтай харилцаж байгаа хүмүүсийн харилцааг таслан зогсоох нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүн зорилго” гэж сайд нь тоглоом наргиангүйгээр шулуухан мэдэгджээ.

Гадаадын хөрөнгө оруулалтад хөнгөлөлт үзүүлдэг бусармаг явдлыг сая УИХ таслан зогсоолоо. Орж ирснүүд нь татварыг Сингапурт байснаас дөрөв дахин, Хонконгт байснаас хоёр дахин их төлнө. Тийм сүрхий юм бол Сингапуртаа очиж үйлдвэрээ барихгүй юу! Хөв хөх тэнгэрийг 45 хэмийн хүйтэнд харж зогсоно гэдэг дурын дуракт олддог хувь заяа биш! Гаалийн татварыг тэглэсэн “Ардчилсан холбоо” эвслийн бодлого бол энэ эх орныг устган

сөнөөх гэсэн далдын хар бодлого. Хураалгаад бай, хураалгаад бай, заавал танай юмыг авч байх алба бидэнд байхгүй, дургүй бол боль!

XX зуун бол миграцийн их эрин. Энд цаг уурын таатай нөхцөл рүү миграци хийхээс гадна, эдийн засгийн боломжтой газар руу шилжих хөдөлгөөн бүр их давамгайлах болжээ. Сонирхолтой нь миграци болгоны шахуу эцсийн цэг нь Америк. АНУ-д 1820 - 2000 онд 70 сая орчим хүн цагаачлан очсон байна. Одоо маш их хориг саад тавьдаг боловч жилд саяас доошгүй хүн далайн чанад дахь диваажинд үүрд амьдрахаар очиж байна.

Үүний дараах том миграцийн төв бол баруун Европ. Үүнээс гадна бүс нутгийн миграцийн олон төв бий. Тухайлбал Төв Америкт Венесуэль, Өмнөд Америкт Аргентин, Чили, Төв Африкт Нигериа гэх мэт. Энэ нь эдгээр орнуудад бусдыгаа бодвол эдийнзасгийн илүү боломжтой гэсэн үг юм. Эдийн засгаас гадна цаг агаар бас их том шалтгаан болно. Ухаан нь Аляскад татварыг тэглэсэн байдаг боловч АНУ-ын энэ муж руу шилжин суух хөдөлгөөн бараг ажиглагддаггүй гэнэ. Эсвэл Австралийн өмнөд муж руу хүн болгон хошууран дайрах мөртөө Төв Австралийн цөл рүү гуйгаад хэн ч явахгүй. Сибирь олон зуун жилийн турш хүний сонирхол татдаггүй байсан тул дэлхийн хамгийн баялагтай энэ газар ердөө л улс төрийн цөллөг, гулаг шорон байрлуулах цэг төдийгөөр ашиглагдаж иржээ. Хятадын Сичуань мужид 100 гаруй сая хүн суудаг, гэтэл Шинжаанд ам км-т нэг, Өвөр

Монголд гурван хүн ноогддог нь цаг ууртай холбоотой. Төвдийн 5000 метрийн өндөрлөгт түр томилолттой хүмүүс л жилээр явж ээлжээ хүлээн хэвтдэг аж. Өөрөөр хэлбэл Австрали, Аляск, Хойд Канад, Сибирь, Шинжаан, Арабын хойг, Монгол зэрэг газар ам км-т ганц хоёрхон хүн амьдарч байхад Холланд, Япон, Өмнөд Солонгос, Хонгконг, Сичуаньд бараг мянга шахам хүн ногддог нь багтаамж гэдэг маш харьцангуй ойлголт байдаг ба үүнд цаг уур, эдийн засгийн хөгжил зэрэг олон бодит зүйл, мөн соёл заншил, хүмүүсийн харилцаа зэрэг бусад субъектив хүчин зүйл нөлөөлдгийг харуулж байна.

Хүн ам сийрэг байна гэдэг нь зах зээл тун бага байна гэсэн үг ба үүнээ дагаад амьжиргааны өртөг өндөр байдаг ба мөн эдийн засгийн чадавх дорой байдаг. Чухам энэ сул талаа багасгах зорилгоор хууль эрхийн болоод эдийн засаг улс төрийн хөнгөлөлт бий болгодог юм байна. Хүүхнээр бол царайлагийг нь ч яахав эрчүүд булаацалдаад завсарт нь үрэгдчихгүй л бол амьдрал нь под хийгээд явчихна. Харин царай муутай нь яадаг билээ? Үгүйдээ л будаж шунхдаад амьтны анхаарал татахыг бодно биз дээ. Гэтэл харин ч урдаас нь араа шүдээ хурцлан хаврын тэнгэр шиг ааш гаргаад байвал...

Манай цаг агаар, бидний ааш араншинг тоолгүй сууж байгаадхэдэн цаас салгаад явчиж чадах хүмүүс бол Хойд Хятад, Баруун Сибирийн тосгоны голдуу ядуу зүдүү хүмүүс л байдаг юм. Түүхийн турш тийм байсан. Жаахан баяжаад ирэхээрээ хятад нь Сан Франциског, орос нь Парисыг мөрөөдөөд эхэлдэг юм. Дандаал тийм байсан. Цаашид ч тийм байх болно.

Мөнөөх шөнийн бааранд тосгоны хэдэн орос хүүхэн шүдээ зуугаад үлдсэн байна билээ. Бид ч яахав одоохондоо нутгаа Амстердам болчихсон мэт сэтгэн чанга чанга шүгэлдэн “Браво Марфушка, браво” гэж л байна. Тэд ч бас хэдэн цаастай болж авуугаа Парис, хөлдүү Улаанбаатар хоёрын аль нь дээрийг заалгалтгүй мэднэ.

Зууны сүүлчийн золиос

Зуун дууслаа. Давхцаад мянган ч дуусч байна. Хүн төрөлхтөн хөгжлийнхөө гурав дахь мянган руу орлоо ч гэж ярьж байна. Зуун өнгөрсөн жил дууссан, дуусаагүй ч гэж маргаж байна. Тэгж яривал Есүс Христийн төрсөн оныг дөрвөөр алдсан байдаг тул шинэ зуун дөрвөн жилийн өмнө эхэлсэн ч гэж маргаж болно. Тооллыг заавал Христийн төрсөн оноор авдаг нь буруу, Шүмэрийн иргэншлээс тоолбол зургаан мянга гараад явчихна гэж маргасан ч болно. Чухам үүн дээрээ тулбал эцэс төгсгөлгүй юм болох ба тухайлбал 1912 оноос тоолол эхлүүлчихээд яваа Хойд Солонгос ч бас өөрийн гэсэн тайлбартай. Чухам энэ ХХ зуунд хүн төрөлхтөн бид нийтлэг нэг иргэншилтэй болжээ. Дундад зууны үед Европт эхэлсэн энэ иргэншил өнөөгийн хоёр зууны давхцал дээр амьдарч буй манай гаригийн зургаан тэрбум хүний дундын өмч юм. Өнөөгийн бидний ердийн гэж үзэж байгаа Христийн он, Григорийн тоолол, латин үсэг, араб тоо, 51 систем, хөгжмийн ноот зэрэг нь ердөө зуухан жилийн өмнөзөвхөн Европ, Америкийн жишиг байлаа.

Бөмбөрцгийг тэр чигээр нь оролцуулсан дайн, дэлхийг хамарсан үзэл суртал, хорвоог эзэлсэн эдийн засгийн хямрал зэрэг даяарчлагдсан үзэгдэл зөвхөн энэ зууны л бүтээл. Зууны төгсгөлөөр манай гариг глобальчлагдаж эхэлсэн ба мэдээллийн хувьд нэг сүлжээнд хамрагдан, хүн төрөлхтөн нэг гэрт ороод ирлээ. Орон зайн утга алдагдаж эхэлж байна гэсэн үг шүү дээ. Ирэх зуун маань бүр ч сайхан болно. Эртний Герегийн Аркадиа буцаж ирнэ. Коммунизмын тухай хүүхэд насны маань мөрөөдөл технологийн дэвшил гэсэн утгаараа эргэж ирнэ. Би ХХ зууны хүн, ХХI зууны иргэн, глобальчлагдсан ертөнцийн гишүүн, хүн төрөлхтөнтэй хөл нийлүүлсэн хөгжингүй Монгол орны ухамсартай эх оронч, технологийн дэвшлийн шинэ утгад гарсан өрх гэрийн тэргүүн, нийгмийн их урсгалыг даган улам сайн сайхан руу тэмүүлэгч эд эс, хүн төрөлхтний үнэт зүйлийг өвлөгч, өөрөө цааш нь дараа үедээ дамжуулагч!

ХХ зуун бол туршилтын их эрин байлаа. Эртний Герег, Ром, Хятад, Энэтхэг, Дахин сэргэлтийн үе, Үйлдвэржилтийн их эрин, Соён гийгүүлэх зуунд технологи, хүмүүнлэгийн их туршилт тавьж байсан бол энэ зуун нийгмийн инженер зүйн эмгэнэлт туршилтаар дүүрэн байлаа. Гэхдээ энд манай зуун технологи шинжлэх ухааны хамгийн үсрэнгүй үе байсныг үгүйсгэж буй хэрэг биш. Атомыг задалж, харьцангуйн онол нээж, ДНХ-ийн бүтцийг тодорхойлж, сансарт нисч, саран дээр бууж, Доли хонь гаргаж, удамшлыг жолоодож, мэдээллийг глобальчилсныхаа хувьд энэ зуун хүн төрөлхтний амьдралын төвшин байтугай амьдрах утга учирт ч аугаа өөрчлөлт хийсэн. Мөнөөх эмгэнэлт туршилтын хувьд сайн (гашуун) сургамж өгснөөрөө эерэг байж болох юм. Энэ зуун галзуурч улайрсан колоничлолоор эхэлсэн. Адам Смит Үндэстний баялаг-аа туурвиснаас хойших 100 гаруй жилийн дараагийн хүмүүс меркантилч үзэл бодлоос салж чадахгүй л байсан нь тэр. Дараа нь хүн төрөлхтний жамаараа явсан бүхий л нийгэм, эдийн засаг, үзэл суртлын түүхэн хөгжлийн диалектикийн эсрэг ХХ зуунд буй болсон марксист онол амьдралд биеллээ олох гэж тэмүүлэхийнхээ хэрээр дэлхийг маань хөмрөхтэй шахлаа. Үүнтэй зэрэгцээд дээд арьстны тухай фашист, нацист онолууд хүн төрөлхтөндүхэл тулгав. Үүний дараа улс орнуудад, бүс нутгуудад салан тусгаарлах, бүхнийг шинээр эхлүүлэх, хөгжлийн диалектикийн мөн чанарын эсрэг хандсан үй олон арцалдаан тэмцэлдээн гарч бүхий л дэлхийгээрээ хувьсгалын өвчинд

идэгдлээ. Эдгээрийн золиос ямар аймшигтай гэж санана. Нэг зуун хорин сая хүн энэ зууны 130 дайнд үрэгдсэн нь 1900 оноос өмнөх хүн төрөлхтний бүх дайнд алагдсан хүнээс хамаагүй их болж байна. Нэг талаасаа технологийн хамгийн дэвшилт зуун маань нөгөө талаасаа хамгийн цуст зуун ажгуу.

Монгол орон зууныхаа толины тусгал байлаа. Дундад зууны хоцрогдолтой, ертөнцөд бараг мартагдчихаад байсан бидэрнийн иргэншлийн салшгүй нэг хэсэг болж, технологийн асарөндөр эрэмбэд гарчээ. Ялангуяа жараад оноос хойш иргэншиж, соёлжиж, хотожсон бидний монголчуудын үе болгон өмнөхүеэсээ тэнгэр газар шиг ялгаатай дээд төвшинд амьдрах боллоо. Хооллох, байрших, үржих хэмээх хүний адгууслаг байгалилаг хэрэгцээ маань улам бүр энгийн болох хэрээр хүмүүнлэг бурханлаг хэрэгцээ улам өсч, технологийн дэвшил биднийг улам итгэлтэй сайхан ирээдүй рүү чиглүүлэн авч яваа юм. Гэвч бидөнөөгийн энэ өндөрлөгт гурван хувьсгал, гурван янзын нийгмийн байгуулал, гуч дөчин мянган хүний амь нас, мянга мянган хүний эмгэнэлт амьдрал, аз хийморь, алдаа эндэгдлээр дамжин хүрсэн билээ.

Өнгөрч буй энэ зууны нэг томоохон золиос бол сэтгэлгээний хоцрогдол, сэтгэлгээний төөрөгдөл юм. Зөвлөлтийн аугаа ихөөрчлөн байгуулагч, хуульч, эдийн засагч Михайл Горбачевын тухай Америкийн Ерөнхийлөгч асан талийгч Ричард Никсонөгүүлэхдээ “Энэ их өөрчлөгч шинэчлэгч хүн хүний түүхэнд буй болсон ховорхон хүнд хатуу, их хүрээ талбай эзэлсэн дэглэмийгөөрчлөх гэж зүтгэснээрээ хүн төрөлхтний өмнө түүхэн гавьяа байгууллаа. Гэхдээ энэ хүний эдийн засгийн мэдлэг нь Америкийн коллежийн дундаж нэгэн сурагчийн хуримтлуулсан мэдлэгийн арван хувьтай л тэнцэх юм. Тэгээд бас тэр арван хувь нь буруу гээч” гэжээ. Анхаар, төлөвлөгөөний комиссын П.Жасрайн тухай биш бүр суут М.Горбачевын талаарх дүгнэлт шүү!? Хүний түүхэнд мундахгүй олон суутан бэлэглэсэн, физик, хими, математик зэрэг суурь шинжлэх ухааны хөгжилтөөр Америктай өрсөлдөхүйц тэр аугаа ард түмний гэр орноо авья явах, хоорондоо зохицох хүний энгийн үйлдэл дээр сэтгэлгээний хувьд орчин үеэсээ аль зэрэг хол хоцорсныг Никсон тун товчхон ингэж өгүүлжээ. Яагаад Зүүн Европын орнуудын Ерөнхийлөгчийн сонгуульд Хойд Америкт гарсан цагаачид нь амжилттай өрсөлдөж, Балтид бол бүр Канадаас ирүүтээ л Ерөнхийлөгч болж, Киргизэд америк хүүхэн Сангийн сайд хийж,

Кавказын орнуудын НҮБ-д суух төлөөлөгчид нь эх хэлээ мартсан авч тэдний гарал үүсэл нэгт Америк, Европын паспортнууд байна? Хэдэн үе дамжин нийгмийн инженер зүйн туршилтад орж сэтгэлгээний гүн хоцрогдолд орсон тэр талбай дээр ердийн нэг дундаж америк, европ, япон хүн ирэхэд л нийгмээ аваад явах төвшинд хэлцэгдэж байна гэсэн үг. Сэтгэлгээний хоцрогдлын энэхүү хам шинж нь хүнтэйгээ хамт дуусна уу гэхээс тархиных нь нэг салшгүй эд эс шиг болчихсон тэрхүү итгэл үнэмшил нь засарч өөрчлөгддөггүй юм байна гэдэг нь өнгөрсөн арван жилийн бидний болоод шилжилт хийж буй дөч гаруй орны ард түмний бас л нэг гашуувгар сургамж дээр тодхон харагдаж байна.

Зууны эцсийн жил Монголд төрийн сонгууль боллоо. Гэхдээ ингэж л таарсан болохоос энэ бол өрнөдийнхөн шоолон бичиж байгаачлан Монголын ард түмэн XXI зуунд социализм коммунизмаа цогцлон байгуулахаар итгэл төгс байгаагаар илэрхийлсэн дүн гэж итгэхгүй байхыг хүсч байна. Хэдхэн сарын дараа хууртагдсан тухай ярьж буруутныг хайх их эрэл

хайгуулд гарч байна. Гэвч бодохул энэ нь сэтгэлгээний хоцрогдлын гадаад илрэл байсан болов уу. Харин дал наяд оны сонины албан мэдээний баатрууд-коммунистууд маань сонгуулийн үр дүнг мөнөөх л сэтгэлгээний хоцрогдлоороо хүлээж авах шиг боллоо. Эргэж ирсэн тэд социализм байгуулах их үйл дотор гарсан будлиант дөрвөн жилийн гажгийг хүн цочтол ярьж, эргэж засан хуучин дардан зам дээрээ баттай зогсох тухай улиглах боллоо. Баян-Өлгийн сая сонгогдсон дарга нь “Хууль ёс манай аймагт эргэж ирлээ” хэмээн тунхаглаж байх юм. Иймэрхүү үгийг иргэншсэн орны жижиг түшмэл сонгуулийн дараа хэлж болох уу, эсвэл Толбо нуурын тулалдаанд ялсан улаан комиссарынүг үү? Хийж сурсан хувьсгал, иргэншсэн соёлт орны сонгууль хоёрын хооронд ямар ялгаа байдгийг мэдэхгүй байна гэдэг маань л өөрөө сэтгэлгээний хоцрогдол л доо. Тэр хүн аймгийнхныгаа архи битгий уу, ажил төрлөө сайн хий хэмээн өвлийн өвгөн шиг сургаал айлдаад энэ үүргийг гүйцэтгэх 45 хоногийн аян зохиож байх юм. Угаасаа архи уудаггүй Өлгийнхнийг улам битгий уу гэдэг нь буруу ч юм биш л дээ, харин ингээд өдөр, сар, жилийгүелж мөчлөөд лоозонт аян зохиогоод явбал манай ард түмэн хоолоо хаанаас олж идэх болж байна? Бусад аймаг, хот, дүүргүүд энэ жишээг дагана гэж бодохоос хүйтэн хөлс бурзайх шиг боллоо. Дархан ийм аянаа өнөөдөр эхлүүлж байна. 1985 онд тэнд халамцуу хүнийг гудамжинд шившиглэдэг аян гарсан ба түүнээс хойш Дарханчууд бүр их архи уух болж билээ.

Сангийн сайд саяхан арван хоёрдугаар сарын 5-нд зурагтаар “Гадуур дураараа хамаагүй үнэ нэмээд байна, иймээс урьд байсанүнийн зөвшлийн комиссыг сэргээнэ хэмээн тоглосон шинжгүйёс төртэйгөөр мэдэгдлээ. “Критика буржуазных экономических теорий” гэдэг хичээл уншин цээжлээд онц авч явсан хичээнгүй оюутны үг ч мөн л дөө. Гадаад хэргийн сайд нь “Сүүлийн арван жил Монголын гадаад бодлого сөнөсөн байна” гэж дүгнээд юун хууль журам байхав. Дүгэрсүрэн сайдаас хойш тус яаманд орж ирж ажиллаж буй бүх хүнийг өөрийнхөө мэдлэгийн төвшингөөр атестатчилж байх юм. Японы милитаристуудыг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд яавч оруулахгүй хэмээн тэрхүү хүндэт индэр дээр системээ эрэлхгээр хамгаалж явсан үзэл суртлын зарцын араншин ч мөн л дөө. Хаа сайгүй сүүлийн хэдэн жил ажилд орсон хүмүүсийг хоморголох, агнах явдал манай орны ХХ зууны сүүлчийн хагас жилд хийсэн үндсэн, гол, ганц ажил байлаа. Цагааныг нийгмээс шахан зайлуулдаг улааны ганц арга л даа.

“Мянганы зам” хэмээх наргиантай суртал нэвтрүүлгийг харин хүмүүс овоо тогтоочих шиг боллоо. Гарсан эх сурвалж нь нэг түшмэл арван жилийн өмнө газрын зураг харж сууснаа хөндлөнгөөр нь улаан балаар нэвт зураас татсан гэнээ. Ердөө л тэр. Далан хоёр онд Монголыг 2000 он хуртэл хөгжүүлэх хэтийн төлөвт Дорнод-Ховдыг холбох замын мастер план байсан л даа. Сүүлд нь наян хэдэн оны 2020 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөөнд ч өөрчлөгдөөгүй учир зам зүүн тийшээ бараг Багануур, баруун тийшээ бараг Солонготын даваа хүрч яваа. Ер нь энэ замын мастер план байгаагаас хэдэн төгрөгийн хөрөнгө оруулалтаар яг таг яаж хийх төсөл нь байхгүй. Хөрөнгө хаанаас босгох аргачлал нь байхгүй, жил жилийн улсын төсвөөс тав гурвыг илүүчлэн аргалж байгаа л даа. Зүгээр л нэг мөрөөдөхийнхувьд бол буурьтай суурьтай улстөрч биш, цэцэрлэг, сургуулийн хүүхдүүдээр “улс орныг цахилгаан сүлжээгээр аалзны тор мэт доторлох мянганы шонгийн мод” гэх мэтийн юм хэлүүлж араас нь өхөөрдөж болно.

ХХI зууны өндөрлөгөөс харахул (тэр нь хэдхэн хоногийн дараа болно) өрөвдмөөр, шоолмоор, хөгжилтэй наргиантай юм ч их л байна л даа. Юу хийхээ мэдэхгүй, хийх ажилгүй сууж

байсан Засгийн газар маань зуд болохоор хариннэг ажил төрөлтэй болж магнай тэнийх шив дээ. Сансрын нисгэгч Гүррагчаа нэг айлын өвөлжөөнд давхиад буужээ. Бодвол ингэвэл тусламж өгнө гэсэн бололтой юм, малчин өвгөн ярьж байна, Үндсэн хуулийн хямралаас болоод бог голдуу арваад мал үхчихлээ, одоо цэц буруу шийдвэр гаргаад тэрийг нь Гончигдорж, Амаржаргал нар дэмжвэл ч хот маань харлана гэж муу ёрлож байна. Сурвалжлага хийж байгаа гэх хоёр гурвын зэрэг үзэл суртлын боолчууд их л ойлгож байгаа бололтой толгой дохицгоон, түүнээ ичих ч үгүй зурагтаар мэдээ болгон харуулж байх юм. Коммунизмыг ажил хийж биш суртал нэвтрүүлэг хүчтэй явуулж байж босгодог юм. Худлаа гэвэл зурагтаа асаагаад үз. Цэнзүүрийг нь МАХН-ын төв байранд өдөр бүр хийдэг ба үүгээр цалингаа авч байгаа нэлээд хүмүүс тэнд туйлын ажил хэрэгч царай гарган сонор сэрэмж алдчихвий гэх, нөгөө талаас сонор алдсан нэгнийгээ саарал ордон руу уралдан матацгааж байгаа. Үүнийг би ийм л байж таарна гэж таамаглаж бичээгүй, үнэхээр ингэж байгаад нь оролцоод хүн нэрээ гутаасандаа зовж яваа хүнээс сонссон юм. Уралдаж хийгээдөрсөж мэдээл гэсэн лоозон дээр үед их байдаг байж билээ. Уралдаж хашгираад, өрсөж мат гэсэн үг л дээ.

Сонгуулийн дараа манай коммунистууд дайралдсан хүнээ сөрөг хүчин гэж хараах боллоо. Гэвч үнэндээ тэд өөрсдөө ирэх цагийн их урсгалын сөрөг хүчин юм. XXI зууны хөгжил дэвшлийн сөрөг хүчин. Ирж яваа цагийн гайхамшигт өнгөнийөөдөөс харуулсан сөрөг хүчин. Мэс заслаар ч эдгэхгүй болсон сэтгэлгээний хоцрогдлоороо Монгол орны ирээдүйтэй харгалдсан сөрөг хүчин. Цагийн даажин, түүхийн золиос. Ирээдүйгүй болсонүзэл суртал сүүлчийн амьсгалаараа амьсгалж байна.

Коммунист үзэл суртал өөрийн золиосоо дуусгаагүй бололтой. Саяхи сонгуулийн дараа манай шинэ үеийн мэдлэгтэй, өрнийн боловсролтой, зах зээлийн хүмүүжилтэй, чухам л энэ орны ирээдүй болсон сайхан залуучуудын нэлээд нь хэсэг нь дэврүүн сэтгэлдээ хөтлөгдөж, зарим нь хууртагдаж, зарим нь бага сага албан тушаалд сэтгэл алдарч коммунистуудтай нийллээ. Тэтгэврийн насанд дөхөж яваа П.Очирбаттай зөрөөд улаан коммунист болж байхыг бодвол сэтгэлгээ, нас хоёр тусдаа ойлголт бололтой юм. Чухам энэ залуус л зууны сүүлчийн золиос болох шиг болов. Олсон мэдлэг боловсролдоо тулгуурлан эх орондоо тус болно гэсэн эдний гэнэн бодол нь үзэл суртлын их машины золиос болон тоосрон замхарч байгааг харахад үнэхээр өрөвдөм. Японд хичнээн жил сурсан Гэрэлт-Од гээд сэтгэлгээ сайтай залуу байна. Одоо тэр Ерөнхий сайдын эдийн засгийн зөвлөх хийж байгаа. Гэрэл, дулааны үнийг огцом өсгөхөөр юун түрүүн улсын мэдлийн сургууль, цэцэрлэг балардаг ба үүнийг нөхөн төлөх мөнгө байхгүй гэдгийг тэр сайн мэдэж байгаа.

Үүний дараа цалинг нэмэхээс өөр аргагүй болно гэдгийг ухаарч байгаа. Ингэсэн тохиолдолд зөвхөн инфляци л Засгийн газрыг аврах ганц эм болно. Инфляци хийгээд өгөхөөр сүүлийн дөрвөн жилээс баригдах болсон барилга, хөрөнгө оруулалт, тэр дундаа “мянганы зам” будаа гэдгийг тэр сайн ойлгож байгаа. Ингэ гэж тэр зөвлөөгүй нь мэдээж. Тэгээд ч гэрлийн үнэ нэмэгдэх, Гэрэлт- Од нэртэй хүн хоёр хоорондоо тийм ч холбоотой юм биш л дээ. Харин хүмүүс энэ соёлтой боловсролтой залууг их л хачирхан харах болно доо.

Батболд гээд сайхан залуу байлаа. Сүүлийн арван жил бизнес хийсэн энэ хүн Монгол орон гадаад харилцаагүйгээр хаашаа ч явахгүй гэдгийг мэдэхийн цаагуур мэднэ. Виз миз хүндрүүлээд л, гадаадад суугаа улсаа гавлаж авчраад л, зарлиг гараагүй байхад элчингүүдээ

гэмт хэрэгтэн шиг дуудаад л, өнгөрсөн арван жил Монголтой хамтарч ажилласан болгоныг империализмын нохой гэж хараагаад л байх нь энэ улсын наанадаж нэр сүр, цаанадаж санхүү эдийн засагт их муу гэдгийг ойлгож л таараа. Энэ нөхөр чинь гайгүй юм шиг байсан ямар хөгийн юм хийгээдунаваа гэж хүмүүс Батболдын тухай л бодох болно. Оросын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр суугаа оронд буй элчин сайд нь дагалддаг протоколтой атал сайд нь хүчин төгөлдөр элчинг биш харин яаманд ажилладаг төрсөн дүүгээ дуудсаны төлөө Батболд хүнд муу хэлүүлнэ гэдэг шударга бус хэрэг л дээ. Америкт боловсрол олсон Мөнх-Оргилыг сонин хаагаад гүйгээд байдаг марзан нөхөр вэ гэж танилууд нь бодох болохоос цаана нь түүнээс үл хамаарсан үзэл суртлын машин сүрэг байна гэдгийг хэн ч ойлгохгүй өнгөрнө. Манайд зуд болоод, Үндсэн хуулиараа хамгаалдаг үхэр, хоньд маань үхээд байна задгай мөнгө ч голохгүй авна шүү гээд л элчин сайд нарын хаалга тогшин шараа түлээ хийгээд яваа хэдэн хуучуудынхаа өмнөөс Тэрбишдагва нүүр улайж л байгаа байх даа. ОУВС тавьдаг шаардлагаа тавьчихаад байхад мөнгөгүй гэх мөртөө парламентын хамаг дарга нар нь бүлэг болж аваад төлөөлөгчийн араас дараагийнх рейсээр Вашингтон хүртэл нэгдүгээр зэргийн суудалд залран хөдөөний монгол аялгаар “Дэнги дэнги” гээд гэгчхээд эргээд л дэлгүүр рүү яаран гүйлдэх нь өнөөгийн өртөнцийг ойлгодог Чулуунбатын хувьд хүнд л байгаа л даа. Манай оронд орж ирж буй хөрөнгө оруулалтаар нэгдүгээрт тасархай яваа газрын тосны асуудлыг Парламентын дарга шахсаар байгаад, авахаас дажгүй монгол хэлтэй, хөлх цөлх хөдөөний дүүгээрээ хариуцуулуулчихаар сайд Ганзоригийн дотор муухай л болж байгаа байх. Муу ч гэсэн Австралид хэдэн жил болчихсон хүн шүү дээ. Эдний хэн нь ч нийгмийн салбарт эхлүүлсэн хувьчлалыг зогсоож, менежментийн хувьчлалаар биеэ даан босч ирж буй ганц хоёр эмнэлгүүдийг эргүүлж хураан “улсын орлого” болгож байгааг таашаагагүй нь мэдээж. Татвар нэмж, гааль чангатгаснаар улс баяжихгүй харин ч авилга цэцэглэнэ гэдгийг ойлгохуйц боловсролтой хүмүүс. Үндсэн хөрөнгө гэдэг бол газартайгаа уялдсан зүйл ба газрын асуудлаа шийдээгүй манайд ийм ойлголт байхгүй гэдгийг мэдэцгээнэ. Газрын асуудлаа шийдээгүй үндсэн хөрөнгийн татвар нь үндсэн хөрөнгийн үнийг зохиомлоор унагах ба тэр нь зах зээлд эргэлдэж буй мөнгөн дүнг доош чирнэ гэдгийг ч сайн мэднэ. Чухам ийм болохоор одоо айл хунараархэсэн зурагтынх нь дугаарыг бүртгээд яваа татварынхны өмнөөс эдгээр боловсролтой залуус ичих нь аргагүй хэрэг юм. “Эрдэнэт” концернийг хууль журамгүй хувьдаа авчихаад түүнийг нь хэлсэн сэтгүүлчтэй “намайг авсан гэж гүжирдэж байна” гэж заргалдахын оронд “авсан. тэгээд яачихаав!” гэж заргалдан шүүх, прокурор, цагдаагаа худалдаад авчихсан “зууны манлай...” өнөө хэнийг энэ хэдэн залуучууд уг нь дотроо буруутгаж л байгаа даа. Цаг хугацаа өнгөрөх тутам хамсаатан нь байсан хэрэгт орно доо, яана! Түүх, цаг хугацаа гэдэг чинь их даажинтай эд шүү дээ.

Иймэрхүү жишээ хэдхэн сар өнгөрсөн гэхэд хангалттай их бий. Энэ залуучууд өнгөрсөн зургаан сард гарсан шийдвэр, түүнийг зурагтаар сурталчилж байгаа увайгүй хэлбэр, архагуудын ярьж хэлж байгаагаас ичиж байгаа, харин хүмүүсөөрсдийг нь үүнд нягт холбон ойлгож буруутгаж байгаа гэдгийг мэдэж байгаа болов уу? Эд нарын бодсоноор биш, хүссэнээр биш, ойлгож сэтгэснийх нь эсрэгээр явж буй процесст нэр нь холбогдож, бараг л уран барилгач нь юм шиг хэлүүлнэ гэдэг угтаа шударга биш хэрэг. Гэвч “золиосгүй хувьсгал гэж байдаггүй юм” гэж коммунистууд хэлэх дуртай. Золиос нь л эд боллоо. Зууны золиос! Зуун дамнасан золио! Үеэ өнгөрөөсөн үзэл суртлыг зуун дамнуулан тээж ирсэн биет хэмээн эднийг дараагүйнхэн шударга бусаар үнэлэх болно. Хорь гучин жилийн дараа эдний үр хүүхэд, ач гуч “Аав аа, та тэр үед хөгжлийн урсгал сөрж сэлээд хаачих гэж байсан юм бэ?!”

ХЭМЭЭН АСУУХЫН ЦАГТ ЗОЛИОСТ ТАЙЛБАР ОЛДДОГГҮЙ НЬ ӨӨРӨӨ ТҮҮХИЙН ДААЖИН БАЙДАГ БИЛЭЭ.

2000.12.26

Солонгосын хойгийн асуудал ба туунийг зохицуулахад монголын оролцоо

Умард Солонгосын өнөөгийн байдал

Умард Солонгос нь ялангуяа Иракийн дайны дараа илүүтэй цочролын байдалд байна. Олон улсын зүгээс үзүүлэх даралт шахалт улам их болохын хэрээр дэглэм өөрийгөө аврах, тэсэж үлдэхийн тулд юу ч хийхээс буцахаа больжээ. Олон жилийн түнш Хятад сүүлийн үед нүүр буруулж дэглэмд шахалтүзүүлэх болсон нь Ким Чэн Иррийг улам хүнд байдалд оруулж байна. Олон жилийн турш, ялангуяа Хүйтэн дайн дууссанаас хойш олон улсын тавцан дээр сүрдүүлэх, эвлэрэх хандлагаүзүүлэх, горьдлого төрүүлэх, гэнэтийн алхам хийх зэргээр дэглэм өөрийнхөө насыг уртасгах зальтай тактик явуулан тодорхой хэмжээгээр амжилт олж байсан нь Иракийн дайны дараагаас явуургүй болж эхэлсэнд Умарт Солонгосын эрх баригчид сандран хөл алдаж байна. Хятад, Орос хоёрын зүгээс сүүлийн арав гаруй жилийн турш үндсэндээ дундыг барьсан бодлого явуулж байсан нь Умард Солонгосын эрх баригчдад зальжин тактикаа үргэлжлүүлэх бололцоо олгож байсан юм. Нөгөөтэйгүүр Клинтонь засаг захиргаанаас аядуу бодлого баримталж, Японы тал байдлыг сайжирна гэж хүлээж байсан, Ким Дэ Жүний засаг захиргаа харилцаагаа сайжруулах гэж хэт махарч байгаа зэрэг олон үйл явдал зальжин тактикаа урнаарүргэлжлүүлэх таатай нөхцөл бүрдүүлж байлаа.

АНУ-ын зүгээс явуулах бодлогын өөрчлөлтийн тусгал.

Бушийн засаг захиргаа буй болоод тун удалгүй ерөнхийлөгч Буш Солонгосыг Ирак, Ираны хамтаар “чөтгөрийн тэнхлэг” гэж нэрлэсэн нь энэ орноос Умард Солонгосын талаар баримтлах бодлогод үндсэн өөрчлөлт гарсныг илтгэв. Тун удалгүй Ким Дэ Жүний ерөнхийлөгчийн хугацаа дуусаж, шинээр гарч ирсэн Өмнөд Солонгосын төр умардынхантай түрүүний ерөнхийлөгчийн адил царайчилсан бодлого явуулахгүй нь тодорхой болов. Умард Солонгосын зүгээс урьдын тактикааүргэлжлүүлэн сүрдүүлэх, хэлэлцээ хийхэд бэлэн байгаа горьдлого төрүүлэх зэрэг хэд хэдэн гэнэтийн алхам хийсэн боловч тухай бүр АНУ-ын зүгээс хатуу хариулт сонсов.

Бүс нутагт тогтворгүй байдлыг хадгалсаар байх нь Хятадын хувьд тун таагүй хэрэг учир Умард Солонгосыг АНУ-тай хэл амаа ололцуулахад зуучлахын зэрэгцээ Умард Солонгосын дэглэмд янз бүрийн хэлбэрээр даралт үзүүлэх алхамд Хятад улс шилжлээ. Асуудлыг зохицуулахад буй болох санхүүжилт, мөнгөний сургаар Орос улс ч асуудалд үл ойлгогдох харилцан уялдаагүй сонин бодлого явуулах болов.

Хятад маягийн социализм байгуулна гэж Ким Чэн Ир

Хятадад ирж туршлага судалсан, чөлөөт бүс буй болгосон,

Өмнөдтэй төмөр зам холбосон, Ким Дэ Жүнтэй уулзсан, ойрмогхон Орост айлчилсан зэрэг нь Япон, Өмнөд Солонгос, АНУ руу сүрдүүлэг үзүүлж буйгаа нөгөө талаас горьдлого байгаа мэт сэтгэгдэл төрүүлэх гэж цаг хожих гэсэн уран тактик байсан нь улам бүр тодорхой болж

байна.

Хятад маягийн ч бай тэрнээс илүү хяналттай ч бай чөлөөт зах зээлийн элемент нэвтрүүлнэ гэдэг дэглэмийн хувьд төгсгөл гэдгийг Умард Солонгосын удирдагчид мэдэхийн цаагуур мэдэж байгаа. Энэ дэглэм хэзээ ч хүний санаанд оромгүй сенсацүзүүлж чаддаг баялаг туршлагатай. Гадаадын элчин сайдын яам руу бөөнөөрөө зугтаах үзэгдлийг хэрэгтэй үед нь зориуд зохион байгуулдаг ч байж болох юм.

Умард Солонгос дахь Хятадын сонирхол.

Умарт Солонгосын дэглэм нь олон арван жилийн турш ЗХУ,

Хятадын түшиг дэмжлэгээр тогтносон билээ. Ялангуяа Хятадын дэмжлэг жараад оноос хойш үндсэн дэмжлэг нь болж байсан.

Сүүлийн арваад жилийн турш Умард Солонгос нь Хятадын айхавтар толгойны өвчин болж хувирчээ. БНХАУ нь өөрийнүлгэр жишээгээр Умард Солонгосыг зөөлөн газардуулалт хийлгүүлж зах зээлийн харилцаанд аяндаа уруу татан оруулж болно гэж горьдож байлаа. Ийм зөвлөлгөөг Янь Шанкун, Зэнь Зяомин нар Умард Солонгосын удирдагчдад шууд тулгаж ч байв. Сайн санааны зөвлөлгөө Кимийн дэглэмийн хувьд яавч хүлээн авагдашгүй зүйл, харин энэ нь дараагийн зальжин тактикааүргэлжлүүлэн тоглох шинэ боломж олгосоор буйг хятадуудөдгөө сайн ойлгож байна.

Хятадад өнөөдөр тогтвортой байдал асар чухал хэрэгтэй байна. Олимпын тоглолт, Экспо үзэсгэлэн зэрэг нь Хятадын нэр төр, нөлөөллийг дэлхийд, тэр дундаа Азид улам бэхжүүлэх аятай далим билээ. Өнөөгийн эдийн засгийн түргэн огцом хөгжлийн темпээ алдахгүй байх нь юу юунаас илүү амин чухал асуудал. Энэ утгаараа тэдэнд АНУ, Япон, Европтой сөргөлдөж байх, тэр тусмаа Умард Солонгосоос болж муудалцах ямар ч хэрэггүй юм.

Умард Солонгосын дэглэм үхэх ч үгүй, сэхэх ч үгүй байнгын тогтворгүй байдал агуулаад байх нь Хятадын хувьд улам бүр аюул занал агуулсан хэлбэртэй болж байна.

1 дүгээрт. Аядуу бус Кимийн дэглэм оршсоор байх нь хэзээч дэлбэрч болох аюултай. Чингэсэн тохиолдолд энэ нь хяналтаас гарна. Дэглэм амиа хорлох дайн өдөөсөн ч, дотроосоо гэнэтийн эргэлт бослогод сүйрсэн ч аль алин нь хяналтгүй дэлбэрэлт болно. Хяналтаас гарсан 1.2 сая цэрэг, 8 сая бэлтгэл цэрэг хоол хувцасны эрэлд гаран юун түрүүн хөрш Хятад руу хөдлөх болно. Харьцангуй чөлөөтэй болсон, чөлөөт зах зээл нэвтэрсэн Хятад нь энэхүү аймшиг дагуулсан миграцийг зогсоох, хянах ямар ч бололцооогүй.

2 дугаарт. Дэглэмд чөлөөт зах зээлийн элементүүд халдааж улмаар зөөлөн газардуулах арга хэмжээ авах нь ч бас аюултай. Энэ нь нэг талаас Ким Чэн Ирийг байхад хүлээж авагдахгүй тоглоом, хүлээж авагдлаа ч дэглэм хяналтгүй сүйрч уламтогтворгүй байдал үүсгэх аюултай.

Хятадын хувьд дэглэмийг илүү чанга хяналттай барьж байх өөр хүний гарт шилжүүлэх, эсвэл хяналттай зөөлөн газардуулга хийх өөр хүнд шилжүүлэх хоёр арга үлдэж байна. Эхнийх нь бололцоогүй зүйл. Гадаад ертөнцөөс таслагдсан Умарт Солонгос тэсэж амьд үлдэх

боллоцоогүй, хянагчийг тэтгээд явах нь Хятадыг АНУ болон бусад оронтой сөргөлдөөнд оруулна. Иймээс хяналттай зөөлөн газардуулгын эзнийг олж тохиромжтой үед түүний гарт Умард Солонгосыг шилжүүлэх арга зам үлдэж байна.

Хятадын хувьд Умард Солонгос нь өмнөдтэйгээ нийлэх, коммунизмаас татгалзах, Оросын талд орох аль ч хувилбар бага санаа зовоох асуудал юм. Юу юугүй тэсрэх бөмбөг шиг болсон энэ өлсгөлөн орныг хэн ч хариуцлагыг нь үүрч өөр дээрээ наахгүй. Ким Чэн Иррийн дэглэм унаа л бол аягүй бол өнөөдөр хамгийн их санаа зовж байгаа АНУ хүртэл үүгээр санаа нь амарч “та нар өөрснөө янзалж ав” гээд зөнд нь хаячиж чадна. Дэглэм унавал хамгаалалт сайтай өмнөдүүд ч бага хохирно, хамаг хариуцлага Хятад дээр унана. Иймээс Кимийн дэглэмд шахалтүзүүлэн зайлуулж өөр найдвартай гарт Пхенянийг атгуулах нь юун түрүүн Хятадын эрх ашиг юм.

Умарт Солонгосын ирээдүй

Хэд хэдэн хувилбар байна:

А. Ким Чэн Иррийн дэглэм цаашид тогтох. Дэглэм өөрийгөө авч явахын тулд улс төр эдийн засгийн ямар ч өөрчлөлт хийх бололцоогүй. Одоо хүртэл баримталж буй гадаад орчноо сүрдүүлэх, горьдлого төрүүлэх замаар үе үе мөнгөн төлөөс, тусламж авч амь зогоох энэ арга нь гадаад ертөнцийнх нь зөрчилдөөн, горьдлого, нэгдсэн бус бодлого дээр тулгуурлаж байв. 2003 оны 8-р сарын сүүлчээр Бээжинд болсон бүтэлгүй уулзалтаас хойш Солонгосыг тойрсон гадаад ертөнцийн дэглэмд хандах хандлага нэгдмэл шинжтэй боллоо. Ийм тохиолдолд дэглэм цаашдын насгүй болно. Дэглэм сүр үзүүлэн байн байн заналхийлж буй боловч үнэндээ гадаад ертөнцдөө шууд аюулчруулах техник технологийн магадлал тун тааруу.

В. Дэглэм унаж өөр дэглэмээр солигдох. Үүнийг өдгөө ялангуяа хятадууд их сонирхож, шинэ хүний гарт дэглэмийг шилжүүлэх бололцоо хайж байна. Гэвч Умард Солонгосыг тайван газардуулж улмаар Хятад маягийн социализмын нийгэм эдийн засгийн реформ хийх хүний гарт шилжүүлэх бололцоо тун тааруу. Тавь гаруй жил ер бусын хүнд чанга дэглэмд оршсон нийгэм өнөөгийн ингэтлээ өөрчлөгдсөн дэлхий ертөнцийн суурин дээр нэг дэглэмээс нөгөөд шилжих магадлал тун муу.

С. Дэглэм нурснаар нийгэм бүрэн хаост автагдах. Ямар ч муу тохиолдолд формаль байдлаар боловч шинэ удирдлага буй болно. Харин энэ нь нэгэнт задарсан нийгмийг их сайндаа л хэдхэн хоног сарын хугацаагаар хянаж чадна. Дүрвэгсэд, мафи, аллага, эмх замбараагүй байдал Солонгосын хойгийн умард хэсэгт ноёлож эгшин зуур хүрээгээ тэлэн Умард Хятад, Оросын Алс дорнод улмаар Өмнөд Солонгос руу түрэх болно. Хяналтаас гарсан энэхүү нийтийг хамаарсан замбараагүй байдал нь бүс нутгийг одоогийнхоос хавьгүй илүү тогтворгүй байдал руу хөтлөх болно. Ямар ч “чихгүй толгойлсон” дэглэмтэй хариуцлага тооцож болно, учир нь ард нь хариуцах эзэн байна, харин эмх замбараагүй болсон тодорхой эзэн толгойлогчгүй үймэгсэдтэй ямар ч хариуцлага тооцох аргагүй юм. Бүс нутагт үүсэх энэхүү замбараагүй байдлын гол хариуцагч нь хохиролыг бие дээрээ шууд амсах Хятад, Орос, Япон, Өмнөд Солонгос болж хувирна.

Байдлыг тогтворжуулах арга зам

Өдгөө Хятад улс үүсч болох аюулаас сэргийлэн Умард

Солонгосын хил рүү цэргийн хүч татаж байна. Гэвч энэ ньөөрсдийгөө тодорхой дэглэмээс цэргийн хүчээр хамгаалж байгаа болохоос үүсэх эмх замбараагүй байдлын түрлэгээс хамгаалж чадахгүй. 38-р өргөрөг дээр буй Америк-Солонгосын цэргийн хүч ч дэглэмийн эсрэг хамгаалалт болохоос хаосын хамгаалалт биш.

Үүсэж буй болох хаосоос сэргийлэх, намжаах нэг арга бол дүрвэгсэдийг олноор нь байрлуулж зах зээлийн ертөнцөд амьдарч анхны сургалт зохион байгуулах хэлбэр юм. Үүнийг Умард Хятад, Оросын Алс Дорнодод олноор нь байгуулж болно. Гэвч дэглэм унаагүй байхад өнөөдөр Умард Солонгостой өдий хүртэл сайн харилцаатай байгаа хоёр хөршийнх нь ийм алхам дэглэмийг улам галзууруулж цочирдсон алхам хийлгүүлж болох юм.

Монголын оролцоо

Монгол нь Солонгосын хойгоос 1 000 км тусгаарлагдсан нутаг. Гэвч нэг талаас Зүүн Хойд Азийн бүс нутгийн интеграцлал хамтын ажиллагаанд оролцох маш сонрхолтой, үүнд эртнээс идэвхийлэн оролцож буй улс, нөгөөтэйгүүр Хойд Солонгостой хагас зуун жилийн турш сайн харилцаатай байсан орон. Өмнөд Солонгостой сүүлийн арав гаруй жил мөн сайн харилцаатай байдаг тул өөрийн нутаг дээр орж ирсэн Умардын цагаачдыг тогтмол Өмнөдөд шилжүүлэн өгч байгаа. Үүний зэрэгцээ Умартынханд жил бүр хүнсний тусламж үзүүлдэг.

Өнөөдөртөө Монгол нь иймэрхүү төрлийн кэмп байгуулах аятай боломжтой, цаг хугацааны тохиромжтой нөхцөл бүрдсэн орон мөн. Монгол нь жилд дунджаар 100 орчим умардын дүрвэгч хүлээн авдаг. Гэвч энэ цөөн тоон дээр түшиглэн кэмп байгуулах нь учир дутагдалтай. Учир нь шууд дүрвэгсэдийн кэмп байгуулах нь дэглэмийг сэрэмжлүүлж улмаар тусгай арга хэмжээ авахуулахад хүргэх ба ингэснээр Монголд дүрвэж ирэх хүний тоо харин ч багасах магадлалтай.

Илүү боломжит хувилбар бол ирээдүйд буй болж магадгүй их хаосд бэлдсэн кэмпийн эх загварыг Монголд байгуулах явдал юм. Монгол-Умард Солонгосын харилцаа сайн байгаа явдалд түшиглэн эхний ээлжинд хоёр орны хамтарсан жоинт вэнчэр хамтын үйлдвэр байгуулаад Солонгосын 3000-5000 ажилчин авч ирж ажиллуулах боломж байна. Нэг ажилчинг жилээс илүү ажиллуулж болохгүй хууль дүрмээр шахан эдгээр ажилчид тооны хувьд өсч болох боловч үргэлж шинэчлэгдэн солигдож байхаар бодох нь зүйтэй. Хэрэв энэ туршилт амжилттай болбол ийм хэд хэдэн хамтарсан үйлдвэрлэлийн газар байгуулж кэмпийн голшруулах боломжтой юм. Энэхүү үйлдвэрлэлийн газар боломжит хаос үүсэхэд шууд дүрвэгсэдийн лагерь болон хувирч болох бололцоотой байх ёстой.

Энэ ажиллагааг үйлдэхэд хэд хэдэн бэрхшээл байна.

1. Монгол нь одоо хүртэл олон улсын дүрвэгсэдийн асуудал зохицуулах конвенцид нэгдээгүй байгаа. Энэ асуудлыг Монголын парламент ойрын үед авч хэлэлцэх шаардлагатай.

2. Кэмп болон хамтарсан үйлдвэрлэл өөрийн хөрөнгөөр байгуулах санхүүгийн бололцоо Монголд байхгүй. Иймээс энэ талын туслалцаа гадаад ертөнцөөс шаардлагатай.

3. Ийм үйлдэл эхлүүлэх, хийхийн тулд Монголын Засгийн газар болон ард түмэнд өөрийн сэдэл байх ёстой. Монгол орны хөгжил дэвшилд тодорхой хувь нэмэр оруулах тодорхой хэмжээний мөнгө, шагнал амлагдсан байх ёстой.

4. Энэ ажиллагааг эхлүүлэхээр шийдвэл яаравчлах нь зүйтэй.

Умард Солонгост хандах гадаад ертөнцийн хандлага ижил төстэй, нэгдсэн болохын хэрээр дэглэм нэг талаас нас нь асар богиносж, нөгөө талаас хүний санаанд оромгүй ямарч үйлдлийг цочирдон хийж асуудал гэнэт өөрчлөгдөн хариу арга хэмжээ авах аргагүй болгож болох юм. Иймээс цаг хугацааны хүчин зүйл энд их ач холбогдолтой байна.

2003 он

Дорнод монголын бүсийн хөгжлийг зүүн хойд азийн эдийн засгийн интеграцитай холбох нь дорнод аймаг

Зүүн Хойд Азийн эдийн засгийн интеграцитай Монгол орныг холбоход юун түрүүн түүний хамгийн зүүн мужийг үүнд түрүүлж холбох, үүнд бэлтгэх ажиллагаа хэрэгтэй юм. Монгол нь 21 аймаг (муж)-тайгаас хамгийн зүүн талд орших Дорнод аймаг нь 123 мянган ам км нутагтай, 74 мянган хүн амтай, хүн амын нягтрал нь 0,6 ам км/хүн юм.

Энэ район нь Монголын хамгийн нам дор газар (550-1200м), жилийн дундаж температур 1-р сард -20 хэм 7-р сард +25 хэм. Нийт нутгийг тал хээр, бага хэсгийг нь ой мод уулс эзэлдэг. Нилээд олон 20 орчим жижиг нууртай, зүүн хэсэгтээ Монголын томоохон нуурын нэг Буйр оршдог ба тэр нь 50м гүнтэй.

Дорнод аймагт Монголын бусад хөдөө нутгийн нэгэн адил мал аж ахуй эдийн засагт голлодог, аймгийн ДНБ-ий 85 хувийг анхдагч салбар эзэлдэг. Адуу, үхэр, хонь, ямаа гэсэн малын нийт тоо нь 850 мянга орчим юм. Энэ нь билчээрийн нүүдлийн мал аж ахуй. Газар тариаланд ашиглаж болохуйц асар их газартай боловч энэ салбар туйлын сул хөгжсөн. 1990 он буюу албадлагын хамтралын систем бутран унаснаас хойш газар тариалан эрхлэх явдал эрс унажээ. Одоо 4, 750 га-д тариалалт хийж 400 га-д хүнсний ногоо тариалж байна.

Уул уурхайн нилээд баялаг энэ мужид бий. Гэвч ихэнх газар нь нарийн сайн судлагдаагүй юм. Тамсагийн районд 1992 оноос нефтийн хайгуул хийгдсэн ба 1998 оноос бага хэмжээгээр

Хятадад экспортлож эхэлсэн юм. Судлаачдийн тооцож байгаагаар энэ бүсд 1,5 тэрбум баррель нефть бий ба өнгөрсөн жил Америкийн хайгуулчид 300 мянган баррель нефть илрүүлснээ зарласан болно. Энд мөн Монголын хамгийн том ураны орд, газрын ховор металлийн орд, цайрын орд бий ба заримыг нь бага хэмжээгээр ашигладаг. Үүнээс гадна жонш, нүүрс, давсны баялаг орд бий.

Дорнод аймгийн хүн амын талаас илүү нь Чойбалсан хотод суудаг. Чойбалсан нь Монголын дөрөв дэхь том аж үйлдвэржсэн хот юм. Энэ хот хойшоо Оросын Борзатай шууд төмөр замаар холбоотой, өөрийгөө болон орчноо хангахуйц цахилгаан станцтай. Мөн хивсний болон, мах боловсруулах үйлдвэр, гурилын үйлдвэр, ноос угаах үйлдвэр зэрэг Монгол улсын хэмжээнд тооцож болохуйц томоохон үйлдвэрүүдтэй.

Дорнод аймаг нь газар зүйн байрлалын хувьд БНХАУ, ОХУ-тай аль алинтай нь хиллэдэг. Хятадын Өвөр Монголын Хөлөнбөөр, Хянган гэсэн хоёр аймаг зүүн талаар нь шууд хиллэдэг цааш нь Жилин мужаар дамжин Солонгосын хойгийн Номхон далайтай 1200 орчим км зайд алслагдсан болой.

ЖИЛИН МУЖ

Жилин бол Солонгос Монголыг холбосон хамгийн чухал муж юм. Түмэн голын төслийг хэрэгжүүлэх Хятадын дотоод төлөвлөгөөний дагуу энэ мужид дэд бүтцийн талаар асар их

зүйл хийгдсэн. Түмэн гол руу чиглэсэн гол замуудыг барьж дуусгаад байгаа.

ХЯНГАН МУЖ

Хянган муж нь Дорнод аймгийг эдийн засаг дэд бүтцийн хувьд Жилин муж болон Солонгосын хойгтой холбоход хиллэж байгаагийн хувьд хамгийн рольтой газар билээ. 60 мянган ам км нутагтай, 1,6 сая хүн амтай энэ муж нь ДНБ-ий 45 хувийг нь газар тариалан эзэлдэг хөдөө аж ахуйн муж. Сүүлийн үед аялал жуулчлал, ялангуяа Хятадын дотоодын туризмыг их хөгжүүлж байгаа. Энд нилээд хэдэн уурхайтайн дотор төмрийн хүдэр,

шохойн чулуу, цахиур ашигладаг. Хятадын дотоод Төмөр замын эцсийн цэг Аршаан нь Монголын хилээс ердөө 35 км зайтай. Аршаан хот нь халуун аршаантай учир сүүлийн хэдэн жил Хятадын аялал жуулчлалын эрчимтэй хөгжиж байгаа цэг болоод байна.

ДОРНОД АЙМГИЙГ БҮСИЙН ИНТЕГРАЦИД ОРУУЛАХЫН ТУЛД ЮУ ХИЙЖ БОЛОХ ВЭ?

Дэд бүтэц.

Чойбалсан хот нь ОХУ-ын Борзатай төмөр замаар холбоотой. Хятадын Аршаан хоттой холбохын тулд 400 гаруй км төмөр зам нэмж татах шаардлагатай юм. Алс Дорнодод Хятад-Оросыг холбосон Мануулын өртөө нь сүүлийн үед хүчтэй хөгжиж буй эдийн засгийн харилцаанаас болж ачаалал нь нилээд хүндэрсэн. Тэгвэл энэ төмөр замыг Чойбалсан хүртэл нарийн төмөр зам татан энэ хотод ачаа болон дугуй солих цэг барих аваас эдийн засгийн нилээд ашиг гарах нь ойлгомжтой. Энэ замыг барихад 500 сая орчим доллар шаардлагатай ба энэ нь хувийн хэвшил болон харилцан зээл, Засгийн газруудын дэмжлэгтэйгээр фанд райзинг хийх бололцоотой. Харин энэ талын судлагаа одоо болтол ядмаг байгаа.

Чойбалсан хотыг мөн Аршааны автозамын сүлжээтэй холбох нь маш чухал байгаа юм. Аршаанаас хил хүртэл хатуу хучилттай зам татах, Халх гол дээгүүр гүүр барих асуудлыг хоёр орны засгийн газрын хэмжээнд тохиролцсон ба энэ ажлыг энэ жилд нь гүйцэтгэж дуусгахаар төлөвлөж байна.

Газар тариалан.

Социализмын үед энэ бүсд газар тариалан эрхэлж байгаад сүүлийн үед унтарчээ. Ашиглаж болох талбай 500 мянган га -д хүрнэ. Ялангуяа Халх голын орчимд хөрс ус нь нэн тохиромжтой. Энд төмс хүнсний ногоо, соба, соёо, улаан буудай тарьж болно гэдэг нь туршилтаар нотлогдсон юм. Хойд Солонгосын талаас энэхүү эзэнгүй газар тариачид оруулжирэн газар эзэмших хүсэлт тавьсан ба энэ нь одоо судлагааны хэмжээнд явж байна. Энд тухайлбал соба тарьж Японд, төмс тарьж Өмнөд Солонгост экспортолж болох бололцоог судалж байгаа юм. Гэвч энэ талаар нарийн судлагаа хийгдсэн юм байхгүй.

Аялал жуулчлал.

Дорнод аймгийн зүүн хязгаарт дэлхийн II дайны өмнөх хамгийн том тулалдаан Халх голын байлдаан болсон билээ. Энд Зөвлөлтийн 20 мянга, Японы 40 мянга орчим дайчдын булш

байдаг. Мөн энэ нутаг нь Хянганы нурууны үзүүр хэсгийнүзэсгэлэнтэй байгаль, Буйр нуур зэрэг байна. Аршаан хот нь сүүлийн үед туризмын томоохон төв болж байгаа учир энэ хот руу чиглэсэн жуулчлалыг нааш нь Халх гол руу сунганөргөжүүлэх бүрэн бололцоотой.

Ашигт малтмал

Сүүлийн үеийн судлагаагаар энд нефтийн асар их баялаг ундарч байна. Энэхүү түүхий нефть нь Хятадын, тэр дундаа Дачингийн районы зах зээлд зориулагдсан юм. Нефтийн нөөц их нь батлагдах аваас эндээс шууд хоолойгоор татахаас өөр аргагүй болох ба нөгөө талаас төмөр зам, хатуу хучилттай зам татах эдийн засгийн шалтаг буй болно. Хятадын энэ хавийн бүсийн нүүрсний хэрэгцээ сая тонноор хэмжигддэг ба хэрэгцээний нилээд хэсгээ хилийн гүнээс татан авдаг. Гэтэл Монголын тал илүүдэл их нүүрстэй, үүний зарим хэсгийг төмөр замаар Орост экспортлодог. Одоо ашиглагдаж байгаа нүүрсний уурхайг шинэчлэн өргөтгөх, шинийг ашиглаж эхлэх олон ажил бий. Энэ талаар зах зээлийн болон ашиглалтын судалгаа ядмаг байгаа.

Уран, цайр, жонш, давсны уурхайнуудыг ашиглах талаарх судалгаа ч бараг хийгдээгүй юм. Эдгээрийн эдийн засгийн хувьд ашиг өгөх нь тодорхой.

Экологи

Энэ бүс нь зүүн Хойт Азийн тал хээрийн бүсийн эрүүл онгонүлдсэн бага газрын хэсэг. Тал хээрийн амьтан ургамалын бүхий л цуглуулга бүхий энэ районд эдийн засгийн эрчимтэй хөгжлийн үед байгалийн тэнцвэрийг хэвээр хадгалах тухай асуудал юун түрүүн шийдэгдэх ёстой. Өнөөдрийн байдлаар зээр, чоно алж устгах, Буйр нуураас загас, сам хорхой зэргийг бэлтгэх нь тодорхой судалгаагүйгээр хийгдэж байгаа. Ялангуяа Хятадын зүгээс байгалийн баялагийг ашиглах компаниуд олноор орж ирж байгаа ба Монголын талаас эдийн засгийн хүндрэлээс болж найр тавин эрх олгож байгаа юм.

Зүүн Хойд Азийн нийгэмлэгээс Монголын засгийн газрын захиалгаар “Дорнод аймгийг Зүүн Хойд Азийн бүс нутгийн хамтын ажиллагаанд оролцуулах боломж арга замыг тодорхойлох” гэсэн комплекс судалгааны ажил хийхээр төсөл боловсруулж байна. Дотроо нийт 18 дэд төсөл агуулсан энэхүү судалгааны төслийн өртөг 300 мянга орчим ам. Доллар болох ба үүний гуравны нэгийг Монголын засгийн газар, 15 хувийг Дорнод аймгийн захиргаа гаргахаар болчихоод байгаа билээ. Бусад үлдсэн хөрөнгийн фон райзинг хийх үүрэг манай нийгэмлэгт ноогдож байна. Энэхүү төсөлд оролцохыг сонирхогч байгууллагуудад уриалж урьж байна.

2003 он

Солонгос ахтай болбол ямар вэ?

Америк судалгаа

Америкчууд Монголын талаар айхавтар судалгаа хийжээ. Судалгааны нэгтгэсэн дүнг “Соросын сан” нэрээр хязгаарлагдмал хүрээнд тараасан байна. Гэвч ийм нарийн судалгааг “Соросын сан” хийсэн юм гэхэд дангаараа үйлдээгүй биз. Энэ нь нэлээд олон жилийн хүн хүч, хөрөнгө мөнгө шаардсан буурьтай судалгаа. Үүнд Монгол улсын өнөөгийн нийгэм, улс төр, эдийн засаг, хүний хүчин зүйл, гадаад харилцаа, социологи, нийгмийн сэтгэл зүйлийн байдлыг сүрхий оновчтой, далайцтай судалж ойрын ирээдүйн дүр зургийг гаргаж ирсэн ажгуу. Мэргэжлийн маш олон хүрээ судалгаанд дайчлагдсан нь илэрхий.

Аливаа судалгаа тэс хөндлөнгөөс хийгдсэн байх тусмаа илүүнэнтэй байдаг. Тэр чанараараа энэ судалгаа нэлээд бодитой, бодитойгийн хэрээр ноцтой, түгшүүртэй бүтээл болжээ. Мэдээж монголчуудын хувьд шүү дээ, түүнээс хөндлөнгийн судлагчид Монголын хувь заяа хаашаа эргэх төлөвтэй байгаа нь ямар пад байх билээ! Түгшүүртэй гэдгийн учир нь одоогийн нөхцөл, ирээдүйн төлөв хар бараан талдаа гарсан байна.

Олон улсын тавцан дээр Орос, Хятадаас өөр газрын сонирхол татахуйц газар зүйн болоод геополитикийн байрлал үгүй, гадаадын хөрөнгө оруулалт татахуйц эрдэс баялаг, зах зээл үгүй, төр засаг нь авилгад идэгдсэн, төрийн бүтэц тогтоц нь оновчтой биш, улс төрийн намуудын аль нь ч төлөвшөөгүй, байгаль цаг уурын сүйрлийн ирмэгт тулсан, уул уурхайн олигтой нөөц одоо болтол илрээгүй, дэндүү бага зах зээлтэй, тархины зугтаалт эрчимтэй болж байгаа (боловсролтой нь гадагш дүрвэж байна), улс даяар өрнөж буй нүүдлийг зохицуулсан бодлого үгүй, засагзахиргааны нэгжийн бүтэц нь оновчгүй учир маш үрэлгэн;, хуулийн орчин бүрэлдээгүй;, нийгмийн дотор хөрөнгийн хувьд баян ядуу, сэтгэлгээний хувьд залуу хөгшин, оюуны хувьд боловсролтой харанхуй, соёлын хувьд хот хөдөөний гэсэн ялгаа нь өдөр өнгөрөх тутам улам ялгаран холдсон;, хүн амын дийлэнхи нь өнөөгийн дэлхий дахины даяаршиж буй бодит фактын эсрэг сэтгэлгээтэй, өөрөөр хэлбэл гадагш дайсагнасан,үл итгэсэн хандлагатай;, хүмүүс нь бизнесийн сэтгэлгээгүй буюу дутмаг, итгэл даах илтгэцүүр ядмаг;, сэхээтэн болон мэргэжилтнийх нь ур чадвар өрсөлдөх чадвар дорой;, гэх мэт, гэх мэт.

Дүр зураг бараан байгаа биз! Энэ судалгаа нь монголчуудыгухамсарлуулж ойлгуулж гэгээрүүлэх гэсэн зорилго агуулаагүй байх. Доромжилж муулж бахаа хангах гээгүй ч байх. Судалгаа гол нь өөрсдөд нь зориулагдсан. Энэ оронтой хамтарч ажиллах ирээдүй байна уу, эсвэл энд нь хог новштой нь зөнд орхичих уу гэдгийг л тодорхойлох гэсэн прогноз. Сүүлийн арав гаруйхан жилийн дотор Өрнийн ертөнц энэ оронд бараг хоёр тэрбум доллараа зарцуулжээ. Дэлхий дахины ДНБ болох 30 триллон доллар, эсвэл АНУ-ын батлан хамгаалах зардалд жилд гардаг 350 тэрбум доллар, эсвэл хөгжиж буй орнуудад жилд үзүүлдэг Японы тусламж болох 10 тэрбум доллартой харьцуулахад энэ нь бага л даа. Харин хүн амтай нь харьцуулахад энэ нь аварга тоо гарна. Ухаан нь энэ хооронд Индонез улс 200 тэрбум доллар авчихлаа гэсэн үг болно шүү дээ. Гэтэл Индонез нь нэг хүндээ 6 доллар буюу арав гаруй жилд 15 хүрэхгүй тэрбум долларын тусламж авчээ.

Тэгэхээр цаашид утга учиргүйгээр ийм их мөнгө үрэх нь галзуу хэрэг. Стратегийн ач холбогдолд нь тохируулах хэрэгтэй. Хүйтэн дайны дараах хөөрөл одоо зогсож байна. Хүйтэн дайны дараа болсон хуваагдал үеэ өнгөрөөлөө. Өнөөдөр Өрнийн ертөнцийн өмнө лалын тулгар үзэл, терроризм, Хойд Солонгос гэсэн өөр асуудлууд тулгарсан бэрхшээл болж байна.

Нэг л үгээр хэлэхэд Монгол өөрийн ардчилж байгаагаар гайхуулж хоол олж идсэн богино зурвас ард хоцров. Нөгөө талаас энэ орон ойрын 20-25 жилдээ өөдлөх, хямралаас гарах ямар ч найдваргүй гэдгийг судалгаа баталжээ. Гэхдээ маш их шургуу хөдөлмөрлөж байж 25 жилийн хойно “хүний зэрэгт” хүрнэ.

Орос ах

ЗХУ-ын нөлөөнд 70 гаруй жил явсан нь монголчуудад алдсан гэхээсээ оносон нь ихтэй үе юм. Дундад зууны үеийн хоцрогдсон бүдүүлэг нүүдэлчид чухам оросуудын нөлөө тусламжаар ХХ зууны соёл иргэншилтэй золгосон билээ. Ялангуяа далаад оныүеэс хүйтэн дайны нэгэн өвөрмөц хэлбэр болох ЗХУ-Хятадын зөрчилдөөн нь Монголд олон тэрбум рублийн тусламж, хөрөнгө оруулалт орж ирэх нөхцлийг бүрдүүлжээ. Хэдийгээр энэ нь нүүдэлчдийн аргацааж амьдрах, бэлэнчлэх, хөдөлмөрөөс хойш суух, бусдын гар харах буюу хулхидах дээрэмдэх ясны араншинг улам хөөргөж дадлыг нь заншил болгон хувиргасан боловч эцсийн бүлэгт бид соёлжиж иргэншсэн ард түмэн болж чадсан.

Харамсалтай нь Орос-Монголын сүүлийн 70 жилийн харилцаа тэгш эрх бүхий түншийнх байгаагүй юм. Илүүтэй тэжээгч-тэжээлгэгчийн харилцаа байлаа. Хүмүүс хоорондын харилцан сонирхол байсангүй, үзэл суртал, геополитикийнүүднээс хандсан төр хоорондын ашиг сонирхол байв. “Курица не птица, Монголия не заграница” гэсэн хэлц үгэнд орос хүмүүст монголчууд, Монгол улс ямархуу хэмжээгээр сонирхлыг нь татаж байсан нь харагдана.

Үүний үнэн нүүр царай хүйтэн дайны дараагаас тод харагдаж эхэлсэн. Оросын төр ч, оросууд ч монголчуудыг таг мартжээ.

Өнөөгийн орос залуучууд Монголыг газрын зураг дээр ч олж зааж чадахгүй байх. Оросын төр засгийн толгойд шинэ үеийнхэн гарчээ. Урьдын бүдүүн бүдүүн дарга нар ирж баахан архи ууж согтоод монголчуудын тулгарсан асуудлыг нүд ирмэх зуур шийдэн бөөн бэлэг үлдээгээд явдаг байсан үе нь ч, нийгмийн харилцаа нь ч, үзэл суртал нь ч, хүмүүс нь ч, геополитик ашиг сонирхол нь ч нэгэнт дуусгавар болжээ. Шинэ үеийн дарга нар Монголыг өр авлагатай ядуу орон гэж харан, урьд өгсөн мөнгөө ямар ч үнээр хамаагүй буцааж авах сонирхлоо илэрхийлсэн прагматикчид.

Монголчуудын ч Оросоос хамаарах хамаарал эрс багаслаа.

Залуу үе орос хэл, Оросын утга зохиол, соёл түүхийг огт мэдэхгүйгээр өсөж өндийж байна. Монголын хувьд ч Зүүн Сибирь гэхээс Орос нийтдээ сонирхлоос гадуур бүс болж байна. Мэдээж хил орчмын газар нутаг Зүүн Сибирь одоо ч цаашид ч асар их ач холбогдолтой байх болно. Нефть нефтэн бүтээгдэхүүн, шатах тослох материал, цахилгаан, зарим нэг техникийн зүйлийн хувьд Монгол нь цаашид ч удаан хугацаагаар Зүүн Сибириэс хараат байх болно.

Харин энэ бүхнийг бэлэн валютаар хийнээү гэхээс бартераар урдаас нь барих юмаар маруухан. Мах, зарим эрдэс нийлүүлж болох боловч аль нь ч Оросын тэгтлээ сонирхолыг нь татах зүйл биш.

Америкчуудын хийсэн судалгаагаар Оросын төр ч, хүмүүс ньч Монголыг огт тоохоо больсоноос гадна цаашид хэрхэн үзэх нь тодорхойгүй гэжээ.

Хятад түнш

Лавтай хоёр мянга гаруй жилийн турш нүүдэлчдийн түнш гэхээсээ дайсан байсан Хятад улс, хятадууд Монгол орныөнөөгийн болоод цаашдын хувь заяанд онцгой үүрэгтэй хөрш юм. Монголчууд хятадуудад итгэдэггүй, тэднийг өөрсдийг нь эзлэх далдын санаатай гэж харддаг, түр зуурын наймааны түншээс цаагуур бодож чаддаггүй, дотроо мөнхийн дайсан гэж хардаг тухай нь судалгаа нэлээд үнэмшилтэй үнэн гаргаж иржээ. Мөн тэнд хятадууд Монголыг түүхий эдийн хямд зах зээлийнх нь хувьд л ашиглаж байгаа болохоос Хятадын ямар нэг тодорхой бодлого Монголд үйлчилж байгаа юм байхгүй гэжээ.

1927 оноос буюу Чан Кайшигийн үеэс, эсвэл арай өмнө Дуан Чируй, Сун Ятсэний үеэс Монголд онцгой хандах болжээ. Хятадын анхны ерөнхийлөгч Юань Шикай хэтэрхий хатуу бодлого баримтласан нь монголчуудыг үргээсэн, иймээс хятад тэвчээр гаргах юм бол нэг л мэдэхэд эх газартаа эргэж ирнэ гэсэн хятадуудын ерөнхий ойлголт байдаг. Гэвч хэт фанатикуудыг эс тооцвол үүнийг ойрын хугацаанд хэрэгжих зүйл гэж аль ч хятад боддоггүй. Өнөөдөр Хятад нь баян өмнөд, ядуу умард гэсэн орлогын илэрхий ялгаатай болжээ. Иймээс ядуугаа баяннь тэтгэж байх шаардлага байна уу гэсэн үзэл ч бас их дэлгэрчбайна. Үүнд ялангуяа Тайваний салан тусгаарлал бүр ч ташуурөгч байгаа юм. Ингэхээр Монголыг нэгтгэх империалист биш юмаа гэхэд хэт националист үзэл бодол бас л үеэ өнгөрөөж байгаа эд. Судалгаанд өгүүлснээр Хятадын төрийн Монгол руу хандсан тодорхой бодлого үгүй аж. Хятад нь өнөөдөр Монголын гадаад худалдаанд онцгой үүрэгтэй байгаа нь төрийн зохицуулалттай гэхээсээ хүмүүс хоорондын худалдаа арилжаа юм. Юутай ч Хятад нь Монголын хувьд хуучин ЗХУ-ын үүргийг орлон гүйцэтгэх сонирхолгүй бололтой. Монголчууд илүү баян өмнөд хятадуудтай ямар ч холбоогүй, Өмнөд ч Монголд ямар нэг сонирхол байхгүй. Ингэхээр Бээжингээс хойшх ядуу Умард л Зүүн Сибирийн нэгэн адил Монголтой худалдаа арилжаа хийдэг. Умардын ч хүн амын аль ядуу хэсэг нь, пүүс компаний тарчиг, шинэ тутам нь Монголтой холбоотой. Илүүтэй прагматик хүмүүсийн хувьд Монголыг хямд төсөр түүхий эдийн хязгаарлагдмал эх үүсвэр гэж хардаг. Энэ нь голдуу малын түүхий эд, байгалийн баялаг, эрдсээр хязгаарлагдана. Бизнес хийх цөөн тооны хятад суурьшиж буй боловч монголчуудын хятадын эсрэг уур амьсгал, шовинизм цаашид суурьших бололцоо олгодоггүй. Үүнийг зөвхөн Оросын Чита мужид сүүлийн арваад жилд ирж суурьшсан хятадуудын тоотой харьцуулан дүгнэж болно.

Япон найз

1991 оноос Монголд орж ирсэн зээл тусламжийн дийлэнхийг ганц Япон даажээ. Энэ нь Японы нийт гадаад тусламжийн зууны нэг хүрэхгүй боловч хүн амтай нь харьцуулахад асар том жинтэй тусламж юм. Судалгаанд өгүүлснээр Европ, Америк нь Монголд ямар ч сонирхол, эрх ашиг байхгүйн нэгэн адил Япондч мөн тийм сонирхол үгүй аж. Японы

тусламж нь прагматик гэхээсээ симпати, романтик үзэлтэй холбоотой. Ердөө хоёр сая хүнтэй, ЗХУ, коммунизмын дарангуйлалд олон жил нухлагдсан энэ орныг эгшин зуур хөл дээр нь босгох аваас Японы нэр хүндэд сайн гэж олон хүн боджээ. Хүн ам цөөтэй, хүн амдахарьцуулахад харьцангуй баялагтай, домог түүхээр Японтой холбоотой энэ орон нь Японы гадаад тусламжийн үр дүнг дэлхий даяар харуулах таатай хялбар үлгэр жишээ гэж зарим нөлөө бүхий япончууд бодсон бололтой. Нөгөө талаас Азийн орнуудад туслах нь Японы өөртөө хүлээсэн нэг үүрэг ажгуу.

Харин харамсалтай нь монголчууд төрийн удирдлагаасаа эхлээд энгийн ард түмэн нь хүртэл энэхүү тусламжийг хуучин ЗХУ-ын үүргийг шинээр орлон хүлээж авч байна гэж ойлгосон.

Үүнд дэлхий ертөнцийг таньж мэдээгүй нь, бэлэнчлэх, тэжээлгэх сэтгэлгээтэй нь, угийн хартай нийгмийн хувьд япончуудад Монголд ямар нэг айхавтар буурьтай эрх ашиг байна гэж тааварласаных нь гол шалтгаан болсон болов уу.

Зорилго нь хэт амбицитай, нөгөө талаас нүүдлийн- социализмын өвөрмөц хольц болсон сэтгэлгээтэй монголчуудын сэтгэл зүйн дадлыг ойлгоогүй учраас тусламжийн асар их мөнгө олон талаар оновчгүй байв. Үүнээс гадна япончуудын Монголтой хамтран ажиллаж байгаа үйл ажиллагаа нь дан ганц төрийнх байсан ба энэ үйлсд нь прагматик сэтгэлгээтэй Японы хувийн хэвшлийнхэн бараг оролцсонгүй. Чухам энэ талаас нь авч үзвэл Японы тусламж нь олон талаар хуучин ЗХУ-ынхтай их адил, өөрснөө хүсээгүй боловч бодит байдал дээр ЗХУ-ыг орлосон шинжтэй болжээ. Төрийн үйл ажиллагаа, оролцоо ихэнхдээ оновчгүй байдаг түгээмэл хууль Японд ч үйлчилдэг аж.

Цаашид ч Япон нь OECD-ийн хүрээнд Монголд тусласаар байх болно, гэхдээ мөнөөх романтизм нь арилах, гутах, арга барагдах, итгэл алдрах тал руугаа нэгэнт оржээ. Японы хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын тухайд гэвэл Япон Монгол хоёр нь эдийн засгийн хамтарсан түншийн хувьд хэтэрхий ялгаатай тааршгүй талууд юм. Японы жижиг үйлдвэрлэлийн ч сонирхлыг Монголын зах зээл татахгүй, эргээд Японы зах зээлийн сонирхох ганц ч зүйл Монголд үгүй. Хамтрагчийн хувьд соёлын хэт ялгаатай, нэг үгээр хэлэхэд Монголын үйлдвэрлэгчдэд Япон хэтэрхий ахдана.

Солонгос загвар

Солонгос бол XX зуунд дэлхийн тавцан дээр цойлон гарч ирсэн онцгой үзэгдлийн нэг. 1960 он гэхэд хүн амд ноогдох үндэсний орлогын хувьд Монголоос хэд дахин ядуу орон байжээ. Дэлхий дээр 70 орчим сая солонгосчууд байдгийн 40 орчим нь БНСУ-д амьдарч байгаа.

Түүхийн хувьд гол төлөв Хятадын вассаль явсан. Селлу, Корио зэрэг хүчирхэг династууд гарч ирж байсан боловч тухай бүрдээ урт насалж чадаагүй. Хятадын соёлыг эртнээс авсан нөгөө талаар энэ аугаа соёлыг Япон руу зөөгч гол үүргийг гүйцэтгэсэн. Япон, Хятадын соёлын аль үнэ цэнэтэйг эртнээс өөриймшүүлэнөөрийн соёлын сайн талуудыг нэмэрлэж, баттай тогтсон уламжлалтай болсон. Түүхийн турш хүчирхэг гүрнүүдын золиос болж байсны хувьд маш их эх оронч сэтгэлгээтэй.

Хятадын вассалиас гаруутаа Японы протектрат, колони болж хувирсан ба дэлхийн хоёрдугаар

дайн дуустал тэдэнтэй тэмцсэн, дайн дуусуут Солонгосын хойг хоёр хуваагдан сүүлд нь олон хэдэн жил үргэлжилсэн Солонгос-Солонгосын дайны гамшгийг амссан, дэлхий даяар хүйтэн дайн дуусчихаад байхад одоо болтол хүйтэн дайны аюул дор оршоор байгаа. Нэг л үгээр хэлэхэд зовлонг амсахаараа нэг болсон ард түмэн.

Зовлон нь энэ ард түмнийг босгож иржээ. Үнэндээ аль лүйлдвэржсэн, аль л эрдэс баялагтай хэсэг нь коммунистуудын мэдэл дэх Умард хэсэгтээ үлдсэн. Нэгэнт 38-р өргөрөгөөр таслагдсан тул БНСУ нь эх газраас таслагдаж үнэн хэрэгтээ хойг биш арал болжээ. Гэхдээ эргэн тойрондоо дайснаар хүрээлэгдсэн тун их эрсдэл аюултай арал! Урьдын дайсан Япон нь эдийн засгийн хамгийн ойр түнш нь болов. Гэвч япончуудыг түнш анд гэдэг утгаар нийгмийн сэтгэлгээ хүлээж авсангүй, үүнээс хойш хоёр үе өнгөрчөөд байгаа боловч өнөө ч энэ сэтгэлгээ амь бөхтэй оршоор. Солонгосчууд япончуудыг өдгөө дайсан биш гэхэд их сайндаа л өрсөлдөгч гэж хардаг. Монголчуудын хувьд хятадын эсрэг үзэл нь нэгтгэх нэг том хүчин зүйл байдгийн нэг адил солонгосчуудын хувьд японы эсрэг үзэл нь эрч хүч гаргах нэгэн эх сурвалж болой. Гэхдээ ялгаатай нь япончууд чадаж байхад солонгос хүн яагаад барахгүй байх билээ гэсэн жөтөөрхөл, шаралхалтай.

Өөрснөө хүлээн зөвшөөрөх дургүй боловч Японы технологийг цаг алдалгүй махчлан хуулдаг. Ялангуяа менежментийг нь. Өдгөө Японы инженер техникчид баасан гарагийн орой үй олноороо Солонгост нисч ирж буугаад хагас бүтэн сайнд өндөр үнээр ажиллан бөөн мөнгө өвөртлөөд даваа гарагийн өглөө Япон руугаа буцаж байна. Чухам энэ хоёр хоногт солонгосчууд Японы ноу хау-г “хууль бусаар” хахуульдан авч өөриймшүүлж байна гэсэн үг. Солонгосын дайнд энэ ард түмнийг америкчууд сүйрлээс аварсан. Чухам энэ нь нөлөөлсөн бололтой өдгөө Солонгос нь Азид Филиппины дараа хоёр дахь том Христосын ертөнц болжээ. Угаас энд күнз, будда, дао, зарим талаар шинто шашин хүртэл оролцоод холилдсон шашинтай орон байлаа. Харин дайнаас хойш христосын шашин улам эрчтэй түрж, ялангуяа залуу үе нь нэг төрлийн шүтлэгтэй болж байна.

Олон жил ядуу зүдүү, харийн эрхшээлд байсан шинэ тутам орны хувьд хүмүүсийн дийлэнх нь сэтгэлгээний хувьд Европ, Америк, Японтой харьцуулахад орчин үежиж амжаагүй байгаа. Дундаас доош давхрагын сэтгэлгээ нь хоцрогдсон, хулхи, хахуульсаг, хэт ази шинжтэй байдлаа хадгалсаар. Гэхдээ дээд зиндаа нь сэтгэлгээний хувьд маш хурдан өрнөджиж, итгэл сайн даахуйц худалдаа аж үйлдвэрийн түнш нэгэнт болж чаджээ. Иймдээ ч өнөөдөр дэлхийн тэргүүлэх 10 том эдийн засгийн нэг болж чадсан байна. Үүнийгээ 1988 оны Олимпын тоглолтоор баталгаажуулж, өдгөө манай гарагийн хамгийн баян хөгжингүй ертөнцийн нэр хүндтэй гишүүн боллоо.

Монгол, Солонгос ахан дүүс

БНСУ-ыг хүлээн зөвшөөрсөн гурав дахь коммунист улс нь Монгол юм. 1989 онд Унгар, Польшийн дараа тэр үеийн Батмөнхийн Засгийн газар ийм зоригтой алхам хийжээ. Үнэндээ солонгос, монголчууд энэ богино хугацаанд тэгтлээ ойртон нөхөрлөнө гэж хэн ч зүүдлээгүй. Дилломат харилцаа тогтоожөгснийг эс тооцвол ойртуулах талаар аль аль төр Засгийн газраас дорвитой алхам хийсэн нь үгүй. Энэ бол хар аяндааа өөрөө бүрэлдэн тогтож цааш хөгжсөн процесс. Өөрөөр хэлбэл санаачлага дээрээс биш доороос гарсан.

1993-94 оныг хүртэл хоёр орон биендээ төдийлөн ач холбогдол өгч байсангүй. Хандивлагчдын уулзалтанд Солонгос хойрго ханддаг байлаа. Хоёр орны төр Засгийн газрын харилцан айлчлал ч ёс төдий зүйл байв. Ялангуяа Монголын анхны ерөнхийлөгч Солонгост айлчлан Ро Дэ Ү-д төрийн хамгийн том одон гардуулсны дараахан огцорсон ерөнхийлөгч шүүхээр орон цаазаар авах ял сонссон нь асуудлыг эргэлзээтэй болгожээ. Магадгүй Хойд Солонгос гэсэн хүчин зүйлээс болж өмнөдүүд Улаанбаатарт элчин сайдын яамаа нээсэн байх. Монгол ч Сөүлд нийтийн орон сууцанд ёс төдий элчингийн байртай байв.

Гэтэл анхны хууль бус ажиллах хүчин Монголоос гарч Солонгост ажиллах боллоо. Эднийг Монголын төр ч явуулаагүй, Солонгосын төр ч хүлээж авья гээгүй. Солонгосчууд монголчуудад элэгтэй, өөрсдийгөө гарвал угсаа нэгтэй гэж үздэг. Энэ нь хөршдөө дургүй байдаг аль ч ард түмний зан. Хөрш биш газраас өөрсдийн домгийн сурвалжийг хайн муу хөршүүдтэй сөргүүлэн тавина. Монголчууд ч хэдийгээр түүхэн үнэн биш боловч өөрсдийн гарвалыг цаст Химлай, Төвдөөс хайдаг. Иймээс солонгосчууд монголчуудад маш элгэмсэг. Ойрмог түүхээсүзэхэд хоёр орны хаад ноёд хатан бэр солилцдог байжээ. Харин гарвал угсаа нэгтэй асуудал нь шинжлэх ухааны хувьд нэлээд эргэлзээтэй хэрэг юм.

Солонгосын зах зээлийн нөхцөл монголчуудад таарч байлаа. Энд юмны үнэ харьцангуй хямд, Япон, Евролынхтой харьцуулашгүй. Барааны чанар харьцангуй сайн, Хятадынхтай зүйрлэшгүй. Очиж ажиллахад хэдийгээр хууль бус боловч хүмүүс нь элгэмсэг. Царай зүсний хувьд хачин адилхан учир гадуурхагдах, илүү үзэгдэх юм үгүй. Япон, америкчууд шиг хэт хуульчлагдсан ертөнц биш учир аргалдаг, комбинаци хийдэг, амьдрах чадвар сайтай монголчуудад таарсан нөхцөл байлаа. Хоёр орны харилцаа өргөжихийн хэрээр нааш цааш явж суух харилцан зорчих, бараа таваар солилцох, арилжаа явуулахадөдөр өнгөрөх тусам улам хөнгөрч байв. Ингэсээр 2003 он гэхэд

Солонгост буй монгол ажилчдын тоо 23 мянга хүрчээ. Энэ нь Монголын иргэд гадаадад байгаа хоёр дахь том цэг (Казакстаны дараа), монгол үндэстэн төвлөрсөн дөрөв дэх том цэг (Орос, Хятад, Монголын дараа), Монгол улсын монгол үндэстэн байрласан гадаадын хамгийн том төвлөрөл болжээ. Өчүүхэн төдий хувь эзлэх төрийн шугамын солилцоо бий ба ихэнхийг нь хувийн хэвшил эзлэх хоёр орны бараа солилцоо худалдаа арилжаа аль хэдийнээ 100 сая доллароос хол давжээ. Зөвхөн Солонгост ажиллаж буй монголчууд жилдээ 80 сая долларын мөнгө, бараа үйлчилгээ хоёр орны хооронд гүйлгэдэг гэсэн тооцоо бий.

Улаанбаатарын машин паркийн дийлэнхийг солонгос машин бүрдүүлэх болов. Солонгосчууд ч Монголд бизнесийн идэвхтэй үйл ажиллагаа явуулах боллоо. Тэд гуанз ресторан, угаалга, машин техникийн үйлчилгээ зэрэг гадаад орнуудад хийдэг уламжлалт салбартаа их амжилт олж байна. Улаанбаатарт гадаадынхнаас хамгийн том коммюнитиг солонгосчууд буй болгожээ.

Даяаршил руу Солонгостой хамт урагшаа

Өнөөдөр манай залуусын нэлээдийнх нь хувьд Солонгос нь үлгэр дуурайлал, шүтээн нь болчихоод байна. Солонгос сериал шиг амжилт олж буй зурагтын олон ангит кино үгүй. Монголд өнөөдөр хамгийн тархсан хэл нь англи уу, солонгос уу (лав орос хэл биш болсон байх)? Залуусын дунд Солонгосын эстрад рок попынхон аягүй бол Америкийнхаас илүү

алдартай байж магадгүй. Монголд загалмайн шашныг сурталчилахад америкчууд гэхээсээ солонгосууд илүү үүрэг гүйцэтгэж байна. Залуусын өмсөж зүүсэн хувцасны маяг моод, үс толгойгоо янзалсан нь Парисынх гэхээсээ Сөүлийнх! Улаанбаатарын дэлгүүр хоршоо, гуанз үйлчилгээний газрын дизайн Хятадынх шиг гэхээсээ Хангүгийнх маягтай. Өөрөөр хэлбэл Солонгос маягийн амьдрах хэлбэр ялангуяа залуусын үлгэр болжээ.

Зарим нь муу хэлэх л байх, гэхдээ үүнд муу юм юу байгаа юм бэ? Хорвоо даяаршиж байна, бид хүссэн ч хүсээгүй ч даяаршилруу урагшилж байна. Бид даяаршилаас хөндий байх арга үгүй, гэхдээ үүнд ухамсартай бэлтгэлтэй орох нь туйлын чухал. Сэтгэлгээ, оюун, соёл урлаг, мэдээлэл, санхүү, менежмент, маркетинг, үйлдвэрлэл, сурган, анагаах ухаан, үйлчилгээ гээд бүхий л салбарууд дэлхий даяараа нийтлэг шинжийг олж байгааөнөө үед бид илүү ойлгодог, илүү сэтгэлд ойр, илүү дотно

Солонгостой улам дөтлөн даяаршиж болохгүй гэж үү?

Үндэсний баялаг бол хураасан алт мөнгө биш харин чөлөөт арилжаа, хүний өөрийгөө бодсон хувийн сэдэл болох тухай 230-аад жилийн өмнө Адам Смит сургасан. Үүнийг хорвоогийн түүх баталж байна. Байгалийн асар их баялагтай орнууд улам ядуурч өлбөрч байхад, дайны дараа нүцгэн хоцорсон, ямарч баялаггүй Герман, Япон, Солонгос улс өнөөдөр нийгмийн хамгийн их баялагийг бүтээжээ. Баялагийг олдоггүй, баялагийг бүтээдэг ажгуу. Баялаг газраас ухдаг алтнаас биш чөлөөт солилцоо, тархинаас гардаг сэдэлд байдаг. Гэтэл нүүдлийн хэвшил-коммунист сургаалыг олон жил мөрдсөн монголчууд меркентальч үзлээсээ огт салж чадахгүй байна. Иргэд нь баялагийн тухай ийм буруу ойлголт сэтгэлгээтэй байхад улс орны хөгжлийн тухай дэмий л нэг бурж болох юм. Чухам бидний меркентальч сэтгэлгээг өөрчлөхөд явж явж солонгосчууд л хамгийн их тус болно. Хээрийн галуу нисэн үл хүрэх алс Солонгосоос монгол хүний хүү мөнгө хийх арга, сэтгэлгээ ойлголт өвөртлөн ирж байна.

Судлаачдын тооцож байгаагаар ойрын ирээдүйд Зүүн Хойд Ази нь дэлхийн хамгийн хүчирхэг хөгжлийн төвлөрөл болох аж. Зүүн Сибирь, Алс Дорнод, Зүүн хойд Хятад, Хоёр Солонгос, Японыг хамарсан энэ бүсд ойрын гучин жилд 30 триллион долларын хөрөнгө оруулалт орж ирнэ гэж тооцоолж байна. Энэхүү аварга интеграцид орох, хавчуулагдаж авах нь Монголын ирээдүйн хөгжлийн магадгүй цорын ганц шаанс, цорын ганц боломж. Солонгостой ойр дотно ах дүү бололцсон дараа үеийн монголчуудад энэхүү бүсчлэл, интеграцид багтан орж хөгжлийн дээд эрэмбэ рүү тэмүүлэхэд илүү дөт, илүү амар байх болно.

Бид өнгөрсөн зууны турш Орос, Хятад, Япон, Америктай төрийн холбоотой байлаа. Төрийн холбоо гэдэг илүү хэврэг, бодит хөрсгүй байдгийг олон жишээн дээр хэлж болно. Тэгвэл сүүлийн арваадхан жилийн дотор Солонгостой тогтоосон холбоо, найрамдал, хамтын ажиллагаа маань илүүтэй хүмүүс, гэр бүл, хувийн хэвшлийг хамарсан илүү амьд илүү давшингуй байгааг үл анзаарч боломгүй.

Энэ хорвоо дээр жам ёсны юм гэж байдаг. Байгалийн хууль болгон жам ёсных. Харин нийгэмд үйлчилж байгаа дэг жаяг, зан заншил, хууль ёс болгон жам ёсных байж чаддаггүй. Ялангуяа төр зохицуулаад л, төр санаачлаад л, төр удирдаад ирэхээр л юм болгон нь жам ёсных бус болдог. Жам ёсны бус байхаараа хөгжих, үргэлжлэх, дэвжих газаргүй болон, дэндүү

хиймэл болж энэ нь харин эрт орой алин боловч ёстой жам ёсоороо “үхдэг”. Хүний нийгэм дэх жам ёсны зүйл хувь хүн, гэр бүл, хувийн өмч, хувийн хэвшлээс үүдэлтэй байдаг. Сэдэл чухам хувь хүний эрх ашигтай яв цав нийцэж байж л жам ёсны болно. Хувийн сэдлээс эх авсан, нэгэнт бий болон хэлбэршсэн жам ёсны зүйлийг улам хөхүүлэн дэмжих нь л төрийн үүрэг. Ийм төртэй улс орон л жамёсоороо баялагт хүрдэг билээ.

2003.02.26

Сарсанд сарьслуулж болохгүй

SARS хэмээн нэрлэгдсэн нэгэн төрлийн айхавтар өвчин гараад дэлхий нийтийг цочирдуулж байна. Энэ өвчин гарсан газар руу хүнээ явуулахгүй гэж улс бүр иргэдээ ятгана. Одоо Монгол улс найман тохиолдлоор дэлхийд 8-р байр эзэлж байгаа ба долоон тохиолдлоор ард нь Герман явна. Хөөрхий төвдүүдэд халдаачих вий хэмээн хятадууд тохиолдол гараагүй Төвд рүү хүртэл жуулчин явуулахгүй хорьчих юм.

Өвчнөөр далимдуулж Засгийн газрыг яллах өчүүхэн ч бодол алга, харин ч нийтлэг зовлон тохиосон тул Засгийн газраа дэмжье гэж уриалах гэсэн юм. Гэхдээ алив төрийн үндсэн хэдхэнүүргийн нэг нь чухам ийм халдварт хөнөөлт тархацаас ард иргэдээ эрүүл мэндийн хувьд ч, эдийн засгийн хувьд ч хамгаалах явдал мөн. Монголын төр үр дүнтэй, шийдвэртэй арга хэмжээ авч байсан сайн туршлага бий. 1944 онд Завхан аймагт дэгдсэн уушигны тахал, 1996 онд Хөтөлд гарсан хижиг өвчин нь энэхүү SARS-аас ч аймшигтай гоц халдварт өвчин, дорвитой арга хэмжээ авсны үр дүнд ул мөргүй дарж авсан билээ.

Сүүлийн үеийн судалгаагаар энэ өвчин уушигны тахал шиг агаар дуслын замаар халдах магадлал нь бага, гол нь А гепатитын нэгэн адил бохир гар, заваан орчингоор илүүтэй халдварлаж байгаа гэнэ. Тиймдээ ч ахуйн ариун цэвэр сайтай Япон, Солонгост ганц ч тохиолдол бүртгэгдээгүй байхад угаас ахуйн соёл муутай хятадуудын дунд хүчтэй дэгдэж байна. Сургууль цуглах болон шинэ жил, цагаан сар, мартын дараа манайд шар өвчний дэгдэлт хүчтэй болдгийг эмч нар сайн мэднэ, энэ маань бидний ахуйн ариун цэвэр аль зэрэг төвшинтэй болохынүнэмшилтэй баталгаа.

1. Ган зуд болсон ч, SARS, шүлхий гарсан ч нэг их гавьяа байгуулчихсан юм шиг орчлонгоор нэг зарлаж мөнгө горьдож байхаа болимоор юм. Зовлонгоо тоочиж олох мөнгө маань жамаараа орж ирэх байсан хэдэн арав дахин их үнээртөгтэй бизнесийг алж байгааг олж харахад тийм ч төвөгтэй биш.

2. Ялангуяа иймэрхүү олон нийтийг хамарсан өвчний дэгдэлтийн үед авч байгаа арга хэмжээ төгс, тууштай, үр дүнг нь заавал гаргахад чиглэмээр байна. SARS гарлаа гэхээр соотогонож баахан дуулиан тарьчихаад долоо хоногийн дараа мартчихаар ямар үр дүн гарах вэ дээ. “SARS гарсан тул манайх 10 цагаас хойш ажиллахгүй, иймд 6-10 цагийн хооронд Ю Би Пааласдаа ирж наргицгаана уу” гэх зар нь авч байгаа арга хэмжээний жинхэнэ мөн чанарыг илтгэнэ. SARS-ын короно вирус Улаанбаатарын цагаар арав нойл нойлд сэрээд “ажилдаа гардаг” гэж хэн ч батлаагүй байгаа шүү дээ. SARS зарим захаар ордог, заримаар нь ордоггүй гэдэг ч худлаа. Нэгэнт Бээжин шиг хааж дийлэхгүй бол ахуйн соёлын өндөр шаардлага тавьсан нь илүү өгөөжтэй биш үү!

3. Өвчнөөс болж учрах эдийн засгийн хүндрэлээ одооноос тооцож түүндээ бэлдмээр байна. “Хөсрий зуд болоогүй бол алаад хаях байсан юм!” гэдэг шигээ хойтон жил бүх бүтэлгүй юмаа SARS руу заагаад зогсож баймааргүй байна. Зөвхөн

5-р сард ирэх байсан хэдэн зуун жуулчин татгалзчихлаа. 8-р сард жуулчиллын оргил үе

болдог. Одоо арга хэмжээ авч цэвэр цэмцгэр болсноо яаралтай зарлахгүй бол хүндрэнэ дээ. Торонто, Хонконг хотууд өөрсдийгөө САРС-аас өмнөхөөс цэвэр цэмцгэр болсон гэж зарлан, хүн үнэмшгэл сурталчилгаа явуулаад эхэллээ. Хэдхэн хоногийн дараа “Улаанбаатар л аюултай болохоос манай Бээжин зүв зүгээр болсон” гээд Синхуа агентлаг зарлаад унавал яана! “Тэртээ тэргүй Монголд зочлох жил зарлачихсан” гээд хүлээгээд хэвгэж байхаар ахиухан хөрөнгө гарган яаралтай арга хэмжээ авч ядахнаа ноднингийн хэмжээний жуулчин хүлээж авья, бага хохиролтой гаръя гэсэн тактик баримтласан нь дээр бусуу?

4. Зовлонгийн үр дүнтэй нь биш шалтгаантай нь тэмцмээр байна. Буруу газар руу сэлэм бариад дайрвал тэмээн дээр ямааны гарз гарна. Ашгүй өвчин гарлаа, юмныхаа үнийг нэмээдэхье гэж хэн ч бодоогүй. Зах зээл жамаараа л явж байгаа. Үнэ нэмэгдэж байгаа нь өвчинтэй холбоотой ньүнэн. Хил хаагдчихаад байхад аргагүй шүү дээ, Хавар болж байхад аргагүй шүү дээ. Үүнтэй холбогдуулан зах зээлийг зохицуулах гэж хөндлөнгөөс нь оролцвол эцэст нь ард түмнээ л хохирооно, эдийн засагт л муугаар нөлөөлнө. 1994 оны зун мах ховордлоо гээд Засгийн газраас махны доод үнэ гэгчийг 500 төгрөг гээд зохиочихсон чинь кг нь 350 төгрөг байсан мах хоёр хоногийн дотор 1000 болж нэмэгдсэн.

Үүнээс болж ард түмэн л хохирсон гэдгийг тэр үед Засгийн газрын гишүүд байгаад өдгөө эргээд ирсэн нөхдүүд сайн л мэдэж байх учиртай даа.

5. Өвчнөөр далимдуулж үзэл сурталжих хэрэггүй (Одоо болтол хэн ч тэгээгүй байгаа л даа). Өвчинтэй тэмцэхэд чиглэсэн Засгийн газрын алив арга хэмжээг улс төр олон нийтийн аль ч байгууллага дэмжин ажилламаар байна. Засгийн газарч өвчнөөр далимдуулж үзэл сурталжин ялархмааргүй байна. Энэ бол биендээ ялархах, биенээ яллах шалтгаан биш, биднийг бүгдийг нь хамарсан зовлон. Зовлонг хамтарч сөрж байж зовлонгийн шалтгааныг арилгана. Үүнийг өөрийгөө буддист гэх болгон цээжээрээ мэдэж байх учиртай.

2003.05.07

Persona non grata

Франц-Монгол нь түүхэн уламжлалт харилцаатай улс. Өлзийт хаан Францын хаанд захидал явуулж байжээ. Францын гэлэн Карпини Ромын папын зараалаар Монголд ирж Гүег хаантай уулзаж байв. Хархорум хотын алдарт мөнгөн модыг XIII зуунд алс Францаас ирсэн Вилхэльм дархан урласан байдаг.

XVII-XIX зууны үеэс Франц нь монгол судлалаар Оросын дараа орохуйц төв болжээ. Монгол судлаач нэрт эрдэмтэн Грүссэ Францын академийн гишүүнээр сонгогдож байв. Францын академийн гишүүн хэмээх нь тоотой хэдхэн эрдэмтэд байдаг гээд бодохоор шинжлэх ухаан хөгжсөн тэрхүү оронд монгол судлалыг хэрхэн өндөрт тавьж буй нь харагдана.

Хоёр орны харилцаа коммунист Монголын өнгөн дээрээс л нэг л бүтэл муутай. Уг нь далаад оны дундуур Франц нь Монголд элчин сайдын яамаа ажиллуулсан НАТО-ийн хоёр дахь гүрэн болжээ. Сайд нь Улаанбаатар зочид буудалд сууна, цонхоор нь төрийн туг нь мандана. Сайд ажлаа тараад ганц бие хүн болохоороо гадуур жаахан дардаг юм биз дээ. Харин манай До яамнынхан хүүхэмсэг түүнд зориуд өнгөний өвчтэй хүүхэн “шургуулж” авчээ. Өвчин авсан эсэхээ мэдээ ч үгүй байсан түүнийг Гадаад яаман дээр дуудаж авч ирээд “өнгөний өвчтэй болсныг чинь зарлана, эсвэл манай талд зүтгэдэг коммунист тагнуул бол” гэж тулгажээ. Гэтэл элчин сайд хүзүүгээ зурж заагаад “миний үүнээс дээших нь Францын төрд хамрагдана, харин дооших хэсэг нь надад хамаардаг юм” гэхийг гараад явсан байна. Энэ бол ядуу, тэнэг дээр нь коммунист бүдүүлэг орны зүгээс нэр төр гээч юмыг бүхнээс дээгүүр тавьдаг эрхэмсэг Франц орныг, түүний төрийг доромжилсон хэрэг байлаа.

Франц Монголоос элчин сайдын яамаа татан авсан төдийгүй ГХЯ нь Монголыг олон жил занасан. Чухам ардчилсан төртэй болсон гэж хамаг бурууг коммунистууд руу чихэж байж, Бямбасүрэн гуай Францад айлчилж байж арай гэж мөнөөх булай хэргийг мартагнуулсан билээ. Гэтэл дахиад л монголчууд мундраа хутгалаа. Дээрх хөгийн ажиллагааг гардан зохион байгуулдаг нөхөр өнөөдөр До яаманд том алба хашиж байгаа шүү дээ. Энэ удаа түүний дарга Нямдорж л зохион байгуулчихлаа. Францаас хүн хулгайлж авчирчээ. Гадаад хэргийн яам энэ ажиллагаанд ухамсартай оролцов. Газар дээр нь зохион байгуулагч нь Нямдоржийн нэг ангийн найз, түүний гуйж дэвшүүлснээр элчин сайд болсон нэг нөхөр. Хулгайлагдсан хүнд ГХЯ хуурамч дипломат паспорт гаргаж өгсөн. Хулгайлсан хүнээ хорт бодисоор муужруулан гурав дөрвөн орны хилийг хуурамч дипломат паспортоор гул барин дамжуулан зөөжээ. Хэрэг мандаад ирэхээр хамаг бурууг элчинд ажилладаг нэг жаахан охин руу чихчихлээ. Тэр нь зайлуул пэрсон нон грата буюу “яажч магадгүй этгээд” гэсэн латин нэртэй “хүндэт цолыг” Францын

Гадаад яамнаас хүртээд туугдаж ирэв.

Женевийн гэрээгээр улс орнууд дипломат хүрээнд биендээ онцгой эрх ямба эдлүүлдэг. Нэг үгэндээ итгэл хүлээлгэдэг. Ачаа барааг нь шалгахгүй, баривчилж байцааж эвгүй байдалд оруулахгүй гэх мэт. Манайхан сүүлийн үед итгэмжлэх жуух бичгээ барихдаа дээл өмсөж гангардаг болсон, дээл нь хэт хутгагүй бол болохгүй, хутгатай хүнийг төрийн тэргүүн рүү

ойртуулдаггүй боловч мөнөөх дипломат итгэлийнхээ хүрээнд хаана ч оруулж л орхидог. Итгэл даагаагүй ямба эдлэгчийг пэрсона нон грата буюу тааламжгүй этгээд гэж зарлан нутаг орноосоо хөөдөг. Энэтхэгт хүн дайрч алчихаад, Хойд Солонгост удирдагчийнх нь тухай буруу утгатай шүлэг зохиочихоод, Нью Йоркод эхнэртэйгээ алалдан алдтлаа зодолдоод энэ цолыг хүртэн хөөгдөж ирсэн тохиолдол урьд гарч байсан. Сүүлийн үед тамхи, архи хулгайгаар зөөж байгаад баригдан туугдагдагсад ч нэлээд гарсан. Харин олон улсын террорист маягийн ийм өөдгүй шившигтэй хэрэг тарьж байсан нь арай үгүй. Дарангуйллындэглэмийн хоцрогдсон орнынхон л иймэрхий юм хийж баригдан шившгээ хутгаж байлаа.

Пэрсона нон грата гэж зарлахад юуны учир яагаад гэдгийг нь тайлбарладаггүй нэг хатуу журам бий. Ийм дэг жаяг байдаг болохоор Францын Гадаад яам ч мөнөөх сайдынхаа өмнөөс хэлмэгддэг консулыг хөөсөн шалтгаанаа тоочсонгүй. Уул нь элчин сайдыг нь хөөх учиртай байсан ч, харин ч зөөлөн хандаж консул дээр нь буужээ. Гэтэл Монголын Гадаад хэргийн сайд зөөлөн хандсан, шалтгааныг нь зарлаагүйг далимдуулж “хүн хулгайлсан асуудалтай огт холбоогүй” гэж ичих нүүргүй тууж байх юм. Тэгэхээр яалаа гэж хөөгдсөн байх нь вэ? Тамхи архи хулгайгаар зөөж байгаад хөөгдсөн гэх эрүүгийн шинжтэй гэмт хэрэг рүү эвтэйхэн түлхэж байх шиг байна. Сүүлийн үед “та нарт хүний нүнжиг гэж байна уу?” гэж асуух дуртай болсон Нямдоржоос энэ асуултыг өөрт нь эргүүлж тавимаар.

2003.10.26

Лалынхан биднийг хашраах болов уу?

1954 оны Женевийн хэлэлцээрийг зөрчин коммунист Вьетнам

Өмнөд рүүгээ төдийгүй, Лоас, Камбож руу өнгөлзөж эхэлжээ. Орос , Хятад хоёр үүнийг нь өөгшүүлнэ. Коммунизмын аюулаас айсан ерөнхийлөгч Эйзенхауэр цөөхөн цэрэг тийш нь илгээв. Дараа нь ерөнхийлөгч болсон Кэннеди нилээд олон цэрэг явуулжээ. АНУ-ын хувьд Зүүн Өмнөд Азид газар нутаг түүхий эдийн ямар ч ашиг сонирхол байсангүй. Гэвч Солонгосын дайн коммунизмын аюулыг нэг мөсөн харуулж өгсөн ба, хэрэвзээ энэ дайнд Америк ороогүй бол хүн төрөлхтний иргэншилд аюул учрах байлаа. АНУ Солонгосын хойгт эрх чөлөөг төдийгүй өөрийнхөө геополитикийг аварч гарсан юм.

Солонгосын дайны зөвтгөл нь АНУ-ыг Вьетнам руу татан оруулжээ. Үзэл санааны хувьд АНУ-ын зөв байсан боловч тэд Вьетнамд гүнзгий шаварт суусан юм. Дайн олон жил үргэлжилж хэдэн зуун мянган америк дайчид амь насаа алдлаа. Дотоод гадаадын эсэргүүцэл туйлдаа хүрлээ. Дэлхийн нийтийн өмнө Хо Ши Миний дэглэм зөв харагдаж эхлэв. Жонсоны дараа ерөнхийлөгч болсон Никсон энэ дайныг зогсоох гэж долоон жил хүч гаргасан юм. Дайн Америкийн ялагдлаар дууссан. Вьетнамаас энхийн хэлэлцээрээр цэргээ гаргасан боловч Умартын коммунистууд 1975 онд Өмнөдөө эзэлдэгээрээ эзэлж, Лаос, Камбожид коммунист дэглэм тогтоолоо.

Иракт америкчууд дахиад гүнзгий шаварт суучих шиг боллоо. 2001 оны 9-р сарын 11-ний террорист халдлагын хариу болгож муу муухайн үүр талибаны Афганистанд богино хэмжээний амжилттай байлдааныг дэлхий нийтийн алгаташилтын дор гүйцэтгэлээ. Солонгосын дайны синдромоор Вьетнамд бодлогогүй орсны нэгэн адил Афганистаны хөөрлөөр Иракт “амжилттай” дайн явууллаа. Шийтийн өлгий, күрдүүдийн овоолго, Ираны дайсан Ирак нь Саддамын дэглэм дор ямар нэг эмх замбарааг хадгалаад байж чаджээ. Өнөөдөр Ираkyг эзэлсэн америкчуудын эсрэг күрдүүд, шийтүүд, суннитууд, иранчууд, Аль Кайда, палистинчууд, сиричүүд, пацифистууд, лалын ертөнц бараг тэр чигээрээ, Саддамын дэглэмийг талархагчид, тэр байтугай эсэргүүцэгчид, Америкийн өөрийн холбоотнууд нэгдэж эхэлж байна. “Өө, алдаа байж, одоохон цэргээ гаргачихъя” гэж болдоггүйгээс хойш америкчууд шавар дотроо хий эргээд л.

Иракийн дайныг өөрийнх нь гол холбоотон Франц, Герман болон, дэлхийн бодлогыг тодорхойлолцдог Хятад, Орос эсэргүүцлээ. Үнэнч нөхөр Япон, Солонгос хүртэл тийш цэргээ илгээхээс цааргалан худал үнэн шалтаг тоочино. Асар их мөнгө амлагдсан Түрэг бодож бодож цэргээ оруулчихсан чинь шанг нь мөн айхавтар хүртэж байна аа! Лалаас уравсан нүгэлтнийг гэгсгээж байгаа нь тэр. Саддамд байгаа гэж гүрийгээд байсан хөнөөлт зэвсэг нь олдож өгөхгүй байгаа учир АНУ-ын нэр нүүрийг бүр ч баллаж байна.

Монгол улс өнөөдөр формалиар дайны байдалд байгаа улс. Бид АНУ-ын холбоотон, тэдэндээ “туслах” гэж шаварт суусан газар руу нь цэргээ илгээсэн. Холбоотон л бол холбоотон, хөөрхий монгол цэргүүд Ираkyн сэргээн босголтонд оролцон хөлсөө дуслуулж байшин барьж байгаа юм гэж хэн ч үзэхгүй. АНУ-тай холбоотон болсон орныг хашраах ажиллагаа

эхэллээ. Дэлхий дээр хамгийн амгалан, хамаг юм нь салан задгай, улайм цайм сүх далайхгүй л бол тайван хэвээд хэвтэж байдаг газар бол Монгол. Сүүлийн хэдэн жил Монголд хамгийн их зөрчил гаргадаг хүмүүс арабчууд. Шонхор агнах гэж байгаа гээд олноороо ирдэг. Гэр бүлээрээ визгүй орж ирчихээд удсан тохиолдол ч бий. Монголд Зөвлөлтийн цэргийн үлдээсэн сум, тэсрэх бодис бүтэн Улаанбаатарыг үнсэн товрог болгохуйц ихээрээ хадгалагдаж байгаа учир гаднаас зөөж авчрах шаардлагагүй. Саяын Станбулын дэлбэрэлтэнд түрэгүүд өөрснөө оролцжээ. Түрэг хэдийгээр

НАТО-ын орон боловч лалын тулгар үзэлтнүүд нь хүчтэй, нэг удаа бүр засгийн эрх ч авч байсан. Манайд түрэгээс олон юм байхгүй.

Гадаадад суугаа элчин сайдын яамдуудад аюулгүй байдлын санхүүгийн заалт байдаггүй. Дуртай нь өдөр шөнийн аль ч цагаар сэлгүүцэхэд хэн ч юу ч хэлэхгүй. Бүх юм нь салан задгай. Нэгэнт цэрэг оруулах хэлэлцээр хийсэн юм бол аюулгүй байдлаа хангах зохих санхүүжилт амлагдсан баймаар. Эсвэл түүнийг нь аваад Худалдаа хөгжлийн банкны хөрөнгө оруулалт руу туучихсан юм болов уу? Онцын хэрэгцээгүй газар элчин сайдын яамаа түр хугацаагаар хаагаад гарсан мөнгөө бусад элчингийнхээ аюулгүй байдал руу хиймээр юм шиг.

Бодлогогүй, хойшлогогүй юм хийдэг эрх баригчдыг зэмлэх гээгүй, ямар ойлгох юм биш. Харин хашраах ажиллагаанд хамрагдвал өөрснөө үхэж магадгүй шүү, Төрийн ордны дэргэд тэсрэх бодистой машин тавьчихаад тэр нь дэлбэрвэл бөмбөгний хэлтэрхий хүнийг эрх мэдэлтэй мэдэлгүй, эх орноо хөгжүүлэх гэж байгаа гэх мэтээр нь ялгалгүй оночихдог, ихэнх тохиолдолдхүүлчихдэг бололтой юм билээ.

2003.11.24.

Зүүн хойд азийн хөгжлийн банк

Зүүн Хойд Азийн эдийн засгийн чуулга, Зүүн Хойд Азийн эдийн засгийн бага хурал гэсэн хоёр байгууллагаас хамтран зохиосон хурал Японы Ниигата хотод энэ 2-р сарын 2-4 өдөр болж өнгөрлөө. Хурлын гол авч хэлэлцсэн асуудал нь нэгдүгээрт Зүүн Хойд Азийн хөгжлийн банк байгуулах тухай, хоёрдугаарт бүс нутгийн зам харилцааны асуудал аж.

Энэ бүс нутаг өнөөгийн дэлхийн хамгийн ирээдүйтэй газарт тооцогдож байна. Бараг л хэмжээ хязгааргүй хурдтай өсөж байгаа зах зээлүүд түүнтэй зэрэгцсэн бас л бараг хэмжээ хязгааргүй түүхий эд энэ бүсэд байгаа ба анх удаа хоорондоо уулзан учрах нөхцөл бүрдээд байгаа билээ. Өнөө болтол хүйтэн дайн үргэлжилсээр байгаа, цэргийн хамгийн их төвлөрөл оршоор байгаа авч энэ нь цаг зуурын асуудал, ойрын хугацаанд шийдэгдэнэ гэдэгт бүгд итгэл төгс байгаа учир дараа дараагийн ажилдаа шуударчээ. Зүүн Хойд Азид ойрын 30 жилд 30 триллион долларын хөрөнгө оруулалт орж ирнэ гэж судлаачид таамагладаг.

Чухам энэ их хөрөнгө оруулалтын хаялага бидэн дээр зах сэжүүрээрээ ч болов дайраад өнгөрвөл манайх шиг өчүүхэн зах зээл сэргээд л ирнэ гэсэн үг.

2020 он гэхэд Япон Солонгос хоёрыг холбосон далай доогуурхи суваг яригдаж байна. Манайд Японыг төлөөлж элчингээр сууж байсан Канада гуай гэхэд өнгөрсөн хоёр жил хийсэн судалгаандаа үндэслэн Оросын Зарубино, Хятадын хүнчин боомтуудыг ашиглан Япон тэнгисээр дамжуулж зам харилцааны гол гудам гаргах тухай сонирхолтой илтгэл тавилаа. Цаашлаад хийн болон нефтийн хоолой, эрчим хүчний нэгдсэн сүлжээ гээд маш олон асуудал хөндөгдөнө.

Энэ бүх хөрөнгө оруулалт асар том мөнгө шаардах нь гарцаагүй. Энэ хөрөнгө оруулалтанд зориулсан хөгжлийн банк хэрэгтэй тухай Ниигатагийн хурал дээр нэлээд ярилцсан хэрэг.

Сонирхолтой нь ийм банк байгуулах анхны санаа Улаанбаатарт төрсөн. Юу гэвэл 1997 онд Улаанбаатарт болсон Зүүн Хойд Азийн эдийн засгийн чуулга дээр асуудал анх тавигджээ. Асуудал улам гүнзгийрэн явсаар гол гурван орон Солонгос, Япон, Хятадын засгийн газраар удаа дараа хэлцэгдсэн ба энэ хооронд уул хөгжлийн банкны төвийг Хятадын Тяньжин хотноо байгуулахаар нэгэнт тогтлоо.

Төслийг биечлэн удирдаж зүтгүүлж яваа хүн болох Азийн хөгжлийн банкны дэд захирал байсан Кац гуай асуудлыг ингэж тавьж байна:

1. Эдийн засгийн хөгжлийн гол цөм нь дэд бүтэц яах аргагүй мөн.
2. Зүүн Хойд Азийн бүс нутгийг дамнасан дэд бүтцийн хөгжил өнөөдөр тун дорой байгаа. Үүнийг хөгжүүлэхийн тулд олон улсын хөгжлийн санхүүжилт гарцаагүй шаардлагатай.
3. Энэ сүлжээг буй болгохын тулд жилд дор хаяж 7,5 тэрбум доллар хэрэгтэй. Хөгжиж байгаа орнууд ийм их мөнгийг эсвэл Дэлхийн банк маягийн олон улсын санхүүгийн институтээс, эсвэл OECD маягийн хоёр талын гэрээний дагуу зээлж хэрэглэдэг тогтсон уламжлалтай.

4. Одоо байгаа байдлаас үзвэл Олон улсын санхүүгийн институт, OECD –ээс жилд их бодож л 2,5 тэрбум доллар гарах бололцоотой, цаана нь 5 тэрбум доллар сох дугааж байна.

5. Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкинд Зүүн хойд Азийн дэд бүтцийн хөгжилд зориулсан “тусгай фонд” байгуулах замаар явж нэг болох боловч энэ нь хязгаарлагдмал, нөгөө талаас удаан хугацаагаарүргэлжлэх боломжгүй.

6. Иймээс бие даасан Зүүн Хойд азийн хөгжлийн банк байгуулах нь хамгийн зөв гарц мөн. Энэ банк хоёр талын, олон талын, төрийн, хувийн бүх хэлбэрийг нэгтгэсэн, хөрөнгө оруулагч бүх талд ашигтай, хандсан тодорхойчиглэлтэй байх болно.

Банк байгуулагдах шатандаа явж байна. Үүнээс Монгол улс яавч хоцорч болохгүй. Ойрын 30 жилд орж ирэх 30 триллионы “хишгээс” ч, бүс нутгийг холбох аугаа дэд бүтцээс ч, энэхүү банкнаас ч дөлөөд байвал эцэст нь биднийг хэн ч тоохгүй. Монголд ямар сонгууль болоод, ямар засаг нь гарч ирнэ тэдэнд падлийгүй, үүнийгээ ч бид өвөр зуураа Зүүн Хойд Ази бол Монгол орны ирээдүйн хөгжил цэцэглэлийн баталгаа хэмээн ойлголцож энэ бүс нутгийг хэн нэгэндээ “өмчлүүлэлгүй”, “жийрхэлгүй” ухаалгаар хамтран ажиллах хэрэгтэй юм.

2004.02.09

Солонгосын түүхэн туршлага- бидний дуурайл

Генерал Пак Жон Хи 1960-аад оны эхээр Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч боллоо. Энэ орон тэр үед дэлхийн хамгийн ядуу орны нэг байв. Дэлхийн дайн аль 45 онд дуусаад улс орон бүр дайны шархаа эдгээж, аниулж байхад Солонгос гурван жилүргэлжилсэн иргэний дайны сүйрлийн яг дараа байлаа. Дайнөдөөсөн умардын коммунистууд илүү үйлдвэржсэн, илүү баян, цэрэг зэвсгийн хувьд ч дахин айлгасаар байлаа. Тухайн үеийнүндэсний баялгийг нь хүн амд нь хуваахад тэр үеийн Монголоос гурав дахин ядуу байлаа. Умардуудаасаа хэд дахин ядуу, гуйлгын тулам. Гадагшаа хийдэг ганц наймаа нь биеэ үнэлэгчид, амьд хүүхэд. Юу гэхээр 60-аад он хүртэл Солонгос нь амьд хүүхэд хулгайгаар гадагш нь экспортолдог хамгийн том орон байж энэ төрлийн гэмт хэргээр дэлхийд хосгүй, толгой цохиж байв. Дайндөнчирсэн хүүхэд ч их байж, түүгээр бизнес эрхлэгчид ч олширч.

Пак улс орноо хөгжүүлэхийн тулд юун түрүүн ард иргэдийнхээ үндэсний ухамсрыг сэргээж, эх оронч үзлийг нь хурцлахаас ажлаа эхэллээ. “Ойрын таван жилд Умард Солонгосыг гүйцье” гэсэн уриаг дэвшүүллээ. “Амьд хүүхэд хулгайгаар гадагш гаргаж ертөнцийн булай болж байхаар тоглоомон хүүхэлдэй гадагш экспортолж хорвоогийн сайшаалыг хүлээе” гэсэн уриаг шууд хэрэгжүүлж эхэллээ. Хүүхдийн тоглоомын зах зээлийг судалж, энэ талын мэргэжилтэн бэлтгэхэд ихэд анхаарч, энэ чиглэлээр үйлдвэрлэл эрхлэгчдийг хөхиүлж гарлаа. Гол нь энэ нь нэр төрөө бодож, муухай нэр хочноос салъя гэсэн тэмүүлэл байв. Гэтэл далаад оны сүүлчээр Солонгос нь хүүхдийн тоглоом, тэр дундаа хүүхэлдэйнэкспортоор дэлхийд нэгд орж бүх зах зээлийг нь гартаа оруулчих нь тэр. Солонгосчууд муухай нэрнээс салсан төдийгүй нэг зүгчигт үндэстнээрээ санаа зоригоо нэгтгэвэл амжилтад хүрчболохыг өөрсдийн нүдээр харлаа.

Далаад он гэхэд умардынхнаасаа хавьгүй урагшаа гараад ирлээ. Ингэнгүүт тэдний түүхэн өрсөлдөгч өширхөгч япончуудтай зах зээл дээр “энх тайванчаар” тэрсэлдээд үзвэл яасан юм гэсэн бодол төрлөө. Ялангуяа гэр ахуйн техник хэрэгслэлээр дэлхийн зах зээлийг эзэлсэн япончууд хөгжлийн дараагийн шат руу орж илүү нарийн зүйл, тухайлбал автомашинүйлдвэрлэл рүү хүчтэй түрж эхэллээ. Ингэнгүүт япончуудын анхаарал сулраад эхэлсэн гэр ахуйн электрон бараа руу дайран Хондатай ижил Хьюндай, Санёотай адил Самсунг, Жи Ви Си-тэй ижил Жи Эс гэсэн компаниуд байгуулан, гадагш зах зээл дээр гарахад нь төрөөс бодлогоор дэмжин түлхлээ.

Гурав дахь дайралтыг 1990 онд дэлхийн коммунист систем задрах үед хийв. ЗХУ болон Зүүн Европ, Хятад гэсэн “эзэнгүй” аварга том зах зээл сулраад ирлээ. Япончуудыг хуулж дагаж хорин жил явсан солонгосчууд багшаасаа илүү хөнгөн шаламгай, овсгоотой болоод авчээ. Хуучин коммунист байсан, гэнэт суларсан зах зээл рүү чухам солонгосчууд хэнээс түрүүн довлон орж, сэхээ өгөлгүй хамгийг нь эзэлж орхив. Америк, Япон, Европын үйлдвэрлэгч нарт бараг юу ч үлдээсэнгүй. 1988 онд Олимпийн наадам өөртөө зохиож, гуравдугаар ертөнцийн орон гэдэг басамжилсан хаягаасаа албан ёсоор гаран, дэлхийн хамгийн хөгжингүй орнуудын эгнээнд орлоо.

Одоо эргээд харъя. Солонгос үндэсний нийт баялгаараа дэлхийд 11-т орно. Аварга Орос улс

XVIII байранд байгаа шүү. Нэг хүнд ногдох үндэсний орлого 12 мянган ам.доллар. Харин гүйцэж түрүүлэх юмсан гэж мөрөөдөж байсан умардын ах дүү нар нь тэднээс 60 дахин ядуу. Гуйлгачин ядууг нь шоолж байн байн “Тоншуул” сэтгүүлдээ матарлаж зурдаг байсан монголчууденөөдөр тэднээс 30 дахин ядуу. Энэ хооронд ердөө 40 жилөнгөрчээ.

Ард түмэн арга эвээ олж, үндэсний бахархлаа буй болгожчадвал баялгийг бүтээж болдог аж. Сайн, тод жишээ нь солонгосчууд. Бид араас нь дуурайж дагаж, үлгэр жишээгээ болгож хөгжлийн тавцан дээр гаран баялаг бүтээцгээе. Солонгосчуудыг дуурайя. Гэхдээ Умард Солонгосыг биш шүү!

2004.06.15

Ардчилал эрх чөлөөний үзлийн гол тээгч нь соёл МӨН

Бжэжински (Brrzezinsky) Шатрын их хөлөг (Grand Chessboard) зохиолдоо хүн төрлөхтний түүхэнд Дэлхийг хамарсан дөрвөн том эзэнт гүрэн байсан тухай тэмдэглэжээ. Эзэнт гүрнүүд оршин тогтнож байсан өөрийн арга барил, онцлог шинжтэй байсан аж. Ромын эзэнт гүрэнд иргэншлийн төвлөрөл нь татах цэг болж байсан бол, Хятадын Мин улсын оршин тогтнох гол механизм нь төрийн хүнд суртал байв. Харин Монголын их эзэнт гүрний оршин тогтнох гол механизм нь дасан зохицол байсан тухай профессор Бжэжински гярхай ажиглан дүгнэжээ.

Монголын эзэнт гүрнээс хавьгүй өмнө Төв Азид бүс нутгийн шинжтэй олон гүрэн оршин тогтнож байлаа. Алтай угсааны нүүдэлчин хүмүүсийн байгуулж байсан энэ олон улс гүрний нийтлэг шинж нь өөрснөө иргэншилгүй барбарин боловч альч иргэншлийг хүлээн зөвшөөрдөг, иргэншлүүдийг нэг талаас дээрэмдэн талж амьдрах боловч нөгөө талаас нь авч үзвэл иргэншлийг нь бэхжүүлж хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулдаг байжээ.

МЭӨ II зуунд тогтож байсан Хүннү империэс эхлээд XVI зуунд Хятадыг эзэлж Чин династийг үүсгэсэн манж нар хүртэл олон гүрэн Хятад, Энэтхэг, Перс, лалын болон христосын иргэншилт улс орныг эзлэх, халдах, вассал болгох зэргээр харьцаж байсан авч бараг бүгдээрээ өндөр иргэншилд уусан алга болжээ. Өнөөгийн Түрэг, Азербайжан, зарим судлаачдын хэлж байгаагаар Унгар зэрэг улс нь анх Төв Азиас нүүн очиж, очсон газрынхаа иргэншилд уусахын зэрэгцээ угсаатны онцлогоо авчүлдсэн ажгуу.

XIII зууны Монголын эзэнт гүрэн тэр үед мэдэгдэж байсан дэлхийн ихэнхи газар нутгийг эзэлсэн боловч тун удалгүй эзэлсэн гүрэн бүрийнхээ иргэншил, соёл шашныг хөхиүлэгч хөгжүүлэгч болжээ. Тэд өөрсдийн соёл, шашин, амьдрах аргаа голж дорд үздэгтээ тэгдэг хэрэг биш, бусдын соёл шашныгөөрийнхтэйгээ сөргүүлж тавихын оронд харин ч дасан зохицож хүлээн зөвшөөрдөгтөө хамаг учир байв. Монголчууд өөрийн унаган бөө шашинтай боловч IX зууны үед манихаизм, XI зуунд нэстори христос шашныг амжилттай өөриймшүүлэн шүтэж байв. XIII зуунд эзэнт гүрний нийслэл Хархорум нь муслим, христос, күнз, дао, буддын зэрэг шашин бүрийн холилдон суусан, өөрсдийн сүм хийдийг байгуулж харилцан мэтгэлцсэн газар байжээ. Дундаг зууны тэр үед ийм байдал хэний ч санаанд багтахгүй явдал байсан ба тэр үед эзэнт гүрэнд амьдарч байгаад ирсэн Марко Полог үзэж харсан бүхнээ ярихад мусульман болон христосын шашнынхан зэрэгцэж сүм бариад харилцан ном хаялцдаг тухай ярианд нь хэн ч итгээгүй учир Marco Millionere буюу Далан худалч Марко гэсэн хоч авч байжээ.

Буддын шашны нэгэн урсгал болох Төвдийн шарын шашин Монголд хожим XVI зууны үед орж ирсэн юм. Хантингтоны ажигласнаар өнөөгийн ертөнцөд буддизм нь өөрийн татах хүчний төв үгүй учир тусгайлан иргэншилд тооцох аргагүй шүтлэг, соёл ажгуу. Үүнээс гадна буддизм нь дотроо эрс ялгаа бүхий олон урсгалд хуваагдсан ба Төвдийн шашныг зөвхөн Монгол, Төвдөд шүтдэг. Өнгөрсөн 400 жилд монголчууд төвдийн шашныг өөриймшүүлсэн төдийгүй Төвд, Энэтхэгийн соёлыг бүрнээ хүлээн авч түүнд зохицсон байна.

Нүүдэлчид болон хятадуудын харилцаа нь бусад үндэстэнтэй харьцуулахад нэлээд өвөрмөц байлаа. Нүүдэлчид өөрсдийн түүхэн туршлагаас Хятадын өндөр соёл иргэншилд амар уусаж байгаагаар ажиглажээ. Иймээс хятадын соёлын хэрэглэгч байхаас нөлөөнд нь орохоос ямагт зайлсхийж байв. Хятадын хөрш бараг бүх орнууд күнз, даогийн шашинд орж ханз бичгээс эхлээд олон соёлыг нь өөриймшүүлж байсан. Харин монголчууд шашнаа алс өөр газраас авч, бичгээ согд уйгараас зээлдэж байв. Энэбол үе уламжлан тогтсон үндэсний үндсэн шинжээ хадгалах гэсэн зөн совин юм. Хэдийгээр хятадууд нүүдэлчдийг бүдүүлэг хэмээн басамжилдаг авч хариуд нь нүүдэлчид тэднийг соёлтой хэмээн биширч байсангүй, харин ч суурьшмал амьдралыг нь мөн л бүдүүлэг доройд тооцон басамжилдаг байжээ. Энэ тухай Америкийн алдарт синологич Овэн Латимор тодорхой ажиглалт хийн дүгнэж бичсэн байдаг.

XX зууны эхээр Монгол нь марксизмыг төрийн суртал болгосон дэлхийн хоёр дахь орон боллоо. 70 гаруй жил буюу хүний гурван үе марксист үзэл баримжаагаар явсан монголчууд орчинтойгоо дасан зохицох нүүдэлчний чадвараараа марксизмыг итгэл үнэмшлээ болгосон юм.

Гэхдээ Орос, Зөвлөлтийн нөлөөгөөр Азийн орнууд дотор

Өрнийн соёлыг хамгийн ихээр тээгч нь болжээ. 1930-аад оныүед хүн амын 80 хувь нь нүүдэлчид байсан бол 2000 он гэхэд нүүдэлчдийн хүн амд эзлэх хувь 18 болсон байна. Гурван үеөнгөрөхөд Төвдийн буддизмын нөлөө бараг үгүй болсон. 1930- аад оны үед хүн амын 30 хувь нь төвд хэлээр ойлгодог, уншдаг байсан бол 1990 он гэхэд хүн амын 70 хувь нь орос хэлээр ойлгодог болжээ. Азийн күнзийн хүмүүжилтэй хятад, солонгос, япон, вьетнам зэрэг ард түмэнтэй харьцуулахад нүүдэлчид нь илүү индивид сэтгэлгээтэй, биенээсээ бага хамаарсан социал ахуйтай юм. Иймээс Оросоор дамжсан өрнийн индивид сэтгэлгээ, түүнтэй холбогдсон соёлыг илүү амар тусган авчээ.

Дэлхийн II дайнаас хойш Монгол улс ЗХУ болон Зүүн

Европын орнуудад 50 мянга гаруй мэргэжилтэн бэлтгэжээ.

Үүний 18 мянга нь Их дээд сургуулиудад сурч төгссөн юм. Газар дээр нь соёл сураад ирсэн эдгээр хүмүүс үндсэндээ Монгол орны нүүр царайг өөрчилж, иргэншүүлсэн билээ. 1990 он гэхэд тухайлбал насанд хүрсэн иргэдийн хоёр хувь нь герман хэлээр ойлгодог байсан нь хуучин Зүүн Германд мэргэжилтэн олноор бэлддэг байсны үр дүн юм. Польш, унгар, болгар, чех, румын хэлээр ярьдаг хүмүүсийн хувь процентаар үзвэл аль орны иргэд түрүүлэх вэ гэхэд Монгол орж магадгүй л юм. Коммунизмаас хойш ч гэсэн Польш, Чех, Унгарт тус бүрт нь мянга орчиммонгол иргэд хуучин холбоогоо ашиглан бизнес хийж байгаа гэсэн тооцоо бий. Хоёр сая хүнтэй Монголын хувьд энэ нь асар их тоо билээ.

Коммунизм задран унасны дараа 40 орчим орон төвлөрсөн төлөвлөгөөнөөс чөлөөт зах зээл рүү, дарангуйллын тогтоцоос ардчилал руу шилжилт хийж байна. Энэ нь өөртөө технологи, соёлын их шилжилтыг агуулж байгаа юм. Өнөөдөр эдгээр орнууд дотор эдийн засгийн ч, улс төр нийгмийн ч давхар шилжилтийг амжилттай гүйцэтгэж яваа Монгол оронд ардчилсан тогтоц нэгэнт эргэлт буцалтгүй үйл явдал болжээ. Монголын өнөөгийн нөхцлийг ялангуяа хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан аль ч оронтой харьцуулахад хавьгүй дээд

төвшинд хүрсэн нь харагддаг. Монголыг шинээр ардчилал тогтоосон орнуудын Ардчилал эрх чөлөөний үзлийн гол тээгч нь соёл мөнүлгэр жишээ болгох талаар ч ярьдаг.

Өнгөрсөн 10 гаруй жилд монголчууд улам өрнөджиж, америкжих хандлага ажиглагдаж байна. Өрнөдийн, ялангуяа Америкийн соёлын нөлөө илт мэдрэгдэх болжээ. Арваадхан жилийн өмнө хүн амын дотор англи хэл мэдэх явдал бараггүй шахам байсан нь капитализмын нөлөөнөөс сэргийлж коммунистууд англи хэлийг төдийлөн сайшаадаггүй байсантай холбоотой. Гэтэл өдгөө англиар ойлгодог хүмүүсийн тоог хувилж авч үзвэл тухайлбал Япон, Солонгос зэрэг Америкийн нөлөөнд удсан орнуудынхаас хавьгүй дээр үзүүлэлттэй болжээ.

Коммунизмын задарлын дараахан олон оронд тус орноос

Өрнөд рүү, ялангуяа АНУ-д цагаачилсан иргэд нь эргэж ирэн шилжилтэнд нь асар их тус болсон билээ. Төрийн удирдах албыг авах, сонгуульд оролцох, зөвлөгчөөр ажиллах, хөрөнгө оруулах, хуучин хамаатан садандаа туслах зэргээр тэдний оруулсан хувь нэмэр асар их юм. Харин аль эрт 20-иод оны үед ертөнцөөс тусгаарлагдсан, Дэлхийн II дайнд бараг оролцоогүй, хаалттай хоёр аварга гүрний дунд оршиж байсан Монголоос Өрнөдөд болон АНУ-д цагаачлан гарсан хүн бараг л огт байхгүй байлаа. Гэтэл одоо зөвхөн АНУ-д гэхэд хорин мянга шахам монголчууд сурч ажиллаж байгаа ба үүнээс нэлээд нь цагаачлалын эрх авчээ.

Монгол улс хойшид Төв Ази болон Зүүн Хойд Азийн бүсэд ардчилалын үлгэр жишээ болж чадах уу? Хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэсэн, ардчилсан төртэй, чөлөөт зах зээлийн тогтоцтой нээлттэй нийгэм бүхий Монгол орон энэ бүс нутагт сайн үлгэр дуурайлал болж чадна. Эдгээрийг багтаасан Өрнийн үнэлэмж нь зөвхөн соёлоор дамжин иргэдийн итгэл үнэмшил болсон цагт бүрэн утгаараа хэрэгжих юм. Өнөөдөр Сэргэн мандлаас эхтэй

Өрнийн иргэншил дэлхийг хамарсан универсаль шинжтэй болж байна. Гэхдээ энд технологи тал нь давамгайлаад, соёл тал нь хоцорч буй тул нийтлэг амжилт үзүүлж чадахгүй байна. Өрнийн иргэншил Европ Америкаас халин Ази, Африк, Лалын ертөнц, Хятад, Энэтхэгт нэвгэрч эхэлснээс хойш 100 жил, магадгүй 50 жил л болж байна. Богино хугацаанд гол нь технологиор дамжин нийтээр хүлээн зөвшөөрсөн үнэлэмж болох замд их амжилт олж буй боловч соёлоор хөлөглөөгүй учир иргэншил хоорондын мөргөлдөөн зөрчил нөгөө талаас хурцдаж эхэлж байгаа юм. 1948 оны НҮБ-ийн хүний эрхийн тунхаглал манай гариг дээр төгс хэрэгжихэд бас нэлээд хугацаа орох болов уу.

Монгол улс Өрнийн иргэншил, итгэл үнэмшил, ардчилал хэрэгжсэн үлгэр жишээ орон болоход ямар ашигтай вэ?

1. Монгол бол коммунизмаас капитализм руу, дарангуйллаас ардчилал руу шилжиж буй орон. Үүнээс гадна уламжлалаараа Өрнийн иргэншилд хамаардаггүй Төв Азийн орон. Түүхэн утгаар нь авч үзэх юм бол Төв Азид асар их нөлөө үзүүлж байсан газар. Иймээс соёлоор дамжуулан чөлөөт нээлттэй нийгмийн итгэл үнэмшилт үлгэр жишээ болбол их тод томруун харагдах болно.

2. Монгол нь шинээр тусгаар тогтносон Төв Азийн ард түмнүүдэд сайн үлгэр жишээ болно.

Эдгээр орнуудын түрэг угсааны олон ард түмэн монголчуудтай уг сурвалж нэгээс гадна түүхэн замнал нь ижил төстэй байсан юм. ХХ зууны турш ч хамтдаа социализм байгуулж байсан билээ. Коммунизмаас хойш нэг дарангуйллыг нөгөөгөөр сольсон эдгээр орны олон иргэдийн хувьд монголчуудын чөлөөт байдал, нийгэм нь нээлттэй, хүмүүс нь эрх чөлөөтэй байгаа нь зорих тэмүүллийн үлгэр болдог юм. Жишээ болох бизээ. Солонгосын дэглэм цаашид удаан тогтох бололцоогүй. Гэвч дэглэмийн маргаашнаас хоёр Солонгос нэгдэх бүр ч бололцоогүй. Өнгөрсөн 60 жилийн хугацаанд нэгүндэстэн энэ хоёр ард түмний хооронд технологийн төдийгүй соёлын дэндүү том зөрөө гарчээ. Хоёр Солонгос нэгдэхийн тулд дор хаяхад хүний нэг үе өнгөрөөхөөс өөр аргагүй. Эгшин зуурын нэгдлийг Өмнөд Солонгосын эдийн засаг ч нийгэмч даахгүй. Хойд Солонгос дарангуйлал унасны дараа хүссэнч хүсээгүй шилжилтийн хүнд хэцүү урт замыг туулж таарна. Эдний шилжилтэнд нийгмийн ижил төстэй системд урт хугацаанд зэрэг оршиж байсан, шилжилтийн 10 гаруй жилийн туршлагатай Монгол сайн үлгэр жишээ болно. Хэрэв ажигласан бол Азийн олон хөрш зэргэлдээ ард түмнүүд бие биендээ нэлээд антипатитай. Харин солонгос, монголчууд өвөрмөц түүхэн симпатитай ард түмнүүд билээ.

4. Монголыг үлгэр жишээ болгоход харьцангуй өртөг бага орно. Ердөө 2 сая гаруйхан хүн амтай энэ орны ядуухан төсвийн 20 хувь нь боловсролд, 10 хувь нь эрүүл мэндийн салбарт зарцуулагддаг. Хэдэн арван жилийн өмнө бүх нийтээр бичиг үсэгтэй болсон. 10 мянган хүнд ноогдох оюутан, эрдэмтэн, эмчийн тоогоор хөгжингүй орнуудын хэмжээнд байгаа. Дундаж наслалт 67. Иймээс нийгмийг соёлжуулж иргэншүүлэх суурь зардлын хэрэгцээ бараг үгүй. Харин нийгмийн салбарынүйлчилгээний чанар, оюутан, мэргэжилтний төвшин маш муу. Гэхдээ өнгөрсөн 10 жилд мэргэжилтнийг Өрнөдөд давтан сургах ажиллагаа маш эрчимтэй өрнөсөн. Төрийн яам. агентлагуудын ихэнх мэргэжилтнийг Өрнөдийн дахин сургалтанд богино хугацаанд хамруулж чадсан нь овор хэмжээ багатайгаар тайлбарлагдана. Хятад, Орос мэтийн том орон байтугай дунд хэрийн оронд ийм түргэн шинэчлэл хийх бодит бололцоо үгүй юм.

Тэгвэл Монголыг үлгэр жишээ болгоход ямар саад байна вэ?

1. Юун түрүүн ядуу байдал хамгийн муу үлгэр жишээ болж байна. Нэг хүнд ноогдох ДНБ дөнгөж 500 гаруй доллар байна. Ардчилал, зах зээл, нээлттэй нийгэмд байснаар нийгмийн баялагнэмэгдэхгүй юм бол ерөөс энэ бүхэн хэнд хэрэгтэй юм бэ гэсэн гутрангуй үзэл нийгэмд газар авах хандлагатай. Ядуурал нь араасаа гэмт хэрэг, хээл хахууль дагуулдаг учир хүний эрхийг тэгтэл нь дээдлэх хэрэггүй юм гэсэн ойлголтыг ч буй болгодог.

Чухам ядуу байдал Эрих Фроммын нэрлэсэн “эрх чөлөөнөөс дайжихуйн” сурвалж болж байна.

2. Боловсон хүчний дорой төвшин. Хэдийгээр тоонүзүүлэлтээр АНУ-аас дутахгүй боловч социализмын үед бэлтгэгдсэн мэргэжилтнүүдийн чанар их муугаас гадна тогтоцын энэ инерци цааш үргэлжилсээр байна.

Монгол – АНУ хоёр дипломат харилцаа тогтоогоод хорин жил ч болоогүй байна. Хоёр орны хамтын ажиллагаа 1990 оноос эхтэй. 1990 онд Төрийн нарийн бичгийн дарга Жэймс Бэйкер Монголд айлчлахдаа нэг сая долларын өртөгтэйгээр АНУ-ын телевизийг цацах эрх болон

тоног төхөөрөмжийг бэлэглэсэн билээ. Хоёр орны соёлын харилцааны түүхийн утгаараа энэ нь туйлын бэлэг дэмбэрэлтэй үйл явдал байсан юм. “Эхлээдүг байв” гэж ариун сударт өгүүлдэг. Монголчууд Америкаас эхлээд үг авсан юм. Монголчууд Төв Азийн цээжинд ардчилал, хүмүүнлэг ёс, эрх чөлөөний нэгэн том бат бэх цайз байх хүсэлтэй. Чухам эрх чөлөө л эцсийн бүлэгт нийгмийн дэвшил, хөгжил, баялаг бүтээлтийн хамгийн ариун, хамгийн аугаа баталгаа гэдгийг өөрийн жишээн дээр харуулах, бусдад үлгэрлэх хүсэлтэй байна. Технологиор биш соёлоор дамжуулж жинхэнэ эрх чөлөөний үрийг суулгадаг гэдгийг батлах хүсэлтэй байна.

Үүний тулд Америктай тогтоосон соёлын харилцаа гол тулгуур болно. Монголчуудад америк маягийн мэдлэг боловсролоор дамжсан соёл хэрэгтэй. Монголын нэгэн алдарт яруу найрагч бичихдээ “Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас, Хүний хүү эрдэм өвөрлөж ирнэ” гэжээ. Монголын олон мянган залуус Америкт ирж суралцан эрдэм өвөрлөж буцвал чухам тэр л мөнөөх Азийн төв дахь эрх чөлөө ардчилалын үлгэр жишээ цайзны фундамент болно.

Нүцгэн үнэн

Капитализм үсрэнгүй хөгжсөн нэг арга нь бирж юм. Аварга том хөрөнгө оруулалт, тэр байтугай том дайнуудыг хөрөнгийн бирж дээрх хувьцаагаар санхүүжүүлэх арга буй болжээ. Бүх Европыг, дараа нь аварга Америкийг төмөр замжуулах ажиллагаа хөрөнгийн биржээс санхүүжжээ. Ганц нэг хүний яавч барах асуудал биш. Ингэхээр юу хийх гэж буйгаа зарлан, түүнээс гарах ашгийг урдчилан тооцоод хувьцаа гарган бирж дээр зарна гэсэнүг. Хүмүүс ирээдүйд буй болох ашгийн төлөө урьдчилж мөнгө төлнө. Олон талаасаа энэ нь мөрийтэй тоглоомны хэлбэртэй. Иймээс ч биржид тоглох гэж хэлдэг.

Дэлхийн хамгийн баян хүн нь Билл Гэйтс. Түүнийг 60 орчим тэрбум доллартай гэгцээнэ. Гэхдээ энэ мөнгөө харуулаадах гэвэл түүнд юу ч байхгүй. Үй олон биржийн хэдэн мянган хувьцаанд тарсан мөнгөний нийлбэр үнэ. Энэ бүх мөнгөө харуулах гээд хувьцаагаа мөнгө болгон татаж эхэлбэл хувьцаа нь унаж аягүй бол ганц тэрбумыг ч бэлнээр нь үзүүлж чадахгүй. Ингэхээр Гэйтсөөрөө 60 тэрбумын үнэлэмжтэй гэсэн үг.

Орчин үеийн зах зээл бол бэлэн мөнгөний гэхээсээ үнэт цаасны зах зээл юм. Зах зээл дээр үнэлэмжүүд эргэлдэнэ. Оролцогчид нь дэлхий тэр чигээрээ. Иймээс алив буурьтай хөрөнгө оруулалт болгон биржээр дамжин үнэлэгдэж мөнгө босдог. Үнэлэмж нь уул компанийн найдвар, бэл бэнчин болоод цаад хөрөнгө оруулах гэж байгаа объект гээд олон зүйлээс шалтгаална.

Оюу толгой-д хөрөнгө оруулагчид Монголын зэсийн орд газрыг бирж дээр тавьж “тогложээ”. Хувьцааны үнэ 15 доллар хүрсэн гэдэг. Энэ үед нь тэд хувьцаагаа зарсан ба үнэ доош унанНүцгэн үнэн3 долларт хүрэнгүүт нь эргүүлээд худалдаж авсан байна. Уул нь энэ нь биржийн дүрмээр хориотой, ерөөсөө луйвар булхай гэжНүцгэн үнэнүздэг зүйл. Гэвч тэд асуудлыг Монголын улс төрийн байдалтай холбож тайлбарласан учир зэм хүртсэнгүй. Үнэхээр ч улс төрийн байдал олигтой байгаагүй л дээ. Одоо хувьцааны үнэ12 доллар хүрсэн ба дахин унавал тэд 50 хувийг нь булааж авах хөдөлгөөн өрнүүлэгч, хуулийг өөрчлөн өндөр торгууль тавих гэж суртачлагч, хуучин кино заалыг бирж болгон хувиргаад их мөнгө босгох гэж оролдогч нарыг буруутнаар зарлаж орхино. Ингээд дахиад Монголын гэсэн хаягтай ямар ч алтан орд дэлхийн хүлээн зөвшөөрөгдсөн бирж дээр толгой өндийлгөх эрхгүй болж байгаа нь тэр. Учир мэдэхгүй хоёр сая ядуу хүн дотроо шудрага баатар болон тодорч хайрлагдах нэг хэрэг, энэ оронд хөрөнгө оруулалт ирэн хөгжил авчрах сувгийг хааж муухай дээр нь улцан болгох нь зоосны нөгөө тал нь. Үүнийг хорлол гэнэ.

Сэнтэрра гоулд хэмээх шинэхэн компани Канадад буй болжээ. Асар богино хугацаанд Канадын зургаа дахь аврага болж. Тэд Монголд Бороо, Киргизд Кумтор гэсэн хоёр ордтой болсон байна. Тэдний 100 хувь эзэмшдэг Кумтор ордын нөөц 300 тонн буюу Бороогоос бараг 10 дахин их. Зөв менежмент, биржийн азтай худалдаа, зоригтой хөрөнгө оруулалтын хүчинд тэд богино хугацаанд бирж дээр овоо мөнгө босгож хувьцаагаа 20 канад долларт хүргэж чадсан байх юм. Хагасыг нь булааж авна, хуулиар торгууль нэмж ноогдуулна гээд байвал тэдний хувьцаа унаж тэдэнд их хохирол учирана. Бусдын хохирол ч яамай, болж болж! Гэтэл үүнээс гадна дахиж Монгол руу хөрөнгө оруулалт хийх зоригтой аавын хүү дэлхийд олдохгүй

болно. Бид зуун саяар нь босгож чадахгүй. Юу үнэн, энэ үнэн! Элдэв-Очир кино театрт мөнгөтэйгээ байтугай мөнгөгүй гуяа ганзгалаад ирэх амьтан бас олдохгүй. Нүцгэн үнэн энэ л байна! Жаахан гашуун л юм даа!

2005.05.07

Монгол улс тусгаар тогтнолоо алдсан ба эргүүлж олсон нь

(Тайваны Их сургуульд уншсан лекц)

Манж нар бол алтай овгийн тунгус угсааны хүмүүс юм. Тэд эртний Боха улсын удам. Бохагаас өмнө манай эриний үед Хүннү нарыг цохисон дунху хэмээх аймгийн тухай түүхэнд үлдсэн байдаг нь эртний манж нар байж магадгүй. 16 дугаар зууны эхээр хагас нүүдэлчин манж нар Нурхачи баатарын удирдлага дор гүрэн улс байгуулж эхэлжээ. Энэ үед тэд Сунгари мөрөн, Япон тэнгисийн хооронд загас барьж, мал маллаж, бага зэргийн тариа тарин амьдарч байжээ. Мэдээж үе үеийн нүүдэлчдийн нэгэн адил манж нарын эцсийн зорилго Хятадыг эзлэх явдал байлаа. Манж нарыг улам томрон түрэхэд хөрш зэрэгцээ монголчууд саад болж байв.

1626 онд Нурхачийг үхэх үед Манж нь цэрэг, улс төрийн хувьд сайтар зохион байгуулагдсан хүчирхэг улс болж дөнгөжээ.

Өөрөөр хэлбэл Хятадыг суларсан үед нь эзлэн түрэмгийлдэг, тэрчинээгээрээ төр улсыг нь нэгтгэж өгдөг умрын зэрлэгүүдийн шинэ үе нэгэнт буй болсон гэсэн үг. Нурхачийн дутууг хүү Абахай нь гүйцээхээр болов.

Энэ үед монголчууд хоорондоо салж муудалцан олон аймагт хуваагдсан байлаа. Албан ёсны хаан нь Лигдэн боловч Цахараас өөр газар түүнийг тоодоггүй, хаанаа гэж үздэггүй байв. Умартын ху нарын тогтсон заншил ёсоор Лигдэн ч байнга Хятад руу халдан тонуул хийнэ. Лигдэнгээс хойгуур илүү хүчирхэг манж нар босч ирж буйг ажигласан хятадууд Лигдэнд мөнгө төлөн манжийн эсрэг умарт хилээ харгалзуулан мануулах гэрээ хийсэн байна.

Лигдэнг дарж авахгүйгээр манж нар Хятадад хүрч чадахгүйбайлаа. Абахайгаар толгойлуулсан манж нар том тулалдаан хийн Лигдэнг сөнөөв. Ийнхүү 1636 онд Зүүн ба Зүүн өмнөд Монгол Манжийн эрхшээлийг хүлээн зөвшөөрсөн юм. Юань гүрний тамга буюу Хубилайн хасбуу тамгыг эзэмшсэн гэх Абахай үүгээрээ Зүүн Хойд Азийг албан ёсоор эрхшээлдээ бариххуулийн эрхтэй боллоо гэж зарласан байна. Ингээд тэрээр Жин буюу Алтан улсаа Чин гүрэн болгон тунхаглажээ. Тэрээр 1638 онд Монголын асуудлыг хариуцсан төрийн тусгай байгууллага байгуулсаныг манж хэлээр Монгол журган гэх ба хятадаар Лифаньюу гэдэг байсан нь өнөөгийн Хятадын бүгд найрамдах улсын Засгийн газрын бүрэлдэхүүнд ордог Монгол Төвдийн хорооны жинхэнэ эх уг нь юм. Эндээс хилийн дотор байдаг гэсэн санаатай Дотоод Монгол буюу хятадаар нэймэнгү гэсэн нэр томъёо буй болжээ. Үүнтэй сөргөсөн хилийн гадаа байгаа гэсэн санаа бүхий Гадаад Монгол буюу вэймэнгү гэсэн шинэ нэр томъёоүүссэн юм.

1644 оны 4-р сард Манж нар Бээжинг эзэлсэн ба хойтон жил нь бүх хятадыг гартаа хийж авлаа. 1683 онд Тайваний арлыг эзэлж, өөрсдийнх нь эсрэг хамгийн сүүлчийн үймээн Учуаны бослогыг дарснаар Чингийн манж нар хүчирхэгийн оройдоо хүрчээ. Гэвч 1684 онд хаан ширээнд суусан Канши үүнд сэтгэл нь ханахгүй байв. Чин династи хоёр зуун жил

гадагш өнгөлзөж эзэнт улсаа томруулах гэж зүтгэж байсанд Канши их үүрэг гүйцэтгэж эхийг нь тавьсан юм. Тэрээр хаан ширээг 60 жил эзэгнэжээ. Цэргийн авьяаслаг жанжин Канши Хятад дахь бослого болгоныг дарсан ба Төвд, Монголыг эзэлжээ.

Энэ үед монголчууд хоорондоо ид муудалцаж байснаар үл барам харилцан байлдаж 1688 онд Ойрдууд Халх Монголыг эзэлж орхив. Канши хоорондоо муудалцан тэмцэлдэх монголчуудыг ажиглан түүнд нь тохирсон бодлого явуулж байв. Жавзандамба хутагтаар толгойлуулсан олон арван халх монголчууд ойрдуудад цохиулан Чин улсад очиж Манжид дагаар орох хүсэлтэйгээ илэрхийллээ. Бүх Монголыг төлөөлөх хууль зүйн эрх эдгээр хутагт ноёдын хэнд нь ч байгаагүй юм. Жавзандамба нь зөвхөн шашны эрх мэдэл дэв зэргээрээ л бусаддаа илүү нөлөөтэй нэгэн аж.

Ийнхүү Дотоод Монголоос хойш 50 жилийн дараа Халх Монголын тусгаар тогтнол алдагдсан юм. Галдангаар толгойлуулсан ойрдуудад эзлэгдсэнээс Манжид дагаар орсон нь дээр хэмээн Халхын ноёд шийджээ. Гэхдээ манж нармонголчуудын баруун хэсэг буюу Ойрдыг эзлэхэд дахиад 60 жилээ зарцуулсан билээ. Каншигийн ач хүү Чан Лин Монголын сүүлчийн тусгаар хэсгийг дөнгөж 1757 онд эзэлсэн байна.

Удтал бэлдэж хэлэлцсэний дүнд Халх Монголыг Манжид дагаар оруулах ёслол 1691 оны 5 дугаар сарын 2-нд Долон нуурт болжээ. Ёслолын өмнө Чин улсаас Канши, Халх Монголоос Жавзандамба нар тусгай тохиролцоонд хүрсэн юм. Монголчууд

Чин династийн субъект болж түүнд хамарч явахаа зөвшөөрлөө, хариуд нь манж нар Монголыг Хятадын нөлөөнөөс хамгаалж явахуурэг хүлээсэн байна. Нүүдэлчин монголчуудыг Хятадын соёл, ялангуяа угсаатны холилдооноос хамгаалж тусгаарлан байлгах, үүнээ хуульчилан мөрдөхийг хагас монгол цусны Канши хаанөөрийн болон дараагийн удмын хаадын үүрэг мөн гэж үзжээ. Энэ нь монголчууд манжид эзлэгджээ гэхээсээ сүверэйн эрхийг нь зөвшөөрсөн вассалын гэрээ байлаа. Хятад хүнийг монгол хүнтэй гэрлэхийг хуулиар хориглох мөртөө манж- монгол хүмүүс хоорондоо гэрлэхийг хөхиүлэн урамшуулах болжээ. Нийт Чин улсын дотор монголчууд тусгай эрхийг эдлэх болов. Монгол нутаг руу хятад хүн суурьшуулахгүй, аргагүй шаардлагаүүсвэл богино хугацаагаар хатуу хяналтаар үүнийг гүйцэтгэх тухай маш тодорхой дэлгэрэнгүй хуулийг 1762 онд буюу Ойрдыг эрхшээсний дараахан Бээжинд 11 дэвгрээр хэвлэн тунхагласан байна.

1907 онд Сүн Ятсэн хувьсгалч байгууллага байгуулан үндэсний үзэл, ардчилал, тэгш эрх гэсэн гурван зарчимт тунхагаа зарлалаа. Үндэсний үзэл гэсэн хэсэгт “Хэдийгээр бид манжүндэстнийг үзэн ядаагүй боловч хятад хүмүүсийг гадуурхан гутаадаг тэдний төрийн болон хуулийн зарчмыг эрс буруу шааж байна” гэсэн байлаа. Сунятсенизмын эхний үеийн гол зорилго нь умрын зэрлэг манж угсаатныг хөөн явуулаад Хятад орныг хятад хүмүүс өөрснөө захирахад оршиж байсан юм. Тэр үеийн хамгийн алдартай урианы нэг нь “Манж угсааны Чин династийг унагаад хятад угсаатны Мин династиа эргүүлж байгуулья”. Өнөөгийн түүх судлал 1912 оны Цинхайн хувьсгалыг хаант ёсыг халж бүгд найрамдах улсаа тунхагласан талаас нь л тайлбарладаг. Энэ нь чтүүхийн үнэн. Гэхдээ асуудлын зөвхөн нэг тал нь л байсан юм шүү дээ.

1911 оны 10 дугаар сард дэгдсэн Сун Ятсэний хувьсгал, 1912 оны 2-р сард Чин улс албан

ёсоор мөхсөн явдал хоёрын завсарт монголчууд өөрийн тусгаар тогтнолыг зарлан тунхаглалаа. Энэ бол 1911 оны 12-р сарын 28 буюу өнөөгөөс яг 95 жилийн өмнө болсон явдал. Энэ бол Монгол улс тусгаар тогтносон өдөр юм. Тухайн үедээ тусгаар тогтнолоо зарласан монголчуудын тайлбар тун энгийн, бас тун үнэн, логиктой зүйл байлаа. 1691 онд монголчууд хятадуудтай биш Манжийн удирдлагуудтай хэлэлцээ хийж тохиролцоонд хүрсэн юм. Хэрэвзээ Манжийн Чин династи байхгүй болж байгаа юм бол монголчуудын тэдний өмнө хүлээсэн үүрэг мөн дуусгавар болж буй хэрэг. Хэрэв Манжийн эзэд эрх мэдэлгүй болж байгаа юм бол Хятад ч тэр, Монгол ч тэрчөлөөтэй болж тус тус өөрийн тусгаар тогтнолыг зарлан бие даах эрхтэй.

Юань Шикайгаас эхлээд Дэн Сяопин хүртэл Хятадын удирдлагууд Гадаад Монголыг өөрийн алдагдсан нутаг мэтээр ярьсаар ирлээ. Монголчууд аль ч үндэстний нэгэн адил тусгаар байж түүнээ хамгаалах эрхтэй. Хятад ба монголчууд хэдэн мянган жилээр хөрш оршиж ирсэн дэлхийн ууган үндэстнүүдийн нэг. Умрын зэрлэгүүд гэгдэх олон үндэстний нэг болох монголчууд олон удаа хөрш Хятадаа эзлэн нэг субъект болж байсан. Түүхээсээ харин Хятадууд умарт ху нарыг эзлэн өөрийн болгож байсан явдал үгүй.

1691 оноос 1911 оны хооронд Хятад ба Монгол нь умрын зэрлэгүүдийн бас нэг үндэстэн болох манж нарын мэдэлд байсан. Гэхдээ энэ бол монголчууд үргэлжлүүлэн Хятадын нэг хэсэг маягаар байх ёстой гэсэн үг яавч биш. Логикоор ч, түүхэн утгаар ч тэр. Харин ч түүндээ тулбал Хятад нь манж нарын дарлалд байсан бол монголчууд харилцан үүрэг хүлээсэн тэдний вассал нь л байсан юм. Вассалын энэ тохиролцоо хатан хаан Цү Шигийн 1907 оны шинэчлэлээр хүчингүй болж эхэлмэгц л монголчууд өөрийн тусгаар тогтнолоо олох улмаар тунхаглах эрхтэй болж байгаа юм.

1911 оны 12-р сарын 28-нд тусгаар тогтнолоо олсон Гадаад Монгол нь 1946 оны 1-р сарын 6-нд энэ эрхээ олж авсан билээ.

IV. Хэнтийн гурван тэнэг

Бат-Үүлийг баривчилсан нь танил тал харсан шинжтэй байна

Дэлхийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл Монголын тухай үг дуугарах нь дэндүү ховор. Ерэн оны ардчилсан хувьсгал л гэхэд Тэнъань миний бослого, Берлиний хана, Прагын жагсаал,

Чаушеску гэх мэтэд дарагдаад төдий л сурталчлагдаагүй. Ерэн зургаан оны сонгуулийн дүнг хэсэг гайхширнаа Оросын хэвлэлд л гэхэд “Монголын хоцрогдсон малчин нүүдэлчид хүртэл коммунизмаас татгалзаж байхад манайд арай ч Зюгановыг сонгочих юм биш байгаа” гэж бичиж байлаа. Харин энэ зуны сонгуулийн дүнг сонсоод жишээ нь Германы “Франкфүртэр Альгэмайнэ” сонинд бичихдээ “Монголыг ардчиллын жишээ болгож гайхуулаад л манайхан очиж туслаад л хөөрцөглөөд байсан, хаа байна. Төв Азийн тэрхүү хоцрогдсон орон өөрийнхөө байранд ч очиж байгаа биз дээ. Мөнөөх л Киргиз, Узбек, Тажикстан, Азербейджан, Түркмэнийхээ өрөөсөн гутал л байгаа биз дээ, болох ёстой юм нь л Монголд болж, тэд өөрсдийн байхёстой заяаныхаа газраа л очиж, бүс нутагтайгаа нийллээ” гэж дүгнэжээ.

Хэдийгээр энэ оны долоо наймдугаар сард Америкийн Ерөнхийлөгчийн сонгуулийн компанийн шувтаргын тоглолт болж “Курск” онгоц живж, Москвад бөмбөг дэлбэрч, Малайзад Анвар Ибрахимийг дахин шүүж, Энэтхэгт үер болж, Парист “Конкорд” сөнөж, Колумбид хар тамхины дайн дэгдэж, Киргизэд Бэн ладений санхүүжүүлсэн лалын цэргүүд довтолж дэлхийн чихийг дэлдййлгэсэн олон үйл явдал болж байгаач гэсэн ойрноос Монгол хэмээх улсад коммунистууд дахин ялж баривчилгаа явагдаж байгаа тухай нэлээд бичих боллоо.

Арав хорин жилийн өмнө бол ч ийм сонин сонин биш байж л дээ, харин одоо мөнөөх коммунизм, коммунист гүжирдлэг, коммунист баривчилгаа зэрэг нь дэндүү ховор зүйл болчихсон болохоор дэлхийн мэдээллийн хэрэгслүүд ихэд олзуурхан шүүрч аваад байх шиг байна. “Нью-Йорк таймс” сонины намдугаар сарын 22-ны дугаарт бичихдээ “Саяхан болсон сонгуулиар парламентынхаа бүх суудлыг авсан коммунистуудөш хонзонгийн баривчилгаа явуулж эхэллээ. Ардчилсан хүчний гол удирдагч нарын нэг Э.Бат-Үүлийг өөрийн нөхөр Зоригийн амь насыг егүүтгэсэн хэрэгт холбогдуулан баривчилав.

Зориг нь 1998 онд үл мэдэгдэх байдлаар гэртээ алуурчны гарт амь үрэгдсэн юм. Коммунистууд үүнийг ашиглан Ардчилсан хүчнийхнийг энэ хэрэгт холбогдуулан сонгуульд ялсан юм” гэсэн бол “Reuter” агентлаг “Монголын ардчилсан хүчнийхэнөөрийн удирдагчаа коммунистуудад баривчуулчихаад шоконд ороод үг ч дуугарч чадахгүй байна” гэж мэдээлжээ. “Лос-Анжелес таймс”, “Зюддойч цайтунг”, “Индепэндэнт”, “Лэ Монд”, “Асахи шимбүн”, “Вашингтон пост” гээд л энэ дэлхий дээр нөлөө бүхий бүх том хэвлэлүүд дуу дуугаа авалцан “Монгол”, “Махчин коммунистууд”, “Ардчилсан хүчний эрэлхэг хөвгүүн Э.Бат-Үүл” гэсэн мэдээллийг хорвоогоор нэг цацаж эхэллээ. Ийнхүү мань Бат-үүл Хятадын

Шэнь Жин, Малайзын Анвар Ибрахим, Мянмарын Ань Сан Сүү нарын зиндаанд очиж Чингис, Хубилай нарын дараа дэлхий даяар алдаршсан Монгол хүнээр нэгэнт тодорч эхлэв. Тэрээр удахгүй хүний эрх, эрх чөлөө ардчилал, шударга ёсны төлөө цогтой тэмцэгч Нельсон Мандела, Лех Валенса, Далай лам, Тереза эх, Мартин Лютэр Кинг нарын эгнээнд очин, орчин үеийн дэлхийн бас нэг шинэ домог болон үлдэх хувь заяатай боллоо. Ухаан нь хэдэн жилийн дараа наймаа хийж яваа монгол ганзагачнаас Буркино Фасогийн иргэн гэгдэх хамартаа ээмэгтэй нүцгэн хар “танай Бат-Үүл гуайн бие сайн уу. Түүнийг муусайн коммунистууд дахиад л хорьчихсон уу” гэж асууж байх жишээтэй. Дэлхийн нөлөө бүхий хэвлэлүүд ядуу, бүдүүлэг хоцрогдсон орны чанга дэглэмтэй тэмцээд яваа юм уу, золиос нь болоод хохирч яваахэн нэгнийг дурсаад магтаад унахаараа орчин үеийн дэлхийд цаадах нь яаж мандан дэвждэгийг бүгдээрээ гадарлана. Нельсон Мандела 25 жил шоронд суусныхаа шанд өнөөдөр дэлхий дээр хамгийн алдартайгаар барахгүй, хамгийн нөлөөтэй хувь хүн болчихсон явна. Польшийн дэглэм Ваненсаг гэрийн хорионд хэдэн сар суулгаатчихсан чинь цаадах нь Нобелийн шагнал хүртэж удалгүй тэр орны Ерөнхийлөгч болсон. Бирмийн дэглэм Ань Сэн Сүү гэгч авгайг бас л гэрийн хорионд суулгасны төлөө тус улс анхны Нобелийн шагналтантай болоод авлаа. Алдарт физикч Сахаров мэргэжлээрээ биш Горькийн хотод цөлөгдсөнөөрөө илүү алдаршиж бас л Нобелийн шагнал авсан. Альберт Лютүли, Дэсмонд Түтү, Адольф Эскювэл, Хосэ Рамос Хорта, Карл фон Оссетски гээд л олон хүн өөрийн амьдарч буй дэглэмтэйгээ тэмцсэн буюу золиослогдсоныхоо шанд Нобельтой болсон билээ. Ухаан нь оссетски гэдэг лам Гитлерийн дэглэмтэй тэмцээгүй боловч Бухеньвальдад хоригдсон учраас шведүүд түүнийг алдаршуулан шагнажээ. Ригобэрта Мэнчү гэдэг тосгоны авгайг ойр төрлийнхнөөс нь өөр хэн ч мэддэггүй байтал Гватемалийн дэглэм түүгээр оролдоод унасан чинь нэг Нобельтон дундаасаа төрүүлчих нь тэр. Харин Шэнь Жин Нобелийн шагналд жил дараалан дэвшээр хариугүй хүртдэгийн даваан дээр хятадууд түүнийг нутгаасаа хөөж Америкт гаргасан учраас хоншоор нь дутсан. Ингээд мань Бат-Үүл Малайзын Ибрахимын хүчтэй өрсөлдөгч болон гэнэт тодорлоо. Анвар Ибрахимыг улсын асар их мөнгө идсэн хэмээн шоронд суулгаж байснаа саяхан буруу хурьцал үйлдсэн хэргээр есөн жилийн ял сонсгосон билээ. Бат-Үүлийг ч гэсэн манай коммунистууд гуанзанд хүн рүү ус цацсан хэргээр шоронд хориод Зоригийг алан хядсан хэргээр үргэлжлүүлэн суулгасан ба тун удалгүй есдүгээр ангид байхдаа багшийгаа зодсон хэргээр ял сонсгох биз. Зоригийн аллагаар нэр цуугаа бадруулж нам байгуулж, сонинд ярилцлага өгч, ном жүжиг бичиж, сайд болж сонгуульд оролцож, депутат болж тодорсон олон олон хүн бий боловч явж явж хамгийн их хожих хүн нь мань Бат-Үүл л болж таарлаа.

Бат-Үүл ч яахав Монголын байтугай Төв Азийн анхны

Нобелийн шагналтан болж өөрөө дааж чаддаг юм бол алдар суугийн ноён оргилд гарах нь тодорхой боллоо. Гэвч энэ нь аль зэрэг шударга хэрэг вэ? Монголд ардчилал буй болоход Бат-

Үүл чамгүй үүрэг гүйцэтгэснийг үгүйсгэхгүй. Гэхдээ цөөхөн монголчууд бидний дотроос шилээд авна гэхэд Бат-Үүл хамгийнчухал үүрэг ролийг гүйцэтгэсэн юм гэж үү дээ? Наян найман онд Төв шуудан энэ тэрийн хаалган дээр нууцаар бичиг нааж явсан л гэдэг юм билээ. Ардчилсан намын анхны дарга байсан байх. Өөр түүнд тэгтлээ овойж оцойхоор гийгүүлсэн юм бий бил үү? Даруу бус зан гаргаж буйг минь өршөөгөөрэй, гэхдээ тухайлбал миний бие энэ нийгэмд Бат-Үүлээс хамаагүй илүү үүрэг гүйцэтгэсэн юм шүү. Тэгэхэд яг шагнал, тэр

дундаа Монгол Улсын нэр төрийг дэлхийд дуурсгах Нобелийн шагнал болохоор Бат-Үүлийг сонгож авч байгаа нь дэндүү шударга бус үйлдэл юм.

Яг баривчлаад нэрийг нь дэлхий даяар дуурсгах дээрээ тулбал намайг ч оронд нь баривчилж болох л байсан шүү дээ. Талийгч Зоригийг алуулдаг өдрийн өглөө таван цагт намайг Япон руу ниссэн тухай хэвлэлүүд зөндөө л шуугисан. Нэрт улс төр судлаач Эрдэнэтуул ганц Бат-Үүлийг л аллагын захиалагч гэж нэрлээгүй. Намайг ч бас дотор нь оруулсан байсан шүү дээ. Иймэрхүү улайм цайм сэжгүүд над дээр бэлээхэн байсаар байтал заавал Бат-Үүлийг нэг муу малгай мартсанаар нь далимдуулж шоронд хийн дэлхий даяар алдаршуулж, Нобелийн шагналд тодорхойлж буй нь дэндүү шударга бус байна. “Өнөөдөр” сонины эрхлэгч Балдорж, мань Бат-Үүл хоёр өвөр түрийндээ орох шахдаг найз нөхөд гэдгийг тэр бүр хүн мэдэхгүй байх. “Өнөөдөр” сонин хоёр жилийн турш тэрхүү аллагын жинхэнэ эзэн бол Бат-Үүл гэсэн таамаглал дэвшүүлэн, түүндээ улам баттай болгохын тулд янз бүрийн цуу зохиосоор байгаад цагдаагийнхныг үнэмшүүлж орхисон нь угаасаа Бат-Үүлийг дэлхийд алдаршуулан Нобелийн шагнал олгох гэсэн эхнээсээ бодсон нууц төлөвлөгөө болох нь батлагдаж байна. Балдорж, Багабанди хоёр “Ардын эрх” сонинг идчихсэн байгаад баригдахад нь мань Бат-Үүл л УИХ дээрэмгөөлсөөр байгаад хэргийг хэрэг биш болгож байсан ба энэ нь хариуд нь Балдорж ингэж тус болохоор сэм тохирсон нь харагдаж байна. Ар өврийн хаалга, сэм хуйвалдаанаар нэгэндээ Нобелийн шагнал олгуулж байгаа энэ явдал бол манай улсын нэр төрийгөргөх биш харин ч унагаж болохоор ноцтой шударга биш үйлдэл юм.

Монголоос Нобелийн шагнал авах анхны хүн бол нэгэнт л улсынхаа нэр төрийг хамт авч явах учраас мэдлэг боловсролтой, хэл амтай, харилцааны соёлтой харахад нүдэнд дулаахан хүн байх ёстой. Гэтэл Бат-Үүл бол англи, франц байтугай оросоорч олигтой ойлгодоггүй, багадаа дөчин мянгатад хулигаантаж яваад хамраа муруй болгочихсон, саяын Малыштай төдийгүй хэдэн жилийн өмнө Рихард Зорге гэгчтэй зодолдож байсан, харилцааны соёлгүй, хар хур гэсэн этгээд билээ. Ийм хүн Монгол Улсыг төлөөлөөд тэрхүү нэр хүндтэй шагналыг авахаар цаана нь бүгдээрээ л нэг иймэрхүү хулигаан царайлсан эх хэлнээсээ өөр юм мэддэггүй мангарууд юм байна энэ монголчууд чинь гэж дэлхий даяараа бодоход хүрвэл яана. Нобелийн шагналыг дагалдаад цэвэр алтан медаль, нэг сая ам.доллар ирдэг билээ. Энэ их хөрөнгийг зөв зарцуулж, улс орныхоо ядарсан эдийн засгийг өөд татахад хэрэглэх совесть түүнд бий юу? Нөгөө Нобелийн алтан медалийг нь хайлуулаад бөгж хийгээд зүүчихсэн цохиж явбал яана. Нобелийн илтгэл гэж нэг чухал юм байдаг. Энэ илтгэлийг англиар бичиж өөрөө уншдаг ба дараа нь дэлхийн бараг бүх хэлэнд орчуулагдаж цацагдан сурталчлагддаг номтой билээ. Бат-Үүл улс орныхоо нэрийг дуурсгахуйц, хүний сэтгэлд хоногшохуйц, сайхан илтгэл бичиж чадах уу? Нобелийн шагналтанг дараа нь дэлхийн нэр хүндтэй их сургуулиуд урин лекц уншуулж, доктор цолоороо шагнан алдаршуулдаг. Гэтэл мань Бат-үүл бол юун доктор, уртаашаа л дунд сургуулийн физикийн багш хүн шүү дээ.

Энэ бүхэн ч бас яахав гэж үзье хамгийн гол нь шударга бус байдлаар түүнийг алдаршуулж байгаа нь дэндүү зарчимгүй хэрэг юм. Алив юманд хэр хэмжээ, логик, зарчим гэж байхёстой. Ганболд, Гончигдорж, Энхсайхан уучлаарай бас би гээд эх орныхоо нэрийг хаана ч нүүр улайлгахгүй аваад явах сайхан залуучууд байсаар байтал очиж очиж Бат-үүлийг шоронд суулгаж

тэр сайхан шагналд дэвшүүлж буй нь шударга ёсыг алдагдуулж байна. Аллагын хэрэгт бидний хэнийг ч холбогдуулж хорьж болох л байсан. Шударгаар уралдуулан шүүж тунгаагаад, дараа нь шагналынхаа нэр хүндийг тухайн хүн дааж чадах эсэхийг нь бодолцоод нэгийг нь шалгаруулан авч шоронд хийх ёстой байсан юм. Энэ бүхнээс үзэхэд сая сонгуулиар гарч ирсэн шинэ Засгийн газар эхнээсээ авахуулаад л шударга бус юм хийж эхэлж байгааг ард түмэн үнэн мөнөөр нь зөв тунгаан шүүх байх гэж итгэж байна.

2000.08.29

МАХН-ЫН ТҮҮХЭН УЛААН ЗАМНАЛ

(Монголын коммунистуудын наян жилийн лит)

1920 он. Бяцхан Сүй гэгдэх генерал Сү Шүжанаар толгойлуулсан Хятадын Анфу бүлэглэлийн цэргүүд Хүрээнд орж ирсэн төдийгүй Монголын автономийг устгалаа. Богд хаанаа өмгөөлөх зорилготой да лам Пунцагдоржоор толгойлуулсан “Ноёдын”, С. Данзангаар толгойлуулсан “Түшмэдийн”, Д. Бодоогоор толгойлуулсан “Ардын” гэсэн гурван дугуйлан үүсэв.

1920 оны 2-р сар. Дугуйлан байгуулагдсаныг сонсоод Бээжингээс Эрхүү орох замдаа Наум Буртман хэмээх большевик Хүрээнд ирж “Түшмэдийн” бүлэг, толгойлогч С. Данзан нартай уулзаж зөвлөгөө өгөв. Буртман буцаж очоод Большевик намын Төв хорооны Дорно дахины секц байгуулсан нь дотроо Монголыг хариуцсан Монгол-Төвдийн хэлтэстэй аж.

1920 оны 3-р сар. Хүрээнд Сороковиков хэмээх большевик ирж Данзангийн түшмэдийн, Бодоогийн ардын гэгдэх дугуйлангийнхантай уулзав. Монголчууд нь Хятадын гараасчөлөөлөгдөх тухай, орос нь дэлхий дахины хувьсгалыг Монголдөрнүүлэх тухай ярив.

1920-6-20. Сороковиков Хүрээнд эргэж ирээд хоёр бүлэг нийлж нам байгуулбал Зөвлөлт засаг туслана гэж амлалаа.

1920-6-25. Түшмэдийн ба Ардын бүлэг нийлж Монгол ардын нам байгуулав. “Гадаад Монголын ардын намын зорилт нь шашин үндсэнд харшлах харгис дайсныг цэвэрлэж, алдагдсанэрхийг эргүүлж аваад, төр шашныг үнэн сэтгэлээр бататган мандуулж, үндсэн язгуурыг алдагдахгүй сахих ба дотоод засгийг үнэн сэтгэлээр сайжруулан засамжилж, ядуу дорд ард түмний тусыг туйлаар бодох ба өөрийн дотоод эрхийг өнөөүүрд сахиж, дарлах дарлагдахын зовлонгүй аж төрөхийг чухал болгоно...” гэж нам байгуулсан Тангаргын бичигт зорилго юугаа тодорхойлжээ.

1920 оны 7-р сар. Богдын дэргэдэх Ноёдын бүлгээс Хятадаасчөлөөлөхөд тусламж гуйсан бичиг Япон, АНУ, Колчакийн Оросын Засгийн газар руу явуулсан бол шинэ Монгол ардын нам шинэ Зөвлөлт засгаас тусламж гуйхаар болон Богд хаанаар тамга даруулан 7 төлөөлөгч Орос улс руу явуулав.

1920 оны 8-р сар. Төлөөлөгчдийг Эрхүүд Гапон хүлээж авч уулзсан боловч асуудлыг шийдэж чадахгүй тул тэднийг цааш Омск руу илгээв. Эндээсээ хагас нь Данзангаар толгойлуулан Москва оржээ. Данзан Ленинтэй уулзаж Монголд буй хятад бүрийн толгойг тас цавчих хүслээ илэрхийлж, харин Ленин хятадууд нь дотроо баян ядуу гэж байгаа, баянг нь л алах хэрэгтэй гэж ярьсан тул хоёр тал ойлголцсонгүй. Тусламж амлуулж ч чадсангүй.

1920 оны 10-р сар. Монголд Барон Унгерний цэрэг орж ирсэн тул Москва МАН-ынханд тусламж үзүүлэх болов. Тусламжийн зорилго нь нэгд Унгерний цэргийг цохих, хоёрт Монголд дэлхийн хувьсгалын галыг бадраах. Коминтернээс Монголд хувьсгал хийхэд зориулж 3 сая рубль хуваарилав.

1920 -10-5. Хувьсгал хийхэд зориулсан мөнгөөр Большевик намын Дорно дахины секцийн Монгол-Төвдийн хорооноос эрхлэн Эрхүүд Монголын үнэн сонинг монгол хэлээр гаргав.

1921-3-1. Дээд Шивээд МАН-ынхан болон хэсэг буриад, орос оролцсон зөвлөлгөөн болов. Хожим 1925 онд үүнийг МАХН- байгуулагдсан өдөр ба тус зөвлөлгөөн нь МАХН-ын анх дугаархурал байсан гэж тогтлоо. Энэ өдөр тус намаас гаргасан албан бичигт Монгол улсын ирээдүйг “...алсдаа Өмнөд Хятад, Умарт Хятад, Төвд, Шинжаантай хамтран холбооны улс болох” гэсэн зорилгоор тодорхойлжээ.

1921-3-18. Хиагтын хил дээр байрлаж байсан хятад цэргийг Монгол-Зөвлөлтийн хамтарсан хүчин цохиж хөөж явуулав. Цохигдсон цэргүүдийг Читагаар дамжуулан нутаг буцаажээ.

1921-7-6. Монгол Зөвлөлтийн цэрэг Хүрээнд орж ирэв. Богдыг дахин хаан ширээнд нь заллаа. Монголын шинэ засгийн газрыг Бодоогоор ахлуулан байгуулав. Ардын намаас Д. Бодоо, Түшмэдийн намаас С. Данзан, Д. Сүхбаатар нар, Ноёдын намаас да лам Пунцагдорж, хурц Магсаржав нар Засгийн газрын бүрэлдэхүүнд оржээ.

1921-8-25. Бошгыг халах залуучуудын эвлэл хэмээх коммунист залуусын хийрхсэн байгууллагыг байгуулав. Энэ нь төр засгийн эрхэнд байгаа ардын, түшмэдийн, ноёдын бүлгийн төлөөлөгчдийг түлхэн унагаж “жинхэнэ коммунист” хийрхэлийг бадраах зорилготой аж.

1921-10-5. С. Данзан тэргүүтэй төлөөлөгчид Москва орж Зөвлөлт засагтай хэлэлцээр хийв. Зөвлөлт улс Монголын шинэ Засгийн газрыг хүлээн зөвшөөрснөө илэрхийлэв. Харин Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхөөс түдгэлзлээ.

1921 оны 12-р сар. “Саж ламын хэрэг” гэгчид 48 хүнийг баривчилж буудав. Ардын намын анхны тэргүүн, Ерөнхий сайд Д. Бодоог түлхэн унагав. Үүнд Түшмэдийн намын С. Данзан, Д. Сүхбаатар нар голлох үүрэг гүйцэтгэжээ. Ноёдын намын төлөөлөгч Жалханз хутагт Дамдинбазар Ерөнхий сайд болов.

1922 оны 8-р сар. Хувьсгалт терроризм гараагаа эхлэв. Буудуулагсадын дунд Ерөнхий сайд асан Д. Бодоо, Дотоод яамны сайд да лам Пунцагдорж, Түр засгийн газрын ерөнхий сайд асан

Чагдаржав нар оржээ.

1923 оны 2-р сар. Ардын цэргийн жанжин асан Д. Сүхбаатар сэжигтэйгээр нас барав. Түүнийг Цэргийн яамны сайдаас нь огцруулж оронд нь Хатанбаатар Магсаржавыг тавьсан байв.

1924 оны 5-р сар. Бээжинд Караханы гэрээ гэгч Зөвлөлт- Хятадын хэлэлцээр болж Монголыг Хятадын салшгүй нэг хэсэг гэж хоёр тал хүлээн зөвшөөрөв.

1924 оны 5-р сар. Богд хаан сэжигтэйгээр гэнэт нас барав.

1924 оны 8-р сар. Түшмэдийн бүлгийн толгойлогч асан, Ерөнхий сайдын орлогч Солийн Данзанг буудан хороолоо. Түүнд хөрөнгөлөг хөгжлийн зам руу санаархсан хэмээх ял тулгажээ.

1924-11-26. Бүгд найрамдах улсыг тунхаглаж, Үндсэн хууль баталлаа. Үндсэн хуулиар Монголын ард түмнийг дарлагч ноёд лам худалдаачид, дарлуулагч ард гэж хоёр хуваагаад эхнийхэд нь ямар ч эрхийг эдлүүлэхгүй, харин ард анги нь ноёлох болсныг тунхаглалаа. Нийслэл Хүрээний нэрийг Коминтерний төлөөлөгч Рыскуловын саналаар Уланбаатар болгон өөрчиллөө.

1925 он. МАХН-ын 4-р их хурлаар намын программ батлав. Капиталист бус хөгжлийн замаар явж ирээдүйд эв хамт нийгэмд хүрэх тухай заасан уул бичиг баримтад Капиталыг эсэргүүцэж, дэлхийн коммунист хувьсгалын талд байхаа нотлон илэрхийлжээ. Монгол ардын хувьсгалт нам гэж МАН-ыг нэрлэх боллоо.

1925 он. Коммунист хүүхдийн байгууллага байгуулав. Залууе өсвөр наснынхан ч МАХН-ын үйл хэргийн төлөө хэзээд бэлхэнбайх ёстой гэж үзжээ.

1928 он. Коминтернээс Б. Шмераль тэргүүтэй төлөөлөгчид ирж төрийн эргэлт хийн “хөдөөний фракц” хэмээх боловсролгүйзалуусыг тоглоомын төрийн толгойд заллаа. Монгол жинхэнэ коммунист улс болон хувирав.

1928 он. Дамбадорж, Цэвээн, Жадамба нарыг төрийн эрхээс зайлуулж Зөвлөлтөд хүргүүлэв. Тэд Монгол улсыг “үлгэрлэвээс Швейцари лугаа адил” замаар хөгжүүлэх санал гаргасандаа буруутжээ.

1928 он. Монголд байсан гадаадын бүх пүүс компанийг хөөж гаргав. Европ, Япон, Хятад, АНУ-ын олон компани, хэдэн мянган хувийн бизнес эрхлэгчид хөөгдлөө.

1929 он. Хувьсгалт терроризм улам хүчээ авлаа. 1915 оны Хиагтын гэрээг толгойлсон, 1921 онд Зөвлөлт засагтай хийсэн гэрээнд оролцсон Ноёдын намын Ширнэндамдинг буудан алав. Мөн Егүзэр хутагт Галсандаш, Манзушир хутагт Цэрэндорж, баатар гүн Гомбо-Идшин нарын зэрэг цагтаа Ноёдын намд хамаарч байсан эх орончдыг буудан хороов.

1929-32 он. Ард түмний хөрөнгийг хураалаа. Мөн жасын хөрөнгө малыг хураав. Хураасан малаараа коммун байгуулав.

1. Ардын аж ахуйтныг нэгтгэх;. 2. Мал сүргийг улсын мэдэлд шилжүүлэх. 3. Хар шар феодалуудыг устгах явдлыг өргөн цар хүрээтэй явуулах. Дарамт үзүүлэхийн тулд ажилгүй болгох. 4. Нударган баячууд нь бага феодалууд болох тул бүхий л талаар тэдэнд дарамт үзүүлэн шахан зайлуулах. 5. Шашинтай тэмцэх ажилд хамгийн харгис аргыг хэрэглэх гэсэн МАХН-ын заавар гарчээ.

1930 он. Монголын уламжлалт 4 аймаг, 2 хязгаар бүхий засаг захиргааны бүтцийг өөрчилж 13 аймагтай болгов. 1994 он гэхэд Монгол нь 21 аймаг, 320 сум 1500 багтай болтлоо тархай бутархай болсон нь Манжийн дарлалын үеийнхээс даруй 3 дахин олон болжээ.

1931 он. Герман, Францад сурч байсан монгол оюутнуудыг эргүүлж татав. Удалгүй тэд бүгдээрээ шоронд оржээ.

1932 он. Тэсвэрлэшгүй хүнд байдлыг эсэргүүцэж ард түмэн бослого гаргалаа. Хэдэн арван мянган хүн улаан Засгаас дүрвэж мал хуйтайгаа гадаадад гарчээ. Дүрвэгсэдийг хил дээр угтан хүн малтай нь пулемотоор шүршин устгасан явдал нэг бус. Бороохой шийдмээр зэвсэглэсэн босогчдын эсрэг МАХН-ын тогтоолоор байнгын арми орууллаа. Босогчдыг аэропланаар бөмбөгдөж, танкаар дайрав. Хээрийн шүүх ажиллуулан хэдэн зуугаар нь нэг дор буудан хороолоо. Босогчдын 60 хувь нь ард гаралтай хүн байсан ба үлдсэнд нь нам эвлэлийн ажилтан, цэргийн офицер тэр байтугай Улсын бага хурлын гишүүн арваад хүн байв.

1932 он. Монголын дотоод хэрэгт Коминтернээс оролцохыг

Москва бүрэн зогсоов.

1934 он. Буриадуудын эсрэг террор эхэллээ. “Хэнтийн бүлэг”, “Дорнодын бүлэг”, “Улаанбаатарын бүлэг” гэсэн гурван бүлгээс тогтсон “Лхүмбийн хэрэг” гэгчийг зохиомолоор мандуулав. Хэдэн зуун хүнийг шүүхээр оруулан буудан хороов. Буудуулсан хүмүүсийн дунд жирэмсэн эмэгтэй ч байлаа.

1936 он Дотоодын хамгаалах газрыг Дотоодыг хамгаалах яам болгох шийдвэрийг МАХН гаргав. Сайд нь Х. Чойбалсан боллоо.

1937-39 он. Их аллага эхлэв. Монголын насанд хүрсэн эрэгтэйчүүдийн 20 хувь нь шүүхийн тогтоол гэгчээр хилсээр амь насаа алджээ. Буудуулагсадын дунд эмэгтэйчүүд, түүний дотор жирэмсэн эмэгтэй хэд хэд байлаа. 767 сүм хийдийн 5 953 барилга байгууламжийг орвонгоор нь нураав. Алагдсан ламын тоо 17 335. Нийт баривчлагдсан хүний тоо 56 938. Ах дүү хамаатан садан, эх эцгээ алдаж өнчирсөн гэр бүл – Монголын бүх хүн ам.

1937-38 он. Монгол улсын ерөнхий сайд Пэлжидийн Гэндэн

“нам бол төрийн улаан булан”, “ЗХУ бол улаан империализм”,

“баяжигтүн” зэрэг уриалга гаргасан ба үүндээ буруутан ЗХУ- руу ачигдаж тэндээ цаазлуулав. Монгол улсын Ерөнхий сайд Анандын Амар Улаанбаатарт хурал дээр баривчлагдан Москва руу ачигдав. Тэрээр шүүх хурал дээр “Би угаасаа улаан засгийг

үзэж чаддаггүй, би оросын ард түмэнд хайртай боловч Оросын

ч Монголын ч коммунистуудад үнэхээр дургүй” гэж хэлжээ. Түүнийг цаазлан хороосон ба харин шарил нь хэзээ ч олдсонгүй.

1940 он. МАХН-ын ТХ-ны Улс төрийн товчооны шийдвэрээр баривчлагдсан хүмүүсийг эрүүдэн тамлах эрхийг Дотоодын хамгаалахад олгов.

1940 он. МАХН-ыг Ю. Цэдэнбал толгойлох боллоо. Гэвч намын болоод төрийн бүх эрхийг Х. Чойбалсан дангаар эдэлж байв.

1940-1946 он. “Зүүн аймгийн хэрэг”, “Сүхбаатар аймгийн хэрэг” зэрэг олон зохиомол хэрэгт энгийн малчид хамарч цаазлагдав.

1942 он. “Сүхбаатар” кино дэлгэцэнд гарав. Монголын ардын хувьсгалыг Сүхбаатар, Чойбалсан нар толгойлсон ба тэд баяд ноёдын эсрэг тэмцсэн, Сүхбаатарыг Богд хаан хорлож алсан гэх мэтийн домог эндээс үүсэв.

1944 он. “Ламаадангийн хэрэг” гэгч мандав. Хувилгаан хэмээх

10 настай хүүхдийг баривчлан хороожээ. Эх эцгийг нь мөн буудаж алав.

1947 он. “Порт Артурын хэрэг” гэгчээр олон хүнийг барьж хоморголон устгав.

1948 он. Түүхийг марксист өнцгөөр харж байх тухай МАХН-ын тогтоол гарав. Чингис хааныг харгис алуурчин гэж тодорхойлоод түүний нэрийг сурах бичиг, уран зохиолд сайнаар дурсахыг хориглов.

1949 он. Анхдугаар таван жилийн төлөвлөгөө. “Ноос алт” хөдөлгөөнд малчдад дааж давшгүй ноосны төлөвлөгөө өгсөн ба биелүүлээгүйг нь шоронд хорьж байв. Ноосны төлөвлөгөө биелүүлээгүй 20 орчим мянган малчид шоронд оров. “Жамбалдоржийн хар хууль” гэгч хэрэгжиж эхэллээ. Монголын малыг 200 сая хүргэнэ гэж МАХН төлөвлөв.

1952 он. Ю. Цэдэнбал ерөнхий сайд болов.

1956 он. МАХН-ын түүх зохиогдов. Ардын хувьсгалыг Сүхбаатар удирдсан, Бодоо Данзан нар эсэргүү байсан, Амар, Гэндэн нар нугалаатнууд, намд “баруун”, “зүүний” нугалаа гарч байв. Монгол улс капитализмыг алгасан хөгжиж байна, ирээдүйд социализмыг байгуулж дуусна, өнгөрсөн алдаа завхрал нь МАХН-ын буруу биш хувьсгалын эсрэг хүчний далд явуулга юм гэх мэтийн олон олон зохиомол зүйлсийг албан ёсны болгожээ.

1957-1962 он. Ард түмнийг алан хядаж байсан хэргийг шалгах комисс буй боллоо. Хилсээр алагдсан хүмүүсийг цагаатгах ажил эхлэв. Цагаатгалд 17 мянга гаруй буудуулсан лам нарыг хамруулсангүй. Ерөөс цагаатгах ажил нь МАХН-ын нэр хүндэд муу гэж үзээд зогсоолоо. Тун нууц байдлаар маш цөөн тооны нам төрийн ажилтныг цагаатгасан нэр хэмээв.

1958 он. “Сэхээтний төөрөгдөл” хэмээх хэрэг үүслээ. Олон арван сэхээтэн хэлмэгдэв.

1958-1962 он. Нам төрийн удирдлагад байсан Цэнд, Дамба, Сүрэнжав зэрэг хүмүүсийг МАХН-ын тогтоолуудаар буруутган цөлөв.

1959 он. Малчдын малыг хурааж нэгдэл байгуулав. Нэгдэлжих хөдөлгөөн ялав. Үүнийг МАХН-ын их хурлаас “1921 оны Ардын хувьсгалтай тэнцэхүйц ололт” гэж үнэлэв.

1959 он. Хувийн хэвшлийн жижиг үйлдвэрлэгчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хөрөнгийг хурааж Үйлдвэр хоршоо гэгчийг байгуулав. Үүнийг сүүлд 1967 онд улсын мэдэлд бүр мөсөн хураан авчээ.

1960 он. Шинэ үндсэн хууль гарч Монгол улс социализм байгуулах “үедээ” оров.

1961-62 он. Монгол улс НҮБ, ЭЗХТЗ-ийн гишүүн боллоо.

1962 он. Д. Төмөр-Очирыг хэлмэгдүүлж хөдөө цөлөв.

Чингис хааны төрсний 800 жилийн ойг тэмдэглэх санаачлага гаргасан учир ялд оржээ. Үүнтэй холбогдуулан Чингисийн дүр бүхий шуудангийн маркыг хүчингүй болгон шатаалаа. Д.Пүрэвдоржийн Чингис найраглалыг хориотой гэж зарлав.

1962 он. “Дахин нийгэмчлэх” хөдөлгөөн болов. Малчид хувьдаа говьд 75 толгой, хангайд 50 толгойгоос илүү малтай байх эрхгүй болов.

1965 он. “Лоохууз, Нямбуу, Сурмаажав нарын намын эсрэг бүлэглэл” гэгчийг илрүүлэн тас цохив. Хэдэн зуун сэхээтэн хэлмэгджээ. Олон арван хүнийг нутаг заан хугацаагүй цөлөв.

Үүнтэй холбогдуулан Лхамжав, Баасанжав нарын хүнийг шоронд хорив.

1966 он. МАХН-ын их хурлаас намын программ батлав. Монгол улс дэлхийн коммунист хөдөлгөөний салшгүй нэг хэсэг гэж тодорхойлоод АНУ-аар толгойлуулсан империализмын эсрэг тэмцэх нь гол үүрэг зорилго гэж үзлээ.

1968 он. Нэрт эрдэмтэн Ц. Дамдинсүрэнг буруутгах компаниг ажил өрнөв. Монголын түүхийн мянган жилийн лит зохиосон нь буруутгах гол шалтаг болжээ.

1969 он. Төрөөс хууль гаргалгүй, зөвхөн МАХН-ын Улс төрийн товчоонд яригдаад Монголд Зөвлөлтийн 70-80 мянган цэрэг байрлах боллоо.

1969 он. Урлагт буй болж буй хөрөнгөтний хэлбэрдэлтийг бут цохисон МАХН-ын Төв хорооны тогтоол гарлаа. Барималч Доржсүрэн, зураач Баяр нарын олон уран бүтээлчид энэ хэрэгт орон Ерөөгийн модны үйлдвэрт мод ачигчаар нутаг заагдав. Төрийн шагналт зураач О. Цэвэгжав “Эхийн сэтгэл” хэмээх цагаан дээр цагаанаар зурсан зургийнхаа төлөө шийтгэл хүлээв.

1970 он. Коммунист аж төрөх ёсны номлол гарав. Хөрөнгөтний хэлбэрдэх үзлийн эсрэг хөдөлгөөн өрнөж залуучууд үсээ ургуулсан бол хүчээр тайрах болсон ба өмдний шуумагны өргөнийг 28 см-ээс хэтрүүлж болохгүй зааврыг бүхүйлчилгээний газарт МХЗЭ-ээс өгөв.

1972 он. Монгол улсыг социалист интеграцид багтаахаар

МАХН-ын ТХ-ы тогтоол гарлаа.

1972 он. МАХН-ын шийдвэрээр ЗХУ-аас 5 жил тутамд 3 тэрбум шилжих рубль зээлээр авах боллоо.

1973 он. Сэтгүүлч Оршихын Цэрэндоржийг үзэл суртлын алдаа гаргасан хэргээр шоронд 7 жил хорихоор болов.

1974 он. Яруу найрагч Р. Чойномыг эсэргүү шүлэг бичсэн хэргээр 5 жил гянданд хорихоор болов. Тэрээр хэлмэгдүүллийг “МАХН-ы машин” гэж нэрлэжээ.

1975 он. Их эрдэмтэн Б. Ренчинг буруутгах хөдөлгөөн өрнөв. Түүний тухай гүтгэлэгийн материал хэвлэлд гаран үүнийг хэлэлцэх ажиллагааг улс даяар өрнүүлэв. Тэрээр хэдийгээр нам бус боловч түүний талаар МАХН-ын тогтоол гарав.

1976 он. Социалист ёсоор амьдарч хөдөлмөрлөх 17 зарчмыг МАХН-ын их хурлаас батлав. Залуучуудаас хамгийн түрүүн шаардах шаардлага нь МАХН-д үнэнч, коммунист үзэлтэй байхыг албан ёсоор тулгалаа.

1977 он. Цэргийн зардал ДНБ-ий 30 хувьд хүрэв.

1978 он. “Гавьяа” гэсэн нийтлэл сонинд гарч “Орос жолоочийн хэрэг” гэгчид холбогдсон олон сэтгүүлч хэрэгт орж цөлөгдөв.

1979 он. “Шүүхийнхний хэрэг” гэгч зохиомол хэрэг үүдэв. Олон хүн хэлмэгдлээ.

1979 он. Нийгмийн өмчөөс шамшигдуулах, хулгайлах явдал ихсэж байна гээд МАХН-ын ТХ-оос социалист өмчийг нүдний цөцгий мэт хайрлах тухай зарчмын хоёр лоозон гарав. Бүх хүнд албадан цээжлүүлж, газар болгонд лоозон хадав.

1980 он. “ШУА-ынхны хэрэг” гэгчийг мандуулж, академич Б. Ширэндэвийг буруутгах компани улс даяар өрнөв. МАХН-ын тогтоол гарлаа.

1980 он. “Эмч нарын хэрэг” гэгч мандлаа. МАХН-ын тогтоол гарав.

1983 он. Жалан-Ажавыг шившиглэх компанит ажил өрнөв. Түүнийг нутаг заан цөлж, хамаатан садан үр хүүхэд найз нөхдийг нь ажлаас нь халж гудамжинд гаргав. МАХН-ын тусгай тогтоол гарлаа.

1983 он. Гуравдагч орны (коммунист бус орны) иргэдтэй гэр бүлсэг холбоо тогтоосон хүмүүсийг эх оронд нь хүчээр татаж авчран шийтгэх МАХН-ын ТХ-ы тогтоол гарав. Үүнээс болж гадаадад сурч байсан 30 гаруй оюутан дуудагдан буцаж ирж, хөдөлмөрийн фронтод шилжив.

1984 он. МАХН-ыг 40 гаруй жил толгойлсон Ю.Цэдэнбал

Зөвлөлтийн санаачлагаар өөрчлөгдөв.

1985 -10- 2. Д. Төмөр-Очир учир битүүлэг байдлаар алагдав.

1988 он. Арбитражийн гүйлгээ буюу “алт диллерийн” гүйлгээг байнга хийж байх үүргийг МАХН-ын ТХ-ы Улс төрийн товчооноос Улсын банкинд үүрэг болгов.

1989 он. М. Горбачев Красноярскт үг хэлж, Хятадтай сайжрахын тулд Монголоос эгшин зуур цэргээ гаргана гэж амлав. Зөвлөлтийн цэргийг гаргаж эхэллээ.

1989-12-10. Анхны улс төрийн сөрөг бүлэглэлүүд үүсч

эхэллээ. Анхны цуглаан зохион байгуулагдав.

1990-3- 7-оос10. Сүхбаатарын талбайд Монголын ардчилсан холбоо өлсгөлөн зарласнаар Монголын нийгмийн байгууламж солигдох эхлэл тавигдлаа. МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцров.

1990 оны 5-р сар. Монголын улс төрийн намуудыг Дээд шүүх бүртгэв. МАХН анх удаа төрд бүртгүүлээ. Урьд нь төрийн бүртгэл зөвшөөрөлгүйгээр төр барьж байжээ. Дээд шүүхээс Монголын ардчилсан намыг дураараа загнадаг, Монголын социал демократ намыг Ленин болон социализмыг шүүмжилдэг хэмээн бүртгэхээс цааргалав.

1990 оны 7 дугаар сар. Монголд анхны чөлөөт сонгууль болов. МҮЭ, МХЗЭ зэрэг нь МАХН-тай нэг “эвсэл” болж сонгуульд орлоо.

1990 оны 9-р сар. Монголд олон намын байнгын ажиллагаатай парламент бий болов. МАХН суудлын 60 хувийг

бүрдүүллээ. Гурван намаас бүрдсэн Засгийн газар бий болов.

1990 он. Коммунист залуучууд болон коммунист хүүхдийн, коммунист үйлдвэрчний эвлэлийн, коммунист эмэгтэйчүүдийн байгууллагууд болох МХЗЭ, МПБ, МҮЭ, МЭБ зэрэг нь тарлаа. Оронд нь олон тооны олон нийтийн байгууллагууд үүсэв.

1991 оны 5-р сар. Өмч хувьчлах шийдвэр парламентаас гарав.

Үүнийг тойруулсан эсэргүүцлийн хийрхэлийг МАХН зохион байгуулав.

1991он. МАХН өөрийн дагах үзэл суртлыг эртний Энэтхэгийн философич Нагаржунагийн сургаал гэж албан ёсоор зарлав. Өнгөрсөн 70 жилийн харгислал, аллага, хэлмэгдүүлэлтийг МАХН бус харин Коминтерн зохион байгуулсан гэж зарлаад энэхүү хэлмэгдүүлэлтэд хамгийн их хохирсон нь МАХН юм гэж сурталчилах боллоо. МАХН-ын удирдагч нь Даш-Ёндон.

1992-1-13. Шинэ үндсэн хууль батлагдав. Олон нам, олон ургальч үзэл, өмчийн олон хэлбэр, үг хэлэх эрх чөлөөг үндсэн хуулиар баталгаажуулав.

1992 он. Малыг малчдад буцааж өгөх хөдөлгөөн өрнөв. МАХН тууштай эсэргүүцэв.

1992 оны 7-р сар. Сонгууль болж МАХН 76 суудлын 71- ийг авлаа. Шилжилтийн хүндрэлийг ардчилал руу тохож, өмч хувьчлах гэх мэтийн ажлыг зогсооно, шударга явдал дахин тогтооно гэсэн нь амжилтын үндэс болжээ. “Алт диллерийн хэрэг” гэгч амжилтын гол үндэс байв.

1992-96 он. Өмч хувьчлал үндсэндээ таг зогсов. Харин энэ хооронд 220 орчим сая долларыг Засгийн газар өөрийн дэмжигч компани пүүсүүдэд тараасан ба өгсөн авсан бичиг баримт нь устан алга болжээ.

1993 он. Монгол орныг далайд гарцтай болгоно гэж МАХНамаллаа. Далайн цэргийн сургуульд анхны оюутнууд явав.

1993 он. Монгол улсын гадаад худалдаа, агаарын орон зайг Хундгар Хосэйн гэгчид Засгийн газар 100 жилээр сэм түрээслүүлжээ. Асуудлыг парламентэд танилцуулсангүй.

1995 он. Тайван жагсаал хийж цалин хөлсөө нэмэгдүүлэхийг шаардсан багш нарыг Засгийн газрын даалгавраар дотор нь тагнуул оруулан чагнах төхөөрөмж тавьсан нь илчлэгдэв.

1995 он. Инфляци түүхэнд байгаагүй дээд хэмжээ болох 325 хувьд хүрлээ.

1996 он. Аварга амжилт бүртгэгддэг Гиннесийн ном-д дангаараа төрийн эрх тасралтгүй барьсан дэлхийн дээд амжилтыг МАХН 75 жилээр тогтоов. Үүний өмнө ЗХУКН нь 74 жилээр рекорд тогтоогоод байжээ.

1996 оны 7-р сар. 75 жилийн дараа анх удаа МАХН төрийн эрхээс сонгуулиар зайлуулагдлаа. Гэвч парламентэд бойкот хийхүйц тооны суудалтай үлдсэн учир Чуулганы хуралдааныг

100 гаруй удаа бойкотлон тасалдуулж нэг төрлийн аварга амжилт тогтоов.

1996 оны 9-р сарын 15. Өнгөрсөн 75 жилд ёс бусаар хэлмэгдүүлэн хөнөөсөн, аллага таллага хийсэн буруудаа Монголын төр Монголын ард түмнээс уучлал гуйв. Жил бүр хэлмэгдэгсэдийн өдрийг тэмдэглэж байхаар болон тэдний дурсгалд зориулж хөшөө босголоо. Төрөөс хэлмэгдэгсэдийн ар гэр үр хүүхдэд нөхөн төлбөр төлөхөөр болов. Аллагыг гардан зохион байгуулж, удирдан чиглүүлсэн гол институци болох МАХН үүнийг өөрийгөө доромжилж байна гэж үзэн ард түмнээсээ уучлал гуйхаас татгалзав.

1997-98 он. Банкны реформ хийгдэв. 1991-1996 оны хооронд

100 орчим сая ам. доллартай тэнцэх мөнгийг зээл нэрээр тарааж, санхүүгийн систем бүрэн нурултанд орсон байжээ. Банкны реформыг мушгин гуйвуулж, гүтгэлэг зохиосноор МАХН чамгүй шуугиан үүсгэж амжив.

1998 он. МАХН өөрийн үзэл суртлын туг Нагаржунагийн онолоос албан ёсоор татгалзаж, Ардчилсан социализм хэмээхүзлийг баримтлах гэж байгаагаа зарлалаа. Шалтгаан нь намын удирдагч солигдож Н.Энхбаяр толгойлох болжээ. 1990 оны нийгмийн хувьсгалыг МАХН ба Үнэн сонин удирдан хийлгэсэн юм гэж сурталчлах боллоо. Коммунист залуучуудын байгууллагыг дахин сэргээн байгууллаа. Нэр нь Монголын ардчилсан социалист залуучуудын холбоо.

1998-10-2. Ардчилсан хүчний удирдагч нарын нэг С.Зориг учир битүүлгээр алагдлаа. Энэ нь Монголын төрийг дэнжигнүүлэх МАХН-ын үндсэн тоглоом болон хувирлаа.

1999 он. “Казиногийн хэрэг” гэгчийг мандуулав. Ардчилсан хүчний доторх хагаралыг ашиглаж хийсэн энэ зохиомол хэрэгт УИХ-ын 3 гишүүнийг шоронд хорилоо.

1999 он. Бойкот хийж хурал хаях хүчээрээ сүрдүүлэн үнэ цэнэт аж ахуйг хувьчлах ажлыг

МАХН бүрэн зогсоож чадав.

2000 оны 7-р сар. Сонгуульд МАХН 76 суудлын 72-ийг авчүнэмлэхүй амжилт гаргав. Энэ нь сонгуулийн тогтоцоос их болжээ. 1996 онд сонгогчдын 43 хувийг авч ялагдаж байсан бол энэ удаа 50,2 хувийг авч парламентийн суудлын 94 хувийг авлаа. “Зоригийн хэрэг” гэгч нь сонгуулийн компаний гол хөзөр байв. Газар хувьчлуулахгүй, ардчилсан хүчнийхнийг шоронд хийнэ гэсэн уриалгууд их амжилтын бас нэг үндэс байв. Сургууль эмнэлэгийг үнэгүй болгох, татварыг 30 хувь бууруулах, цалинтэтгэвэрийг 2-3 дахин нэмэгдүүлэх амлалт өглөө. Сонгуулийн нэгж хороодын нийт бүрэлдэхүүний 90 хувь нь МАХН-ын гишүүд аж.

2000 он. Сүүлийн таван жилд Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт анх удаа хасах үзүүлэлттэй гарлаа. Хасах 1,5 хувь болсон нь Монголын иргэн бүр урьд жилээсээ 12 мянган төгрөгөөр ядуурав.

2000 он. Олон улсын байгууллагуудтай хамтарч хийж байсан төрийн бүтэцтэй холбоотой бүх хөтөлбөрийг зогсоов. Үзэл суртлын шалтгаанаар төрийн мэргэшсэн 15 мянган хүнийг ажлаас нь халав. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлийн хуулийг хүчингүй болгож Засгийн газрын дор Телевиз радиог авав. Чөлөөт хэвлэлүүдийг нийлүүлж Чөлөөт хэвлэлийг дэмжих сан гэгч олон нийтийн нэг байгууллага болгоод даргаар нь МАХН-ын даргын эхнэр тавигдав. МАХНамын төв хэвлэл Үнэн дахин төрийн татаасаар хэвлэгдэх болов.

2001 он. “Мянганы зам” хөтөлбөрийг дэвшүүлэв. 7 500 км болох энэ замд нийтдээ 7 тэрбум ам. доллар шаардлагатай юм. Монголын Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 1 тэрбум доллар. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 1 хувь хүрччадсангүй.

2002 оны 3-р сар. ЗХУ-д тавьсан 9,8 тэрбум шилжих рублийг 11 тэрбум ам. доллар гэж Монголын Засгийн газар хүлээн зөвшөөрөв. Энэхүү их өрийн дөнгөж 7 хувь нь Эрдэнэт, Монросцветмет зэрэг байгууламжинд зарцуулагдсан ба 60 гаруй хувь нь хөдөө аж ахуйн нэгдлийг бэхжүүлэхэд үрэгджээ. Нэг хүнд ноогдох хүлээн зөвшөөрөгдсөн гадаад өрөөр Монгол улс дэлхийд тасархай нэгдүгээрт оров.

2002 он. Үнэ цэнэт аж ахуйн хувьчлалыг авилга луйвар хулгай болгон хувиргалаа. Сэтгүүлч Ханддолгорыг шоронд хорих ялааршийтгэлээ. Газар хувьчлах хууль гарсан боловч тариачдад биш компаний эздэд газрыг өмчлүүлэх болов. Үүнийг эсэргүүцсэн тариачдын цуглааныг хүчээр тараав. Шөнө дундын үед 53 хүн баривчилсны дотор сэтгүүлч 10 орчим хүн байжээ. Хэвлэлийн эрх чөлөөний олон улсын үзүүлэлтээр Монгол нь 40-р байрнаас 76-р хүртэл хойшлов.

2002 оны 12-р сар. Монголын малын тоо толгой социализмын үеийнхдээ буюу 36 саяас 23 сая хүртэл буурлаа.

2003 он. Сөрөг хүчний удирдагч Д. Дорлигжавыг ангуучлах ажлыг бүтэн хоёр жил хийсний эцэст АН-ын шинэ дарга М.Энхсайхан руу довтлох шинэ гараа эхэллээ.

2003.03.01

Зүүний намуудын овоолго

Чөрийсөн нэгнийг “энэ амьтны амь нь хаанаа байгаа юм бол гэмээр” гэж зүйрлэж ярьдаг. Зарим нэгний ярьж бичиж байгааг харахад “зайлуул энэ амьтны бор тархи нь байдаг л байгаа даа, бурхан минь” гэж бодогдмоор. Эрдэнэбатын нам, Ардчилсан намтай эвсэлдэж байгааг их хурлын гишүүн гэх нэг зайлуулөөртэйгээ таарсан нэг шар сонинд тайлбар хэлж бичүүлжээ. Эрдэнэбатын нам зүүнийх гэнэ, Ардчилсан нам барууных гэнэ. Баруун, зүүн хоёр нийлээд баларч сүйрч байгаа гэнэ. Бараг л морь, туулай хоёр эвцэлдэхээр юу яаж байгаа юм байх. Урьд нь социал демократ нам барууны намтай эвцэлдэж завхайраад Социал интернээсээ хөөгдсөн гэнэ. Хамаг залуу, идэр насаа дотор нь манаргаж хүн матаж, гүтгэж өнгөрөөсөн өөрийнх нь МАХН-ы машин зүүний магнайд ганцаар шовойн хоцорч байгаа гэнэ.

Нэг нь ярьж, нөгөө нь сонсож, гурав дахь нь үнэмшиж... хоорондоо таарч л байвал яахав дээ. Нэгэнтээ л мань субъект хүний дансанд байгаа болохоор юу донгосох нь “хүний эрх”. Гурван жилийн өмнө сонгуулийн үеэр Дорноговиос Улаанбаатарт сонсогдтол “Манай нам бид хоёр газраа яасан ч хувьчлуулахгүй”, “Социал демократ нам бүүр цаад дэлхийн байгууллагаасаа хөөгдсөн шүү дээ” гээд л гуагачаад явсан. Энэ хоёроос илүү юм өөрийнх нь ярианы багтаамжийн бүүр цаад аппаратанд нь багтаагүй бололтой.

Монголд зүүний, хэт зүүний, дэндүү зүүний, арай дээ гэмээр зүүний, ультра зүүний, тултал нь зүүний намууд л бий. Улс төр судлалын үүднээс бол үүнээс өөр нь огт үгүй. Үүнийг сонгуулийн уриа лоозонгоос авахуулаад хууль тогтоох байгууллагын “туурвиж” байгаа хуулиудаас дурайтал харж болно. Ганц ярьдаг юм нь хуваарилалт. Хуваах юмгүй байж л шударга хуваарилах тухай ярина. 2000 оны сонгуулиар энэ ядуу оронд улс төрийн тав зургаан нам нийлбэр дүнгээрээ 7-9 тэрбум долларын зүйл хуваарилах тухай амалсан гээд бод доо. Хагасыг нь хүнээс гуйланчилж олж ирээд ирээд 400 сая доллар цуглуулж чаддаггүй орон шүү дээ. Орчин үеийн манай гарагийн аль л бүдүүлэг хоцрогдсон цэг болгонд өрнөдөг халуухан яриа, маргааны үндсэн гол сэдэв. Бүтээгээгүй баялагаа шударга сайхан хуваах талаар улс төрийн намууд нь маргалдан хэн нь илүү сайхан тэгш хуваах талаар уралдан цэцэрхэнэ, өрсөж амлана. Ардчилсан тогтоцын аль л сүүдэртэй сөрөг үзэгдэл нь хоцрогдсон бүдүүлэг газар дагнасан хэлбэрээр ардчиллыг төлөөлнө.

Ярьсан шигээ сайхан шударга хуваарилчиж байна уу гэхээр үгүй. Хоцрогдсонхоо хэрээр хомхой. Баялаг бүтээж чадахгүй мөртөө байгаа жаахныгаа нүд хальтрам муухай аргаар, голдуу төрийн нэрээр авилгадаж шамшигдуулна. Нийгэм нь жил ирэх тутам ой гутам ялзарч, ядуу орнуудын уралдаж улам ядуурах тэмцээнд орж буй мэт яаран хойшоогоо тэмүүлцгээнэ. Одоо Монголд Дотоодын нийт бүтээгдэхүүн нэг хүнд ноогдох байдлаар 1999 онтой харьцуулахад 50 мянган төгрөгөөр доошилчихоод байна. Үр дүн ердөө л энэ. Хүн толгойтой бүр нь ийм тоогоор ядуурч дээ. Хэт зүүний намуудын уралдааны төлбөр энэ.

Саяхан Ардчилсан нам өөрийн үзэл баримтлалыг тунхаглан баталлаа. Албан бичиг дээрээ “баруун төв рүү” л гэж байгаа юм. Болтугай болтугай. Баруун үзэлтэй болж баялаг бүтээхээ байг гэхэд зүүн төв рүү тэмүүлж, ядахнаа эхлээд баялаг бүтээгээд дараа нь түүнээ хуваарилах тухай баримтлал гаргаж ирнэ гэдэг Монголдоо л суу билэг! Ингэж үнэгүй болгоно, тэгж

хөнгөлнө,өвөлжөөний чинь үүд хүртэл мянган зам татна, өндөр хүчдэлээр биеийг чинь орооно гэж сонгуулиар өрсөлдөж амлахгүй, харин баялаг бүтээгчдийг дарамтлахгүй байж байгаад овоо мөнгөтэй болоод ирэхээр нь татвараар хагасыг нь хурааж аваад та нартаа тараана гэж ярих нь байна шүү дээ. Энэ бол урьдынхыг бодвол хавьгүй эрүүл ухаан, манайдаа л гайхамшиг гэж болохуйц дэвшил.

Үнэгүй юм цохиодохъё гэсэн хүний хомхой санаан дээр биш, баялагийг өөрөө бүтээж чаддаггүй юм гэхэд бусдын бүтээх бололцоог хаахгүй байя гэсэн эрүүл ухаанд түшиглэж ажиллана гэсэн үг. Уул нь МАХН ч гэсэн улс төрийн байтугай байгалийн баруун зүүнээ ялгахгүй амьтасд хөтлөгдөж явахаар бас жаахан баруун тийш буурь сэлгээд эрүүл саруул платформ дээр эвсчихмээр юм.

2003.05.21

Ерөнхий сайд аа, та арай дэндэж байна!

Монгол улсын иргэн баабараас

Монгол улсын ерөнхий сайд намбарын энхбаярт бичсэн ил захидал

Эрхэм хүндэт Ерөнхий сайд Н.Энхбаяр таны амрыг эрье. Танд ил захидал бичих болсон шалтгаан нь нэгдүгээрт, Монголын

40 мянган компаниас 25-ийг нь ялган авч гаалиар “ногоон гэрлээр” оруулж байх таны тушаалын тухай, хоёрдугаарт үүнийг шүүмжилсэн намайг гүтгэгч хэмээн цоллож өөрийгөө арга ядсан байдлаар өмгөөлсөн “сүрхий” мэдэгдлээ хэд хэдэн сонинд давхар тавьсан тухай болно.

Хоёрдугаар асуудал нь эхнийхтэйгээ харьцуулахад тун чөчүүхэн юм. Үүнийг Мягмараар бичүүлж Худалдаа үйлдвэрийн танхимын дарга Дэмбэрэл гэгчээр гарын үсэг зуруулуулж, эхнэрийнхээ мэдэлд байдаг сонинд тавиулсан л юм билээ л дээ. Одоо цаашид олон сонинд тавьж, радио телевизээр байнга уншин, ард түмнийг “Баабарыг жигших сарын идэвхтэй ажилд” уриалан дуудах биз. Гарын үсгээ зурсан нөхөр чинь “би юун дээр тамгаа дарчихваа!” гэлээ гэгчээр танд хүчиндүүлж ийм юм хийчихсэндээ бантан хүнээр дамжуулан надаас өршөөл эрсэн. Дараа нь би бас утсаар баахан аашилсан. Олон нийтийн байгууллагын сонгогдсон энэ дарга бас таны зөвлөх хийдэг юм гэнэ. Энэ зэргийн бялдууч, мунхаг, нэр төрд дуртай хүн “хүчиндүүлээд” явж байхад гайхах юм алга. Миний мэдэхээр сүүлийн арав гаруй жил Монголд байгуулагдсан нам болгоноордамжиж, сүүлдээ амьтны элэг доог болох гэж байгаа юм шиг “нам бусчуудын нам” гэгчийг байгуулан өөрөө даргархаж ч явсан, одоо танай намын сүүдэрт амь тээж хоолоо олж идэж яваа юм байна.

Ярианы гол нь нэг дэх асуудалд байна. Би “Тагнуул ба улсын (аль улсын?) нууц” өгүүлэлдээ “...Шуугианыг [Ц.Нямдоржийн тагнуулын] далимдуулаад Ерөнхий сайд маань өөрт нь хамгийн их хахууль өгсөн 25 компанийг “ногоон гэрлийнхэн” гэжөхөөрдөж “итгэл” хайрлав. Спирт зөөгөөрэй, бусдын ачааг энэ онцгой эрхээрээ далимдуулан зөөж мөнгө хийгээрэй гэсэн урилга. Чухам энэ л Үндэсний эрх ашигт хохиролтой шийдвэр баймаар юм. “Итгэл даалгүй” цаана нь үлдсэн 10-20 мянган компани нь үүнийг эсэргүүцээч. Үндэсний эрх ашгаа бодооч! Эсвэл ч... ингүүлж байхдаа таарсан ч амьтад даа!” гэж бичсэн нь таны эгдүүцлийг төрүүлжээ. Монгол улсын 40 гаруй мянган компани (Намайг Сангийн сайд байхад 1999 онд ийм тооны компани улсын бүртгэлтэй байсан) дотроос 25 компанийг “итгэл даадаг” гэж гаалийн үзлэг бүртгэлээс чөлөөлж хэлсэн амаар нь бүртгэн татвар авч байх болсноо та ичих ч үгүй “хүнд суртлыг арилгаж байгаа юм” гэж тунхаглажээ. Ганц хоёр “үзмэрийн” зориулалттай компанийг эс тооцвол ихэнх нь танд ээлтэй ханддаг компаний жагсаалт хавсаргасан энэ тушаал шийдвэрчинь Монгол улсын одоо үйлчилж байгаа хууль журам, түүний дотор Үндсэн хууль зөрчсөн ноцтой гэмт үйлдэл гэж үзэж байна.

Эрхэм Ерөнхий сайд та арай дэндэж байна. Ерөнхий сайдын алба хашина гэдэг дагалдаад асар их эрх мэдэл өгч байгаа боловч энэ болгон хуулийн хүрээн дотроо хязгаарлагдсан байх

учиртай. Саддам Хусейн, Ким Чэн Ир, Муамри Каддафид л ийм эрх байдаг байх, миний Монгол орон хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг ардчилсан төртэй, нээлттэй нийгэм шүү гэдгийг улам бүр увайгүйтэн дур зоргоороо авирлах болсон танд дахин нэг сануулъя. Нохойг хэн ч саахгүй нь ойлгомжтой харин таныг бол хэлж шүүмжлэх, буруушаах эрх Монголын аль ч иргэнд бий шүү.

Итгэл даасан компанийг Татварын газар өөрийн үзэмжээр нарийн нягтлан шалгалгүй жил өнжөөдөг ёс бий. Учир нь итгэл алдвал дахиж өмнөхийг нь шалгаж илрүүлж болох бололцоотой. Гэтэл гааль бол нэг л удаа орж ирээд алга болдог зүйл. Итгэл алдсан эсэхийг нь хожим мөрдөн мөшгих бололцоо бараг байдаггүй. Хойд Солонгост Дотоодыг хамгаалахын компаниуд нь гаалийн “ногоон гэрлээр” ордог юм билээ, тэд хайрт удирдагчдаа асар их мөнгөн хахууль өгөх үүрэгтэй байдаг, өгөөд илүү гарснаа өөрснөө авдаг аж. Та очиж очиж ийм увайгүй муухай юм дууриаж ч явах гэж дээ!

Дөнгөж хөл дээрээ тогтож ядан эхлэлийн шатандаа яваа Монголын хувийн бизнесийн салбарыг та л үзэл суртал улс төрийн хандлага чиглэл, үнэлэмжтэй болгосон. Төрийн албыг намд нь хандивласан мөнгө төгрөгийн хэмжээгээр баримжаалан зарж борлуулдаг бүдүүлэг харанхуй аргыг XXI зууны Монголд та л нэвтрүүлсэн. Хувийн хэвшлийнхнийг “манай”, танай” хэмээн үзэл суртлаар ангилан, заримыг нь “ногоон гэрлийнхэн” болгож, заримыг нь зориуд шалгалт нэрээр дарамтлан рэкетлэх аргын монгол хувилбар бол таны ШБОС! Та гүтгүүлж зовж буй хөөрхий зүтгэлтний өрөвдөм дүрийг сайн эсгэж чаддаг. Хүний нэрээр юм бичүүлж уйлагнаж явахаар үнэхээр гүтгүүлсэн юм бол шүүхэд хандах нь илүү ухаалаг алхам биш үү? Чухам чингэж чадахгүй болохоороо л нэг их ажилтай хүн шиг “зав алга” гэх чинь илүү инээдтэй сонсогдож байна. Та шүүхэд нэхэмжлэл гаргавал нэр бүхий компаниуд танаар дамжуулан намд чинь мөнгө төгрөг хандивлаад түүнийхээ шанд албан тушаал, эрх мэдэл, элдэв хөнгөлөлт олсон жишээг би бас чадах чинээгээрээ гаргаж тавья. Таүүнийгээ авилга хахууль биш гэж нотлохын тулд нэлээд зовно доо.

Та хэдийгээр орос хэлний багш боловч нэгэнт одоо багшийн ажил эрхлээгүй, сүүлийн арваад жил улс төрийн ажил гүйцэтгэж улмаар Монгол орны хувь заяаг шийдэх том намын дарга, сайд, Ерөнхий сайдын ажил алба хашиж байгаа учраас макро эдийн засгийн наад захын мэдлэг ойлголттой байх нь таны хувьд зайлшгүй үүрэг. Чухамхүү ийм хөнгөлөлт, хамгаалалт, ялгаварлан гадуурхалт, протекционизм нь улс орны эдийн засгийн цаашдын хөгжилд хамгийн том гай бэрхшээл авчирдаг болохыг та заавал мэдсэн байх үүрэгтэй. Та энгийн ийм зүйлийг мэдэж сонссон байж л шийдвэр гаргах ёстой, энэ бол миний эх орны өмнө хүлээсэн таны үүрэг.

Францын нэрт эдийн засагч Фрэдэрик Бастиагийн Хууль, Нобелийн шагналт эдийн засагч Мильтон Фридманы Хувь заяагаа сонгох нь, Марк Скаузэний Эдийн засгийн ухаан эдүгээчлэгдсэн замнал (Марк Скаузэн гуай энэ намар манай орондөөрийн биеэр морилон ирж лекц уншина) гэсэн та ч уншаад элбэг ойлгочихмоор сонгодог эдийн засгийн хялбаршуулсан бүтээлүүдийг миний бие монгол хэлнээ хөрвүүлж хэвлүүллээ. Гай болтол би л орчуулчихсан болохоос цаад бүтээл нь их сургамжтай, улс орон яавал хөгждөг яавал балардгийг яруу тод илэрхийлсэн үнэхээр гайхалтай бүтээлүүд байна билээ. Эрнандо дэ Сатогийн Капиталын нууц хэмээх шидээвэр бүтээлийн англи хувийг хэн нэг нь танд

бэлэглэсэн гэж би дуулсан, та бэлэг сэлтэн дотроосоо ухаж байгаад тэр гайхамшигт номыг дахин илрүүлэн олж уншвал тун зүгээр юмсан. Ядуу орнууд яагаад хөгждөггүй, ядуу чигээрээ л байгаад байдгийн цаад учир шалтгааныг нээж илрүүлсэн энэ бүтээл Нобелийн шагналд дэвшчихээд яваа. Та энэ сонгодог бүтээлийг уншиж ойлговол хөнгөлөлттэй зээл учиргүй ихээр нь оллоо хэмээн хөөрч давхихаа больж, “манай орны сүүлийн нэг жилд гаднаас авч ирсэн юмны 40 гаруй хувь нь эргүүлж төлөхгүй зүгээр л авчихсан юм” хэмээн сайрхахаасаа ичих болно. Дундад зууны Европын хаад шиг, өнөөгийн хар Африкийн маршал, генералууд шиг хөрөнгө баялгийн тухай ийм болхи хоцрогдсон меркетальч ойлголттой байх нь таны хэрэг боловч XXI зуун гарчихсан орчин үеийн Монгол орны Засгийн газрын тэргүүн ийм ойлголтүнэлэмжтэй байх нь миний Монголын ирээдүйд балагтайгаар тусах учраас энэ бол зөвхөн таны үзэмжийн асуудал биш.

Дундад зууны Францын Сангийн сайд, тань шиг меркенталист Жан Батист Колбэрт баахан бизнес эрхлэгчдийг дуудаж авч ирээд “Та нарт манай төр яаж тусалбал зохиолтой вэ?” гэж асуужээ. Гэтэл тэд “лэс фэр” буюу “биднийг зүгээр зөнд нь л орхичих, энэ л хамгийн том дэмжлэг” гэж хариулсан юм гэнэлээ. Монголын хувийн бизнесийн салбарыг та зөнд нь орхижэх оронд минь тус болж үз. Чухам та бид хоёр хөндлөнгөөс оролцож сайн хүн болох гэж саад тотгор болохгүй бол энэ салбар хөгжиж Монгол орны ирээдүйг босгож ирэх болно.

Ёсыг бодож танд амжилт хүсье.

БААБАР

2003.06.19

Намаа “шинэчлэх” хуучин арга

Улс төрийн нам гэгч ардчилсан тогтолцоотой хамт гарч иржээ. Аль бүлэг ардчилсан сонгуульд төрийн эрх барих вэ гэдэг дээр бүлэглэлүүд үүсч сонгуулийг зохион байгуулдаг байв. Улс орноо яаж хөгжүүлэх, ямар зам мөрөөр урагшлах тал дээр хувь хүмүүс, бүлэглэлийн хооронд маргаан байж л таарна. Үүгээрээ талцдаг болсон нь дараагийн шат. Орчин үеийн улс төрийн намуудад хооронд нь ялгагдах зүйл маруухан болсон. Америкийн Ардчилсан нам, Бүгд найрамдах нам, Германы Христосын ардчилсан нам, Социал демократ намын хоорон дахь зарчмын ялгаа үндсэндээ алга болжээ. Өдгөө өрсөлдөгч бүлэглэлүүдийн хоорон дахь тэмцэл нь ардчилсан тогтоцыг авч явдаг үндсэн арга барил болсон байна. Ялагдсан нь ялснаа хянаж байдаг сайн механизм үүнээс өөр нь үгүй. Иймээс олон намын систем нь ардчилсан төрийг өөрийг нь авч явдаг тулгуур механизм мөн.

Ядуу, буурай, хоцрогдсон, ардчилаагүй орнуудад энэ механизм яаж ажилладаг вэ? Загварыг нь Ленин, Сталин, Мао, Гитлер, Муссолини нар гаргаж ирсэн. Төрийн эргэлт, иргэний дайн эсвэл шуудхан ардчилсан сонгуулиар өөрснөө гараад ирнэ. Тэгээд нэг намын тогтоц буй болгоод бусад улс төрийн хүчнийг боймлон хаана. Дараа нь өөрийн нам дотроо цэвэрлэгээ хийнэ. Ингээд удирдагчийг дагасан монолит үүсгэж авна, улс орон нь авторитари дарангуйллын систем болж хувирна. Сталин яг ингэж хийсэн. Нам байгуулсан “гавьяатнууд” үхэж дуусахад нам жинхэнэ нам болно гэдгийг тэрээр илэн далангүй хэлж байв. Нийгэмд хийрхэл үүсгэн, түүнээ тойруулж намыг үүсгэн санаачлагчдыг шахан зайлуулж байв. Сталины хувьд шахан зайлуулна гэдэг нь алж устгана гэсэн үг л дээ. Ингээд үзэл бодолнь хамаагүй, гол нь өөрт нь “хайртай” шинэ хүмүүсийг олж дэвшүүлэн өөрийгөө хүрээлүүлнэ.

Орчин үеийн ертөнцөд энэ арга төдийлөн явахгүй. Саддам Хуссэйн, Кастро, Ким Чэн Ир, Каддафи гээд цөөн тоогоор буй боловч насгүй болсон. Ингэнгүүт Сталины аргыг “ардчилсан” байдлаар хийдэг шинэ загвар буй болжээ. Латин Америк мэтийн “соёлжсон” орнуудад өргөнөөр ашигладаг энэ аргын Монгол загварыг одоогийн Ерөнхий сайд Энхбаяр амжилттай гүйцэтгэсэн жишээг харагтун.

Эхлээд тэрээр орчин үеийн ертөнцөд таарахааа больсонүзэл сурталтай коммунист намын толгой руу тэмүүлсэн. Холбоотон нь Гомбосүрэн, Бямбасүрэн, Чимэд гээд МАХН-ын доторх шинэчлэгч үзэлтэй ланжгарууд байв. Эрхэнд гаруутаа бүгдийг нь гол гаргасан. Дараа нь Ардчилсан хүчнийг гол дайснаа гэж зарлаад төрийн эрхийг эргүүлж булааж авах шинэ бүлэглэл байгуулав. Гол холбоотон нь Энэбиш, Отгонбилэг, Нямдорж, Бямбадорж, Баяр, Шаравдорж, Багабанди гэх мэт “дунд гарын” боловч голлох шийдвэр гаргагчид байлаа. Төрийн эрхэнд гарвал эдэн шиг хэрэггүй юм байхгүй. Иймээс намынүзэл бодлыг өөрчилж байна, намыг шинэ хүчнээр, ялангуяа залуучуудаар сэлбэж байна гэдэг нэрийн дор тэднийгээ шахан зайлуулах “ардчилсан” аргыг намын дотор нэвтрүүлэв. Ингээд90 оны бужигнаанаас хоосон хоцорсон, гэхдээ төлбөрийн чадвар гайгүйтэй, аль ч намд харьяалагдаагүй яваа шинэчүүлийг “нээн” олж ирлээ. Намд шинэ сэлбэгч хэрэгтэй, мэдээж санхүүгийн дэмжлэг хэрэгтэй, хамгийн гол нь намын даргыг тойрон хүрээлэгчид бүр илүү хэрэгтэй. Ийм замаар Мөнх-Оргил, Удвал, Баатарсайхан, Шагдарсүрэн, Мөрөн, Арвин, Хүрэлсүх... гээд үй олон шиноконууд мөнгөө төлөөд ороод ирэх нь тэр. Цааш цаашдаа эд нь Энхбаярын тойрон

хүрээлэгчдийн жижиг тойргууд үүсгэх нь мэдээж. Завхан аймагт сумын багш хийж байсан хүн нам засгийн “Үнэн” сонины ерөнхий тоймч болоод хотын иргэн болж байр савтай болон мандсанахаа буян заяаны ачыг хариулах ёстой биз дээ. Байгаль өгөөгүй авьяасыг нь намын дарга тушаалаар өглөө шүү дээ.

Төдхөн төрийн гол шийдвэр гаргагч институтүүдийг мөнөөх “тойрон хүрээлэгчид” эзэллээ. Муу ч юм юу байхав, гэхдээ эдэнд байраа тавьж өгөхийн тулд мэргэжлийн 15 мянган албан хаагчид гудамжинд гарлаа. Алив улс орон чанаржсан иргэд дээрээ тогтдог гэж үзвэл Гэгэээрлийн яамны төрийн нарийн бичгийн дарга, доктор Бат-Эрдэнийг техникум дүүргэсэн хөдөө сумын багшаар солилоо гэхээр л Монголын төрийн чадвахи эрс буураад явчиж байгаа юм.

Муу өвчин халдвартай. МАХН ч яахав ингээд ашиг горилсон бэртэгчдээр “шинэчлэгддэг” байж. Хоцрогдсон бүдүүлэг орнуудад ийм маягийн “шинэчлэл” авилга ядуурлын эх уурхай болж байна. Улс төрийн идэвх сонирхол байхгүй нэг сайхан гар л казинод тоглож байгаа юм шиг нэгэн “шинэчлэгчид” мөнгө тушааж намынх гишүүн болж аваад дараа нь тавьсан мөнгөөржүүлж авч болохуйц төрийн албан тушаалд тавигдлаа гэсэнүг шүү дээ. Мөнгийг тарьдаггүй болохоор тэрээр нийгмийн аль л ядуу хэсгийн баялагийг төрийн нэрээр дээрэмдэж авч байгаа хэрэг. Ингэхээр улс төрд зүтгэх нь сайхан байгаа биз?

Энхбаярын сайхан жишээ Монголын улс төрийн бусад намуудад халдах шинж ажиглагдана. “Лидерүүд гэгчээсээ салж байж л алив нам цэвэршинэ”, “Алив нам анх байгуулсан хүмүүсийнхээ шилийг харсны дараа жинхэнэ нам болдог” гэх мэтийн яриа хэллэг элбэг сонсогддог боллоо. Уул нь ч Сталины л үг л дээ. Лидер буюу хошуучлагч гэсэн албан тушаал хаана чгүй. Олон түмэнд танигдсан өөрийн хүчирхэг хүрээлэлтэй, хошуучилж чадаад байгааг нь л олон түмэн хар аяндаа тэгэж нэрлэдэг байх. Энэ “албан тушаалыг” олон түмэн, цаг хугацаа өгдөг. Нээлттэй нийгэмд хэнд нь ч мөнөөх хошуучлагчтай

өрсөлдөх түрүүлэх бололцоо бий. Хээл хахууль авилгаар тойрон хүрээлэгч болон хошуучлах, энэхүү “горилогч нар” дээр тулгуурлан намаа ”шинэчлэх” зэрэг бол харин манайдаа л шинэ юм болохоос хоцрогдсон аль ч оронд хэдийнээ нэвтэрчихсэн хуучин ШБОС юм.

2003.09.16

Хэрэв энэ тоглоом байсан юм бол одоо хэдийнээ шоглоом болсон

Ерээд оны эхээр дэлхий нийтийг хамарсан ардчилсан хувьсгал урьдын Францын хувьсгал, 1848 оны хувьсгал, колонийн задрал зэрэгтэй харьцуулахад харьцангуй тайван хувьсгал байлаа. Нэг талаас хүн төрөлхтөн хавьгүй иргэншсэн, нөгөө талаас коммунизмын уналт нь дайнаар биш бодит ялагдлаар дууссан тул бараг цусгүй хувьсгал байв. Гэвч ямар ч хохиролгүй “найран дундаа” болж өнгөрсөн процесс биш. Чехсловакийн 1989 оны хэрэг явдлыг “хилэн зөөлөн хувьсгал” гэж нэрлэдэг, гэхдээ л тэнд 14 хүн амиа золиослосон. Орост 1991 онд бас л цөөн хүмүүсүхэж хожим Орос улсын баатар болцгоож байлаа. Латвичууд зурагтынхаа дэргэд жагсаал хийж байж цэргийн мөргөлдөөнд хүрсэн. Румын, Албанид бүр ч эмгэнэлт явдал боллоо. Югослав олон жил үргэлжилсэн иргэний дайнд татагдан орсон.

Эдэнтэй харьцуулахад нийгмийн нэг тогтоцоос нөгөөд шилжих процесс Монголд маш тайван, нийгмийн зөвшилцөөнөөр явагдсан. Хулганы хамраас цус гараагүй гэж энэ хувьсгалыг толгойлогчдын нэг Бат-Үүл хожим бахархан тодорхойлж байлаа. Монголчуудын тайван ухаалаг, хүлээцтэйг нэмж бахархахаа мартсангүй.

Арван жилийн дараа харин өөрөө гүтгэлэгээр шоронгийн хаалга татах нь тэр. Энэ хооронд цус аль хэдийнээ урссан байлаа. Хувьсгалын гол удирдагчдын нэг Зориг гэртээ 17 хутгалуулж амь насаа алдав. Хэн ингэснийг бүү мэд. Өөрснөө биенийгээ ингэсэн юм байгаа юм хэмээн хувьсгалаар үзэл суртлаа алдагсад ам нийлүүлэн орлилолдоо. МАХН-ын зохиолч Дожоодоржүүнийг нь харсан байдаг, МАХН-ын сэтгүүлч Төрмандахзургийг нь буулгачихсан, МАХН-ын цагдаа Доржготов онолын хувьд тогтоочихсон, МАХН-ын “Үнэн” яагаад ийм болсныг нь “үнэнгээсээ” маргах аргагүй тайлбарласан, энэ явдлын буруутан нэгэнт тодорхой тул сонгуулийн маргааш гэхэд л шоронд хийнэ гээд МАХН ард түмэндээ амалчихсан, МАХН-ын намын үүр болгонд цуст аллагын цаад жинхэнэ эзэн нь Бат-Үүл, Элбэгдорж, Да.Ганболд нар юм гээд өөрийн шугамаар баталчихсан байв шүү дээ. Бат-Үүлийг шоронд суулгаж суулгаж суллалаа. Хэн ч түүнээс уучлал гуйсангүй, хөөрхий минь ч гэсэнгүй. Монголд ардчилал хөгжиж байгаа нь энэ. Харин ч парламентийн танхимаас одоо болтол иймэрхүү үг арвин цухалзсан хэвээр.

Хуулиар батлагдаж хууль ёсоор болсон тендер дээр “казиноийн хэрэг” гэгчийг үүсгэн хэсэг хүмүүсийг хэлмэгдүүлж эцэст нь бас л хүний амь хохирлоо. Хуулийн хүрээнд болсон банкны реформыг мушгин гуйвуулж хэсэг улсыг идээчин уугаачингаар нь цоллолоо. Жа Пүрэв гэгч энэ тухай ном бичиж намынхан нь худалдаж аваад улс орноор нэг тараасан. Хожим энэ асуудлаар МАХН-ын Энхбаяртай уулзаж “үнэхээр идсэн уусан бол би шоронд орьё, гэмтэнг цээрлүүлэх нь хууль шүү дээ, үгүй бол та нар ядахнаа миний өмнө уучлал гуйх ёстой” гэхээр “сонгуулиар жаахан халуураа л биз, улс төрч хүн байж иймхэн тоглоом даахгүй байхдаа яахав” гэж билээ.

Энэ бүхэн “тоглоом даадаг” улс төрчид гэгчдийнхээ хүрээнээс өдгөө хавьгүй хальжээ. Зүв зүгээр ажлаа хийгээд сууж байсан 15 мянган төрийн түшмэд, албан хаагчид “ардчилсан

хүчний үед ичихгүй ажлаа хийгээд сууж байсан” гэсэн шалтгаанаар гудамжинд гарч амьдралаараа хохирсоныгоо тоглоом наргиа гэж үзэхгүй байхаа. Сонгуулийн үеэр МАХН-ыг дэмжээгүй хэргээр халамжийн шугамаар тараагдаж байгаа гурил будаахнаас хасагдаж байгаа тэтгэвэрийн эмгэний хувьд энэ нь зүгээр нэг тоглоом биш болов уу даа.

Ойрд орой болгон зурагтаар Энхсайханыг зүхэх боллоо. Ард түмнээс хурааж авсан мөнгөний өртгөөр харааж байгаа хэрэг шүү дээ. Тэрэн шиг муу хүн үгүй бололтой юм. Хажууд нь түүний үеийн, адилхан 40 мянгатад өссөн, адилхан орос англихэлтэй, дутуу нь эрдмийн зэрэг цолгүй нэг тарган шар залуу (40 нэлээд гарсан хүнийг “залуу” гэх үү, “хижээл” гэх үү?) манай үеийн манлай баатраараа дуудуулна. Түүн шиг сайн хүн алгаа! Шалтгаан нь арай ч дээ гэмээр хараалгуулдаг нь ажилгүй, өмнөөс нь санаа зовом магтуулдаг нь харин зурагтын цалинг ч бас гартаа давхар атгадаг нэгэн. Монгол оронд ардчилал өөрийн онцлогоор хөгжиж буй нь энэ. Нэвтрүүлэг хийж буй хүмүүс нь ч өөр болж.

Үзэл суртлын тэмцлийн фронтын ахмад дайчин бурхиуд араар нуугдах болжээ. Далдаас зааж өгнө. Харин дэлгэцэн дээр, сонины хуудсан дээр аль ч учраа олохгүй, ирээдүйд томоохон сэтгүүлч болчих юмсан гэж гэнэн мөрөөдсөн жаахан хүүхдүүд. Бүтэн үг хэлж сураагүй нялх амьтдыг ашиглах болж. Гэнэн мөрөөдөлдөө хөтлөгдсөн чааваас охид хэнгэнтэл санаа алдаж нүүр амаа хачин болгон цээжилсэн үгээ сумын клубын уран сайханч шиг уншина. Зусардах ухаанаа ч олохгүй. Ямар сайндаа “манай ерөнхий сайд 500 саяыг хахуульд өгье гэхээр голоод авдаггүй тийм шударга хүн” гэж долигоноод цаадахаа бас алаад хаяхав дээ! Үнэндээ бол эдний ирээдүйг л алж байгаа юм. Зөнөгүүд хоорондоо үзэлцсээр байгаад хэнийгээ ч дийлсэн юмгүй үхэж үрэгдэж дуусна. Харин үе дамжсан өшөө хорсол хожим тэр хэдэн тэнэг нялх юмнууд дээр унана. Ядаж эх эцэг нь анхааруулдаггүй юм байх даа!

Ерэн онд биенээ гүтгэж “тоглодог” байж. Одоо энэ бол хэдийнээ шоглоом руугаа орсон. Энэ хооронд цус урссан, шорон орон болсон, хүний амь сүйдсэн, олон арван мянган хүн амьдралаараа хохирсон. Нэр төр, хувь заяагаараа хохирогсодыг тоолж барахгүй. Завсраас нь ашиг завшаан хайгчид ч сүрэглэнэссөн. Нийгмийг хувааж хагаралдуулсан буруутанг хожим үхсэн хойно нь түүх шүүх биз. Гэтэл тэрнээс нь өмнө “шүүх” гэж олон мянган хүн зурагтаа хага өшиглөх шахаж байна шүү дээ. Ингэхээр л энэ тоглоом биш л дээ.

Дараа нь яах вэ? Өширхөл хорсол улам лавширна. Өнөөдөр Монгол зурагтаар хараалгуулдаг, магтуулдаг хоёрын хяналтаас гарна. Тэд ч үүнийг зогсоож чадахгүй. Нэг талаас зусардагчид, нөгөө талаас өширхөгчидийн хооронд хоолойгоо хэрчилцсэн тулалдаан болно. Завсарт нь мөнөөх учраа мэдэхгүй саваагүйгэнэг бацаанууд ч өртөнө. Өширхөгсөд, зусардагчдын байр сонгуулиар солигдоно. Хүрээ нь харин хавьгүй тэлсэн байх болно. Хуулийн зөв тогтоцгүй, ардчиллын туршлагагүй хоцрогдсон орнуудад энэ нь цаашилсаар иргэний дайнд хүргэсэн жишээ ч мундахгүй. Иргэний дайнаа байг гэхэд төрийн нэрийн өмнөөс гильтондолцоно. Робэспьер айсуй!

2003.09.21

Хоргодох байр

1864 онд Олон улсын ажилчдын холбоо байгуулагдлаа. Санаачлагч нь К.Маркс, Ф.Энгельс. Үүнийг мөн Интернационал гэж нэрлэнэ. Марксистуудтай таарахаа больсон анархистууд 1872 онд Анархист интернационал байгуулагдхав. Харин үүнээс нэлээд хожим 1889 онд 2-р Интернационал байгуулагджээ. Гол зорилго нь ажилчны хувьсгалт үйл хэргийг терроризм болгож буй анархистуудын эсрэг хандсан юм. Энэ зууны арваад оны үед чухам энэ интернационалаас Ленин тэргүүтэй коммунистууд салан тусгаарлажээ. Тэд өөрийн интернационалийг 1919 онд Москвад байгуулав. 3-р интернационал ч гэдэг, гэхдээ Коммунист интернационал нэрээр ихэд алдаршжээ. Гол зорилго нь 2-р интернационалыг ажилчин ангийн эсрэг хандсан оппортунист хөдөлгөөн гэж зарлаад чухам тэдэнд дайн зарлажээ. Өөрсдийгөө оппортунист гэж нэрлүүлсэн социал демократ намууд 1921 онд Вени хотноо 2 хагас интернационал буюу Олон улсын социалист намуудын ажилчны нэгдэл хэмээх шинэ байгууллага байгуулсан ба гол дайснаа большевизм гэж зарлалаа. Үүнээс нэлээд хожим перманент хувьсгалыг номлогч Троцкий 1938 онд 4-р интернационал гэгчийг байгуулж хувьсгалтүйлийг бүх дэлхий даяар явуулахыг уриалах болов. Дайны дараа 1951 онд Өрнөдийн социалист, социал демократ намууд Социалист интернационал байгуулав. Тэд өөрсдийгөө 2 хагас интернационалийн албан ёсны залгамжлагч гэж нэрлээд голүзэл суртлын дайснаа дарангуйлал, түүний дотор большевизм, коммунизм гэж тунхаглажээ. Интернационалуудын товч түүх иймэрхүү байна.

XX зууны түүхийн нэгээхэн томоохон хэсэг нь чухам энэхүүолон интернационалуудын хоорондын тэмцэл болой. Баруун социалистууд, социал демократ намууд хүн төрөлхтний нийтлэгүнэт зүйлсийг эрхэмлэж, парламентийн ардчиллыг зөвшөөрдөг бол анархистууд, дараа нь коммунистууд, мөн троцкистууд эсрэг байр суурьтай байв. Аль аль нь нийгмийн тэгш хуваарилалтын төлөө боловч арга техникийн хувьд болохоор тэс хөндлөн юм ярьцгаана. Хөрөнгөтөн буржуй нарыг ерөнхийдөө л зүхэх болохоос бие биенээ гол дайсан болгож үзэж байлаа. Сталины заавраар Германы коммунистууд Социал демократуудтай тулалдаж байж Гитлерийг засгийн эрхэнд гаргасан. Сталин Этлитэй гэхээсээ консерватив Чөрчилтэй амархан хэл амаа ололцож байв. Бүхий л коммунист орнуудад хамгийн ихээр дайсагнан суртчилдаг байсан бай нь Скандинавын социализм байлаа. Большевик Орос болон Зүүн Европын коммунист орнууд буй болуутаа меншевик, социал хувьсгалчид, социал демократууд, социалистуудтай хамгийн хатуу тооцоо бодожүй олноор нь алж устгаж байв. Өрнөдийн орнуудад ч социал демократ намууд л буржуй нараа бодвол илүүтэй коммунизмын эсрэг хамгийн тууштай зогсогч нь байсан юм.

Хүйтэн дайн дууссаны дараа биенээ үздэггүй дайснуудын хооронд хачирхалтай нь эвлэрэл буй болж эхлэв. Наяад оныүед Рейган, Тетчер нарын байгуулсан Дэлхийн ардчилсан холбооүзэл суртлын гол сөргөлдөгч нь болж хувирсан учир Социалист Интернационал өөрийгөө хуучны коммунистуудаар сэлбэж эхлэв. 50 – 100 жилийн түүхтэй интернационалчид дэлхийн хамгийн том цэгүүд болох Энэтхэг, Хятад, АНУ, Оросын улс төрийн намуудыг өөртөө нэгтгэж чадаагүй явсан, энэ утгаараа зөвхөн Баруун Европын үзэгдэл хэвээр явж иржээ. Гэтэл шинэ боломж нээгдлээ.

Польш, Чех, Румын, Унгарын хатуу коммунистууд нэрээ солиод зүсээ хувилгаад хүрээд ирэв. Хуучин уламжлалаасаа татгалзсан, цоо шинээр зохион байгуулагдсан, дайнаас өмнө байсан социал демократ намынхаа уламжлалыг авсан, намынхаа бүх өмчийг төрд буцааж өгсөн гэх мэтийн түмэн сонирхолтой шалтаг тоочсоор ирнэ. Үнэндээ эдгээр намууд шинээр зохионбайгуулагдсан гэх боловч дал наяд оны үед явуулдаг байсан бодлогоо л ардчилалыг сэргээн тогтоосон орнуудад явуулна. Коммунист дэглэмд хүний бүхэл бүтэн 2-3 үе амьдарсан хүмүүст эрх чөлөөнөөс коммунист амлалт илүү нөлөөтэй байдаг аж. Никарагуагийн Сандиногийн коммунистууд булааж авсан зүйлсээ цаг нь ирэхээр эгшин зуур өөрсөддөө хувьчлаад эргээд помещик нам болон хувирсан нь дэлхийн коммунист систем зүсээ хувирган санхүүгийн олигархи болох сайхан жишээ болжөгөв. Энэ жишээ ялангуяа хуучин ЗХУ-ын Дундад Азид цэцэглэн хөгжиж байна.

Коммунистууд өөрийн тогтнож ирсэн зуу шахам жилдээ хүн төрөлхтний эсрэг том гэмт хэрэг үйлдсэн. Фашизмд хөнөөгдсөн хүний тооноос тэдэнд алагдагсад илүү гарна. Өнөөдөр Социалист интернационалынхан хуучин коммунистуудыг “засарсан”, “хүн төрөлхтний нийтлэг үнэлэмжийг зөвшөөрдөг болсон” гэх мэтээр цайруулах болжээ. Герегийн хар хурандаа нар, Франкогийн фашистууд ч дайны дараа “засарсан” харин хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг нь түүх өршөөгөөгүй. Тэгвэл яагаад коммунистууд нүгэлт гэмт хэргийнхээ төлөө өршөөгдөх ёстой билээ?

Үнэндээ Социалист интернационал нь олон улсын хэмжээнд гэмт хэрэгтнүүдийн хоргодох газар болж хувирахна уу гэсэн сэтгэгдэл төрнө. Анголын МПЛА нам, Монголын коммунистууд “засрах” байтугай бүхий л хуучин уламжлал, бэлэг тэмдэг, занал зүхлээ хадгалсаар Социалист интернационалын хоргодох газрын хаалгыг тогшиж эхэллээ. Монголын коммунистууд энэ жижиг буурай орны насанд хүрсэн эрэгтэйчүүдийн 20 хувийг “ангийн дайсан” хэмээн буудан устгажээ. Үүнийхээ төлөө тэд ард түмнээсээ уучлал гуйгаагүйгээр барахгүй үүнээ хувьсгалт уламжлал хэмээн бахархсаар. Коммунист амлалтаар нийтийн сонгуульд ялсан тэдний удирдагч “дарангуйл гэж бидэнд ард түмэн саналаа өгсөн” гэж улайм цайм мэдэгдэх боллоо. “Ардчилал, коммунизм хоёрын дундуур явахыг гурав дахь зам гэж Социал интерн болон Тони Блэйр тодорхойлсон” гэж бас нэг удирдагч нь олон улсын Стар ТВ-ээр тунхаглав. Чухам энэхүү өөрийн ойлгосон “гурав дахь замаараа” урагшлан сэтгүүлчдийг барьж хорих, цөөнхийг гадуурхах, тайван жагсаалыг хүч хэрэглэн тараах, мэдээллийн хэрэгслийг монополиялох, нийгэмд дахин айдас хүйдэс буй болгох урьдын зуршмал аргаа идэвхтэй сэргээж эхлэв. Ганцхан жишээ. Клинтонь засгийн газар солигдоход 3 мянган хүн ажлаасаа халагджээ. Хүн амаар 140 дахин цөөхөн Монголд 2000 онд коммунистууд Засгийн эрхэнд гарахад улс төрийн шалтгаанаар 15 мянган хүн ажлаасаа халагдав. Харин тэднийг буудсангүй, учир нь Тони Блэйрийн зааж өгсөн гурав дахь зам! Ардчилал, коммунизм хоёрын дундуур Социалист интернационалтайгаа урагшаа!

Социалист интернационалын дараагийн гишүүд хэн болох вэ? Умарт Солонгосын Хөдөлмөрийн нам, Кубын коммунист нам, Ливийн Каддафигийн нам, Сирийн Асадын нам гэх мэт. Харин Иракийн БААС нам, Камбожийн Пол Потынхон гишүүн болж амжилгүй тарчихлаа.

Шударга царайгаар мөнгө олох нь

Ноднин өвөл Хэнтийн нурууны аглаг тайгаар явлаа. Мөнгөнморьт, Хэнтийн Өмнөдэлгэр, Батширээтийн хойд хэсгээр гэсэн үг. Самарчдын 5-6 мянган хүний сүрэг. Самарчдын хамгийн холоос ирсэн нь Ховд, Өмнөговийнхон. Самар цайруулалт хүртэл механикжаад, махны машин шиг юмаар цайруулна. Кг самар газар дээрээ 2000 төгрөг. Машинтай байтугай морьтой хүн явж хүрэхгүй газар самрын зах зээлээ дагаад бүх төрлийн үйлчилгээ гарчиж. Зах, гуанз, дэлгүүр буурчийн газар бүхий төвлөрсөн үйлчилгээ аглаг тайгад гурванч газар буй болжээ. Байхгүй ч юм алга. Мөнгөний нэгж ньүндсэндээ цайруулсан самар. Өвгөнтийнхон ч очиж. Ганц кг самар түүж түүнээ газар дээр нь борлуулан архидаад л, маргааш нь шараа тайлахын тулд дахин ганц кг самарт явах жишээтэй. БОЯ Хятадын хэдэн компанид самар экспортлох лиценз заржээ.

Өнөөдүүл нь Цэргийн яамыг хахуульдаад монгол дайчдыг авчирчихсан самар түншүүлж ч байх юм. Гэвч хүмүүсийн ихэнх нь мөнгө олох, амьдарлаа тордох гэж хөхөө өвлийн хүйтэнд эзгүй тайгад хэдэн сараар тэнүүчилж явна. Сөрөг үзэгдэл байлгүй яахав, байгаль орчинд халтай олон юм гарч байгаа. Гэхдээ бугын эвэр чив хөөцөлддөгтэй харьцуулахад хамаагүй гайгүй.

Барсболдын самраас олдог хахууль нь багадсан юм уу,өөр зөндөө олон бизнес байхад ганц үүгээр дагнаад яахав гэсэн юм уу, гэнэт “эх оронч” сэтгэл нь хөдлөөд энэ жилээс самар экспортлохыг тас хорьчихов. Самрын үнэ газар дээрээ2000 байснаа Улаанбаатарт зөөж авчраад 700 төгрөг болтлоо шалдаа буулаа. Хятадууд самар худалдаж авдгаараа л авна. Харин ч хямдхан, бүр амар. Учир нь Өрнөдийн зах зээл дээржижиглэнгийн үнээр кг цөмсөн самар 70 мянга орчим төгрөг. Хятадуудын унац эрс дээшиллээ. Газар дээр нь 2 мянгаар авдаг байснаа Улаанбаатарт хүлээж суугаад л голж шилж байгаад 700- аар авна. Кг дутамд нь 300 төгрөгийн хахууль Барсболд, Баатар нарт өгчихөд зүв зүгээр хилээр гаргаж л таарна. Хожоо нь дор хаяж 1000 төгрөг. Самарчдын алдагдал дор хаяж кг тутамд 1300 төгрөг. Угаасаа ингэж төлөвлөсөн ч байхаа даа?

Сөрөг үр дагавартай зүйлийг шууд хуульчлан хорих нь хамгийн хялбар гэхдээ хамгийн мунхаг арга. Сая УИХ архины эсрэг тэмцэж байгаа дүр үзүүлэн 12 цагаас хойш согтууруулах ундаа худалдаалахыг хорьсон хууль гаргаж бизнес хийв. Учир нь архины бизнес далдуур орж улам цэцэглэн хөгжих үндэс буй боллоо. Шөний хоёр цагт хэн ч коко кола уух гэж бааранд очихгүй нь лав. Америкийн гучаад оны мафийн цэцэглэл, гэмт хэргийн гааралт чухам иймэрхүү хорион дээр гаарч хөгжсөн. Хэдэн жилийн өмнө “ёс суртахууны өндөр хэмжүүртэй” Ганди, Шаравдорж нарын гишүүд Монголд биеэ үнэлэхийг хуулиар хориглуулж үүнийг гэмт хэрэг гэж үзэхээр болголоо. Үүнээс хойш ийм төрлийн цэнгээн зогсоогүйгээр барахгүй улам цэцэглэхийн зэрэгцээ далд байдалд орсноороо гэмт хэргийн сүлжээ, нийгмийн халдварт өвчний хүрээг чамгүй тэлжээ. Эдний зүтгэлээр шүү дээ. Сөрөг үзэгдэлтэй хүрээг нь хумих байдлаар тэмцэх хэрэгтэй гэхээр эх орныхоо байгаль орчинд дайсагнадаг, архидан согтуурах явдлыг өөгшүүлдэг, садар самууныг дэмждэг нэр хүлээнэ. Гэтэл үнэндээ энэхүү тас хорих шийдвэр гаргагсадчухам эндээсээ ашиг олох өчүүхэн атгаг аргаа нэгэнт олчихсон байдаг билээ.

Монголд өнөөдөр мөрийтэй тоглох нь тас хориотой. Хуулиар шүү. Чухам тэрхүү хорилцож байсан хүмүүс өнөөдөр зориулалтын нууц газруудаар орох буюу байгуулах замаар хамгийн их далд мөнгө олж байгааг би сайн мэдэх юм байна.

2003.11.30

ХЭВЛЭЛД ЭЭЛТЭЙ ХҮН

(олон улсын сэтгүүлчдийн эрх чөлөөний өдөрт зориулсан онигоо)

Крупская пионерүүдтэй уулзаж, Ленин аль зэрэг хүнлэг хүн байсан тухай ярина.

-Разлив нуурын хөвөөн дэх нэгэн өглөө. Владимир Ильичөвсөн овоохойнхоо гадна суугаад сахлаа хусахаар боллоо. Төө хэрийн урттай сахлын тонгоргоо хурцлан суув. Гэтэл арваад насны нэг хүүхэд хаанаас ч юм гарч ирээд хараад суучихлаа. Ленин хутгаа хурцлаад л, хурцлаад л, байн байн нөгөө хүүхдийг нүднийхээ булангаар хараад л. Хүүхэд ч томоотой номхон зогсоод л. Ленин ч хутгаа хурцлаад л. Тэгж тэгж хурцалсан хутгаа далд хийчихэж билээ. Ленин хүүхдэд ийм л хайртай хүн байсан юм. Тэр хүүхдийг хурцалсан хутгаараа хэрчээд албал алах л байсан шүү дээ.

Одоо онигоо биш үнэн юм ярья. Сүүлийн дөчин жилд гурван сэтгүүлч шоронд оржээ. Оршихын Цэрэндорж Цэдэнбалын засаглалын үед 1969 онд бичсэн зүйлээсээ болж аавын хаалга татсан байна. Үүнээс хойш олон олон засгийн үед ийм явдал давтагдахгүй явсаар Энхбаярын Засгийн үед хоёр ч сэтгүүлч ээлжлэн шорондов. Эхнийх нь сэтгүүлч Ханддолгор, дараагийнх нь Монголын нэг өдөр сонины нэг жаахан охин. Шорон бол жаахан охидын очдог газар биш л дээ. Тэр дундаа Монголын шорон бол тамын ёроол. Ерөнхий сайдын эхнэр “Чөлөөт хэвлэлийг дэмжих сан” хэмээх хувийн маягийн байгууллагатай. Тэгээд эхнэр нь ярьж байна аа. Нөхрөө “хэвлэлд ээлтэй хүн”-ээр шалгаруулж шагнаж байх юм. Үнэн сонин дээр Ерөнхий сайд “хэвлэлд ээлтэй хүн”-ээртодорлоо гээд мөнөөх ээлтэй хүн гэдгийг нь хашилтад хийчихсэн нийтэлсэн байхыг бодоход егөөдөөд ч байгаа юм шиг. Монголд сэтгүүлчдийн эрхийг хамгаалах хоёр гурван байгууллага “бий”. Дарга нар нь гэх шогрий чааваасууд нялх хүүхэд шоронд очсончинь тавлан долигнох юм. Нөгөө бар арслан болсон шар сонинууд нь шоронд хийсэн Ерөнхий шорончинг нь шагнан долдойдох юм. Би онигоо яриагүй, болсон явдал хүүрнээд байна шүү дээ.

Крупскаягийн яриа бол онигоо, Цолмонгийн явдал бол баримт. Гэхдээ сүүлчийнх нь эхнийхээсээ илүү аймаар, илүү инээдтэй. Амьдрал уран сэтгэмжээс түрүүлж явдаг жамтай аж, энэ хөөрхийлөлтэй оронд.

Онигоо дуусаагүй байна. Манай үеийн нэрт гүтгэгч Мөрөн хэмээх цагдаа нялх хүүхэд цагдаадаа өгч захиалж байж шоронд хийчихсэнийгээ “Миний сонгуулийн өмнөх зар сурталчилгаа” гэж бахархангуй өгүүлэх юм. Сонгууль дөхөхөөр өвчин нь хөдөлдөг юм шиг байгаа юм. Өөрөө цагдаа хариуцаж байсан мөртөө 2000 оны сонгуулийн үеэр ардчиллынхан Зоригийгоо алчихсан гэсэн санааг хоёргүй нэг утгаар ойлгогдохоор “зар сурталчилгаа” хийгээд явсан нөхөр шүү дээ.

Чингисийн шууд удмын хатагтай Цолмон Ерөнхий сайд асан өөрийн нөхөр Энхбаярын хэрхэн хүмүүнлэг байсан тухай зурагтаар ярина.

-Туулын хөвөөнөө Улаанбаатар хэмээх хот байхад нэгэн

өглөө Намбар ван Энхбаяр маань сонин аваад үзтэл Уянга хэмээх хүүхэн сэтгүүлч түүний маань Казинод орооцолдсон баримтыг олоод сонинд тавьчихжээ. Манай нөхөр шүүхдэж шүүхдэж байгаад тэгсхийгээд орхисон. Тэр муу хүүхэнд цаазаар авах ялөгвөл өгөх л байсан. Хэд хэдэн сэтгүүлчийг шоронд явуулсан боловч араас нь уйлагнан бараг л уучлал гуйж, шоронгийн хуяг нартай уулзан бага дарамтлаарай, цөөхөн хүчирхийлээрэй гэж захиж байсан баримт нь өдгөө архивт үлджээ. Ийм л шударга,өрөвч, хүмүүнлэг хүн байлаа даа.

2004.05.03 буюу Олон улсын сэтгүүлчдийн эрх чөлөөний өдөр

Хэний мөнгөөр хэн наргина вэ?

Сонгууль угтсан наадам, шоу Монгол үндэсний их баяр наадмыг ардаа хол хаялаа. Үндэсний наадам гурав хонодог бол сонгуулийн найр хоёр сар үргэлжилнэ. Мөнгө хайран биш. Мөнгөн тэмдэгт нь плакат, шоу, нэвтрүүлэг, зарлал, сонин хэлбэрт өөрчлөгдөн тэнгэрээс хур болон бууна. Хэдэн арван тэрбум төгрөг. Зах зээлийн эргэлт нэмэгдэж байгаагаараа эдийн засгийн хувьд муу бус үзэгдэл. Харин хэний мөнгө энэ их үерт урсана вэ?

Бид бүгдээрээ татвар төлөгчид. Энэ хорвоо дээр Робинзон Крузогоос өөр татвар төлөлгүй амьдарсан нэг ч хүн үгүй. Хараахан төрөөгүй гэдсэндээ байгаа хүүхэд ч татвар төлдөг. Татварыг заавал татварын байцаагчид аваачиж өгдөг юм биш. Агга гурил, үмх мах худалдаж авсан ч хагас нь татвар болон төсөвт очно, үлдсэн хагас нь үйлдвэрлэгчид очно. Кг гурил 500 төгрөгөөр авлаа гэж бодъё. Борлуулагч болон үйлдвэрлэгчидүүнээс 240 төгрөгийг нь татварт өгөөд, өөрснөө 260-ийг нь хувааж авна. Ингэхээр улсын татварт борлуулагч, үйлдвэрлэгч биш, худалдан авагч та л жинхэнэ төлөгч нь байгаа биз дээ.

Чи сард хэдэн төгрөг олно, түүнийхээ бараг хагасыг татвартөгч байгаа. Аль ч нийгэм ганц ч иргэнээ татвараас гадуур байлгадаггүй. Хүний нийгэм угаасаа ийм билээ.

Монголын 2 сая хагас хүн хүүхэд хөгшин гэлгүй толгой дараалан татвар төлж байна. Энэ мөнгийг өөрсдийн сонгосон гэгдэх гишүүддээ хариуцуулж, Засгийн газартаа захиран зарцуулах эрхийг нь олгосон хэрэг. Захиран зарцуулагсад мааньёноодөр хуруу хумсаа хуйхалж, Тамирын мөсийг долоож олсон хэдээр маань наргиж гарлаа.

Ариунааг МАХН 80 саяар худалдаж аван сар сурталчилгаанддуулуулах болж гэнэ. Зах эээлд ийм үнэ хүрч байгаа Ариунаагаараа бахархахаас өөр яахав. Түүний зөв. Түүний хувьд энэ нь шударгаар олж буй мөнгө.

Харин түүнд өгч буй мөнгө бол эрх баригчдын гараар орсон бидний мөнгө. Энэ наян саяыг хөдөлмөрийн ариун орлого огтоос үгүй Энхбаяр зурагтаа зарж гаргаагүй, төрийг байтугай амиа аваад явах нь эргэлзээтэй Бямбадорж байшингаа зараад авчраагүй, Идэвхтэн хэдийгээр хэд хэдэн дэлгүүртэй помещик боловч тэндээсээ улаан мөнгө гаргаагүй.

Эцэст нь бидний буруу. Эцэст нь ард түмний буруу. Эцэст нь системийн буруу. Учир нь өөрийнхөө бүх мөнгөний тэн хагасыг хүнд найдаж өгчөөд араас нь хянах байтугай сураг ч тавихаа мартжээ. Өөрийнх нь мөнгийг плакат сонин болгоод өөрт ньөгөхөөр учиргүй баясан нам засгаа улам хайрлах юм бид.

Достоевский нэгэнтээ “ямар л ард түмэн байна, тийм л төр дээр нь байдаг гэж хэлжээ. Иракийн ард түмний байгаа царай нь л тэр учраас Саддам Хусейнтэй болсон гэсэн үг. Гурван жилийн дотор гурван сая хүн нь өлбөрч үхчихээд байхад мэргэн жолоодогч Ким Чэн Ирээ шүтсээр суугаа умард солонгосчуудын талаар өөрөө ямар бодолтой байна?

Зарчим алдагдахын цагт...

Үлгэр шиг юм ярья. Гэхдээ үнэхээр болоод өнгөрчээ. Ардчилсан нам хуралдаад дарга нараа сольчихжээ. Ардчилаагүй нь ч сольчихдог юм чинь сонин юу байхав! Дарга нар нь эзгүй байхад гэнэт хурал зарлаад огцруулан шинэчилсэн юм байна. За даа, иймэрхүү хуйвалдаан энд тэндгүй л байдаг, тэрний нэг л биз. Хуучин дарга нь хууль дүрэм зөрчсөн хурал гэж үзээд гадаадаас эсэргүүцлийн факс явуулжээ. Даргаа өгөхгүй л гэсэн юм биз дээ. Шинэ дарга нь өөрийгөө жинхэнэ “жогорхой” мөн гэдэг талаар хэвлэлийн бага хурал хийжээ. Даргад дуртай л юм байгаа биз. Манай өнөөгийн араншинд байдаг л нэг үйл явдал. Иймэрхүү юманд нийгмээрээ дэндүү дасаж дээ.

Одоо сонин юмыг нь хэлье. Хуучин даргын эсэргүүцлийн факсыг Монголд хэвлэж нэвтрүүлэх газар олсонгүй. Эрх барьж буй хэсгийн эрх ашигт хортой гэж үзсэн хэрэг. Гэтэл Монголын радио нэвтрүүлчихсэн байна. Гэхдээ шинэ даргын мэдэгдэлтэй хамт нэвтрүүлжээ. Өөрөөр хэлбэл хүмүүс маргалдагч хоёр талын аль алины байр суурийг сонсож өөрийн дүгнэлтээ гаргах бололцоо олгосон гэсэн үг. Чөлөөт нийгмийн үндсэн баримталдаг зарчим. ийм л байдаг, ийм л байх ёстой, ийм байлгахын тулд хүн төрөлхтөн олон зуунаар тэмцсэн, ийм зарчмыг л тэртээ 15 жилийн өмнө Монголын ардчилсан холбоо тунхагласан.

Үзэл суртлын мангасууд цочирдлоо. Дараа нь цуглаж хуралдав. Буруутныг тодруулахаар шүү дээ. Ингээд Монголын радиогийн орлогч дарга Ханддолгор Ардчилсан намын хуучин даргын мэдэгдлийг бүр байчихаад бүхэл бүтэн улс даяар цацах зөвшөөрөл өгсөн нь газар дээрээ нотлогдож, улайм цаймбаригдав. Радио телевизийн дарга Б.Ганболд хэмээх Ху намынүнэнч зүтгэлтнийг дуудаж авчраад буруутан Ханддолгорыг одоохон ажлаас нь гаргаж, радиогийн байшингийн өмнө билэг тэмдгийн шинжтэйгээр лааз өшиглүүлэхийг үүрэг болгох нь тэр. Нөгөө Ганболдын нүд нь ёстой магнайн дээрээ гараад ирж дээ. До яамны Нямдорж ийм үүрэг өгсөн бол гайхаад байх юм алга, байнга л ингэж дарамталж байдаг юм чинь. Гэтэл энэ үүргийг мөнөөх “ардчилагчид” түүнд даалгасанд цочирдсон хэрэг.

Асуудал дороо өндөр авч, ардчилсан зарчмыг хамгаалдаг сүүлчийн Могикан Бат-Үүлийн сонорт хүрснээр бөөн хэрүүл уруул болон эцэст нь Ерөнхий сайдаар шийдүүлэн нэг удаа тогтмор аядсан байна. Түрхэн дээ, одоохон доо! Дахиж үзэл суртлын алдаа гаргахгүй болзолтойгоор.

Монголын коммунистууд болоод ардчилагчид хоорондоо юугаараа ялгаатай юм бэ? Цаг хугацаа өнгөрөх тусам үндсэн ялгаа нь арилсаар байна. Аль алин нь Монгол улс хөгжих ёстой гэдэг дээр ам нийлж байгаа. Зах зээлийн тогтоц, нээлттэй нийгэм Монголын хөгжлийн таатай орчин гэдгийг эцсийн бөлөгт хүлээн зөвшөөрч байгаа. Хувийн хэвшил давамгайлсан эдийн засгийн бүтцийг мөрөөдөх болсон. Хээл хахууль нь улс орны хөгжлийнчөдөр тушаа мөн гэдгийг бараг л ойлгож байгаа. Улс орон цаашаа явахаа больчихсон үндсэн шалтгаан механизмдаа байна, иймээсүүндээ томоохон реформ хийх нь зүйтэй гэж аль алин нь үнэн санаанаасаа ний нуугүй ярьж байгаа.

Гэхдээ коммунист гэдэг бол хэн нэгнийг шоолж ичээхийн тулд хочлоод байгаа юм биш, цаад

араншин, биеийнх нь эд эс болтлоо суусан ойлголтыг нь хэлээд буй хэрэг. Коммунист хүнч гэсэн сайн бизнесмэн, сайн эцэг, сайн дарга байдаг төдийгүй сайхан сэтгэлтэй, ирээдүйгээ улам сайхан болгох хүсэл эрмэлзлэлтэй байдаг. Харин нийгмийн ирээдүйг сайн сайхан болгох өөрийн бодож олсон аргаа 100 хувь яс мэдэж байдаг учир, тэр бэлэн жорыг нь шүүмжилсэн хүнийг тэвчдэггүй. Коммунист хүн империалист Америкийн холбоотон ч болж болно, хувийн өмчийг шүтэн бишрэгч болж өөр дээрээ ч жишээзүүлж чадна, Ленин, Сталины хөшөөг ч нурааж дөнгөнө, “Төр ба хувьсгал” зохиолыг хэрэглээний зориулалтаар жорлондоо тавьжч чадна, ижилхэн нэртэй гурван эхнэртэйгээ нуух байтугай бахархан сонин болгоноор ярилцлага ч өгчихнө... харин бусдын шүүмжийг бол ёстой тэсэхгүй. Өнгөрсөн дөрвөн жилд гурав дөрвөн сэтгүүлч шоронгийн хаалга татаж, хэдэн арваараа цагдаагийн үүд сахиж, олон зуугаараа “хахуулийн золиос” болсонд гайхах юм үнэхээр үгүй. Тэд энэ хавчлагаа өөрийн зөнгөөрөө хийдэг, хэн ч ингэхийг шаардаагүй байхад төрөлх инстинкт нь бүр дотроос нь, бүр голоос нь хатгадаг. Энэ бол тэдний араншин, төрөлх чанар! Хэрэв чөлөөт хэвлэлийн эсрэг, үг хэлэх эрхийн эсрэг “дорвитойхон” хөдлөхгүй юм бол ямар юмных нь коммунист байх билээ.

Монголын “ардчилагчид” гэгчид араас нь орлоо. Чоно дагасан гэрийн нохой илүү аюултай гэдэг. Тэд мөн л чөлөөтүгийг аргумент мэтгэлцээнээр биш, хууль, шорон, ажлаас халах, хашраах, сүрдүүлэх, лааз өшиглүүлэх, хахуульдах, засдаг зан гаргах, худалдаж авах аргаар боймлох сурталд нэвчиж эхэллээ. Цаад боохойноосоо ялгарах юм алга. Ариун зарчимд шан харамжаар үйлчилсэн бол, илүү төлсөн тохиолдолд чөтгөр ороолонд ч үйлчилнэ. Дөрвөн жил лааз өшиглөсөндөө гутарч, лааз зарчим хоёрыг хоёуланг нь үзэн ядаж буй хэрэг юм даа. Нарийн яривал би ч чөлөөт хэвлэлд дургүй, усанд чанасан шар будаанд дургүй шигээ дургүй. Гэхдээ бусдыг чанасан будаа идэхийг хориглох эрх надад байхгүй. Үүнийгээ л би зарчим гэж ойлгодог.

Хэдхэн сарын өмнө энэ буланд тэртэй тэргүй “хүн” байжүзээгүй До яамны Нямдоржийг “Тагнуул Нямдорж хүнээ байжээ хөө” гэж бичиж байхдаа хэзээ нэг цагт хүн шиг харагдаж, зарчим ярьдаг байсан нөхдийнхөө тухай тун удалгүй “ардчилсан хүчнийнхэн ч алийгаа алдаж ээ хөө” гэж бичих юм чинээ санасангүй. Зарчим дээрээ нийлээгүй юм бол юун дээр нэгдсэн хэрэг вэ? Албан тушаал, авч луйвардах, ахиухан хулгайлах, авилга идэх, аргалж торгоох... ердөө л энэ үү? Тэгвэл үүнийг чинь шайка, мафи, бүлэглэл, ганг энээ тэрээ гэж өөрөөр нэрлэдэг шүү дээ. Намайг багад тавин мянгатын ногоон Чойлонгийн бүлэг, дөчин мянгатын мангар Чукагийн бүлэг гэж байсан. Лав л тэднийг

Чойлонгийн улс төрийн ардчилсан нам гэж нэрлэж байгаагүй лямдаг.

2004.12.25

Намуудын дампуурал

Одоогоос 150 орчим жилийн өмнө анх Англид улс төрийн нам буй болжээ. Нэгэнт төрийн дээд институци болох хууль тогтоох гүйцэтгэх эрхийг хэрэгжүүлэгч байгууллагыг ард түмнийүзэмжээр, тэдний чөлөөт сонголтоор буй болгодог болсон болохоор сонгуулийн ажлыг зохион байгуулах олон нийтийн байгууллага хэрэгтэй болсон байна. Тэр нь улс төрийн нам юм.

Улс төрийн намыг нэн чухалчилж үздэг байсан хүний нэг нь Маркс. Тэрээр үндэстэн дамнасан нэг ангийн нам байгуулахыг санаархаж байв. Энэ нь анхдугаар интернациональ. Ард түмний чөлөөт сонгуулийг зохион байгуулах ёстой төрийн бус байгууллагыг төржүүлж, сахилгажуулж төрийг булаан авах хэрэгслэл болгосон анхны пионерүүд нь Италийн фашист Муссолини, Оросын большевик Ленин нар билээ. Бусад улс төрийн бүлэглэлийг зөвшөөрдөггүй, улс орны дотор бол нийгмийн бүх эд эсэд нэвчсэн, төрийг гартаа тас барин нийгмийг дарангуйлж байх бүлэглэл буй болгох санаачлага эднийх, үүнээч гүйцэлдүүлж чадсан. Ленин бүр цаашилж намын дотор ч элдэв фракц бүлэглэл байхыг хориглосон бүтэц зохиосон билээ. Улс төрийн намын энэ бүтцийг улам хөгжүүлэн төгөлдөржүүлсэн хүмүүс нь Германы нацист Гитлер, Хятадын коммунист Мао нар билээ. Дарангуйллын системтэй болоод ирэхийн цагт мөнөөх ард түмний сонгуулийг зохион байгуулах үндсэн утгаа алдаж, нийт ард түмнийг хамарсан дарангуйллын багаж зэвсэг болон хувирчээ. Эд бүгдээрээ “нам бол масс” гэж үздэг, гэхдээ нөгөө масс нь хуарангийн сахилга баттай, бусад өөр ямар ч үзэл бодлыгүл тэвчдэг, дарангуйлагч төрийн сахилгажуулагч бороохой байлаа.

Улс орноо гадаадын булаан эзлэгчдээс чөлөөлөх хэд хэдэн бүлэг Монголд 1920 онд буй болжээ. “Нам нэгдэж, сэм хуйвалдана” гэсэн үгнээс анх монгол хэлэнд “нам” гэдэг үг буй болжээ. Харин эдгээр бүлгүүд нийлж салсаар эцэст нь 1924 он гэхэд Лениний намын бүтэц зохион байгуулалтыг олсонбайна. 1928 он гэхэд бүтэц, зохион байгуулалт, нийгмийн үүрэг, сахилга бат зэрэг бүхий л үзүүлэлтээр мөнөөх л Муссолини, Ленин, Гитлерийн намтай нэг стандартынх болж чаджээ. Ийм намын бүлэглэл нь улс орныг жолоодох үүргийг хэний ч зөвшөөрөлгүйгээр өөртөө авдаг. Тэгэхээр сонгууль ч гэж юу байхав, тийм үүргийг гүйцэтгэх шаардлага ч юу байхав!

1990 оноос МАХН нийгмийг жолоодох үүргээсээчөлөөлөгдсөнөөр орчин үеийн иргэнжсэн ойлголтоор улс төрийн нам болж хувирлаа. Зэрэгцээд МоАН, МСДН, МҮДН байгуулагджээ. Нийгэм нээлттэй боллоо, гэвч ийм нийгэмд тохирсон улс төрийн нам гэж юув, ямар зохион байгуулалттай, үүрэг зорилготой, гадагшаа ба дотогшоо ямар механизмаар хөдөлдөг зэрэг талаар хаалттай нийгмийн гишүүдийн хэнд нь ч ойлголт байсангүй. Ганц авч болох үлгэр нь МАХН-ын туршлага. Ингээд шинэ буй болсон бүх намууд гишүүнчлэлэээргөжүүлэх дайн хийжээ. Тэр үеийн статистикт болон өөрсдийн суртчилгаанд нь үнэмших юм бол насанд хүрсэн хүн амынхаа тоотойгоо тэнцүү буюу илүү хүмүүс намд харьяалагдах болов. Хүмүүс илүүтэй прагматик байдаг тул маш олон нь бүх намуудад зэрэг элсэж байлаа. Намын удирдлагууд сургуулиар яван хүүхдүүдийг ч энэ тоглоомдоо нэгтгэж байв. Явцын дунд Монголд улс төрийн намын утга учир бүрнээ үгүй болох нь тэр. Иймэрхүү жишээ шилжилтийн олон оронд зэрэг давхцаж байсан юм.

Мөнөөх Ленин, Гитлерийн жишээгээр намыг дахин нийгмийг жолоодогч бүлэглэл болгох гэж оролдсон хүн нь Н.Энхбаяр. Тэрээр 1997-2005 онд МАХН-ыг толгойлж байхдаа Монголын ард түмэн дотроос шилмэл үүлдрийн омог буй болгохоор зорьжээ. Ницшөтэй хагас дутуу танилцсан бололтой. Хяналтгүй эрх мэдэл, нийгмийн гадуурхал, хүчний байгууллага, сүрдүүлэг, ард түмний мөнгө өмч хөрөнгө, эрүүл ухаанаас нэлээд алсуур суртал нэвтрүүлэг зэрэг ашиглаж болох болгоныг хэрэглэснээр тэрээр маш их амжилт олов. Намаа ленинжүүлж, маожуулж чадаад байгаа юм шиг харагдав. Гэвч хуурамч амжилт.

Өөрийгөө тахин шүтүүлэх гэсэн нэг бус тэнэглэл нь нээлттэйнийгэмд явцыг олсонгүй. Чингис хааны хүргэн гэдэгт нь чхүмүүс төдий л үнэмшсэнгүй.

Монгол дахь улс төрийн намууд эхнээсээ нээлттэй нийгэмдүл таарах бүтэц зохион байгуулалттайгаар буй болсон тул улам явуургүй болон бүгд дампуурлаа. Баруун, зүүн, төвийн, фракцтай, фракцгүй, үндэсний, нэг компанийн, ах дүүгийн, гэрээслэлийн, хонзогнолын, баячуудын, борчуудын гээд байж болох төрөл зүйл нэр хаягтай байсан авч хэн нь ч зөв механизмтай нам байгуулж чадсангүй. Натураль үр дүн нь нам нэртэй бүлэглэл өнгөн дээрээ байгаа юм шиг харагдавч дотор бүрээ эрх ашгийн бүлэглэлүүд болон хуваагдсан ба тэр нь өөр юутай ч нийлэн мутант болон цааш үргэлжилдэг механизмтай аж. Ард түмний сонгууль дээр өөрийн нэр дэвшигчийг унагах, бүлэглэлүүд биенээ худалдаж авах, худалдагдах, наймаацах ньөнөөгийн Монголын аль ч улс төрийн намын үндсэн ажил. Энэ бүхэн зөвхөн мөнгөн дээр тогтох ба зөвхөн мөнгөөр хэмжигдэнэ.

МАХН-д нэгдвэл ажил хийлгүйгээр амьдарч болно гэсэн ойлголтыг Энхбаяр нийгэмд өгсөн учир олон залуучууд тийш хошууран зарим нь үнэхээр тийм байдгийн үр шимийг харуулсан амьд зурагт хуудас болон гольф тоглон найрааны начин царайлаад хэврүүлж явна. Ингэж болдог сайн зам байна гэж залуу үедээ ойлгуулсан нь нийгмийг моралийн хувьд улам ялзруулж байгаа билээ. Өдгөө Алтан гадас нам руу ч залуучууд тэмүүлээд уналаа. Ажил хөдөлмөр хийхээс өөрөөр бас сайхан амьдарч болдгийг зааж өгдөг “Миний их сургууль” тэнд бий.

Үхсэн хүнийг эмчилж болдоггүй. Өөрийн үүргээ гүйцэтгээд нэгэнт үгүй болсон өнөөгийн улс төрийн намуудыг эмчлэх бололцоо үгүй л болов уу. Учир нь бүтэц зохион байгуулалт, хөдлөх механизм нь нээлттэй ардчилсан нийгэмд яав ч зохицохгүй гэдгээ амьдрал практикт нэгэнт харуулсан. Улс төрийн шинэ хуваарилалт, түүнээ дагасан шинэ бүтэц механизм хэрэгтэй. 150 жил нээлттэй нийгмүүдэд хэрэглэж ирсэн, зам зууртаа хичнээн олон шалгарал даван улам төгөлдөржсөн, иргэншсэн, олон улсын тэр л механизмыг “шинэ” гээд байна л даа. Үнэхээр Монголын нээлттэй ардчилсан нийгэмд шинэчлэлхэрэгтэй болжээ. Энэ нь улс төрийн намын тогтоцоос л эхлэхээсөөр аргагүй.

2005 он

Ээлжит бус сонгууль руу!

Нийгэм самуураад, хүмүүс ядууран төрд итгэх итгэл алдраад эхлүүт нийгэм өөрөө тогтворгүй болж эхэллээ. Энхбаярын дэглэм унаснаар хүмүүс санасан бодсон болон эсэргүүцэж буй зүйлээ ил хэлж шүүмжилдэг болжээ. Олон нийтийн янз бүрийн хөдөлгөөнүүд үүсэн янз бүрийн шаардлага тавьж, нэг талаас харахул хар дарсан зүүд шиг феодалын ёс сэргэсэн богино хугацааны дараа нийгэм эргээд эрүүлжиж эхлэв. Ерөнхий феодалд бэлэг хахуулиа өгчихвөл доошоогоо юу ч хийж болдог, хуулийг үл тоон огоорч өөрийн хавтгай дээр бас нэг феодал болж аваад доороосоо хахууль аван суудаг феодалын бурангуй ёс халагдаж эхэллээ. Феодалын ёс гүнээ нэвчсэн Монголын цагдаа хүртэл эрүүлжихнүүдээ гэмээр болж эхлэн юутай ч жижиг хамжлагатан нарт эрүү үүсгэн, хавтаст хэрэг нээж, тэр байтугай түрүүнийхээс нь баривчилж эхлэв. Ердөө жил хагасын өмнө Нямдорж сайдыг хэн “муухай” гэж хэлэв, Ерөнхий феодалын хатанг хэн муулав гэж хайсан, баривчилсан, байцаасан, бараг цорын ганц ажилтай байсан товарищууд шүү дээ!

Олон нийт сэрж байна. Бухимдаж байна. Өөрсдийнх нь юмыг өөрсдөөс нь хулгай хийгээд дээрээс нь доромжилж байгаа юм шиг өөрсдөөр нь өөрийгөө магтуулж байсныг хүмүүс одоо л мэдээд уурлаж байна. Хайчилж байгаа туузанаас авахуулаад гурван дуракын машин шатахууны мөнгө хүртэл, тарааж буй одонгоос нь авахуулаад гадаадад жуулчлах тийз хүртэл, сэтгүүлч байцааж буй цагдаагийн цалингаас авахуулаад эрхэм дээдсийн орд харшийг хүртэл тэнгэрээс хүртээдэг юм биш хүмүүс өөрснөө хармайнаасаа төлж байгаа юм байна гэдгийг өөрснөө ойлгож эхэлж байна. Хуучин хүү өөрийг нь хөмөрч орхисон тогооноосөөрөө цухуйж, цамцныхаа заханд багтахгүй болтлоо таргалсан олон олон даргыг гайхан харж буй дүр зураг.

Үймсэн олон эдүгээ хувьсгал ярих боллоо. Их хурлыг тараая, Засгийн газраа онхолдуулъя, тэгээд оронд нь хэн гарч ирэх вэ? Лав Засаггүй улс гэж хүний түүхэнд байгаагүй. Өнгөрсөнхаваржин Энхбаярыг даган бүх аймгаар орж “Монголд авилга байна гэдэг бол гүтгэлэг” гэсэн нэг сэдэвт лекцээ уншиж явсан нөхөр түлхэж аваад оронд нь очих уу? “Бурхан минь ийм шүүгчээс л манийгаа аварч үз!” гэж Крыловын нэг үлгэрт гардаг. Хүний өмчийг сүйтгээд улаан мах тэврээд зугтаж байсан тэр хүмүүс нийгмийг анагаагчид мөн үү? Нөгөө хар тамхи татаж согтчихоод баахан газрыг дэлбэлдэг амьтсын тухай яриад ч хэрэг байна уу? “Аварга дээд сургууль” гэсэн хаяг мандуулчихсан шил болгоныг хагалж хүний машин өшигчиж явсан “найрааны бялзуухайнууд” уу?

Өнөөгийн УИХ-ын гишүүд хичнээн муу муухай байгаад эд ард түмний мандаттай улс. Эднийг сонгосон. Эднээс мөнгийг нь авч байгаад долоон буудлын Должин чавганц сонгосон юм. Должин чавганц Үндсэн хуулиар сонгох сонгогдох эрхтэй. Энэ бол зарчим. Энэ бол чөлөөт нийгмийн хамгийн анхны постулат. Энэ бол зөрчигдөж болохгүй үнэ цэнэ!

Итгэж байсан юм, хууртагдчихлаа, амлалтанд нь молигодууллаа, даанч ингэнэ гэж санасангүй гэх мэтийн тайлбар бол өнөөдөр дэндүү явуургүй эд. 15 жил өч төчнөөн чөлөөт сонгуульд орчихоод дандаа л “хууртагдаж” байсан бол үгүйдээ л толгой нь ёо ёотой байж таарна. Асуудал нэг нь хуурсан нөгөө нь хууртагдсандаа биш, төрийг ажиллуулах өнөөгийн механизмдаа байна. Ингэхээр механизмаа өөрчлөх шаардлагатай.

Өнөөгийн УИХ нь “сонгуулийн хууль”, “намуудын тухай хууль”-ийг яаралтай шинэчлэн батлаад өөрөө тарах нь хамгийн оновчтой зүйл байна. Энэ хоёр хуулийн үндсэн дээр парламентийн ээлжит бус сонгууль явуулж азаа үзэхээс өөр хувилбаргүй болсон мэт. Мөн энэ их хурал өөрөөс нь хэд дахин илүү ялзарчихаад байгаа Сонгуулийн хороо хэмээх дээрэмчдийнүүрийг орвонгоор нь солих ёстой. Чоно борооноор гэдэг болохоор парламент солигдож олон түмэн үймж байгаа энэ үед Ерөнхийлөгчид хамаг юмаа завшуулбал нуухыг нь авах гээд нүдийг нь сохолж орхино. Ерөнхийлөгчийн сонгууль, УИХ-ын сонгууль, орон нутгийн сонгууль гурвыг зэрэг, хурдан, реклам багатай үтэр түргэн хийж дараагийн нөхдөл найдаж залбирах лажил байна даа. Яагаад гэхээр шинээр сонгогдсон Төр өөрийгөө ажиллуулах дараа дараагийн механизмыг гаргаж ирэх учиртай юм. Тийм юм руу одоо байгаа хэдийг ойртуулах хэрэггүй, ёстой нэг завааруулна даа.

Намууд гишүүнчлэлгүй байх, төрийн албан хаагч ямар чнамын гишүүн үл байх, улс төрийн ба төрийн ажлыг эрс зааглаж өгөх асуудал нь намуудын тухай хуулинд тусгалаа олох ёстой. Харин сонгуулийн хууль нь асар томсгосон тойргоор холимог байхад буруудах юмгүй. Гэхдээ сонгогдогч этгээд худалдаад авах бололцоогүй болтол том тойрог байх нь нэгдүгээр ач холбогдол юм. Өнөөдөр олон нийтийн байгууллага сая зурагтаар ярьж буй “УИХ бушуухан тараадах, надад цаана нь хийх ажил зөндөө байна” гэх шиг юманд хөтлөгдөж боломгүй санагдана. Лениний террорист сурах бичгийг цээжилчихсэн эрдэмтэн 15 жилийн өмнө Смольный байгуулан залуучуудыг Өвлийн ордон руу тухирч байж билээ. Олон нийтийн хөдөлгөөнүүд ийм замаар явбал Энхбаяраасаа дор юм болж олон жил үргэлжилсэн эмгэнэл драм болно.

Олон нийтийн хөдөлгөөнүүд хичнээн шударга сайхан байгаад тэдэнд ард түмнээс өгсөн мандат байхгүй. Гэвч тэд УИХ-ыг дээрх хоёр хуулийг бушуу батлаад тарахыг шаардах, уул хуулиудыг боловсруулахад өөрийн төлөөлөгчөө бүрэн эрхтэйгээр оролцуулах, ээлжит бус сонгуулийн өмнө өнөөгийн зүтгэлийн үр шимээ олж авахын тулд тасралтгүй цуглаан жагсаал хийх, сонгуульд оролцож сонгогдох бүрэн эрх бол харин бий.

2005 он

Ардчилсан нам өөд болов

Саяхан сонгуулийн явдал Ардчилсан намыг нэг мөсөн алга болж, түүхийн дурсгалын дэвгэрт мөнхжин хоцорсныг баталлаа. Энэ намыг төлөөлж Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон Энхсайхан нь зөвхөн бие даагчийн хэмжээнд үзэлцэв. Сонгуулийн компани эхлэхээс зургаан сарын өмнө олон нийтийн өмнө шившгийг нь дуудаж дүүжилчихсэн хүнээ намын их хурлаар бараг л 100 хувийн саналаар тодруулах нь тэр. Дараа нь нөгөө зуун хувьтнаа унагах хөдөлгөөн намын бүх аппарат, давхрагад өрнөлөө.

Бараг арван хуруунд багтах цөөн хүн бүхий сонгуулийн штаб хэрээрээ зүтгэсэн боловч Ардчилсан намын нэр нүүр болсон олон эрхтэн дархтанууд нэр дэвшигчээ зүйл бүрээр хорлож байв. Сонгуулийн тактик сайн, бодож боловсруулсан зүйл байсан авчөөрийн зүгээс дэмжлэггүйгээр барахгүй гутаагдаж алиа алдаж байлаа. Өөрийн нам руу буюу намын нэр дэвшигч рүү хандсан дайралтыг зохион байгуулагч, шууд илэрхийлэгч нар нь намаа төлөөлж төрийн өндөрлөгт очигсод байсан. Ардчилсан нам нэр дэвшигчдээ ганц ч төгрөг өгөөгүй гээд бод доо. Намын бүх шатны нэгжид хандсан “намаа задалсан Энхсайханыг сонгох хэрэг байгаа юм уу!” гэсэн философилог асуулт мессеж чухам Засгийн газрын гэсэн хаягаар шуурхай тарж байсан ба гардагч нь намын удирдлага байв. Сонгуулийн хороо илэрхий булхай хийж байхад чухам Ардчилсан намыг төлөөлж парламентэд суугсад хэн хэнээс илүү луйварчдыг өмгөөлж байв.

Монголын өрх болгонд хүрэлцэхүйц хэвлэсэн нугалбар сурталчилгааны арван хувь нь ч эзэндээ очиж чадсангүй. Үүнийг бөөнөөр нь өрсөлдөгч намынхандаа худалдах, хав дарах, устгаж шатаах явдал Ардчилсан намын анхан шатны байгууллагуудад түгээмэл өрнөсөн. Үүнээс гадна үл оролцох, үнсэн дээр шалз болгон хаях хөдөлгөөн өрнөж, дэмжигчдийг сонгуульд оролцуулахгүй ажиллагаа явуулсан нь амжилттай боллоо. Хүн амын 30 гаруй хувь нь сонгуульд огт оролцоогүй дүн бол энэ ажиллагааны үр дүн.

Өдгөө талийгч болчоод байгаа Ардчилсан нам бол 1990 онд шинээр байгуулагдан Ардчилсан хүчин гэсэн ерөнхий нэртэй болж парламентад суудал авсан гурван намын цогцолбор юм. Ийнхүү Ардчилсан нам шинэ Монголын түүхэнд өөрийн гялалзсан сайхан үүргээ биелүүлээд, өдгөө нэгэнт түүхийн дурсамж болон хоцорлоо. Алив улс төрийн намын эцсийн зорилго нь сонгууль байдаг, энэ үндсэн үүргээ биелүүлж чадахгүй бол түүнийг их бодож л сонирхогчдын клуб, олон нийтийн байгууллага, бүлэглэл, сайн дурынхан гэх мэтээр нэрлэнэ. Чухам л энэ утгаар Ардчилсан нам улс төрийн байгууллага нэгэнт биш болжээ.

Нам бол масс гэсэн Лениний томъёоллыг баримжаа болгон нээлттэй нийгэмд энэ онолыг хадгалж үлдэх гэсээр яваад байгалийн жамаар Ардчилсан нам аяндаа алга болж байна. Ийм утгаар авч үзэх юм бол МАХН ч олон жилийн насгүй. Ардчилсан нам устан алга болж улс төрийн системийн хямрал үүсэж байгаа нь жам ёсны процесс болохоос эмгэнэл биш юм. Чухам энэ хямрал нээлттэй нийгэмд улс төрийн нам хэрхэн байгуулагдажүйл ажиллагаа явуулдаг олон улсын шалгарсан жишгийн системийг Монголд буй болгох шинэ бололцоог нээж байна. “Жаран хоёрын бүлэг”, “Эвслийн Засгийн газар” гэх мэт нүдэн дээр болж буй процессууд нь хэсэг бүлэг хүн үзэл бодлоосоо урваж шаравсан явдал гэхээсээ одоо үйлчилж

буй улс төрийн намын тогтоц өөрөө амьдралтай авцалдахгүй байгаагийн гадаад илрэл.

Ийнхүү Монголд улсад төрийн хүчний цоо шинэ хуваарилалт тулгаран ирлээ. Энэ хийгдэх ёстой, үүнийг хийхгүйгээр цааш удаан тэсэх гэж оролдвол харин хямрал нь эмгэнэл болон хувирч болох юм. Коммунист үеэл суртлын дараахи нийгмийн шинэ үнэлэмж бүрэлдэн тогтсон төдийгүй, төлөөлөл, шийдвэр гаргагчдын нас, ертөнцийг үзэх үзэл, өрөнхий ойлголт нэгэнт жигдэрчээ. Гэтэл өнөөгийн улс төрийн намын тогтоц нь нийгэмд авилга хээл хахууль, гэмт хэрэг, хулгай, шамшигдуулал, хариуцлагагүй явдлын “хууль ёсоор” оршин тогтнох шимтэй хөрс болсоор байна. Нийгмийн ямар ч байгууламж бүхий оронд, ерөөс хүний нийгэмд гэмт хэрэг гэж үзэгддэг, тэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар ял шийтгэл хүртдэг хүнд гэмт хэргүүд чухамхүү өнөөгийн улс төрийн намын системээр өмгөөлөгдөн харин ч гавьяа зүтгэл мэтээр үнэлэгдэх болжээ. Нийгмийн үнэлэмжийг ингэж хөлөөр нь толгой хийвэл тэр нийгэм улам ядуурч, “хүний” гэсэн дүрмээс холдон “шугуйн” гэсэн тодотгол руу ойртоно. Сөнөдөггүй юм гэхэд өндийхгүй.

Ард түмний итгэл үнэмшлээр төрийг удирдах бүлэглэл, тэдэнд хяналт тавих хүчтэй сөрөг хүчний бүлэглэл ямар ч тохиолдолд зайлшгүй хэрэгтэй. Монголд болж буй улс төрийн намын системийн хямрал нь энэхүү зайлшгүй байх ёстой хоёр орон зайг аль алиныг нь онгойлгож өгч байна. Ардчилсан нам сайн нам байсан, шинэ Монголын түүхэнд, Монголын ард түмний өмнө үнэлж баршгүй гавьяа байгуулсан. Гэвч энэ нам өдгөө байхгүй, орон зай нь хоосон үлдлээ.

“Хаан нас барлаа, хаан мандтугай” гэсэн ухаалаг франц үг байдаг. Юм жамаараа дууссан бол арынх нь залган гарч ирдэг хорвоогийн дийлдэшгүй хууль. Ардчилсан нам жамаараа нас барлаа... одоо хэнд “мандтугай” гэсэн ерөөл тавих вэ?

2005.06.03

Онош тавьсан моргийн эмч, хутгалчихсан алуурчин хоёрын хэн нь хэрэгтэн бэ?

-Ардчилсан намын ҮЗХ-ны хурал дээр Баабарын хэлсэн үг-

Би сонгуулийн ажиллагаанд оролцоогүй, хаана ч ямар ч ажилд томилогдоогүй. Захиалгаар ном, сэтгүүл, зурагт хуудас хийлцсэн. Ямар нэг хариуцлага үүрэхгүйгээс гадна өөртөө хамаагүй юмыг ярихгүй.

Гэхдээ хөндлөнгөөс харагдсан хоёр гурван зүйл хэлье. Намын нарийн бичгийн дарга саяхан болж өнгөрсөн Ерөнхийлөгчийн сонгуулийг дүгнэж сайхан илтгэл тавилаа. Харин дарга та наад уншсан материалаа хаанаас олов. Миний мэдэхээс Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр ганц ч үзэгдээгүй шүү дээ. Илтгэлээс үзэхэд намын дэд дарга Б.Мөнхтуяа сонгуулийн компанийн дэд дарга байсныг сая олж сонслоо. Нөгөө нэг дэд дарга Н.Батбаярыг Японы телевизээр сумо бөхийн үеэр хоол идээд сууж байхыг нь харсан юм байна. Миний сонссоноор Ерөнхийлөгчийн сонгуульд зориулж манай намаас утасны төлбөр гэж ердөө 50 мянган төгрөг өгсөн гэнэлээ. Миний л хөндлөнгөөс дүгнэж байгаагаар манай нам саяын сонгуульдөөрийн эрчим хүчний 20 хувийг хүнээ ялуулахын төлөө, 80 хувиа гаргаж ирсэн хүнээ эргэж нам дарахын төлөө зарцуулах шиг боллоо.

Ардчилсан нам өөд болсон тухай би бичсэн. Би аналитик хүн, улс төрийн байдлын тухай өөрийн задлан шинжилгээг хийдэг. Монголын аль ч иргэнд ийм эрх бий. Долоон буудлын Должинчавганц ч Ардчилсан нам сүйрчээ гэдэг юм уу, сүндэрлэн босч байна гэсэн өөрийн дүгнэлтээ гаргах, бусдад хэлэх эрхтэй. Магадгүй иргэн хүний хувьд үүрэгтэй ч байж болох юм. Алив улс төрийн намын эцсийн бөгөөд ганц зорилго нь сонгууль. Ардчилсан нам энэ үүргээ биелүүлэх байтугай хөсөрдүүлж байнагэдэг нь энэ нам юутай ч улс төрийн нам гэдэг шинжээ гэжээ гэсэн үг. Магадгүй марк цуглуулагчдын юм уу, автомашин сонирхогчдын клуб байж болох юм. Өнөөгийн нээлттэй нийгэм, зах зээлийн тогтолцоонд Ардчилсан намын бүтэц тогтоц, бүрэлдэхүүн таарахаа больжээ. Ийм хувь заяаг МАХН ч хүлээж байгаа. Энэ хоёр голлох нам нийгэмд өөрийн гүйцэтгэхүүргээ биелүүлээд дуусгавар болсон тул цаашид оршин тогтнох бололцоо муутай болжээ. Хуучин арга барил, тогтоц, механизмаараа шүү дээ. Иймээс улс төрийн шинэ хуваарилалт, шинэ тогтоц, шинэ бүтэц хэрэгтэй болжээ. Энэ нь улс орны цаашдын хувь заяаг шийдэх чухал зүйл шүү. Би ингэж л хэлсэн, ингэж л бичсэн.

Онош тавьсан моргийн эмч хэрэгт орох ёстой юу, хутгалаад алчихсан алуурчин хэрэгт орох ёстой юу? Намайг онош тавьсны төлөө манай дарга нар хэлэх хэлэхгүй үгээр загнаж, орон даяар хараалаа. Би төрд алба хаадаггүй. Хулгай хийдэггүй учир элдэв юм булаацалдаад байх сонирхол алга. 1994 оноос хойш намын нэг ч алба хашиж үзээгүй.

Миний сонирхол татах ажил биш байна билээ. Та нараасаа болоод сонгогч олноосоо гуйгаад зовоогоод байх юм надад огт үгүй. Би хэнд ч гай болоогүй. Гэтэл дарга нар маань намайг “зайлбал таарна” гэх юм. Би хаанаас зайлах болж байна? Тогтоол шийдвэр гаргаад намайг үхүүлэх гэж үү? Тэрийг бол би зөвшөөрөхгүй. Лидер гэж цол хэргэм, албан тушаал байхгүй

шүү дээ. Дуртайдаа хүнийг тэгж нэрлэхээд одоо болохоор лидер чи зайл гээд байх юм. Хамаа алга намайг лойдор л гээд нэрлэх л дээ, гомдох юм ер алга. Би хэнд ч өгсөж авирч юм цуглуулахад нь саад болоогүй. Айлд ороод алтан гудсан дээр нь гараад тэрийгээд хэвтчихсэн юм байхгүй шүү дээ. Үнэндээ та нар л талцаж хэмлэлдээд байгаа болохоос би бие даасан хүн, гадсынхч, гэдсийнх ч биш. Энхсайханы ч хүн биш.

Улс төрийн хүчний шинэ хуваарилалтын тухайд бодит байдал ийм болчихоод байхад ичингүйрээд байх юу байна аа? Хуучин механизм чинь огт явахаа болилоо шүү дээ. Эх орныхоо тусын тулд улс орноо аваад явахуйц улс төрийн намын шинэмеханизм, хуваарилалт, тогтоц руу орох хэрэгтэй байна. Ямар эх орноосоо урваж байгаа биш, санаа нийлдэг нийлдгээрээ өөрөөрийн шинэ сонголтоо хийгээд явбал нийгэмд л тустай. Эх орноосоо урвасан гэгдсэн ч яадгийм. Иргэний харьяаллаасаа гарч байгаа бөх байна. Гадаадын тагнуул хийсэн гэгдэх нөхөр том дарга болж улс орноо цааш чирч явахаар тодорлоо. Тэгэхэд санаа нийлсэн хүмүүс шинэ хуваарилалтад ороход буруудах юм юу байна? Санжийн Баяр бид хоёр олон жилийн дотно найзууд, нэг нам байж болох нь байна шүү дээ. Гончигдорж, Нямдорж хоёр биенээ дэмжээд л дэвшүүлцгээгээд гүйлдэх юм, нэг намд ороод хамтарч ажиллахад буруу юм юу байна, нэг намд зүтгэцгээг л дээ, эх орны тусын тулд үүнд буруу юм алга. Гагцхүү шинэ хуваарилалт маань нээлттэй нийгэм, зах зээлийн тогтоцдоо таарсан, олон улсын жишгийг дагасан, удаан амьдрах чадвар бүхий механизмтай байх ёстой л гэж би бичсэн.

2005. 07.06

АЛТАН ГАДАС АЛЬ ЧИГИЙГ ЗААНА ВЭ?

2000 оны сонгуулиар нарим тавиулсан ардчилсан хүчин нэгдэж нэг нам байгууллаа. Сахил хүртээд шал дордов. Байгуулагдсаныхаа бараг маргаашаас эхлээд намын даргын төлөөх загалмайтны дайн дэгдлээ. Шинэ намын суурь нь МоАН, МСДН. Гэвч 2001 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших бололцоотой хоёр бух зөвхөн эрх ашгийнхаа төлөө мөргөлдөж эхэлсэн ба үүнд өөрийн талын дэмжлэг хайсан М.Энхсайхан урьд МоАН-аас салж байна гэж орилон жорлонгийн өрөөнд сайхан харагдан мурчийж байсан салан тусгаарлагч жижиг бүлгүүдийг улс төрийн нам нэрээр авч шинэ намыг эхнээс нь булингартуулсан билээ.

2001 оны Ерөнхийлөгчийн сонгуульд АН хагаралдаж аваад оров. Энэ хагарал дээр буй болсон нэгэн бүлэг “Алтангадас” хэмээх фракци болж мэндэллээ. Энэ бүлэглэл эхнээсээ нэг талаас нутаг жалгын сүнсэн дээр, нөгөө талаас нам дамнасан шинжээр буй болсон юм. Ерөнхийлөгчид МАХН-аас дэвшсэн Н.Багабандийг унагах зорилготой Ерөнхий сайд Н.Энхбаярын бүлэг Алтан гадас фракцийг төрөх үеэс нь холбоотон болсон билээ.

Намын удирдлагын төлөөх Р.Гончигдорж, М.Энхсайхан нарын тэмцэл улам лавшрахынхаа хэрээр бүлэглэл хоорондын дайн болж өргөжин, нөгөө талаас нийгэмд сөрөг хүчний үүрэг гүйцэтгэх ёстой улс төрийн намыг сулруулж хамаг нэр хүндийг нь барж орхилоо. Сөрөг хүчингүй улс төрийн тавцанд асар том вакуум үүссэн ба энэ орон зайг хэн дуртай нь эзэлж эхэллээ. Энэ зайн ихэнхийг Н.Энхбаярын ба Н.Багабандийн бүлэглэл хоёрын тэмцэлдээн эзэлсэн харин М.Энхсайхан, Р.Гончигдорж нар энэ тулаанд хутгалдан хийж буй үйлдэл болгон нь мөнөөх хоёр аваргын тэмцээний уухай түрлэг төдий болж хувирав. Энэ нь эрх аваад ид томорч байсан Н.Энхбаярын мафи бүлэглэлд нийгмийн баялгийг хоосруулах, хяналтгүйгээр үрэн таран хийх, луйвар булхай явуулах, хууль ёсыг гажуудуулах, нийгмийг тэрчигээр авилгажуулах чөтгөрийн тоглоомд ихээхэн эрч нэмсэн юм. Ардчилсан нам энэ жилүүдэд босоо ороолонг тэтгэн томруулахад маш том үүрэг гүйцэтгэсэн. Алтангадасынхан илүүүрэг гүйцэтгэж луужингийнхаа мэргэн заалтуурыг Энхбаяр руу хандуулав.

2004 оны сонгууль алтангадасынхны хувьд томоохон ялалт болсон юм. Сонгуулийн үр дүнгээр тэрээр жижиг бүлгэнцрүүдийг бүгдийг нь өөртөө нэгтгэж, заримыг нь холбоотон болголоо. Хамгийн хачирхалтай нь дөрвөн жил байлдсан М.Энхсайханыхаа холбоотнуудыг бүгдийг нь урвуулж цаадахаа бараг шалдалж орхив. Энэ шалдарсан хүнийг 2005 оны Ерөнхийлөгчийн сонгуульд түлхэж унагахад нэг их хөдөлмөр орсонгүй.

Алтангадасынхны намдаа ажиллах арга технологи нь Энхбаяраас хуулж авсан ердийн дээрэмчин булхайчны барил. Намын доторх янз бүрийн үзэл бодлыг нухчих бүлэглэж нохой мэт довтлох, энэ хэрэгтээ яль шальгүй албан тушаал амлагдсан өчүүхэн амьтдыг ашиглах, ҮЗХ-ийн сонгууль зэрэг намын удирдлагыг буй болгох сонгуулийг булхайдах, худалдаж авах, бөөрөлхөж шахах, амлах зэрэг болой. Хүний нийгмийн үеүийнхний хэрэглэж сурсан шалгарсан ердийн булай арга тактик.

Нэгэнт улс төрийн нам, нам гэсэн утгаа алдсан учир тодорхой зорилгыг биелүүлэх түр зуурын бүлэглэлүүд үүсэх ба дараагийн асуудал дээр эрх ашиг нь зөрвөл дайсагналцана. Энд

хаа очиж “Алтангадас”-ынхан нэлээд биежсэн тогтвортой маягийн бүлэглэл байсаар байгаагийн нэг шалтгаан нь жалгын томъёон дээр тулгуурласанд оршино. Өөр нэг шалтгаан нь эрх мэдэл байсаар байхад бүлэглэлийг нилээд тогтвортой аваад яваад байж болдог гэдгийг Н.Энхбаярын харуулсан сайхан туршлага бий.

Аймаг хошуу нэг их дамнаагүй боловч нам дамнахыгзүүлээд өгсөн алтангадасынхан одоо болох нийгмийн хөдөлгөөнд хамгийн их хохирох хэсэг ба ерөөсөө ч үнэн хэрэгтээ ийм бүтэц их хэврэг байдгийг мөнөөх л Н.Энхбаяр бас харуулаад өгсөн билээ.

2005.12.21

Нэг иймэрхүү л юм болсон юм даа

Зэмэксисийн “Форест Гамп” киног үзсэн үү? Вьетнамын дайнд гавьяа байгуулсан Гамп Вашингтонд очиж Ерөнхийлөгчөөс одон гардаж авна. Нийслэл хотоо сонирхож явсан тэрээр дайныг эсэргүүцсэн том цуглаанд санаандгүй ороод явчихна. Цуглаан зохион байгуулагч дайны баатар Гампаар үг хэлүүлэхээр болно.

- Би та нарт нэг болсон явдал ярьж өгье хэмээн үгээ эхэлж байх үед нь нэг генерал хамаг микрофоныг нь салгаад хаячихдаг. Хэдэн зуун мянган хүний өмнө байлдагч Гамп микрофонгүйгээр юу яриад өнгөрснийг хэн ч сонссонгүй, ойлгосонгүй. Цуглаан зохион байгуулагчид микрофон чанга яригчийг эргэж ажиллуулах гэж мунгинасаар арайхийж залгатал Гамп,

- За нэг иймэрхүү л юм болсон юм даа гээд үгээ төгсгөж байлаа.

Шинэ он гаруут Монголын Засгийн газар гэнэтхэн онхолдоод явчихлаа. Юу болов гэмээр дунгуй хадаад л явчих нь тэр. Энэ тухай Форест Гамп юу өгүүлэв? Микрофон тасраад нэмэр дээр нь хүмүүс орилолдоод юу болоод өнгөрснийг хүмүүсийн ихэнх нь сайн ойлгосонгүй ч үгүй, сонссон ч үгүй..

Кино зохиолыг бичиж, найруулсан Энхбаяр олон алдаа гаргасан учир тоглож буй Гамп байтугай дэглэгч өөрөө ойлгохоо больчихлоо.

Кино сценари ингэж эхэлжээ. 2004 оны сонгуулийг Энхбаяр Төрөө улам хямрааж, түмнээ улам ядууруулсан их амжилтаар угтсан юм. Тэрээр төрөлх намдаа ч, түмэн олондоо ч нэг хүний дарангуйлал тогтоох гэж хэт улайрсан боловч мянган жил эрхчөлөөтэй явсан нүүдэлчдийн удам хүлээж авсангүй, Маогийншалыг хуулбар түүнийг ширээнээсээ гулсангуут харин ч урьд байснаасаа дордсоноо харуулж эхэллээ. Тэр одоо Ерөнхийлөгч болсон. “Монголчууд ЭВ-тэй байхдаа хүчтэй” гэсэн үл ойлгогдох оньсгон лоозон тавьсаар байгаад гарч ирсэн. ЭВ гэдэг нь ЭнхВауаг гэсэн үг бололтой. Харин сонгуулийн дараа түүний өрсөлдөгчийн “авилгачдыг цээрлүүлнэ”, “эх орны баялагийг иргэд тэнцүү эзэмшинэ” уриа нийтийг хамарлаа. Ингээд эвслийн Засгийн газрыг унагах бодит зайлшгүй хэд хэдэн шалтгаан түүнд буй болсон юм.

1. Хэдийгээр хожим Ч.Улаан өөрийн харъяаллаар далимдуулан өөртөө өмчлөөд авчихсан боловч үнэндээ гаалийн Баатар бол түүнийг аль намын бүлгийн дарга байх үеийнх нь гарын нарийн. Зүтгэлийг нь үнэлж өөрөө түүнийг гаалиар шагнасан юм. Мянганы замын их дээрэмчин Буд, Улаанбаатарын ноймор нэг помещик Бадамжунай гээд Баатарын араас явах хуулийн нормоо хэдийнээ давуулан биелүүлсэн луйварчид бүгд түүний гарын бүтээл. Эдний хэн нь ч Иудай. Аврагч түүнийг 30 мөнгөн зоосоор эргэлзэх юмгүй зарж орхино. Ингээд үлдсэн амьдралаа эрх чөлөөний Куба арлын зүүн эрэг дээр “Туантана мираа” гээд дуулаад сууж өнгөрөөх болбол яана! Ингэхээр нэгэнт эрчээ авч эхэлж буй ангуучлалыг ямарч үнээр хамаагүй зогсоож олны анхаарлыг өөр зүгт хандуулах ёстой.

2. Монголын түүхэнд гэгээтэй үлдэх боломжоо Ерөнхий сайд байхдаа алдсан. Дарангуйлагчийн бүтэлгүй хуулбар, МАХН-ын толгойг залгигч, хээл хахуулийн төрүүлсэн ориг эцэг гээд гарцаагүй үлдэх нотолгоотой хочууд нь хэдийнээ бэлэн болсон. Хэдийгээр өөрөө энэ бүхнээ газрын шүүхээр биш тэнгэрийн шүүхээр оруулж үнэнийг тогтооно гэж заалдаж буй боловч тэнд очоод ч цагаадна гэдэг магадлал нойль! Газар дээр цагаадах сүүлчийн боломж нь Ерөнийлөгчийн нэрээр Монголын гадаад харилцааг сайхан болгох. Хэн ч үгүйч гээгүй тиймүү ч гээгүй байхад “Бушийг би авгайтайгаа нийлж урьж авчраад шүтүүлээд гарсан” гээд үглээд салдаггүй. Ерөнхий сайд байхдаа улсын 70 мянган доллараарзуучлуулж байж гар барин хамт зургаа татуулсан Буш нь шинэ Ерөнхий сайдыг урьсан төдийгүй өөрийнх нь нэрийг нь ч сонсоогүй олон бизнесүүдтэй уулзуулах цагийн хуваарь гаргаад явуулчихжээ. 1990 онд Да. Ганболдыг ганц удаа урьсан Даосын хурал хоёрдахь удаад Монголоос Элбэгдоржийг урьж орхижээ. Сүүлийн 15 жилд донорын цус л цутгадаг Япон анх удаа хөнгөлттэй зээл олгохоор боллоо. Энэ болгоныг тасар татахгүй юм бол ямар юмных нь Чингисийн хүргэн байх вэ дээ.

Ингээд Засгийн газрыг огцруулах нь огцруулаад авлаа. Гэтэл том алдаа гаргажээ. Шинэ Засгийн бүрэлдэхүүнд хэн хэн орно гэнээ? Эрдэнэбат тэргүүтэй Эрэл компани – энэ бол эргэлзээгүй Багабандийнхан. Энхсайхан тэргүүтэй АН-ын сөрөг фракц - дахиад Багабандитай холбоотой, өнөө гайхал Гүндалай – Багабанди эхнэртэй нь утсаар ярьсан асуудлаар мань хүн өөрөө нөхөр нь биш байж жил хардаж гүйсэн. Энэ Энхболд гэдэг нөхөрч цагтаа Багаад сайн байж аавдаа цол өгүүлж байсан, аягүй бол эргээд 30 мөнгөн зоосоор зарж орхино. Багабандийн Санж Баяр нарийн бичгээрээ далимдуулж МАХН нэрээр хичнээн тагнуулч шургуулах юм билээ. Алджээ! Эртний өст Багаад амьдаарааөвчүүллээ л дээ!

Ингээд кино зураг авалт дундуур зохиолдоо засвар оруулжөөрчиллөө. Гэнэт суудал дээрээ эргэн шинэ Ерөнхий сайдыг хүлээж авахгүй гээд гэдийчихэв. “Үндэсний эв нэгдлийн Засгийн газар” гэсэн афоризм зохиолоо. Сонгуулийн дараах эвслийн засгийн газраас ганцхан ялгаа бий нь тэгэхэд тоогоогүй Жагаагаа энэ удаа урьжээ. Гончигоо, Оюун хоёр энэ ЭВ-д орохгүй гээд гэдийчихлээ. Гэвч Монголд 30 мөнгөн зоосоор хэн нь ч хэнийгээ зардаг гэдгийг ийм наймаа олон жил эрхэлсэн хүний хувьд анддаггүй тэрээр албан тушаалгүй удаж гуриатан голдоо ортол гомдсон Гончигоог үлдээн дүү нарыг нь нэг нэгээр нь дуудаж 30 мөнгөн зоос амлалаа. Амлах бол түүний мэргэшил. Чухам ингэжөөрийн багийг бүрдүүлдэг юм. Өнөөдөр түүний үнэнч цэргүүд, харин маргааш бол түүнд хаягдах шоронгийн хоригдлууд!

Өнөөдөртөө арай цадаж амжаагүй өлөнгүүд, маргааш хоолондоохордох хүнд өвчтөнүүд. Энхбаяр эднийг сайн мэднэ. Ийнхүү шинэ баг бүрдэхэд бэлэн боллоо. Түүний зангаагаар хоёр дугаар ээлжийнхэн тогоо тавгаа хангинуулсаар хоолондоо орохоор ирцгээв. Гүтэн аппетит!

2006 он

Үүд хоймрын зайтай суугаа гончигсүх, хүрэлдорж хоёрт ялгаа юу байна?

I

Цаана чинь гамшиг боллоо! УИХ-ын чуулган дээр МУ гамшигийн сайд Хүрэлсүх “Ху намын далбааг шатаасан тухай” хамгийн сүүлийн үеийн, хамгийн гамшигт мэдээг чирж орж ирлээ. Гамшгаа хүзүүн дээрээ тохчихож! Хярвас үнэртээд л... Тойруулсан улаан дусал бүхий дүрстэй уул далбаа дундуураа салж унаад гамшигийн мөрөн дээрээс салбалзах нь нүд халтирам гамшиг. Яагаад ч юм энэ далбаа надад бүтнээрээ байгаадч “савны рак” гэж нэг иймэрхүү юм байдаг болов уу гэж төсөөлөгддөг болохоор одоо энэхүү залуу хунвэйбиний хүзүүн дээр салбайгаад байж байгаа нь огидос хүрмээр сэжиглэм!

Гамшигт сайдын ярьж байгаагаас үзэхэд Сүхбаатарын хөшөөрүү МАХН-ы дайснууд шээж баасан юм гэнэ. Аль гурван жилийнөмнө Энхбаяр гурван тэрбум төгрөгөөр Хятадын компаниар цардуулахад тэд зэрэгцүүлээд жорлонгоо шовойлгочихсон байсан биз дээ. Нөгөө далбааг нь Элбэгдорж чүдэнз өгч явуулаад шатаалгасан гэнэ. Тийм байж болно, тэрийг нь заавал гамшиг сайд өөрөө ноцоож үздэг нь ч юу юм бэ дээ. Элбэгдоржчүдэнзтэй холбоотой асуудлаараа гамшигт сайдаас уучлал гуйх ёстой төдийгүй сайд өөрөө түүнийг мөнөөх хярвастай даавууны сэгний өмнө сөгдүүлж байгаад мөргүүлнэ гэнэ. Үгүй бүр яг ингэж үгчилж ярьсан шүү. Согтуу л байх шиг байна лээ. Гэхдээ энэ зэрэгтэй цойлчихсон гамшиг хямд муухай найрка хусчихсан баймааргүй юм. Төрийн буян гэж байна даа. Магнай дээрээ дазэыбао ороож наасан мань гамшиг үүсгэгч (хэмжигч?)бачимдан орилно,

- Цаана чинь сүйд боллоо! Сүх жанжны байгуулсан намыг гутаалаа. Чойбалсан, Цэдэнбал, Батмөнхийн намыг доромжиллоо. Монгол Улсад тусгаар тогтнол, эрх чөлөөг авчирсан манай намыг доромжиллоо. Миний нам энэ орныг байгуулсан юм! Нам ба эх орноо аварья.

Энэ орны өнгөрсөн бүхий л түүх ял гавьяатайгаа бүх монголчуудад хамаатай. Сүх жанжны байгуулсан нам л гэнэ, түүхийн шинэ баримтаас үзэхэд худлаа л даа, гэхдээ тэр нь яахав, миний эх эцэг ч тэр намд харьяалагддаг. МАХН гэж улс төрийн бие даасан нам байсангүй, төр барих нэг өвөрмөц дарангуйллын багаж байж. Түүнд бид хүссэн ч хүсээгүй ч бүгд хамаарч байсан. Гэхдээ энэ байгууллага өөрийн логиктой байлаа. Хүрэлсүх шиг солиотой нь их бодож сумын эвлэлийн дарга хийгээд тэндээ л тэнэгтэж сууна. Дээшээ өндийх шанс үгүй! Бөөс болгон өөрийн зиндаа, идээшлэх талбайтай. Нам засгийн нэр унагана гээд энэ амьдсыг хүнд харуулдаггүй байв.

Улс төрийн ардчилсан нам МАХН 1990 онд байгуулагдсан. Ардчилагдахын хирээр “хөөрхөн” амьтсын цоролзох дөрөө болж хувирав. 1996 оны сонгуульд энэ нам ялагддаг шөнө намын дарга Даш-Ёндон гуайг Хүрэлсүх гэгч балмад офицер элэгдэж унагав.

Үүнээс хэдхэн сарын өмнө энэ нөхөр архинд орсон МАХН- залуу гишүүдийг Францаас эм авчирч эмчилнэ хэмээн намын бланкан дээр төсөл хийн “Ард” банкнаас 150 мянган ам доллар аван үзэх мөргүй болгон луйвардсан эрүүгийн хэрэгтэн шүү дээ! Ийм мундаг

“баатрыг” “намаа шинэчлэх” хүрээнд Энхбаяр олж ирж тэжээн өвчнийг нь эдгэршгүй болтол архагшуулсан түүх энэ болой. Өдгөө МАХН-аар хөл гул хийн өндөрлөгт гарч хулгай хийгчид тун олон болжээ.

90-ээд оны дундуур Ц.Мөнх-Оргил гэгч залууг би таних. Социализм сөнөнө гэж мэдээгүй байж байгаад УТТ-ны хүргэн болж маш том алдсан боловч засарч байгаа гэдгээ нотлохын тулд МАХН гэдэг үгийг бүтнээр нь дуудаж ч чадахгүй, замд нь 3 - 4 удаа сүрхий огиулдаг байж билээ. 2000 оны намар Энхбаяр түүнийг олж ирж сайд болгов. Мөнгийг нь шударгаартөлсөн юм гэнэ билээ. Намрын дунд сарын 17-нд түүнийг МАХН-д элсүүлж чойг зүүж өгөв. Үүнээс хойш тэр туранхай хөх залуугийн жавьжнаас боок идчихсэн аятай “манай МАХН болбоос” гэсэн хүн айлгадаг цагаан хөөс үргэлж сахарч байх болов. Энхбаяр Буштай уулзаж, харин Мөнх-Оргил үүнийг авгайгаараа зуучлуулсан гээд улсаас 70 мянган ам доллар шууж орхих юм! Буян Жагаа, Марубини, Засгийн газар гурвын асуудал Лондонгийн шүүхэд очлоо. Мөнх-Оргил зохицуулна гээд тэндөвөлжив, хаваржив, зусав. Бүх асуудлыг 60 мянган долларт багтаан шийдсэн ухаалаг хуульч Мөнх-Оргилын ярилцлага үе үе сонинд гарна. Өдгөө бүх протоколоос үзэхэд тэрээр Лондонгийн шүүх хуралд цор ганц удаа харагджээ.

- Тэр нөхөр энд юу хийж суугаа хүн бэ?

- Би Монголын сайд Мюнк Оржийл байна.

- Зээл явагдаж байх 1995 онд та хаана байсан бэ?

- Тэгэхэд би хувийн бизнес хийдэг байсан.

- Тэгвэл энд хэлэлцэх асуудал танд падгүй юм байна. Та шүүхийн танхимийг яаралтай орхин гарна уу!

Лондонгийн шүүхэд Монгол улсын төлсөн зардал 1.5 ам доллар болжээ.

II

Гончигдорж сэтгүүлчдэд ам мэдүүлэг өгнө. МАХН-тай эвсэж алдаа гаргаад хулхидуулсан гэнэ. Дахиж ингэж алдахгүй гэнэ. Засаг шинээр байгуулбал үхэж байсан ч хууртаж орохгүй гэнэ. Нүдэнд нь нулимс хуржээ. Гэхдээ хор шар агуулсан цог алга. Ердөө л найр наадамд тоогдож уригдалгүй гэртээ хоцорсон өвгөн хүний цагаан гомдол!

Энэ хүнийг би арван таван жил өмөөрч гүйсэн. Хавийн амьтантай бүгдтэй нь муудалцсан. Зарчмаа, ардчиллаа, намааөмөөрч явсан царай минь энэ. 15 жилийн өмнө сэтгүүлч С.Цогтсайхан “Алаг бөмбөг” гэдэг альюу гэсэн нийтлэл хэвлүүлжээ. Гончигдоржийн тухай юм! Өрөөсөн тал нь улаан, нөгөө тал нь хөх бөмбөг. Шаардлагатай газар хэрэгтэй талыг нь мань хүн ээлжилж үзүүлнэ. Тэр үед 13-ын бөмбөг гэж нэгтийм дүлий эрзийнэн алаг бөмбөг байдаг байсан. Зориулалтын бөмбөг ховор учир түүгээр л бүгдийг орлуулж тоглоно. Оногдвол алуулна шүү дээ, өвдөнө гэж жигтэйхэн. Харахад хөөрхөн гэмгүй, алаг бөмбөг! Мань Цогоо Гончиггоог алаад өгөхийн зэрэгцээ Монголын утга зохиол бичлэгт бөөн бөөнөөр нь нээлт хийжээ. Хашилтаар тоглох эрдэм үзүүлэв. Аугаа! Шүтэм! Гэвч би юу дутах билээ? Алаг

бөмбөгийг өмөөрч оцон шувуу бүхий “Дөрвөн аргын тоо”-гоо тэрлэлээ. Хашилтаас гадна бас хаалт гэж байдаг юм. Монголын утга зохиолын хэлэнд шинэ аяс хэлбэр оруулах гэсэн Цогоо бид хоёрын өрсөлдөөн! Бидний хурууг дамжин алаг бөмбөг эргэлдэнэ. Нэг харсан улаан, нөгөө харсан хөх...!

Гоол... Гончигоо дэд ерөнхийлөгч! Гоол... Гончигоо депутат! Гоол... Гончигоо Их хурлын дарга!

Цаг явсаар, бөмбөгний будаг гарч өгөршжээ. Алтанхуяг бөмбөгийг залж тоглолтонд орууллаа. Гоол... Махны үйлдвэр! Батхүү заллаа, шидлээ, орлоо, гоол... МИАТ...!!!

Ху намын бүлгийн дарга Идэвхтэн бөмбөгийг ... биш ээ, өөрийн орлогч Гончигоог тоглолтонд орууллаа, шидлээ... уул нь гоол. Гоол ч гэж дээ гоол л юм даа. Түй чоорт, шидэлтээс ядахнаа 50 сая унагаж чаддаггүй ийм бөмбөгний сэгээр хэн юу хийдэг байна аа? Идэвхтэн бүр гайхаж орхив. Тэдний нам шинэчлэгдээд бүх тавилгаа сольсон. Лав л ийм хагархай, өгрийн 13-ын бөмбөг ганц ч үлдээгүй. Дуртай хүн болгон таних тэмдэг, им тавьсаар байгаад хэн ч таних аргагүй болсон үлдэнгэр!

Ардчиллын түүх, ардчилсан хүчин гэдэг бол бас л миний түүх, миний үеийнхний салшгүй нэг намтар. Бидүүнийг бүтээлцсэн. Энэ бол Монголын ард түмний бүтээл, монголчуудын нэгээхэн түүх. Энэ бол бидний бахархал. Гэвч тэгээд юу гэж, бахархаад л давхиад байх уу? Цээжин дэх бахархал нэг тусдаа, бодит амьдралын шаардлага шал ондоо. Олон намын тогтоц бий болгох, парламентат ёсыг бүрэлдүүлэх ардчилсан хэвснэ суурь тавих үүрэгтэйгээр ардчилсан хүчин бий болсон.

Ш

Монголд улс төрийн намууд 1990 онд л зэрэг зэрэг буй болсон. Манай МАХН 85 нас хүрсэн л гэх юм. Үхдэггүй ээ! Үнэндээ төрийн бүтцийн салшгүй нэг хэсэг байсан тэр үеийн МАХН шалэмнөө ойлголт юм. Шинэ ардчилсан улс төрийн нам МАХН бол Очирбат нар, Даш-Ендон, Багабанди, Ганди, Зэнээ, Батхишиг нарын үеийнхний цоо шинэ бүтээл. Монголд олон намын тогтоц буй болгох, парламентад ёс бүрэлдүүлэх, ардчилсан дэг буй болгоход үнэлж баршгүй түүхэн үүрэг гүйцэтгэсэн. Харин Энхбаяр энэ намыг дахин төрийн багаж, галын хайч, өөрийн дэглэмийн шагнал шийтгэлийн ташуур болгон “шинэчлэх” гэж байж нэг мөсөн морийг нь унууллаа. Дээр би бүхний нүдэнд ил харагдаж байгаа хоёрыг л жишээ болгож авснаас үнэндээ ээлжээ хүлээж хоолондоо оочирлож байгаа жуликууд цаана нь толгойны хуурснаас хавьгүй олон байна. Чухам тэдэнд 85 жилийн настай үхдэггүй Каше МАХН-ын дуусашгүй гавьяаны домог хоолшилтонд нь хэрэг болоод байгаа юм.

Социализмын үеийн МАХН, ардчилалын үеийн МАХН хоёр Энхбаярын богино дэглэмийн үеийг эс тооцвол тэс өмнөө зүйл. Гэвч өдгөө аль аль нь түүхэн үүргээ гүйцэтгээд дуусчээ.

Үлдээсэн өвийг нь хусах гэсэн, дөрөө хийж төрийн машин руу довлон түмэн олноо дээрэмдэх гэсэн санаатнуудын гишгүүр болчиж. Учир нь Монголын түүхэнд гүйцэтгэх ёстой үүргээ нэгэнт дуусгасан болохоор цөөврүүдийн цуглах газар болж. Ямар юмны чинь ардчилсан социалист үзэл, үүнийг чинь мөнөөх цөөврүүд л хоолны цэс нэрс гэдэг утгаар нь

сайн тогтоочихсон яваа. Намаа шинэчлэнэ гэнэ, аврана гэнэ, үхэгсэдийг амьдруулах арга шинжлэх ухаан ч олоогүй байна, оллоо гээд философи утгаараа хэрэгтэй юм уу? Зомби ертөнц хэрэгтэй юу?

Яг энэ утга, үнэлгээ Ардчилсан намд хамаатай. МАХН ичсэндээ бушуухан залуужлаа (Хүрэлдоржоор!). Ардчилсан нам ичсэндээ бушуухан буурь суулаа (Гончигсүхээр!). Удахгүй энэ процесс эсрэгээр эргэнэ, хариу нь адилхан л гарна. Габриэль Маркезийн Зуун жилийн ганцаардал романд гарах гарцгүй мөнхийн эргэлтэнд орчихсон жижиг нийгмийг үзүүлдэг. Эмэгтэй болгон нь Урсула, эрэгтэй болгон нь хурандаа Бондиа.

Нэг яльгүй дэвшил гарвал зөрөөд нэг ухралт гарна, нийлбэр нь нойль. Урсула Бондиа хоёр л гэрлээд байна, Урсула, Бондиа төрүүлээд л байна, Хэн нь хэн, яахын тулд хаанаас энэ нийгэмд ямар зорилготой ирсэн юм, бүү мэд. Гарч болдоггүй чөтгөрийн тойргоор 100 жил явна. Гарч болох ганц гарц нь гахай сүүлтэй хүүхэд аль нэг Урсулагаас төрөх ёстой ба тэр нь энэ жижиг нийгмийг бүрэн сүйрүүлэн устгаж тойрог алга болох ёстой домог! Зохиолын эцэст энэ үнэн ирж нийгэм бүрэн сөнөснөөр Зуун жилийн ганцаардлаас гардаг! Манай нийгэм энэ чөтгөрийн тойрогт орчихлоо. Орчин үеийн хурдацтай ертөнц ийм гарцгүй тойргийг удаахгүй, бушуухан гахай сүүлтэй хүүхдийг нь илгээнэ. Тэрийг нь Төрөө хямруулж түмнээ ядууруулах ганц үүрэг бүхий МАХН, Ардчилсан нам хоёр төрүүлнэ, Монгол орон чөтгөрийн тойргоос гарна, далимд нь нэг мөсөн устаж үгүй болно.

Хорвоо өөрийн хуультай, тэрийгээ хэнээр ч зөрчүүлдэггүй юм. Гахай сүүлтэй хүүхэд төрөхөөс өмнө Монголын Урсула, хурандаа Бондиа хоёр бушуухан алга болох ёстой. Энэ орон зайн дээр өнөөгийн ертөнцийн өнгө утганд таарсан улс төрийн шинэ хүчин шинэ хууль, шинэ логик, шинэ дүрмээр буй болж байж Монгол орон сүйрэлгүйгээр чөтгөрийн тойргоос гарч болно. Тэгэхгүй бол энэ хоёр нам өөрийнхөө мутант хувилбарыг нэмж төрүүлээд байна. Саяхан шинэ нам төрлөө, дахиад хэд хэд жирэмсэлчихээд байна. Үхснийх нь шинэ нам! Нэр нь л шинэ юм байгаа биз. Гахай сүүлтэй хүүхэд төрөх улам ойртсоор. Төрийн алба намчлалтай, түүгээр шалгуур хийдэг байхад яаж шинэ нам төрөх юм бэ? Аравхан мянган төгрөгний цалинтай байсан ч тэрхүү төрийн алба эрдэнийн суудал, учир нь түүгээр ард түмнийг дээрэмдэж болдог юм. Нэгэнт ийм болохоор өдгөө улс төрийн намууд яаж ч шинэчлэгдээд, ямарч гоё лоозон тавиад хүссэн ч хүсээгүй ч луйварчин дээрэмчдийн үүр хэвээрээ л байх болно!

Манай Гончигоо нээлттэй чөлөөт зах зээлийн үед өөрөөөөрийгөө шударга өрсөлдөөн дунд аваад явах тал дээр тун ч гавихгүй. Гэхдээ их хөөрхөн дуулдаг юм. Философитой дуу дуулна. Үлэмжийн чанар бол тэр чигээрээ үүрд хувиршгүйорших ертөнц үгүй тухай нарийн бясалгал шүү дээ. Гончигоо цангинуулна ...үхэх үйл нь ирчихсэн бол үүд хоймрын зайн хоорон дахь 3-4 метрийн ялгаа юу байна?... Үнэн үнэн! Анхүүнийг хэн хэлэв? Будда юу, Бодисадва юу, Адишаа юу, Зонхов уу, Данзанравжаа юу? Лав Гончигоо биш, тэр дамжуулж л байгаа юм. Харин өөрөө ойлгож байгаа болов уу?!

Энхбаяр Vs Энхбаяр

Жэкил доктор, Хайд гуай хоёр гээд Стивэнсоны сонгодог зохиол бий. Жэкил бол эрдэмтнээс гадна хүний хувьд ариун, шударга, хүний дээд билээ. Тэрээр өөр дээрээ шинжлэх ухааны туршилт тавьж орхисон чинь шөнө болохоор адгийн амьтан болж хувирдаг болчихлоо. Бүдүүлэг, хорон, атгаг ёстой шаарын шинж бүрэлдсэн тэрээр хүн алж, хүүхэд тамлаж, эд зүйл сүйтгэнэ. Гэгээ оруут л Жэкил доктор болон хувирч эелдэг, хүндлэг, тусч, энэрэнгүй сайхан гэгээн дүртэй болох аж. Жэкил доктор мөнөөх шөнийн адгийн шаарыг жигшин тэмцэх боловч яаж ч үл чадна. Хайд буюу нуугдмал гэсэн нэртэй нөгөө шаар бол үнэндээ ариун Жэкил өөрөө билээ. Жэкил өөрөө өөртэйгээ тэмцэнэ. Түүнээсөдөр ариун сайхан санаа гарч түүнээ хэрэгжүүлэх боловч, шөнө нөгөөх өөдгүй Хайд ариун болгоныг гутаан араатан шиг аяглана. Жэкил тэмцээд ч үүнийг яаж ч зогсоож үл чадмой. Ер нь санаа нь хичнээн бурхан шиг хүн байгаад ч дотор нь нүгэлт санаа бас агуулагдаж байдаг.

Мань ерөнхийлөгч Энхбаяр сүүлийн үед дажгүй юм ярьдаг болж. УИХ-ын намрын чуулганы нээлт дээр, мөн ойрмогхоноос зурагтаар ярьж буй нь сайн хүн юм гэж ойлгохоор. Төлөөлж буй энэ орондоо хайртай ч байж магадгүй өнгөтэй. Лав л зөв юм ярьж байна. Төрийн мэргэшсэн албыг нэг мөсөн самарч 15 мянган хүнийг улс төрийн үзэл, намын харъяаллаар нь ялгаварлан нэг дор халж байсан тэрээр өдгөө ийм үйлдлийг бараг л гэмт хэрэг гэж нэрлэж байна. Иргэн болгон нийгмийнөмнө тэгш боломжтой байх ёстой гэнэ. Төр хамгийн чадварлагаа шигшиж чаддаг байхын тулд бүгдэд ижил боломж олгох ёстой. Төрийг намын нөлөөллөөс салгаж төрийн ажилтныг нам бусболгох хэрэгтэй гэнэ. Ёстой үнэн үг, үхрийн шар тос. Намын харъяаллаар улаан хамгаалагч мулгуу бацаануудыг өөд нь татвал биенээ гэгээн цагаан өдрөөр дүрээд алчихдагийг Мао, Энхбаяр хоёр мэдвэл мэдэхээр болсон.

Эцсийн бүлэгт Энхбаяр маань авилгын эсрэг тэмцэхээр боллоо. Түүнийг Монголын авилгын загалмайлан эцэг гэдэг. Мэдээж Энхбаяраас хавьгүй өмнө авилга хахууль буй болсон байж таарна. Тэрээр авилгыг системчилж төрийн ажиллах механизмын зохион байгуулалттай шалгуур болгон хөгжүүлсэн юм. Дөнгөж сонгуулийн дараа өөрийн намын биш “гудамжныхныг” өгсөн мөнгөөр нь зэрэглэн үнэлж сайд, агентлагийн дарга болгож, дагуулаад намынхаа чойгийг өгч байв. Эндээс улс орныг өөрөөсөө багийн албыг хүртэл хэрсэн аалзны торны жишиг буй болсон. Төрийн ямар ч алба тодорхой тогтсон ханшаар худалдагддаг, өрсөлдөөний үед үнэ хаялцдаг номтой болсон доо. Төрийн алба хааж буй болгон хууль зөрчигч, их бага хэмжээний хулгайч луйварчин болж хувирлаа. Хэн ч хэнтэйгээч барьцах юмгүй болсон ийм талбай дээр тэрээр өөрөө “улсын тэргүүний авилгач”, хамгийн том хулгайч, цадахаа мэдэхгүй бирд болон хувирсаан. Одоо автор нь өөрөө иймэрхүү механизм бол буруугаар барахгүй улс орныг сүйрүүлнэ гэж байна. Зөвөө, зөв.

Энд хоёр Энхбаяр байна. Нэг нь Хайд гуай, нөгөө нь Жэкил доктор. Нэг нь шөнөөр булай болгоныг үйлдэнэ, нөгөө нь өдрөөр сайн сайхныг мөрөөднө. Биенээ үгүйсгэнэ, биентэйгээ тэмцэлдэнэ. Ер нь санаа нь хичнээн нүгэлт хорон муухай хүн байгаад ч дотор нь зарим нэг зөв санаа агуулагдаж байдаг аж. Юутай ч Энхбаяр Монгол улсын ерөнхийлөгч. Тэр бидний улсын төлөө сайнаар бодож гэгээтэй ирээдүйг мөрөөдөн зүтгэх нь монголчууд бидэнд л хэрэгтэй. Иймээс бид Хайд-Энхбаярыг даран сөнөөхөд тусалж, Жэкил-Энхбаярыг бүх талаар

дэмжмээр байна. Ингэх нь бидэнд л хэрэгтэй. Ерөнхийлөгчийн сонгуулийнүеэр өөрийгөө цэвэр цусны сайн хүн гээд бусад дэвшигчдийг хольцтой цустай эрлийз хурлиийзаар нь дуудан рекламдаж байсан Хайд-Энхбаярыг даран сөнөөх хэрэгтэй. Ядахнаа л нэр нь дэвшээд байгаа тэр алба нь Монгол улсын эв нэгдлийн бэлгэтэмдэг ухаантай юм шүү дээ. Гэтэл газар хувьчилбал Монгол улс сөнөнө гэсэн намын нөхдийнхөө аксиом ойлголтыг тас цохин газрыг хувьчилж эргэлтэнд оруулсан Жэкил-Энхбаярыг дэмжих хэрэгтэйгээр үл барам зөвхөн үүнийх нь төлөө идэж уусан олон тампуу хөрөнгийн явдлыг нь өршөөж тэр байтугай алдаршуулж хөшөө барин хөхиүлж ч болох юм.

Түүгээр нийгэмд учруулсан хохиролтой нь дүйхүүц буянүйлдүүлж чадвал уг нь зүгээр, ядахнаа нойллохсон. Мууг үйлдэх амархан, сайныг бүтээх тун хэцүү. Энэ хэцүүг одоо тэр үйлдэг, цөмөөрөө дэмжин уухайлцгаая. Монголын нийт хадгаламж эзэмшигчдийн ганцхан хувьтай тэнцэх хүмүүсийн алдангыг бусдаар нь төлүүлнэ гэх мэтийн хорон санааг нь харин таслан зогсооно шүү. Өөрөө гол буруутан нь юм чинь өөрийнхөө жоороор төлөг.

2006 оны 10 дугаар сар

Ордон дүүрэн салаавч

Үндэсний эв нэгдлийн Засгийн газрын хоёр гишүүн найрамдлын гэрээ байгуулж байна. Нэг нь Эрчим хүчний эзэнт гүрнийг төлөөлж, нөгөө нь гай гамшгийн бүгд найрамдах улсыг төлөөлж буй бололтой юм. Ясир Арафат, Рабин хоёроос хойш ийм лут найрамдлын гэрээ харсангүй. Израиль, Палестин хоёрт НҮБ- ээс 1948 онд газар зааж өгснөөс хойш тувт хоорондоо байлдсан энэ хоёр орон эвийн гэрээнд гарын үсэг зурсанд нь дэлхий баярлаж, терроризмаар хагас зуун жил хичээллэсэн мань хоёрт Нобелийн энхтайвны шагнал өгч байв шүү дээ. Гэвч хүн төрөлхтний найдварыг хөсөрдүүлэн хоёр жилийн дараагаас нь урьдахаасаа ширүүн байлдаад унасан. Бусаддаа үлгэр дууриалзүүлж буй Монголын хоёр сайд хэдийгээр хоёр сарын дараа дахин биенийхээ эсрэг дайнд мордох нь мэдээж боловч юутайч ланжгар гоё гарын үсэг зуралцаан боллоо. Босоод тэврэлцэж байна. Гараа чанга чанга атгалцана. Энэхүү түүхэн үйл явдлыг тэмдэглэхээр ард нь царан дээр шампан дарс тавьсан оны гоо бүсгүй талимааран зогсоно. Нэг засгийн газрын хоёр яам “цаашид хамтарч ажиллаж биендээ тус харилцан туслалцана” гэж эвийн гэрээ байгуулаад үзэглэж буй хэрэг шүү дээ. Харилцанүл довллолцох конвенц! Хундага тулгалаа. Урьд бол “найрамдал- дружба” гэдэг байсан одоо юу гэдэг болсон юм бол? Банзай! Вансүй! Фройндшафт!

Үндэсний эв нэгдлийн Засгийн газар буй болсон цагаасаа хойш бүтэн жилийн турш иргэний дайны нөхцөлд амьдарч байна. Гол зэвсэг нь салаавч. Засгийн газрын бодлогын эсрэг аян дайны шанг нэгэн сайд татаж салаавчтай жагсаал удирдав. Байнга салаавч үзүүлж байх нь хөдөлмөр их орох учраас бэлэн салаавчхармайж явдаг болсон гэсэн. Дараагийн сайд газрын баялагийгөөрийн мэт толгой даан наймаалцаж танхимдаа салаавчүзүүлэв. Миний сонссоноор Ерөнхий сайдаа салаавчтай гараараа зодох гээд ширээ тойруулан хөөсөн гэсэн. Өөр нэгэн сайд нь Ерөнхийлөгчийн бараа бологч болж аваад Үндсэн хууль руу салаавч үзүүлээд тэр чигээрээ хөшөөрхүү юм болоод тогтчихов. Малын инженер гэх (энэ нь цол юмуу, мэргэжил юмуу бүү мэд, өөрийгөө л ингэж нэрлэсэн шүү дээ) нэгэн зулзган сайд Ерөнхий сайдын бусаддаа үзүүлдэг салаавчны үүрэг гүйцэтгэх болов. “Ерөнхий сайд бид хоёр л их шараа болж байна, энэ бол бид хоёрынх шүү” хэмээн хоёр гараараа зэрэг салаавч тавина. Заримдаа толгойгоо эрхий хуруу орлуулан салаавч үзүүлнэ. Зангарагатай салаавч!

Засгийн газар гэдэг бол нэг субъект. Энэ субъект хууль хэрэгжүүлэх, гүйцэтгэх үүрэгтэй. Энд олон үзэл санаа, бие даасанүйл ажиллагаа, бодлогын зөрөө байх учиргүй. Тухайн бие хүн бодлоготой санал зөрвөл юун түрүүн багийн бүрэлдэхүүнээс гарч, дараа нь салаавчаа тавьдаг номтой. Эс тэгвээс нэгэн Засгийн газар бодлого хэрэгжүүлэх бололцоогүй болно. Уул тоглоомын дүрэм энэ л дээ. Миний сонссоноор өнөө маргаашгүй Засгийн газрын нэг яам нөгөөгөө шүүхэд өгөх гэж байгаа гэсэн.

Ёстой ориг тоглоом. Залуу хунвэйбин маягийн өсвөрийн салаавччингууд гүйцэтгэх Засгийн салаа мөчир, контор тасалгаа болгоноор нэг. Тэд нэг талаас хахууль нэхэн ард түмэн руу салаавч үзүүлэхээс гадна хоорондоо авилгаа булаацалдаад нэг нэгэндээ салаавч үзүүлэн шүүхдэцгээнэ.

Уул нь улс төрийн олон намууд нэгдэж дундаасаа Засгийн газар байгуулбал үүнийг “эвслийн”

гэж нэрлэдэг. Дэлхий даяар тогтсон нэршил. Иргэний дайн болж биенийгээ алж байж санаа нь амардаг бүлэглэл бүхий оронд энх тайван тогтуут тэртэй тэргүй хэн нь ч хэнийгээ ч дийлэхгүй учир Үндэсний эв нэгдлийн Засгийн газар байгуулдаг. Камбожи, Анголд ийм л Засгийн газар байгуулж байв. Үүнийг л “Үндэсний эв нэгдлийн” гэж нэрлэдэг, бас л дэлхий даяар тогтсон нэршил. Камбожид бүр эвлэрч өгөхгүй болохоор нь нэгэн зэрэг хоёр Ерөнхий сайдтайбайж үзэв шүү. Яг ижил эрхтэй хоёр Ерөнхий. Харин 17 ижил эрхтэй Ерөнхий сайдтай гэж сонсоогүй юм байна. Ингэхээр манайд процесс эсрэг талаасаа болж байгаа юм байна. 17 зонхилох хүчин Үндэсний эв нэгдлээ бодож түр Засаг байгуулж, удахгүй иргэний дайн болох юм болов уу даа.

Ардчилсан аль ч орны жинхэнэ ил тодоор салаавч тавилцдаг газар бол парламент. Гэхдээ учиртай, намууд хоорондоо салаавчүзүүлцгээнэ. Энэ бол зарчмын салаавч. Хэрэв мөнгө баялаг булаацалдаж хэрэлдвэл уг этгээд улс төрийн тавцангаас эгнэгт хөөгдөнө. Тогтсон жишиг. Харин манай УИХ бол салаавч л тавьж байвал хэн нь хэн рүүгээ нь хамаагүй. Хамгийн томыг нь спикер тавьж харуулна. Уул нь ёс жудагтай газар спикер нь хурал зохицуулдаг учир харин ч салаавч үзүүлдэггүй учиртай юм л даа. Манайд болохоор танхимд түүний хиртэй хумс бүхий ясархаг салаавч хамгийн өндөрт гозолзоно. Тэрээр гагц гишүүд рүү төдийгүй намууд, олон нийтийн хөдөлгөөн, ТББ, ард түмэн рүү салаавч үзүүлээд тэр чигт нь орхичиж. Их бүдүүлэг, салаавч руугаа нулимж байгаад л гозолзуулан хавийн амьтныг зүхэн заналхийлнэ. Салаавч тавьдаггүй жорлонгийн мухар ч үлдсэнгүй. Шекспир нэгэнтээ “солиорол нь хүртэл дэс дараатай” гэсэн байдаг. Гишүүд хэдийгээр хамаа замбараагүй харилцан салаавчүзүүлээд байгаа юм шиг мөртөө нарийн ажиглавал өөрийн логик дэс дараатай. Тухайн луйврын ажиллагаан дээр хоёроос дээш бүлэг болон булаацалдан салаавчлалцах боловч дараагийн луйвар дээр шинэ талцал үүсэн түрүүний дайсан шинэ нөхөр болон хувирна. Мөнхийн дайсан, мөнхийн нөхөр гэж байхгүй, мөнхийн эрх ашиг бий гэдэг үгийн түргэвчилсэн утгыг эндээс харж болно. Юун мөнхийн, ердөө л хоёр цагийн дайсан гэж байхгүй, гурван цагийн нөхөр гэж байхгүй.

Гэхдээ хүн болгонд 250 мянган доллар өгнө гэхээр Үндэсний аугаа их эвлэрэл буй болж буйг анзаарсан биз дээ. Уг нь аугаа эвлэрэлийг буй болгож болох шанс харагдаж байна, даанч дааж давшгүй өртөг орох бололтой. Үндэсний их салаавчийг мань Ерөнхийлөгч үзүүлэн удирдана. Тэрээр сүүлийн үед Засгийн газар, улс төрийн намууд руу энэхүү хуруунуудын комбинацнугалбараа байн байн харуулах болов. Ард түмний хамгийн их дургүй нь хүрч байгаа субъектүүд мөнөөс мөн тул тэрээр ард түмнээ төлөөлөн энэ ёслолыг хийж буй хэрэг. Харин энэхүү дургүй хүрэм байгууламжийн автор, уран барилгач нь өөрөө учраас үнэмшил муутай харагдаад байна. Баахан дарга доргыг нэр заан салаавч үзүүлнэ. Гэтэл өөрөө эцэг нь. Төрийн албыг наймаалцан зардаг явдалд салаавч тавин эсэргүүцнэ. Гэтэл өөрөө анхны дэлгүүрийг нээн дуудлага худалдааны шавыг тавьсан. Нийгмийн баялаг тоногчид руу салаавч үзүүлнэ. Өөрөө зохион бүтээгч нь. Төрийн бүтэц, үйл ажиллагаа руу салаавч тавина. Гэтэл өөрөө зохиогч нь. Авилгач нар руу салаавч үзүүлнэ. Гэтэлөөрөө хамгийн том авилгач. Ингэхээр Ерөнхийлөгч салаавчийгөөр рүүгээ харуулж нүүр рүүгээ тавиад байгаа хэрэг байх нь.

Хэнтийн гурван тэнэг

Урьд нэгэн тээврийн жолооч Дорнодод шатахуун хүргэчихээд буцаж явжээ. Хээр замаас холгүй боодог хийгээд сууж байгаа гурван эртэй халз таарч. Гэдэс нь хонхолзож явсан жолооч бөөн баяр хөөр болон буув. Тарваганы боодог гал дээр шаргалтаад бэлэн болжээ. Харин нөгөө гурав боодогтоо хүрч ядаад нэг л янзгүй, жолоочийг гал руу урив. Жолооч хутгаа гарган тарвагыг огтолтол урдаас нь буудан сүйд болов. Мань гурав ерөөсөө боодог хийж үзээгүй, ганц тарвага алсныгаа гэдэс дотрыг нь гаргасангүй хэдэн улайдсан чулуу бөгсөөр нь чихчихээд халуун нурман дээр тавьж орхисон юмсанж. Үүнээ янзлаад идэх гэхээр айгаад биен рүүгээ чихээд сууж байтал жолооч ирсэн аж. Тарваганы гэдэс дотор, халуун шөлөнд будагдан түлэгдсэн жолооч:

-Газар газрын тэнэгүүд ганц ганцаараа явдагсан, Хэнтийн тэнэгүүд хэлхэлдээд гурваараа явдаг хэрэг үү – гээд машиндаа суун одсон гэдэг. Дээхэн үед их л яригддаг байсан онигоо доо. Хот айл ганц ч тэнэггүй бол уйтгартай, хоёр тэнэгтэй бол илүүдчихдэг гэж Гамзатов зохиолдоо ёгтлон бичсэн ч байдаг.

Тэнэг гэсэн тодорхойлолт бий. Гэхдээ энэ нь дэндүү тодорхой бус, өргөн утгатай нэр юм. Дээрх гурав жишээ нь сайн офицер, мундаг бөх, гаргууд барилгачин байж болно л доо. Танкан дотор, ногоон зүлгэн дээр, краны бүхээгт хэн ч тэднийг ингэж дүгнэхгүй харин боодог хийх тал дээр бол аргагүй л тэнэг. Илт оюуны хомсдолтой л биш бол ерөөсөө тэнэг хүн гэж хаана ч байхгүй. Хэн ч аль нэг юмыг чаддаг, мэддэг, тэрэндээ авьяастай л байж таарна. Үүнтэй адил ухаантай гэсэн тодорхойлолт ч бас ийм. Бүхнийг мэддэг, чаддаг гэж хэн байх билээ. Бид гол төлөв нийгмийн дунд зөв зохицон гэр орноо, нэр төрөө аятайхан аваад явдаг хүнийг ухаантай гэдэг. Тийм хүн чадахгүй хэвтэж заавал боодог хийж тэнэгээ дуудуулаад байдаггүй учраас ухаантай байдаг. Цагаа, газраа олоогүй бол хэн ч тэнэг болох нь.

Энхбаяр бол лавтай улс төрчийн хувьд тэнэг хүн биш. Гэхдээ ухаантай нь сайн байх албагүй, тэнэг болгон муу хүн байхөстой биш. Тэрээр засаглалын өвчин туссан, нийтийн эрх ашгийнүл ойшоодог, өөртөө хэрэгтэй гэсэн зорилгоо биелүүлэхийн тулд адгийн арга хэрэглэдэг, бусдыг зорилгодоо ашиглахын тулд шатрын хүү шиг үзэж зориуд буруу газар нь байрлуулж тэнэг хүн бүтээдэг увьдастай нэгэн. Тэнэгүүд түүнд л үйлчилж байвал эцэст нь гарах хор холбогдол хамаагүй. Тэрээр урлагт дуртай, автамхай, хүмүүсийн хувь заяа, улс үндэстний ирээдүйг урлагийн бүтээл болгон бүтээж залах сонирхолтой. Үүнийг нийгэм судлалд нийгмийн инженерчлэл гэж нэрлэдэг. Томоохон сонгодгууд нь Мао, Муссолини гээд бий. Ердийн нийгэмд хүмүүс өөр өөрийн хувь зохиолоороо явна. Харин иймэрхүү уран бүтээлч захирагч буй болохоор хүмүүс буруу газар өрөгдөж, буруу юм хийж тэнэгтэж өгдөг. Түрийний бөөс толгой руу авирч гарна. Хувь зохиолуудын санаандгүй их эргэлтүүд нийгмийг өөрийг нь маш сонирхолтой дүрс хэлбэрт оруулж, эрэг шураг болсон хүмүүс нь хүмүүн бус сонин сонин авир гаргацгаана. Трагедомеди амьдралын ердийн норм болон хувирна. Моллер, Шекспир хоёр нийлж бичээд ийм өнгө дүрс, найрлын тухай бодож олжчадахгүй.

Британника хэмээх дэлхийн хамгийн том нэвтэрхий толь жил болгон хавсралт гаргадаг. Тэнд Н.Энхбаярын тухай бичихдээ МАХН-ыг хуучин хөгшин ортодоксуудаас нь салгаж, намаа

залуужуулж чадсанаар социалист интернациональд нэгтгэсэн гэжээ. Өрнөдөд Монголын тухай бичдэг хэдхэн зөвшөөрөгдсөн англо-саксон хүмүүс бий, тэд байнга манайд ирж англитай дарга нартай нөхөрлөдөг болохоор дээрх сайнүнэлгээг өөрөө хэлж өгөө биз. Ер нь ч гучаад оны үед Сталин, Гитлер нарын тухай өрнийн лавлахууд магтан биширч бичиж байлаа. Түүхийн үнэн хожим илэрдэг болохоор зайлуулагдсан гэгдээд байгаа хөөрхий МАХН-ын хөгшин ортодокс хэмээн хоч хүртсэн үеийхнийг хожмын цаг цагаатгах биз. Өнөөдөртөө

МАХН-ыг залуужуулсан гэгдээд байгаа тэр улаан хамгаалагчид л хожмын түүхийн шоглоом юм. Төрийн албаны 15 мянган хүнийг халж байж тэрхүү хуньвэйбин нар чадахгүй мэдэхгүй газраа байршуулагдсан билээ.

Хятадын Соёлын хувьсгалын үеийн улаан хамгаалагчидөдгөө 50 эргэм насанд хүрсэн ба өнгөрсөн амьдралаа бүрэн алдагдсан хэмээн гашуудаж явдаг. Нэг олдсон амьдралаа хийүрсэн тэд Маог юунаас ч илүүтэй зүхнэ. Төстэй хувь заяа манай тэнэгүүдийг хүлээж байгаа байх. Мэргэжлийн, оюуны, боловсролын, моралийн, жудгийн наад захын шаардлага хангахгүй хөөрхий тэд УИХ-ын гишүүн, сайд, яамны хэлтэс газрын дарга, мэргэжилтэн, захиргааны ажилтан хийж амьтны доог болж байхаар сайн уурхайчин, барилгачин, ганзгачин, ченж, нинжа, ачаа зөөгч хийгээд явж байсан бол ядахнаа ганц олдох амьдрал нь утга учиртай, үхэхийн цагт сэтгэл амар байх байсан. Тэнэгүүд яаман дээрээ цуглаад “одоо цөмөөрөө намынхаа даалгаварыг сайн биелүүлж лидерүүдийнхээ нэр төрийг хамгаалж, сөрөг хүчинтэй сайн тэмцэнэ шүү” хэмээн тоглосон шинжгүй буурьтай яриад сууж байхаар яахав? Мэргэжлийн хүнийг гудамжинд гаргаж байж очсон тэр албаа тэртээ тэргүй ойлгохгүй учраас намчирхах, үзэл сурталжих, өөрийг нь нам залуужуулахад ашигласан хүндээ үнэнчээ харуулахыг ганц ноогдсон үүрэг нь гэж ойлгоно. Хууль бусаар, хээл хахуулиар, сүрдүүлгээр, хүнд суртлаар орлого олохыг чухалчлах ба энэ нь амьдралаа авч явах ганц эх үүсвэр, үүнийгээ үнэнчээр зүтгэж буйд нь зүй ёсоор олдож буй шагнал мэтээр үзнэ. Энэхүү “зүйёсны” шангаа булаацалдан биенээ гэгээн цагаан өдрөөр хутгалж орхино. 2000 онд дөнгөж орон нутгийн сонгуулийн дараахан сумын засаг даргын алба булаацалдаад биенээ алчихсаныг бодоход ийм үзэгдэл хамгийн дээрээс хамгийн доод хүртэл нийгмийг тэр чигээр нь хамарсан бололтой. Намын өмгөөллийн дор ямар ч гэмт хэрэг үйлдэж болно гэсэн үзлээс л шуугиулаад байгаа Хадгаламж зээлийн хоршооны аймшигт үер бий болсон билээ. Эдэнд хууль, ёс заншил, хүний жудаг огт хамаагүй гагцхүү Их Удирдагчийн тушаал л хүчинтэй. Эд бие дааж бодож сэтгэхчадваргүй учир удирдагчийн хэлсэн бэлэн томъёо, гаргалгаа, дүгнэлтийг давтаж явах хувьтай. Эд алив үзэгдэлд анализ хийхчадваргүй учир буруу газар байршуулагдсан цагийн золиос юм.

Олз омог арвинтай ийм тэнэгтэл 2004 оны сонгуулиас хойш МАХН-аас хальж халдварлан тархлаа. Буруу газар зүтгэж байж байршиж аваад аль болох тэнэгтэж өгвөл ашиг орлого арвин аж. Хагас дутуу бичиг үсэгтэй, үнэндээ олсон мэргэжил боловсрол үгүй үүргийн худалдаачид эх орон, ард түмэн, үндэсний аюулгүй байдал зэрэг аль л өнгөтэй өөдтэй лоозонг дуу хадаан орилж тэнэгийн шинэ шинэ рекорд тогтоон уралцах явцдаа хулгайн орлогоор баяжих хэрээр үүнд нь атаархаж хорсон рекордыг нь эвдэх хүслээр цээжээ оволзуулсан дараагийнхан нь хоолны хоёрдугаар ээлжээ хүлээж ядан тэчъяадаж бэлтгэл сургууль хийн тэнэгтэцгээнэ. Хэдий их тэнэгтэнэ, төдий ихүнэлэгдэнэ, үнэлэгдэх хэрээрээ шагналын хэмжээ нэмэгдэнэ. Ерөнхийдөө нийгэм маань галзуугийн больниц болжээ.

Мао Зэдун засгийн эрхийн төлөөх тэмцэлдээ улаан хамгаалагчдыг амжилттай ашиглаж дөнгөсөн боловч дараа нь тэднийгээ дарж авах гэж их зовсон. Эхнэр Зян Цинь нь соёлын хувьсгалд үнэмшчихээд Хятадын таван мянган жилийн иргэншлийг түлхэж унагах шахсан. Үүнтэй төстэй явдал манайд болж байх шиг. Намаа залуужуулж, ортодокс хөгшчүүлийг хөөн зайлуулсан гээд байгаа тэнэгүүд өдгөө насанд хүрч өөр зуураа хор найруулж сураад өсгөсөн эзэн рүүгээ салаавчүзүүлэх нь их болжээ. Энхбаяр урлагийн бүтээл хийх гэж байгаад Франкэнштайн бүтээчихсэнээ ойлгож нийгмийн эрүүл саруул хөгжлийн тухай ярих боллоо. Гэвч олон зүйлийн тухайд нэгэнт хоцорчээ. Нийгмийг төлөвшүүлэхэд цаг, хөдөлмөр ордог бол гаж бүтэцтэй болгоход амархан байдаг ба тэр нь халдвартай, архагшидаг, чулууждаг аж. Бусад аль ч улстай адил Монголд ерөнхийдөө тэнэг хүн ховор л байж таарна. Харин энд тэндгүй хүмүүс буруу байршчихаар сая таван зуун мянган ам км талбайгаар дүүрэн тэнэгүүд. Гурваараа, гучаараа, гурван мянгаараа хэлхэлдээд л хээхэлзээд л, тэнэгтээд л. Ам км-т ноогдох хүнээрээ Монгол хамгийн сийрэгт ордог, харин Төрийн

Хэнхэг

Шатар тоглож байгаад хожигдох болохоороо хөлгөө өшиглөөд хаячихдаг хүн байдаг. Бүр зодоон цохион болж, шарлахсанаасаа эс юм болно. Английн нэрт шогч Бэнийн ийм кино хүртэл байдаг.

Энхбаяр “шатар” тошложээ. Шатар ч гэж дээ, луйварчин болж тоглохгүй юу. Тоглох ч гэж дээ, үнэнгээсээ. Худалдаа хөгжлийн банкийг залгих төсөл. Юун түрүүн тоглоомд монголчуудыг оруулахгүйн тулд байж болошгүй хүнд нөхцөлтэй хувьчлалын тендер зарлав. 50 сая долларын үндсэн хөрөнгөтэй,

10 жилийн туршлагатай банк л өрсөлдөөнд орох гэнэ. Тендерт ньөөрийнх нь нотлосноор дэлхийн санхүүгийн ертөнц тэр чигээрээ оролцон өрсөлдөөд эцэст нь уул уурхайн түүхий эд дамлан борлуулдаг, банкны салбарт ганц сарын ч туршлагагүй Жэральд Метальз гээч компани ялсан аж. Гэтэл ялагч маань тендерт заасан хугацаанд мөнгөө төлдөггүй ээ. Хугацааг нь сунгаад л байлаа, сунгаад л байлаа, таг чиг. Эрдэнэтийн зэсийн баяжмалын экспортод монополь тогтоож өгсний шанд тендерт нэрээ оруулж, банк худалдаж авах мөнгийг нь түр зээлэх нөхцөлтэй тоглоомын төсөл байлаа. Ингээд Люксенбургт нэг авсаархан компани бүртгүүлээд тэр нь ХХБ-ыг авах юм болов. Авсаархан гэдэг нь тэд 66 мянган долларын үндсэн хөрөнгө буюу гайгүй жипний хөрөнгөтэй нь тендерийн өгөгдсөн нөхцлөөс даруй мянга дахин бага байлаа.

Миний сонссоноор ирээдүйд ориг монголчууд энэ банкыг Жэральдаас салгаж авахын цагт ЕС хорин хувийг нь хувьдаа авахаар тохиролцжээ. Жэральд 12 сая доллар зээлүүлсэн гэхэд хорин хувь нь адаглаад л 2,5 сая болно гэсэн үг. Үүнээс гадначимэг болсон бага сага хувьцааг өөр банк, байгууллага, хувь хүмүүст зарсан нь луйврын мөн чанарыг далдалж байх үүрэгтэй аж.

Зэсийн үнэ ид өсөж байсан үед Эрдэнэтийн баяжмалд сүүлийн долоо найман жилд 25-65 хувийн хяналт тогтоож байсан Жэральд хүссэндээ хүрсэн учраас банкны хувьцаагаа эргүүлжөгөхөөр болжээ. Энэ хооронд түүхий эдийн үнийн өсөлтийн буянаар Монголын эдийн засгийн тогоо ч лут томорсон юм. Зэсийн үнэ төдийгүй банкны үнэ ч аймаар өссөн. Жэральдын 12 сая доллар зах зээл дээр 54 сая доллар болсон хэрэг. Иймүнийг тэдэнд Монголын санхүүгийн нэг бүлэглэл санал болгов. Анхны гэрээний дагуу үнийн санал эхэлж тавих эрхтэй алтан хувьцааг эзэмшигч нь Монгол банкны Чуук аж. Гэтэл энэ хооронд ХХБ-ы гэрээг үндсээр нь өөрчилж, өнөө алтан хувьцаа байтугай хувьчлалын чимэг болж байсан Швейцарийн Лугано, Недерландын Эн Жи Барэнс банкууд тоглоомонд нэрээ хавчуулсны шагналаа хүртээд аль хэдийнээ үзэх мөргүй алга болжээ. Анхны гэрээг мань Энхбаяр яаж өөрчилсөн гэхээр хорин хувийг нэгэн компанид хадгалуулжээ. Жэральд нь зэсийн баяжмал тогтмол авч байсны шанд л хорин хувиа өгч буй хэрэг. Мөнөөх компанид ингэхээр зэс гаргах эрх олгоно гэсэн үг. Нэгэнт ингэсэн болохоор хуучны хамсрагсад одоо гай болно. Энэ бол Энхбаярын үндсэн мэх. Сталин гучаад оны үед Ягода, Ежов, Берия нарыг яаж ээлж дараалан хэрэглээд хаяж байлаа.

Чуукыгаа Энхбаяр аль хэдийнээ гол гаргаад нулимчихсан байсан тул тэрээр шинээр тодорч буй санхүүгийн бүлэглэлд элсэж орхихгүй юу. Ингээд Худалдаа хөгжлийн банк Монголын шинэ баян Эрдэнэбилэг гэгчийн гарт орж хөөрхий Энхбаяр хоосон хоцрох нь тэрээ. Хов хоосон ч юу юм, юутай ччамлалттай болчиж буй хэрэг. 54 саяын 20 хувь гэдэг дор хаяж л 10 гаруй сая доллар. Энэ бол Энхбаяр байтугай нь харамсмаар мөнгө. Уг нь тэрээр луйвар санаачилж хөгжүүлж явсан болохоос хууль ёсоор түүнд ганц цент ч ноогдох ёсгүй л дээ. Гэвч тэрээр гэгээн цагаан өдрөөр дээрэмдүүлчихлээ гэж үзэн маш ихээр гашуудан өөрийгөө өрөвдөв. Ингээд л хөлгөө өшигчиж унагааднаншилдаанд биеэ бэлдэвш. Хутга тармуур ш гарсаахуй. Хаарт тоглож мөрий алдсан түүний нүд аймшигтай, бас сүртэй.

Худалдаа хөгжлийн банкыг Хувьдаа авна гэсэн яалаа даа Хуурамч бичиг баримтаар Хульхидана гэсэн яалаа даа Яалаа даа яалаа даа, Энхбаяр аа

Ингээд өөрөө муриулчихдаг байгаа. Хууль бус тоглоом тоглож байсан учраас мөнөөх хорин хувийн асуудал ердөө л аман тохироо байсан болохоос бичгэн баримт үлдсэнгүй. Бичиг байгаад ч тэр нь шоронгийн батлагаа л болно шүү дээ. Тэрээр ХХБ-ы асуудлыг шалгуулна гэж саяхан зурагтаар ярьдаг юм байна. Үүндээ хаа хамаагүй арван хэдэн жилийн өмнөх

Чингис буудлыг хүртэл хавчуулсан гээч. Хачир болгож байгаа ухаантай юм. Жэральд хэмээх Монголыг идэх гэсэн аймшигт махчин шулмас байсан тухай айдас төрөм хоррортой үлгэр ярин түүнийг болон монгол хань хамсаатныг нь дарах ариун дайнд мордохыг уриалж, эс чингэвээс эх орноос уравсанд тооцох тухай шантаажтай мэдээ туурвина. Бүтээл нь сонин болон хэвлэгдэж эх орны дөрвөн зүг найман зовхист шөнийн цагаар өртөө дамжин тархана. Жэральд махчины эрэн сурвалжлагдаж буй монгол хань хамсаатны дүрс зураг мэдээнд бас хавсраатай. Эх орон даяар эзэн хааны зарлигийг биелүүлэхээр эрслэн бослоо.

Үнэхээр ХХБ хулгай луйврын аргаар хувьчлагдсан. Хууль сөхвөл гол дээрэмчин нь өөрөө. Харин цааш нь худалдаж авсан хүмүүст ял тохох нь Энхбаярын хөлгөө өшиглөж хаяж буй наншилдаан аж. Түүнээс хатуу үүрэг авсан цагдаа болон хүчний байгууллагууд, хууль шүүхийнхэн хатуу нэхэлтэй шахаанаас харин яаж мултрах юм бол. Энхбаяр бол нийтэч хүн. Ганцаараа идсэн гахай таргалдаггүйг мэдэх тэрээр үргэлж хамт олонтойгоо хувааж хооллодог. Гахайнаас ялгаатай нь тэднийхээ идсэн хоолыг нарийн хэмжиж баримтжуулдаг аж. Хоол угаасаа хулгайнх байдаг учир бүх хамсаатнууд шоронгийн норм ханган биелүүлнэ. Эргээд тэднийгээ энэ баримтаар нь шантаажилж чаддаг учир нөгөөдүүл нь юу л хий гэнэв хамаагүйгал ус руу харайгаад л орчихдог юм. Өөрийнх нь нэгэнтээ хэлснээр түүнийг зөвхөн Бурхан л шүүх юм гэнэлээ. Гэтэл хөөрхий мөрдөнгийнхөн, шүүгчид, хуульчид, тагнуулынхан, татварынханыг газрын хуулиар шийтгэнэ. Ингээд л ууралсан бух туйлж гарлаа. Тэрээр одоо юуг ч түйвээхэд бэлэн байна. Аль хэдийнээ самраад эхэлчихсэн. Солонгосын шүүхээр шийдээд өнгөрсөн асуудлыг энд сөхөн тавьж мөрдөлт мөшгилт хөгжүүлээд явааг юу гэхэв. Тэдний албаны хүмүүсийг гуйжөөрөө өөртөө гомдол мэдүүлээд “хоёр орны хамтын ажиллагааг” хөгжүүлэх аж. Өөрөө асуугаад л, өөрөө хариулаад л. Цагдаа хууль биелүүлдэг болохоос тушаал гүйцэтгэгч биш. Гэхдээ энэ бол онолын л асуудал. Гэмт хэрэгтнүүд, хамсаатнууд цагдаа хувцастайгаар боссыг тушаал биелүүлэн шудрага царайлан гүйлдэнэ. Хууль ном эргэн ирэхийн цагт хаашаа бултах юм бол?

Мань хүн засаг толгойлж байхдаа төрийн ордны зүүн талын байшин буюу хуучин хэвлэлийн

комбинатыг хусчихжээ. Кувейтийн хаан 800 жилийн ойг тохиолдуулан монголчуудад Төрийн ордон бэлэглэснийг наад их хурлынхан чухам хорлонтой юм шиг зориуд яг тэнд барина гэж бажигадуулах нь тэр. Тэгэхээр нь Кувейт руу утасдуулж энэ бэлгээс татгалзаж байгаагаа хэлж оронд нь оношлогооны төв бариулья гэжээ. Кувейт нь хаант улс учир хааны тушаал буцдаггүй учиртайг цаадуул нь хэлээд хэрэв оношлогоо бас хэрэгтэй юм бол шинээр хүсэлт гарга, өгье гэжээ. Увайгүй эр байгаа биз? Ер нь сонин этгээд дээ. Өлсөөд байдаг юм болов уу? Миний мэдэхээр янз бүрийн нэрээр авчихсан өч төчнөөн газар түүнд бий. Багтаж шингэхгүй хөрөнгө нь Байгал далайн эрэгт ч тулсан. Тэгсэн мөртөө л өлсөөд. Идээд байгаа мөртөө цаддаггүй ийм өвчин анагаах ухаанд тэмдэглэгдсэн байдгийг хэнхэг гэдэг.

2007.02.06

Социалист (ардчилсан?) Залуу луйварчид

Тэрбумаар хулгайлжээ. Энэ бол өнөөдөр манай албан тушаалтнуудын орооцолддог ерийн нэг хэрэг. Төгрөг болохоороо энэ бол мянга нь нэг доллар болчихдог арвын есөн зэрэгт буюу арван оронтой тоо юмсан.

Тэрбум гэсээр байгаад манайхан бүр тоохоо байчихаж. Урьд хязгааргүй олон гэхийг түм гэдэг байж. “Түм наслах болтугай”, “түмэн амьтан түжигнээд” гэх мэтээр ярьдаг шүү дээ. Гэтэл түм бол одоогийн хэлээр арван мянга буюу тэрбумаас зуун мянга дахин бага тоо шүү дээ. Гэтэл энэ арван мянган төгрөгний төлөө саяхан Дорнодод нэг эмэгтэй 10 жилийн ял авлаа. Түүнээс сая дахин ихийг хулгайлсан нь одонгоо гялалзуулаад л улам том тогооны шанагыг нь барьсан дарга болон дэвшинэ.

Хадгаламж банкыг тоночихжээ. Саяхан 20 сая дол- лараар зарсан банк. Шинэ эзэн нь мөнгөө тоолоод үзсэнчинь 13 тэрбум сох. Энд тэндгүй тэрбумаар нь ху-саад байдаг болсон болохоор энэ хэмжээний мөнгөний тоонд манайхан төөрөлдөөд хармайныхаа хэдтэй адилтгах шахдаг болжээ. Энэ нь мянга гурван зуун удаа сая төгрөг гэсэн үг шүү дээ. Юу ч гэх юм бэ дээ, 13 мянган хүнд тэтгэврийг нь тавьж болно гэсэн үг. Эсвэл алдарт 100 саяын Гансүхийн хэрэгтэй харьцуулахад 130 дахин том ху-лгай. Хадгаламж банк ул- сынх байсан дотор нь ийм юм байгаа гээд хэлэхээр нь Мон- голын төрд итгээд л уутыг нь задалж үзэлгүй сохроор ит- гээд авчихаж. Задлаад үзтэл авсан үнийх нь хагас байдаггүй.

Чингис банк авсан юм. Орос эзэнтэй энэ банк манайдаа гадны хөрөнгө оруулалттай хамгийн том банк. Монгол орон алттай, нүүрстэй, урантай, жонштой... хөрөнгө оруулахад найдвартай. Ингээд Оросын Хөдөө аж ахуйн банк 100 сая доллар оруулж энэ банкийг томруулахаар шийдсэн аж. Лав би тэгж сонсоод “овоо доо” хэмээн эх орныхоо хөгжил дэвшлээр бахархан суув. Тэмбэржүржиг... Мөнгийг нь ху-лгайлчихаж. Оросоос орж ирэх хөрөнгө оруулалт будаа болоо биз. Хэн одоо итгэх вэ. Ирвэл мафи л ирнэ. Ингээд хужаануудтайгаа л заваараад л хоцорно.

Ху-л-гайч нар МАХН-ын залуу халаагийнхан гэнэ. Бүр удирдаж барьдаг залуу дарга нарын армийнх аж. Ер нь тэдний шинэ зуунд үйлдсэн ху-лгай дээрмийн зах зухаас цухалзаад эхэлсэн нь ганц үүгээр дуусахгүй гэнэ шүү. Эрүүл нийгмийн Манлай тоолж байна аа. Хадгаламж зээлийн хоршоо гэдэг тэдний оролцоотойгоор, бүр зохион байгуулалттайгаар хийгдсэн эд аж. Байсхийгээд л шүүхээр орж хэдэн жил аваад инээж гараад байгаа хэд чинь ху-гийн ху-лгайч нарын залуу удирдагчид юм байна. Зарим нь цагаандаа гарчихсан, зарим нь мөнгөө хээр булчихсан учраас хэдхэн жилийн ял авсандаа хөөрөн догдолж буй нь тэр аж. Мөнгөө булаацалдаад нэгнийгээ гэгээн цагаан өдрөөр ху-тгалаад алчихдаг байгаа. Төрийн на- рийн хийж байгаад албаны хамаг юмаа тоноод дээрээс нь ажиллагсдынхаа цалинг идээд зугтаачихсан нэг хүнд гар бас л залуу удирдагч гэнэ. Өөр нэг яаманд төрийн нарийн хийж байгаад ху-лгай хийсэн нь баригдан шүүх цагдаа дуудангуут консул болоод гадаадад гарчихсан бас нэг залуу удирдагч гарыг луйвар арвин болсон өнөө үед хүмүүс бараг мартаа биз.

Ху-йгаар тонодог тэр “удирдагчид” тээр жил Э.Бат- Үүлийн тракторчдын жагсаалын хөлд гишгэгдсэн за-мын хашлаганы гурван боржуур тэврээд “хайран улсынөмчийг” хайрлан хайрын нулимс дусаах байдалтайгаар зурагтаар енгэнцгээж байсныг санаж байна уу, та минь.

Баатар Баатар л гэнэ. Шүглэсэн их луйврын дөнгөж үзүүр нь шүү дээ. Энэхүү социалист залуу луйварчдын байгууллагын удирдагч болно гэдэг их том өрсөлдөөн бололтой. Мафийн толгойлогч болно гэсэн үг. Дон болж байгаа хэрэг. Байгаль ху-далдах албан яамыг давхраар нь толгойлж байсан нэгэн

Доныг би гайхаад байдаг юм. Уул нь зүй номоороо банкны Цолмонгийн доод нааран дээр хэвгэж байх ёстой тэрээр хувь заяаны цоорхойгоор өөр ижил нэртэд үйлчилж мөнгөөр гулгиулаад нааж явах юм. Америкийн элчин түүнийг авилгач гэж шууд нэрлэж байна. Лав л авгай хүүхэд төрөл төрөгсдөөрөө Америкийн виз авах эрхгүй, хар дансанд нь орсон юм гэнэлээ. Ер нь ч Америкийн хуулиар тэдний тусламжийг шамшиг-дуулсан хэнийг ч насаар нь АНУ-д зорчих эрхийг нь хасдаг номтой. Түүгээр барахгүй тэдний татвар төлөгчдийн мөнгийг ху-лгайлсан хүнийг дэлхийн хаанаас ч авчирж шүүн шоронд суулгадаг. Панамын Норвега, Оросын атомын сайд гээд олон жишээ бий. Богд уул зардаг салбар компанийн эзнийг нь баривчлахад гараашаас нь 17 машин гарсан гээ биз дээ. Цадахаа мэддэггүй өлөн бирд. Өөрөө бол Тэрэлж хүртэлх дархан газрыг

700 гаруй компанид зарсан гээд бодохоор аргагүй социалист мафийн холбооны эзэн мөн байгаа биз. Гэтэл хөөрхийг мафийн толгойлогчоос нь огцруулаад сүүлд ургасан нэг эвэр мөргөж ор-хисон гэж байгаа. Аргаа олноо тэр хүүдий, Ерөнхийгийнхээ ээж тэтгэврийн чавганцыг өөрийн зөвлөх болгочихоод Улаанбаатарын утааг арилгах өртөг өндөртэй гадаадын төс-лийг хариуцуулчиж байгаа юм. Байгаа утаагаа одоо хар даа.

Энхбаяр 2000 оны сонгуульд “Ардчилсан намынхан Зоригийг хөнөөсөн” гэж гүрийсээр байгаад үнэмлэхүй ялалт байгуулан Монголын хөрөнгийн эзэн болсон билээ. Ингээд төрийн албыг үнэ дуудан зарж гарав. Олон чухал местийг гудамжнаас ирсэн нөхөд үнэ цохин авч байв. Тэд тэр дороо л наян жилийн түүхтэй намын удирдлага болон овойж оцойн гийгүүлэх нь тэр. Бод доо, Харвард төгсөж ирээд л шууд коммунист намд элсчихдэг гэнээ! Эсвэл цаад газар нь Харвард биш, эсвэл хөөрхий тэр жудгаа алдсан төрөлхийн луйварчин. Хандив өргөсөн луйварчин юунд хүрч мандаж болдгийн жишиг болж үзүүлэнгийн плакат болдог байгаа. Ингээд өнөө Гүнжинлхамын жишгээр ажиллана гэгчээр мөнхийн оргилд хүрэх гэсэн луйварчдын социалист уралдаан залуучуудын дунд өрнөх нь тэр. Ийнхүү тонуулын бүхэл бүтэн систем үүсэн бэхжиж чулуужсан хэрэг. Энхбаярыг авилгалынзагалмайлсан эцэг гэдэг ортой үг. Ортойгоор ч барахгүй.

2000-2004 онд Энхбаяр янз бүрийн чимэгтэй 23 удаагийн оны хүн болж байсан юм. Тэр болгонд элбэг дэлбэг хавтгай найр болдог байлаа. Оны аугаа хүнд өгөх бэлэг сэлтийн цуваа үл тасарна. Энхбаяр ч өөрөө шалиг зантай, урлагийн хурц мэлмийтэй хүний хувьд уянгын халилтай найр ёслолд үхдэг нэгэн. Ямар сайндаа л “Нострадамын мэргэлсэн шинэ Чингис” гэж хошгируулаад Хасбуу тамга гээд зуугийн лааз шиг том сийлбэртэй мод тэврүүлчихээд өрөөсөн нүдэндээ доголлон нулимстайгаар ард түмнээ энхрий ялдмаар мишээн харж бай-хав! Бялуурсан найрны зардлыг бараг тухай бүрд нь социалист ху-лгайч залуучууд гаргадаг байлаа. Гаргах ч гэж дээ, улсаас ху-лгайлаад тийш нь зөөнө. Үүнээ намдаа өргөж буй хандив

гэж нэрлэнэ. Хандивлахыг Энхбаяр шаарддаг байв. Шаардахч гэж дээ, эвгвй харахад л болоо. Харин хандивын мөнгө хаанаас олохыг хэлж өгөхгвй. Албан тушаал өгчихөөд байхад яаж хандивлахаа мэдэхгвй бол хохь нь шvv дээ. Үндэсний их удирдагчийн нөөлөг, Ху нэртэй намын аугаа хамгаалалт байхад залуу удирдагчдад айх юм байсангвй. Тэрбумаар нь. Саяар бол гологдоно шvv дээ. Зөвхөн тэрбумаар нь!

Зээ, Торой банди

Тогос Чvлтэм

Чvлтэмийн Улаан

Самбарын Энхбаяр – сонсоо

Хажуудахаа тононо Харснаа тууна Хариуцсанаа ху-сна...

За ингээд Энхбаяр баахан залуучуудыг хошгируулж амьтан болгоод ээлж дараалан шорон руу vддэг байж. Тэрэг эвдсэн бярууг нь тийш илгээгээд, номхон томоотойг нь дарамтлаад явна биз, шvvх прокурор атгаж байгаагийн хувьд тэгж л таарна, тэгсээр ч байна, энэ ч яахав! Хамгийн гол нь тvvний санаачилж, зохион бvтээж, загалмайж, аравнайлан амь оруулж бирдболгосон энэ тогтоцыг яах вэ!? Нам бамбайтай, намбар хаалттай хэд нь энэ жижиг зах зээлийг ёроолгвй авдрын мөнгөөр цохиж унагаад эзэгнэчихээр эрvvл өрсөлдөөний тухай санах ч хэрэггвй. Социалист залуу луйварчдын холбоо, Хадгаламж банк зэрэг бол тогтоосон системийнх нь дөнгөж vзvvр шvv. Дараа би та нарт Худалдаа хөгжлийн банкны эргэн тойронд юу болоод байгааг ярьж өгөмц.

2007.02.21

Зургадугаар палатын ослын буулт

-Энэ нөхөр бол шизотой

-Үгүй, би хөдөө эрүүл агаарт төрсөн.

-Тэндрээс нэг сая доллар завшсанаа яахнав?

-Тэгвэл нүүрэлдүүлэл дээ. Еэ муу... өөрөө гурван тэрбумыг хусчихаад...

-За тэгэхээр ийм байна. Үхсэн хүнийг чандарлахад их учир бий. Эхлээд сайхан шатаагаад, дараа нь ясыг нь гурилын модоор сайхан ганжиндаж нунтаглаад, тэгээд элдээд, тэгээд шавартай хутгаад... сайхан гоё зуураад... тэгээд тос усыг нь тохируулж сайхан зуураад, тэгээд сайхан нэг тийм гоё болоод ирэхээр нь суврага бүтээж байгаа юм даа. Тэгээд ном уншуулнаа. Хамаагүй ном уншуулбал нөгөө үхсэн хүний чинь сүнс нь төөрөөд ороолон болоод эргэж босоод шөнө мөнөөр сүйд хийнэ шүү дээ. Ингэхээр чаддаг мэддэг алдартай лам хүнээр л хийлгэх

ёстой. Ёстой үхэнгүүт нь л шарилыг нь сайхан шатаагаад, ясыг нь сайхан махнаас нь салгаж байгаад элдээд нунтаглаад, сайхан гоё зуураад... Миний утас уу? Захиалга авч байгаа... Утас маань ерэн ес...

-Энэ нөгөө намынхан бол идээчин уугаачин юм байна. За тэр нөхөр... бас тэд нар бол улсаас их мөнгө завшсан. Би сайд хүн болохоороо хамаг баримтыг нь олчихсон. Хэрэг гарахаар тэрнийг нь илчлэх гээд л байгаа юм. Дээлийг нь нөмрүүлнэ...! Би юу...?, би тэрэнд уг нь хамаагүй л дээ. Гадуур л тэгж шуугиад байх юм. Их хурлын гишүүний нэр төр хуулиар хамгаалалттай шүү. За за тэр яахав. Адилхан гишүүн байж тоглоом даадаггүй юмуу даа! Хэн чамайг шоронд хийнэ гэсэн юм? Манай нутагт дээл нөмрүүлнэ гэдэг чинь барилдаад унагана гэсэн үг байхгүй юу.

-Бид саяхнаас хорт хавдрыг эдгээдэг эм хийлээ. Хорт хавдар ингээд байхгүй болов. Хүн төрөлхтөн олон мянган жил үүнийг эдгээх гээд чадахгүй байхад бид хийв. Хамгийн гол нь монгол хүний ген гэдэг бол ийм мундаг юм. Бид ДОХ эдгээх шатандаа явна. Тэр ч амархан л даа. Монгол хүн ч цаанаа өөр тусгай гентэй. Ариун генээ л цэврээр нь хадгалж яваарай, монголчууд минь!

-Том дарга бид хоёр ууланд гараад. Нэг олсноос холбоотой дүүжлэгдчихвээ. Сүүлдээ хоолой боогдоод амьсгал авч чадахаа болиод... Том дарга маань их сайн хүн. За та минь түүнд л итгээрэй. Итгэл даах хүн дээ, дарга маань. Би түүнд зориулж шүлэг тэрлэснээ уншия. Зээ... Миний хэнз дарга магнай халзан зурвастай...

-Одоо ингэж байгаа юм шүү дээ. Хүний оюуны илтгэцүүр гэж байна. Уншаад л судлаад л байвал нэмэгдээд л байна. Намайг харахгүй юу, уншаад л ном уншаад л байсан чинь толгой маань томроод малгайдаа багтахаяа больчихсон шүү дээ.

-Өө за за. Намайг хууль зассан гээд загнаад байгаа ухаантай юм уу? За тэгвэл та нар сонс, хохь чинь шүү, би одоо хэлчихье, дахиж би хууль засахгүй шүү. Гуйсан ч засахгүй шүү, дураараа байтугай ерөөсөө засахгүй шүү, хохь чинь шүү. Батлагдсан хууль чинь тэгээд тэр чигээрээ явж байг, мэдүү. Ёстой хохь чинь, би л лав УИХ-аас батлагдсан хуулийг дахиж засаж байхгүй дэг, хохь чинь ээ, хохь чинь...

-Сая би говийн тэр аймагт очиж тэнгэрийн тахилга хийвээ. Бороо орохгүй ган гачиг болоод их зовж байна, тэд. Аймгийн дарга нь гуйгаад аймаг хөгжүүлэх сангаасаа 30 сая төгрөгөө барьж ирж гуйгаад... Ингээд их богд Чингис хааныхаа сүнсийг

дуудваа. Богд Чингис маань хүрээд ирвээ. Асууж байнаа,-Юу болов? Би хэллээ, -Ган гачиг болоод ард түмэн зовж шаналаад мал үхээд энэ тэр гэхгүй юу. Сүнс хэлж байнаа, бишээ Чингис Богд маань,-Зүгээрээ ингэсхийгээд бороо оруулаад өгье. За тэгсэн чинь асгачихдаг юм байна. Ороод байдаг, ороод байдаг. Хичнээн сайхан зун болов оо.

-Би хулгай луйвар хийгээгүй гэдгийг бурхан гэрчилнэ. Хууль номоор нь л явсан. Улс орноо л гэж явахад... ийн ийн. Тэр банк, тэр өрнөөс чинь би юу ч аваагүй гэдгийг хожим бурхан тэнгэр шүүнэ... Одоогийн манай шүүх үү? Чадахгүй ээ чадахгүй. Ганцхан тэнгэрийн шүүх л шударгаар шүүнэ. Гандангийн ахлах лам хүртэл япончуудын зурагт аваарай, хуваагаад тэнцүү аваарай гэжөгсөн 110 мянган долларыг дараа нь 120 байсан гэж гүрийгээд надаас тоолж байгаад 60 мянган доллар цохиж орхисон шүү дээ. Яахав би шударгаар тоолоод л өгсөн.

-За энэ миний бичсэн ном. Уншаад долоо хоноход л гадаад хэл сурчиж байгаа юм. Хагас жилийн дотор 25 хэл сурч болно. Маргааш Их дэлгүүрт зарна, худалдаж аваад л уншвал шууд гадаадаар инээж ханиагаад эхлэнэ. Намайг хөдөө сурч байхад багш маань толгой руу их зоддог байж билээ. Ингэж л би хүн болж хүмүүжсэн юм даа.

-Энэ сайд адилхан сайд байж сайд намайг сүрдүүлээд. Тэгээд би их айж байгаа. Айгаад унтаж чадахгүй байна. Надад төрийн тусгай хамгаалалт өгч энийг шорон моронд явуулж өгөөч. Яанаа, ий, би айгаад байнаа... Бид хоёр эвлэрсээн. Би айхаа больсон. Улсын хөрөнгө мөнгийг хайрлаад тусгай хамгаалалт авахаа болилоо. Одоо бид хоёр та нарыг харж байхад эвлэрээдүнсэлдье... Өчигдөр би айсандаа болоод эвлэрчихжээ. Би айгаад л байна. Ерөнхий дарга маань эвлэр гэж загнаад байхаар нь би айсандаа айгаад эвлэрчихсэн юм.

-Ум ядам, лувсан, гомбо сухаа, чойжоо, хаймчиг, цэдэнбал, сүрэн, чойбалсан, балдан, нямаа, балай багш, чогжоо, хум сухаа. Ум хум сухаа сухаа. Дашийн шогоо. Мөнгөө төлөөрэй. Ердөө иймхэн үү?

Үхсэн баас сухаа...

-Би эх орондоо маш их хайртай учраас газар шорооноос нь аваагүй, лиценз энэ тэрийг үзэн яддаг хүн л дээ. Тэгсэн надад хулгайгаар сэм газар өгсөн байна. Миний паспортыг хулгайлж канондоод, регистрийн дугаарыг минь тавиад, гарын үсгийн минь дуурайж зураад ингээд надад газрын лиценз өгч орхисон байгаа юм даа. Таван мянган доллар миний өмнөөс төлж байгаад надад газар өгсөн байна. Би тэр этгээдийг олно, энэ талаар шүүхэд хандана. Энэ бол хуулиар хамгаалагдсан их хурлын гишүүний нэр сүрэнд халдаж байгаа хэрэг юм. Олноо би,

Тэр таван мянган доллар надад өгсөн этгээдийг, заавал олно.

-Манай Монгол орныг хятадын эрлийзүүд Хятадад худалдаж дууслаа. Төр засгийн удирдлага 100 хувь хятадын эрлийз болжээ. УИХ-ын бүх гишүүд хятадын эрлийз юм. Бүх аймгийн дарга болон иргэдийн хурал тэр чигээрээ эрлийз. Малчид хүртэл эрлийзжиж байна. Монголын нийт хүн амын 99 хувь нь хятадын эрлийз болжээ... Би юу? Би бол цэвэр халх цустай, хэдийгээр өвөө маань өвөр газраас шилжин ирсэн боловч жинхэнэ говийн хольцгүй шижир халх билээ, би.

-Торой банди, Тогос Чүлтэм, Чүлтэмийн Улаан, улаантны Энхбаяр сонсоо, хавьтсанаа хусна, харснаа шаана, хажуудахаа мурина, хариуцсанаа гол гаргана... Улаан туг залуучууд хоёр ихэр юм. Уралдаан... тэгээд юу гэдэг билээ? Морины уралдаан бил үү?

-Энэ жил улсын наадамд сайхан барилдаж 20 саяар начны болзол хангасан алдарт бөх тэрэндээ зориулж “Тамирчны алдар хямдхан олдоогүй” дуугаар цэнхэр дэлгэцээр мэндчилж байна.

-Сайхан хэрэлдэх сайхан ш дээ. Миний их хурал дээр хэрэлдэж байгаа маань сонгогч олны маань л захиас. Хөөе чи юу гэж хуцаад

байгаа юм? Зоригийг чи алаа биз дээ муу хар п...аа минь ээ... х х х

-Монгол хүн бол онцгой гентэй юм. Иймээс олон авгай авах хэрэгтэй. Герман, англи хүүхнүүдийг гуравдугаар авгайгаа болгож авах ёстой. Хууль л гарчих юм бол тэдний хүүхнүүд наашаа цувж гарна шүү дээ. Намайг авгайтай юу гэж асууж байгаа юм уу? Авгайтай байсан. Даанч намайг хаяад явчихсан.

-Би хэдийгээр их хурлын гишүүн болсон ч гэсэн жилд хоёр удаа нүцэглэж ард түмнээ баясган баярлуулах болно.

-Ээжийнхээ ачийг яанам бэ хөө...

-Тэгвэл чи яагаад төрүүлсэн эхээ сүхдээд алчиж байгаа юм?

-Хүн дуу дуулж байхад чинь битгий мангартаад бай. х х х

-Чоно буудаагүй ээ, үнэг алсан. Би буудаагүй ээ, манай дүү буудсан, Ёопооны парлаантын гишүүн бишээ тэдний хамгийн аймаар том намынх нь гишүүн, яг над шиг. За муу цагдаа царайлсан лалар сэтгүүлч хулгайчаа хохь чинь шүү. Тэр чинь онхолдсон юм биш. Ослын буулт байхгүй юу. Жудогийн тамирчид ослын буулт хийхээрээ дээшээ хараад л хялайгаад унадаг ш дээ, лалар аа. Улс орноо хөгжүүлэх гэж ослын буулт хийж байхад чинь битгий дүнкүү царайлаад байгаарай лалар аа.

-Зургадугаар палатынхан тариагаа хийлгээрэй. Эмээ уугаарай, тариагаа хийлгээрэй.

Үгүй, энэ зургадугаар палатын хаалган дээр бичсэн “МОНГОЛ

21” гэсэн хаяг юу гэсэн үг вэ? Хүндэрсэн өвчний нэр биз? Халдвартай юм байх даа, бүгдээрэ тусаад бүгдээрээ хүндэрчихсэн байх чив.

-Чи шизотой, гэхдээ чамайг цагдаад өгөхөө болилоо.

-Үгүй, би нуурын эргээр хөл нүцгэн явдаг байсан, гэхдээ чамайг огцруулахаа болилоо.

Анхаар, хүүхдээс хол байлга!

Юу ч ойлгодоггүй мөртөө сайхан санаа агуулсан гал цогтой хүмүүсийн цаана л эрх чөлөөнд учрах хамгийн том аюул нуугдаж байдаг.

Шүүгч Луис Брэндис

Нямдорж дахиад л хэрэгт ороодохлоо. Урьд тагнуулын хэрэгт орооцолдсон. Хөөрхийг үүгээр нь далимдуулж нэлээд гөвсөн дөө. Гадаадын тусгай албатынхантай уулзсан баримт нь гараад ирсэн хэрэг. Гэхдээ яаж ч бодоод амьтны цуураад байгаа шиг тэрээр тагнуул хийгээгүй юм. Аль зэрэг эх орончийг нь мэдэхгүй, юутай ч ийм ажилд түүнийг хэн ч тоож ашиглахгүй. Уулзсан уу, уулзсан. Согтсон уу согтсон, чалчсан уу чалчсан. Гэхдээ түүнд дэлгээд байх материал ч байсангүй. Цаадуул ньчухал албаны хүн болохоор юм мэдэж байж магадгүй л гэж горьдсон хэрэг. Манай хөөрхийд ордон хавиар яваа хов живээсөөр ямар мэдээлэл байх вэ дээ. Тэр дарга тийм нарийн бичгийн даргадаа хандардаг, тэр дарга тийм юм идсэн байх зэргийн тэрэнтэй тэрэнгүй шар сониноос олоод мэдчиж болох зүйл дээр зориуд урагш нь аваачиж буудалд суулгаж ухааныг нь гартал архидуулж бэлэг сэлт өгч явдаг цаадуул нь ч цаадуул, мэрэгжилдээ л тааруу бололтой.

Нямдорж тагнуул байх учиргүй гэж би хэд хэд бичсэн.

Өмөөрсөн ч юм биш, хүнийг нь мэдэх юм болохоор ийм амьтнаар тагнуул хийлгэж байдаг орон юу л боллоо гэж сансарт хүн нисгэж, цөмийн эрчим ашиглаж, хөгжлийн хурдцаараа дэлхийг цочоож байв гэсэн ердийн харьцуулсан анализаа л хэлсэн хэрэг. Манай хөршүүд шугуйд модон дээр чармай нүцгэнсуудаг, 18 үгэнд багтааж хоорондоо харилцдаг, сүүлний үлдэгдэл нь 10 см-ээс дээш бол ч Нямдорж сүпэр Ганс Колос болж орхино л доо. Тэгсэн сайхан гар шүү, тагнуул биш гэж бичлээ гээд намайг гал түймрийн бүртгэл хариуцдаг цагдаад өгч орхиж байгаа юм. Би яахав дээ, Нямдорж тагнуул биш гэж би бичсэн, үүнийхээ төлөө хариуцлагаа хүлээнэ, хэрэв мөн юм бол та нар батлаадах л гэсэн. Баталж чадаагүй шүү, ингээд тэр тагнуул бишээрээ үлдсэн. Багадаа үзсэн киноны мөрөөдөл нь будаа.

Мань хүнийг саявтар Үндсэн хуулийн цэц авч хэлэлцээд

Үндсэн хуулийг зүйл бүрээр зөрчсөн болохыг нь өөрт нь хэлжөгөв. Харин ойлгуулж чадаагүй байх. “Би угаасаа засдаг, яршиг зүгээр одоо үүнээс хойш засаж чадахгүй шүү” гээд байгаа хүнд яаж ч ойлгуулах юм билээ. Ард түмэн өөрийн үзэмжээр хэн нэгнийг төлөөлүүлэн сонгодог, тэд нь нийлж байгаад ард түмний хүсэл зоригт нийцүүлэн энэ оронд үйлчлэх хуулийн хүрээг тогтоож өгдөг гэсэн энгийн үнэнийг энэхүү өөрийгөө хуульч гээд үнэмшчихсэн нөхөр 15 жил парламентад суугаад, Хууль зүйн яамыг нь чамгүй хэдэн жил толгойлчихоод огт ойлгохгүй л явна шүү дээ. Хүнийх нь хувьд би түүнийг ойлгож л байна л даа. Гайхах ч юм алга.

Асуудлыг өөр талаас нь авч үзье. Батлагдаад гарчихсан хуулийг хэн нэг нь засаад цоохорлоод унаж болохгүй гэдгийг тэр үнэхээр ойлгохгүй байна. Тэрнээс биш зарим нэгний хэлээд

байгаа шиг хэн нэгнээс мөнгө төгрөг авч байгаад зориудаар зассан зүйл түүнд байхгүй. Тэгэхэд ухаан хэрэгтэй шүү дээ. Болох болохгүйн зааг мэдэхгүй амьтан. “Намайг сайд боллоо гээд найз нөхөд маань гурван давхар байшин, жип машинаар шагнасан” гээд хөөрцөг болчихсон ярилцлага хийгээд явдаг амьтан шүү дээ, чааваас. Хахууль өгөхөөр тэрнийг нь авилга гэж ойлгохгүй талархаад яваа хэрэг. “Над шиг хууль хийх хэмжээний хүн байхгүй” гэж улаан цагаангүй хээв нэг мэдэгдэнэ. Үнэхээр ч ийм хэмжээний хүн түмд нэг, бичиг үсэгтэй улсын дотор бумд нэг, хуулийн дипломтой хүмүүсийн дунд саяд нэг тохиох ховор нь ч ховор бодьгал л даа. Тэгэхээр хөөрхий байгаа нь л тэр юм, түүнээс улс орноо хорлочихье гэж бодсон юм байхгүй, эсвэлаамьтан хүний захиалгаар хийсэн ч юм огт үгүй.

Эндээс ямар сургамж гарч ирж байна? Хүүхдийн гарт шүдэнз бариулж болохгүй л гэсэн үг. Тэсэрч дэлбэрэх болон амархан шатах зүйл, мөн эм тариан дээр “Хүүхдээс хол байлга!” гэсэн анхааруулга үргэлж байдаг. Хүүхдийг гадуурхаж байгаа хэрэг биш, хариуцлага хүлээх чадваргүй, болох болохгүйг ойлгохгүй, хор холбогдлыг нь мэдэхгүй учраас л тэдэнд итгэхгүй байгаа хэрэг шүү дээ. Ганц хэлтэй, түүгээрээ ч зөв ярьж чаддаггүй хүн, “Харвардын коммунист” гэгдэх хөөргөн хархүүтэй нийлээд хууль хийчихсэн чинь 10 мянган төгрөг хулгайлаад тэрүүгээрээ талх авсан эмэгтэй 10 жилийн гяндан авчиж байна шүү дээ. Хулгай хийх нь буруу боловч хуулийн адикват чанар буюу алив хүн хийсэн хэрэгтээ тохирсон зэм хүртэнэ гэсэн анхдагч ойлголтыг шүдэнз барьсан хүүхэд яаж ойгох билээ. Иймээс түймэр тавьчихсан хүүхдийг дахиж ингүүлүүлэхгүйн тулдөмдийг нь тайлж байгаад бөгсөн дээр нь зоддог, хашраадаг, харин шатсан зүйлийн хариуцлагыг эргэн тойрны насанд хүрсэн хүмүүс хүлээх учиртай болдог. Хөөрхий зайлуул, цаанаа муу юм бодоогүй юм чааваас гэдэг хуулийн логик байдаггүй. Иймийг нь өршөөл гэж өөрөөр нэрлэнэ. Өршөөлөө гээд дахин шүдэнз бариулдаггүй, бүр холхон аюулгүй газар аваачдаг. Насанд хүрсэн хүнд энэ нь цөллөг, гэрийн хорио, тусгаарлал, сэтгэцийн больниц, ажлаас халах зэрэг байдлаар илэрлээ олно. Энд мораль, моралийн эрх зэрэг юм яримааргүй байна, хүүхдэд дэндүү хүнддэнэ.

УИХ-ын дарга болсны хувьд гэвэл “Баахан хүн шоронд хийчихсэн чинь нөгөөдүүл чинь гараад ирлээ. Одоо намайг төрийн хамгаалалтанд оруулж өг. Төрийн төлөө зүтгэсээр байгаад амь насаараа хохирох нь, одоо л та бүхэн хүний жудаг гарга” гэж гуйсаар байгаад болсон гэнэлээ. Наадуул нь ч жудаг гээч юмаа гаргаж. Хүүхдийг эрхлүүлж гарт нь заазуур бариулчиж. УИХ-ын дарга болсныгоо ч цэргийн хамаанд өгдөг тушаал буулгадаг дарга гээд ойлгочихсон хэрэг, өнөө учир мэдэхгүй жаал нь. Байлдаж тоглож байгаа ухаантай юм биз дээ. Наадуул нь ч их хурлын дарга бол зөвхөн хурал зохицуулагч юмшүү ч гээд хэлээд өгчихдөггүй. Спикер гэхээр генерал хавьцаа л юм ойлгоо л доо.

Харин Энхбаяр саяхан нэг сонин юм ярьдаг юм. Япон яваад иржээ. Өөрөөр хэлбэл гэгээрчихэж. Манайхан нэг хэсэг бүх юм төрд байх ёстой гэж туйлширдаг байсан гэнэ. Дараа нь бүх юм хувьд байх ёстой гэж нөгөө тийшээ туйлширсан гэнэ. Одоо дэлхий даяар энэ хоёр туйлшралын дундуур төр, хувь хүн хоёр хоёр талаасаа түншлэн хөрөнгөө хамтатгаад хөгжил дэвшилд хүрдэг болсон гэнэ. Үүнийгээ англиар “гурван П” гэдэг (ингэнгүүт нь надад ч өөр юм бодогдсон шүү!) гээд Public- Private-Partnership гэж тайлав. Төр өмчтэй байгаад түүгээрээ менежмент хийхээрээ л ёстой дампууруулж өгдөг үнэнийгөдгөө хорвоо нэгэнт таньсан. Паблик гээд байгаа нь ерөөсөө төрийг болоод төрийн өмчийг хэлж байгаа юм биш. Үүнийг дунд сургуульд заадаг болсон. Олон эзэмшигчтэй, тайлан тооцоо нь нийтэд илэрхий

компанийг л хэлдэг. Паблик компани нь хувийнөмч, эзэмшигч нь олон. Ингэхээр Энхбаяр мэддэггүйгээсээ болж сайхан сэтгэл гаргаж бантанг нь хутгах гэж байна. Эсвэл сүүлийн үед их яригдаад байгаа ашигт малтмалын том ордуудыг хэрхэн эзэмших тухай яриаг өөрийн хорон санаа руу эргүүлэх гэж зориуд ингэж тайлбарлаж байна. Аль нь ч байсан үр дүн нь хортой. Эхнийх нь сайхан санаат мулгуугийн хорлол, дараагийнх нь хорон санаат өөдгүй амьтны зориудын явуулга. Эсвэл шүдэнз барьсан хүүхэд, эсвэл мэс нуусан Брут.

Цэцийн хурал дээр Бямбадоржийг харав уу? Дүүг нь зодож байгааг хараад ах нь учрыг нь ч олсон юм байхгүй нүдээ аниад зодолдоод унадаг шүү дээ. Тийм дүр төрх харагдаж байгаа биз. Бас л хүүхдийн л явдал. Ах бацааны гарт гай болж хутга байвал яана. Хаа хамаагүй хүн бүлэх нь байна шүү дээ! Хууль бол заазуур юм гэж Нямдорж хаа нэгтээ сонссоноо ишилж хэлж байсан. Хүүхдийг хутга, шөвөг, заазуурнаас бас хол байлга!

2007.03.07

Table of Contents

III. Зууны сүүлчийн золиос

Олон тулгуур ба олон туйл

Браво Марфушка, Браво

Зууны сүүлчийн золиос

Солонгосын хойгийн асуудал ба туунийг зохицуулахад монголын оролцоо

Дорнод монголын бүсийн хөгжлийг зүүн хойд азийн эдийн засгийн интеграцитай холбох нь дорнод аймаг

Солонгос ахтай болбол ямар вэ?

Сарсанд сарьслуулж болохгүй

Persona non grata

Лалынхан биднийг хашраах болов уу?

Зүүн хойд азийн хөгжлийн банк

Солонгосын түүхэн туршлага- бидний дуурайл

Ардчилал эрх чөлөөний үзлийн гол тээгч нь соёл мөн

Нүцгэн үнэн

Монгол улс тусгаар тогтнолоо алдсан ба эргүүлж олсон нь

IV. Хэнтийн гурван тэнэг

Бат-Үүлийг баривчилсан нь танил тал харсан шинжтэй байна

МАХН-ын түүхэн улаан замнал

Зүүний намуудын овоолго

Ерөнхий сайд аа, та арай дэндэж байна!

Намаа “шинэчлэх” хуучин арга

Хэрэв энэ тоглоом байсан юм бол одоо хэдийнээ шоглоом болсон

Хоргодох байр

Шударга царайгаар мөнгө олох нь

Хэвлэлд ээлтэй хүн

Хэний мөнгөөр хэн наргина вэ?

Зарчим алдагдахын цагт...

Намуудын дампуурал

Ээлжит бус сонгууль руу!

Ардчилсан нам өөд болов

Онош тавьсан моргийн эмч, хутгалчихсан алуурчин хоёрын хэн нь хэрэгтэн бэ?

Алтан гадас аль чигийг заана вэ?

Нэг иймэрхүү л юм болсон юм даа

Үүд хоймрын зайтай суугаа гончигсүх, хүрэлдорж хоёрт ялгаа юу байна?

Энхбаяр Vs Энхбаяр

Ордон дүүрэн салаавч

Хэнтийн гурван тэнэг

Хэнхэг

Социалист (ардчилсан?) Залуу луйварчид

Зургадугаар палатын ослын буулт

[Анхаар, хүүхдээс хол байлга!](#)